

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
12 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 10
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11 – 170

<i>Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	16 – 34
<i>“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	34 – 47
<i>Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	47 – 129
<i>Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	129 – 156
<i>“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	157 – 158
<i>“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	158 – 170

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 11-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар, Ж.Батжаргал, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Ш.Бямбасүрэн, С.Бямбацогт, О.Номинчимэг, Ч.Ундрэм, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, О.Амгаланбаатар, Б.Заяабал, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Л.Оюун-Эрдэнэ, Д.Пүрэвдаваа, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, Д.Батлут, Х.Булгантуяа, Д.Ганбат, Л.Гантөмөр, Б.Тулга, Х.Тэмүүжин;

Тасалсан: Х.Баттулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан–54 минут, С.Амарсайхан–3 цаг 15 минут, Ч.Анар–01 минут, Т.Аубакир–1 цаг 10 минут, М.Бадамсүрэн–48 минут, Д.Батбаяр–07 минут, О.Батнайрамдал–31 минут, П.Батчимэг–44 минут, Э.Батшугар–25 минут, Ж.Баярмаа–1 цаг 07 минут, Э.Болормаа–3 цаг 04 минут, Г.Ганбаатар–1 цаг 36 минут, С.Ганбаатар–02 минут, Т.Доржханд–52 минут, Б.Дэлгэрсайхан–1 цаг 05 минут, Б.Жавхлан–3 цаг 41 минут, Б.Жаргалан–1 цаг 15 минут, Д.Жаргалсайхан–4 цаг 20 минут, Ж.Золжаргал–25 минут, Ц.Мөнхбат–4 цаг 12 минут, П.Мөнхтулга–1 цаг 23 минут, З.Мэндсайхан–05 минут, Н.Номтойбаяр–34 минут, Э.Одбаяр–29 минут, С.Одонтуяа–4 цаг 14 минут, Г.Очирбат–20 минут, Б.Пунсалмаа–1 цаг 14 минут, Р.Сэддорж–07 минут, Б.Түвшин–29 минут, Д.Цогтбаатар–2 цаг 45 минут, Б.Чойжилсүрэн–11 минут, Б.Энхбаяр–04 минут, Ж.Энхбаяр–21 минут, Р.Эрдэнэбүрэн–06 минут.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаярт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Бум-Очир, П.Сайнзориг, А.Ариунзаяа, Б.Мөнхсоёл, Д.Энхтүвшин, Ч.Номин, Р.Эрдэнэбүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хариулж, тайлбар хийв.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Учрал: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 50
Бүгд: 81
38.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн найруулгын санал:

Н.Учрал: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийн “нийтээр амрах” гэснийг “долоо хоног бүрийн амралтын” гэж өөрчилж, “давхацсан бол” гэсний дараа “давхацсан өдрийг” гэж нэмж, төслийн тайлбарыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 57
Бүгд: 81

29.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Хоёр.ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Учрал: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 51

Бүгд: 81

37.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

**Гурав.НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Н.Учрал: 1. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 74

Бүгд: 82

9.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хороодын танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, М.Ганхүлэг, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн нар хариулж, тайлбар хийв.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хамтарсан Байнгын хорооны хуралдаанаас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Учрал: 1.Төслийн 5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 40

Бүгд: 89

55.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Н.Учрал: “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 41

Бүгд: 90

54.4 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын зөвлөх Б.Лхамсүрэн, Э.Нямбаяр, Э.Бүжинлхам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал Д.Бат-Өлзий, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын Олон улсын арбитрын хэлтсийн дарга О.Цолмон, Сангийн яамны Татварын бодлогын газрын төслийн зөвлөх Ч.Мөнхшүр, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Б.Лхагважав, мөн танхимын Гадаад худалдааны бичиг, баримт баталгаажуулалтын газрын дарга Э.Бадамхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх М.Отгон нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ариунзаяа, О.Цогтгэрэл, Ц.Идэрбат, Ц.Туваан, Л.Мөнхбаясгалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Б.Лхагважав нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 45 минут үргэлжилж, 13 цаг 05 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 03 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 14 цаг 03 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг соёрхон батлах асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Д.Ганмаа, Ч.Номин, Г.Лувсанжамц, Д.Батбаяр, Ж.Золжаргал, Н.Номтойбаяр, Ж.Алдаржавхлан, Б.Пунсалмаа, Б.Жаргалан, Д.Энхтүвшин, Б.Бейсен нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Б.Лхагважав, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /15:40/

Дөрөв. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос, бүтээгдэхүүний хэлтсийн дарга Ч.Чулуунбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Батмөнх, референт М.Мандхай нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал 15 цаг 58 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ариунзаяа, О.Цогтгэрэл, Б.Түвшин, Н.Номтойбаяр, Б.Бейсен нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /16:46/

Тав. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын

дарга Ч.Дондогмаа, Хуулийн газрын ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх, М.Мандхай нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /16:49/

Зургаа. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, Хуулийн газрын ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ариунзаяа, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /17:15/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 47 дугаар сургуулийн 12а ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 97 дугаар сургуулийн 12е ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын урилгаар “Монгол хурандаа” нийгэмлэгийн Багануур дүүрэг дэх салбар зөвлөлийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын “Оюуны ундраа” сургуулийн 12г ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн

Д.Энхтуяагийн урилгаар Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаагийн урилгаар Сүхбаатар дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын урилгаар Өмнөговь аймгийн Социал-демократ Монголын залуучуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн урилгаар Өмнөговь аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын цэцэрлэгийн багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 58 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 99 гишүүн ирж, 78.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 11-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 20 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 47 дугаар сургуулийн 12-ын ангийн “а” багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Ж.Ганбаатар гишүүний мэндчилгээг дэвшүүлье. /алга ташив/

Улсын Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна.

Улсын Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. 55 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Түүнээс өмнө мэдээлэл дуулгая.

Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг нарын 78 гишүүний өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулаад байгаа.

Энэ хуулийн төслийн ажлын хэсэгтэй холбоотой анхаарвал зохих асуудлууд гарч байна.

Хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу анх уг хуулийн төслийг санаачилж өргөн мэдүүлсэн гишүүдээс Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Л.Энхнасан, Х.Баасанжаргал нарын 4 гишүүн нэрээ татсан бичгээ Улсын Их Хурлын даргад хүргүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37.5-д хуульд хууль санаачлагч өөрийн санаачилж өргөн мэдүүлсэн хуулийн төслийн ажлын хэсэгт орохыг хориглосон зохицуулалттай байдаг.

Энэ нь Улсын Их Хурал хуулийг аливаа ашиг сонирхлын зөрчил, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, зөвхөн ард түмний нийтлэг эрх ашигт нийцүүлэн батлах ёстой гэсэн бодлогын илэрхийлэл, хууль тогтоогчид бидний мөрдвөл зохих алтан дүрмийн нэг гэдгийг онцлон хэлмээр байна.

Нэрээ татаж авсан хууль санаачлагч тухайн хуулийн төслийн ажлын хэсэгт орж болохгүй гэсэн зохицуулалт байхгүй учраас нэрээ татсан 4 гишүүний 3 нь

буюу Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Л.Энхнасан, Х.Баасанжаргал нар уг ажлын хэсэгт ажиллаж байгаа.

Тэгэхээр хуулиар мэдээж нэрээ татъя гэсэн бичгээ ирүүлэх нь хуулиар хориглогдоогүй. Гэхдээ энэ асуудлыг дэгийн тухай хуулиар зохицуулаагүй ч Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 3.14-д хориглосон байдаг. Тухайлбал, Гишүүний ёс зүйн дүрэмд гишүүн бүрэн эрхийн хүрээнд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл санаачилж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дараа тухайн хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллахыг хориглоно гэж тодорхой заасан.

Тиймээс цаашид анх санаачилсан хуулийн төслөөсөө нэрээ татаж авсан гишүүн тухайн хуулийн төслийн ажлын хэсэгт орохгүй байх дэгийн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлага үүсэж байна. Хуулийн хийдэл үүсэж байна.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очирт дэгийн хуулийн зохицуулалтыг ёс зүйн дүрэмтэй нийцүүлэхэд хуулийг дахин боловсруулж нийцүүлэх шаардлагатай байна.

Тийм учраас Ц.Сандаг-Очир даргад дэгийн хуулийг ёс зүйн дүрэмтэй нийцүүлэх чиглэл өгч байна.

Ер нь Их Хурлын гишүүд хуулийг санаачилна гэдэг өөрийнхөө саналыг, өөрийнхөө тухайн хууль дээр баримталж байгаа гол зарчмуудыг тусгачхаад нэгэнт хууль баригдаад хэлэлцэж эхлэхэд би хуулийн төсөл санаачлагчаас нэрээ татна гэж хэлээд ажлын хэсэгт орно гэдэг бол энэ өөрөө ёс зүйн дүрмээ зөрчиж байгаа л асуудал шүү дээ.

Энэ чинь 60 хоногийн хугацаанд хуулийн төслийн хэлэлцүүлэгт нь оролцоод, өөрөө санал бодлоо тусгаад, тэгээд Их Хурал дээр хэлэлцэх эсэхийг нь дэмжсэний дараа албан бичгээр би хуулийн төсөл санаачлагчаас нэрээ татаж байна гэдэг чинь энэ өөрөө ёс зүйн дүрэмтэй нийцэхгүй.

Өнөөдөр хуулийн хүрээнд хориглоод байгаа зүйл байхгүй. Гэхдээ энэ ёс зүйн дүрэм дэгийн хууль хоёрыг нийцүүлэхгүй бол цаашдаа ийм асуудал үүсээд байх юм байна. Одоо мэдээж хуулийн төсөл санаачлагчаас нэрээ татна гэдэг Их Хурлын гишүүний бүрэн эрх учраас бид хүлээж авна. Гэхдээ энэ өөрөө хоорондоо нийцэхгүй байна.

Тэгэхээр үүн дээр Төрийн байгуулалтын байнгын хороо дэгийн хуулиа эргэж харахгүй бол ийм доголдол, хуулийн давхардал, хийдлүүд олон байна.

Өнөөдөр Улсын Их Хурлаас батлагдсан хүчин төгөлдөр 378 хууль дээр зөвхөн хиймэл оюунд суурилсан хууль зүйн дүн шинжилгээ хийлгэж харлаа.

Гэтэл 378 хуулийн 50 мянга гаруй заалтад 1323 заалт дээр хүний эрхийн зөрчил үүсэж байна гэдэг шинжилгээ гарсан.

Тэгэхээр Үндсэн хуульд заасан 18 эрх, эрх чөлөө байдаг. Үүнийг 97 нэгж эрх болгон задлаад –

- ▶ иргэний **59 эрх,**
- ▶ эдийн засгийн **24 эрх,**
- ▶ улс төрийн **14 эрх,**

-хиймэл оюуны тусламжтайгаар дүн шинжилгээ хийж ажиллаж эхлээд байна.

Тэгэхээр энэ ондоо багтаагаад **parliament.mn** дээр хиймэл оюунд суурилсан шинжилгээ гээд тавигдана.

Тэгэхээр Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа хууль, Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлж байгаа хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлж байгаа хуулиудыг иргэд өөрсдөө parliament.mn дээр ороод тухайн хуулийн файлыг нь **upload** хийгээд үзэхээр хуулиудын давхардал, хийдлүүд нь шууд нээлттэйгээр дүн шинжилгээ хийгээд гарна гэсэн үг.

Тэгэхээр цаашдаа парламент –

- ▶ **Нэгдүгээр шатанд** эрх зүйн дүн шинжилгээ хиймэл оюун дээр суурилна.
- ▶ **Хоёрдугаар шатад** эрх зүйн дүн шинжилгээ Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтэс дээр анализ хийнэ.

Ингээд хуулиудын давхардал, хийдлүүдийг арилгаж, харж байхгүй бол одоо нэг тийм эмх замбараагүй байдалтай болоод байна шүү дээ.

Хууль санаачилдаг. Дуртай үед нь хуулиа татаад авдаг. Тэгээд хууль би огт санаачлаагүй шүү гээд бичиг ирүүлдэг. Нэгэнт хуулиар хориглогдоогүй учраас хууль санаачлагч өөрөө хууль санаачлагч нэрээ татаж байна гээд хуулийн хүрээнд нь авдаг.

Тэгэнгүүт буцаагаад ажлын хэсэгт оръё гээд бичиг ирүүлэхээр хуулийн хүрээнд хориглогдоогүй учраас Их Хурлын даргын зүгээс оруулахгүй байя гэдэг тайлбар тавих хууль зүйн үндэслэл байдаггүй. Тэгээд оруулаад явдаг.

Тэгэхээр Тамхины хууль дээр ийм асуудал үүссэн. Үүнийг Төрийн байгуулалтын байнгын хороо дэгдээ дахиад өөрчлөлт оруулахаар энэ чуулганы завсарлагаанаар ажиллацгаая.

Мөн бүлгийн дарга нараас Тамхины хууль дээр Их Хурлын гишүүдийг оруулъя гэдэг саналаа ирүүлсэн.

Тэгэхээр нэгтгээд нэмэлтээр бүлгийн дарга нараас ирүүлээд байгаа гишүүдийн нэрийг нэмээд даргын захирамжаар өргөтгөсөн байдлаар хуралдуулаад явах нь зохимжтой.

Гэр бүлийн хууль дээр Хууль зүйн байнгын хороо ажлын хэсэг байгуулсан байна гэж би сонссон.

Тэгэхээр Гэр бүлийн хууль өргөн цар хүрээтэй асуудал. Энэ өөрөө Төсвийн байнгын хорооны төлөөлөл заавал орох ёстой. Үүнд нөгөө тэтгэмжийн асуудал яригдаад байна.

Эдийн засгийн байнгын хороо бас оролцох ёстой юм билээ.

Дээрээс нь Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо оролцохгүй Гэр бүлийн хууль гэж байхгүй.

Тэгэхээр энэ ажлын хэсгийг Их Хурлын даргын захирамжаар байгуулна.

- Б.Найдалаа дарга ямар ямар гишүүдийг ажлын хэсэгт оруулмаар байгаа вэ гэдэг саналаа өгөх ёстой.
- Төсвийн байнгын хороо Н.Наранбаатар дарга саналаа өгөх ёстой.
- Эдийн засгийн байнгын хороо Р.Сэддорж даргын зүгээс хэн хэн гэдэг гишүүдийг оруулмаар байгаа вэ гэдэг талаараа саналаа өгөх ёстой.

Ингээд нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд энэ завсарлагааны явцад хэлэлцүүлгүүдийг хийнэ ээ.

Түүнээс зөвхөн Хууль зүйн байнгын хороо татаж авчхаад Ажлын хэсэг байгуулах нь зохимжгүй.

Тэгэхээр Гэр бүлийн хууль дээр Их Хурлын даргын захирамжаар шинээр ажлын хэсэг байгуулна гэдгийг Та бүхэнд хэлье.

Тэгээд бүлгийн дарга нар бас нэрсээ өг. Тэгээд ингээд өргөтгөсөн байдлаар энэ завсарлагааны явцад Гэр бүлийн хууль, түүнийг дагасан хуулиудаар хэлэлцүүлгүүдийг өрнүүлнэ ээ.

Тэгээд олон нийтийн хэлэлцүүлгүүдийн үр дүнд Гэр бүлийн хуулийг батлах шаардлагатай гэдгийг Та бүхэнд хэлье.

64 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 50.8 хувьтай.

Их Хурлын гишүүдийнхээ энэ өглөөний мэндийг айлтгаж, гишүүдийн ирцийг танилцуулъя.

50.8 хувьтай, 64 гишүүн ирсэн байна. Гишүүдийг танхимд бас урьж байна.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснээ мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 6 асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт. Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Тавдугаарт. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Зургадугаарт. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Нэг.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн
2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн танилцуулна.

Б.Хэрлэн гишүүнийг индэрт урьж байна.

Б.Хэрлэн: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, О.Батнайрамдал нарын зүгээс 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.17 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар, тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасах, мөн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг нийтээр тэмдэглэх баярын өдөр долоо хоног бүрийн амралтын өдөртэй давхацсан тохиолдолд давхацсан өдрийг дараагийн ажлын өдөр шилжүүлэх, төслийн тайлбар хэсгийг хасах гэсэн найруулгын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир.

Н.Учрал: Б.Хэрлэн гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан нэрсээ ирүүлсэн байгаа.

Нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ хууль төрийн албаныханд л их чухал байх.

Хувийн хэвшлийнхэн үйлдвэрлэлээ явуулж, баялаг бүтээж, цалингаа тавих нь хамгийн чухал. Дээрээс нь янз янзын түрээс төлж байгаа тэр хүмүүс өдөр болгон ажиллаж байж хэдэн төгрөгийн түрээсээ төлж амьдрал ахуйгаа авч явах нь хамгийн чухал байгаа.

Тийм учраас эдийн засаг хүндэрсэн үед энэ хуулийг хэлэлцэх нь чухал биш юм.

Ер нь эдийн засаг хүндэрсэн байна. Энэ асуудлаа эхэлж яриач ээ. Гадуур мөнгөтэй хүн алга. Аж ахуйн нэгжүүд татварын дарамтад орж дансаа хаалгаж байна. Цалингаа тавьж чадахгүй байна. Ийм л нөхцөл байдалд орсон байна.

Төсөв хүндрээд төсвийн алдагдал нийтдээ 3 их наяд төгрөг болж байна. Би бүр 9 сарын 18-ны өдөр Их Хурлын танхимд хэлэхдээ 1.3 их наяд төгрөгийн төсвийн алдагдалтай боллоо. Оны эцэс гэхэд 3 их наяд төгрөг хүрэх нь гэдэг зүйл хэлж байсан. Яг энэ дээрээ хүрээд ирж байна.

Өнөөдрийн байдлаар аж ахуйн нэгжлийн орлогын албан татвар 1 их наяд төгрөгөөр тасараад байж байгаа. Дээрээс нь АМНАТ-ын орлого 1.4 их наядар тасараад байна.

Тэгэхээр энэ бүх зүйлийг яаж нөхөж байна вэ гэхээр гадаадын өр зээл тавьж байж л нөхөж байна.

- Гадаадаас 2.2 их наяд төгрөгийн бонд босгож алдагдлаа нөхлөө.
- Дотоодоос 500.0 тэрбум төгрөгийн бонд босгож алдагдлаа нөхлөө.

Дээрээс нь 800.0 тэрбум төгрөгийн гадаад зээл авч байна.

Энэ онд гэхэд 3.5 их наяд төгрөгийн гадаад бонд, зээлээр төсвийн алдагдлаа нөхөж байна шүү дээ. Өр гэдэг бол тамтаггүй боллоо.

Дээрээс нь Монгол Улс нүүрсний эдийн засагтай орон болсон.

▪ Өнөө өглөө –

- ▶ **коксожсон нүүрс** - - 30 доллароор уналаа.
- ▶ **эрчим хүчний нүүрс** - - 3 доллароор уналаа.

Үүнийг мэдэж байгаа хүн байна уу.

Дээрээс нь “Эрдэнэс Тавантолгой” чинь 11.1 сая тонн нүүрсний мөнгийг урьдчилж авч хэрэглэхээд одоо нөгөө нүүрсээ гаргаагүй байж байна шүү дээ.

Ийм нөхцөл байдалтай байж байхад Та нар амралтын өдөр яриад байж байгаа юм.

Нүүрс чинь өвөл өсдөг шүү дээ. Гэтэл өсдөг үеэрээ унаж байна гэдэг чинь эдийн засагт асар их аюулын дохио авчирч байна гэсэн үг байхгүй юу даа.

Тийм учраас эдийн засаг хүндэрч байна.

- Аж ахуйн нэгжүүд чинь арай ядан ажиллаж байна.
- Татварын дарамтаа багасга.
- Дансыг нь нээ.
- 21 мянга 800 гаруй компани, аж ахуйн нэгж, иргэдийн дансыг хаасан байна.
- Дансуудаа нээ л дээ.
- Оны эцсээр хүмүүстээ цалин тавьж, шинэ жил болон амралтын үеүдээ тэмдэглэмээр байдаг.
- Гэтэл дансыг нь хаасан. Ямар ч гүйлгээ байхгүй.
- Дээрээс нь татварын дарамт нь хэрээс хэтэрсэн.

Энэ бүх татварыг чинь доороос өндийдөг хүн байхгүй байна шүү дээ. Нүүрс нь сайн явахгүй болоод ирэнгүүт нь яаж байна вэ гэхээр татварын дарамт урсгал явж байснаа сүүлийн хэдэн жил тувт өслөө шүү дээ. Айхтар өслөө. Хамаг хүмүүсийн халаасыг хоосолж байж, аж ахуйн нэгжүүдийг хоосруулж байж татварыг нь хурааж авдаг ийм л эдийн засаг болсон. Тэрийг нь үрэлгэн зардалтай тансаглалтай зарцуулдаг ийм л төр засагтай болоод байна шүү дээ.

Тийм учраас компани, аж ахуйн нэгжийн талаар авч байгаа арга хэмжээнүүдээ зөөлөн болгож, дансыг нь нээж, тэгээд тодорхой хугацаа өгч хүмүүсийн бизнесийг дэмжих нь төр засаг, Их Хурлын хувьд маш чухал байна. Энэ талаар ярьцгаа. Өдөр шилжүүлдгээ тэр... /минут дуусав/

Н.Учрал: Санал хэллээ. Д.Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Би тайлбар, тодруулга хийх гэсэн юм.

“Битүүний өдрийг амралтын өдөр болгох” гэдэг миний санаачилсан санал. Одоо хэлэлцэж буй хуулийн төслөөс өөр төсөл шүү гэдгийг би олон нийт болоод гишүүддээ хэлмээр байна. Тэгэхгүй бол хооронд нь холиод байж магадгүй.

Миний санаачилж байгаа хуулийн төсөл намрын чуулганд багтаад ороод ирэх байх, батлагдана гэж найдаж байна.

Миний санаачилж байгаа хуулийн төсөлд зөвхөн “битүүний өдрийг амралтын өдөр” болгон шилжүүлэх тухай асуудал шүү. Б.Уянга гишүүн тэргүүтэй гишүүдийн санаачилж байгаа хуулийн төслөөс агуулгын хувьд өөр төсөл шүү.

- Бидний хэлэлцэж байгаа хуулийн төсөл нь “хагас, бүтэн сайн өдөр хэрвээ амралтын өдөр таарах бол түүнийг шилжүүлэх” тухай байгаа.
- Минийх “битүүний өдрийг амралтын өдөр болгож тооцъё” гэсэн агуулгатай байгаа.

Монгол Улс нийтдээ 16 өдөр амардаг юм байна. Олон улсын жишгээр тийм өндөрт ордоггүй.

Хуулийн төслийг оруулж ирсэн гол шалтгааныг би юу гэж ойлгож байна вэ гэхээр 16 өдөртөө ерөнхийдөө 16-аад нь монголчууд амардаггүй юм байна. Гол төлөв жил тойроод үзэхэд 9, 10, 11 өдөр л амардаг юм байна. Бусад өдөр нь хагас, бүтэн сайн таарахаар дандаа амрахгүй яваад байдаг.

Монголчууд бид жил тойроод 9-өөс 11 өдөр амардаг гэж үзвэл жишээ нь 2025 онд гэхэд 6 өдөр нь хагас, бүтэн сайн таарч байгаа учраас 16 өдрөөс 11 өдөр амрах байх жишээтэй. Өнгөрсөн жилүүдэд мөн ингэж явсан. Түүний өмнөх жилүүдийг би бас өөрийн хуулийн төслийн хүрээнд тооцож үзсэн. Ерөөсөө 9-өөс 11 өдөр л амраад байгаа юм билээ. 9-өөс 11 өдөр бол яг дэлхийн дундажтай харьцуулахад ерөнхийдөө багадаа ордог юм байна. Дэлхийн дундаж 17, 18 байгаа юм билээ.

Тийм учраас хуулийн төслийг оруулж ирсэн гэж ойлгож байна.

Миний гол хэлэх гэсэн санаа юу гэхээр “битүүний өдөрт амардаг байх тухай” хуулийн төслөөс өөр хуулийн төсөл шүү. Яг амрах өдрийг нь тооцоод үзэх юм бол минийх нэг өдрийн тухай асуудал. Энд 6 өдрийн тухай асуудал хамгийн багадаа яригдаж байгаа. Ийм ялгаатай зүйл байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Түүнчлэн бас нэгэн зүйлийг хэлье. Мэдээж би сая Б.Пүрэвдорж гишүүний хэлж байгааг ойлгож байна. Аж ахуйн нэгжүүд ажиллаад эдийн засаг, хөрөнгө мөнгө, санхүүгийнхээ асуудлыг шийдэж байх нь илүү зүйтэй байгаа гэдгийг ойлгож байна.

Амралтын өдрүүд хэт богино байхаар, дээр нь хагас, бүтэн таарахаар үүнийгээ дагаад маш их хүмүүс яардаг. Үүнийгээ дагаад авто замын зөрчил нэлээд их гардаг. Гэмт хэрэг, зөрчил их гардаг. Их өсдөг ийм тооцоо судалгаа байгаа юм.

Тийм учраас тодорхой хэмжээгээр амралтын өдрүүдийг анхаарах нь зүйтэй шүү. Үүнийгээ дагаад олигтой амарч чадахгүй. Тэгээд хагас, бүтэн сайн юм уу, бусад өөр өдрүүд давхцах юм бол яарч сандарсан хүний тоо нэмэгддэг. Түүнээсээ болоод хэрэг зөрчил гардаг эрсдэлүүд байдгийг энэ ташрамд анхааруулаад хэлмээр байна.

Амралтын өдрүүд нь нэлээд тавиу таарсан үед харьцангуй авто замын хэрэг зөрчил багасдаг. Амрах өдрүүдийн тоо дэндүү их тулаад юм уу, багасаад ирэх тусам авто замын хэрэг зөрчил нэмэгддэг статистик тоо бас байдгийг анхааруулж хэлмээр байна. Баярлалаа.

Н.Учрал: П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Гишүүддээ өглөөний мэндийг хүргэе.

Хуулийн төслөөр амралтын өдрүүдэд нийтээр амрах баярын өдрүүд таарвал Засгийн газар тодорхой хэмжээний өдрүүдийн тохируулга хийж, ажлын өдрүүдийг шилжүүлэхээр явдаг. Тэгэхдээ үүнийгээ тулгаж хийгээд хувийн хэвшилд жоохон төвөг учруулдаг талууд байдаг. Ажил төрлөө зохицуулахаас эхлээд, эргээд тухайн байгууллагын санхүүгийн ачаалал өгдөг.

Мэдээж нийтээр тэмдэглэх ажлын өдрүүдийг ажлын өдрийг болгохоор цалин тодорхой хэмжээнд нэмэгдэж олох ёстой. Үүнийгээ дагаад нийгмийн даатгалын шимтгэлийг ч гэсэн ахиу төлнө гэсэн үг шүү дээ. Ажил олгогч талаас төлж байгааг. Хувь хүн ч гэсэн олж байгаа орлогынхоо хэмжээгээр.

Тэгэхээр ийм зүйлүүдийг тулгаж хийгээд их хүндрэлүүд учирдаг байсан. Уг нь Засгийн газарт ажлын өдрүүдийг шилжүүлэх гэдэг юм уу, амралтын өдрүүдийн тохируулгыг хийхдээ тухайн жилд ийм үйл ажиллагаа, тохируулгыг хийхээсээ өмнөх жилийнхээ 12 сард Засгийн газар шийдвэрээ гаргаад үүнийгээ нийтэд зарладаг уг нь их хялбар байсан юм болов уу гэж бодож байгаа.

Зайлшгүй дараагийн ажлын өдрүүдэд шилжүүлнэ гээд хатуу хуульчлах гэж байна л даа.

Тэгэхээр сая гишүүдийн хэлээд байгаа зүйлүүд ч ортой. Нэг талдаа ажил, амралтыг зөв тохируулах нь хувийн хэвшил бизнес төлөвлөгөөнөөсөө эхлээд хүний нөөц бүх зүйлүүдэд уялдуулж ажиллах тэр бололцоог олгож байгаа.

Үүнийгээ дагаад ямар хэмжээний санхүүгийн гэдэг юм уу, эдийн засгийн гэдэг юм уу нөлөө аж ахуйн нэгж, байгууллага, ер нь нийгэмд үзүүлэх бол? Үүнийг хуулийн төслөөр тооцож гаргасан юм байна уу? Эргээд эдийн засгийн агуулга талаасаа хувийн хэвшилд ачаалал өгөхөөсөө гадна зорьж байгаа тэр суурь шалтгааныг нийгэмд зөв ойлгуулах нь зөв байх.

Түүнээс биш Улсын Их Хурал ажил амралтын өдрүүдийг зохицуулах гээд байгаа биш тодорхойгүй буюу Засгийн газрын заримдаа үзэмжээр шийдээд байгаа асуудлыг шийдье л гэж байх шиг байгаа юм. Энэ хуулиар.

Тэгэхдээ 2026 онд ийм тохируулгыг хийхдээ 2025 оны 12 сард Засгийн газар нь зарлахад л болох байгаа юм. Ийм ийм өдрүүдийг ингэж байгаа гээд. Ийм байдлаар явсан нь зүгээр байсан юм биш үү гэдэг зүйл байгаа юм. Энэ асуултад хууль санаачлагчаас хариулж өгөөч.

Ер нь ямар хэмжээгээр хувийн хэвшилд санхүүгийн нөлөө үзүүлэх, дарамт нэг талдаа байна. Энэ чинь цалин өснө. Нийтээр амрах баярын өдрүүдэд хүн ажиллуулна гэдэг чинь. Үүнийгээ дагаад бусад зүйлүүд байна. Ийм зүйлүүд байгаа.

Хоёрдугаарт, энэ тохиолдолд хувийн хэвшил гэрээний асуудал боловч зарим талаараа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн гэрээн дээр нь нөгөө түрээслэгч тал хөнгөлөх асуудлыг харилцан тохиролцох, магадгүй зарим тийм захиргааны шинжтэй байдлаар зохицуулах талууд байдаг юм билээ. Нэг талдаа цалин өсгөдөг. Түрээс зарлаж байгаа. Эсвэл амардаг. Энэ чинь түрээс л яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хэдийгээр хоёр иргэний хоорондох гэрээний асуудал мэт боловч иймэрхүү зохицуулалт дээр тухайн өдрийн түрээсийг нь ядаж ердийн журмаар байдаг юм уу, эсвэл тодорхой хэмжээгээр хөнгөлөх нөхцөл байдал руу оруулах асуудал уг нь бусад хууль дээр бас орж ирэх ёстой л юм билээ. Тэгээд үүнийгээ дагаад жижиг аж ахуйн нэгж амархад орлого тасарна. Үүнийгээ дагаад түрээсээ төлөхөд ч хүндрэлтэй байгаа.

Тэгэхээр үүнийг тооцож бодсон зүйлүүд байна уу? Уг нь аж ахуйн нэгж, байгууллагууддаа ээлтэй байдлаар зохицуулалтуудыг бид хийх ёстой.

Тэгэхээр энэ чиглэлдээ хариулж өгөөч ээ. Тэр түрээсийн асуудал дээр нь тодорхой хууль, зохицуулалт... /минут дуусав/

Н.Учрал: Б.Уянга гишүүн асуултад хариулъя.

Б.Уянга: Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе.

Б.Пүрэвдорж гишүүн, Д.Бум-Очир гишүүн, П.Сайнзориг гишүүн, тэгээд өнөөдөр яг хуулийн төсөлтэй холбоотой асуулт асуух гэж байгаа бүх гишүүдийн асуулт, хэлэх үгийг анхааралтай сонсоод нэлээн сайн, ер нь бүх орон даяараа л ярилцах нэг сэдэв нь нийтээр амрах баярын асуудал болох байх гэж бодож байна. Нийтээр тэмдэглэх баяртай холбоотой.

Тэгээд сая П.Сайнзориг гишүүний асуусан асуулттай холбоотойгоор хэрвээ нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтан байвал нэмэгдэл хөлсийг тооцох тухай Хөдөлмөрийн тухай хуулийн 2.2 болон 109.4-дэд зааж өгсөн байдаг.

Тэр харилцаагаар цалин хөлсийг хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно. Эсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 3 дугаар сарын 17-ны А/49 дүгээр тушаалаар нэмэлт ороод тэгээд нийтээр амрах баярын өдөр хэрвээ ажилласан бол цалин хөлсөн дээр нь нөлөө үзүүлээд илүү төлөөд явдаг. Хувийн хэвшил талдаа.

Тэгээд түрүүн Б.Пүрэвдорж гишүүний хэлснээр жижиг, дунд бизнес эрхлэх гэж байгаа түрээсийн төлбөр төлдөг иргэдэд тодорхой хэмжээний төлөө үзүүлнэ.

Төрийн байгуулалтын байнгын хороон дээр гишүүдтэй ярилцаад гишүүдийн саналыг сонсож байхад Ч.Номин гишүүн нэлээн гаргалгаатайгаар тайлбарыг хэлж байсан.

Тэгэхээр өнөөдөр хуулийн төсөл дээр асуулт асуух үеэрээ талаараа сайн хэлж өгөх байх.

Тэгээд нийтээр амрах баярын өдөртэй холбоотой хуулийн дагуу Монгол Улсад 9 баярын 16 өдрийг амралтад хамруулаад явдаг.

Та бүхэн бүгдээрээ санаж байгаа байх. 2022 он хүртэл амралтын өдөртэй хагас бүтэн сайнтай давхацвал яах вэ гэдгийг Засгийн газар зохицуулдаг харилцаа хуульд байсан.

2022 онд Хөдөлмөрийн тухай хууль шинэчилж найруулагдахдаа энэ харилцаа байхгүй болсон.

Тэгээд ер нь хувийн хэвшилд ажиллаж байхад ч тэр, төрд ажилладаггүй байхад хууль хэрэглэгдэхгүй, ойлгогдохгүй, ойлгомжгүй байна гэсэн иргэдийн шүүмжлэл байнга байдаг. Түүний нэг нь энэ байсан.

2024 онд цагаан сарын өдрүүдийг Засгийн газар хуулийн заалт нь байхгүй учраас шийдвэрээ гаргах боломжгүй байх үеэр ажиглаад хуультай танилцаад үзэхэд энэ заалт байхгүй л байсан.

Тэгэхээр нь буцаагаад оруулъя гээд ажиллаад Хууль тогтоомжийн тухай хуулиараа оруулж ирж байгаа л асуудал. Тэгээд эдийн засаг хүнд байхад албаар амрах тухай яриад байгаа юм энд ерөөсөө байхгүй.

Хууль тогтоомжийн тухай хуулиараа л өгсөн бүх бүрдүүлбэрээ бүгдийг нь хангуулаад одоо л дараалалд ороод л хэлэлцэгдэж өнөөдөр бид ярьж байгаа асуудал гэдгийг онцолж хэлэх нь зүйтэй байх.

Н.Учрал: Мэндчилгээ дэвшүүлье.

Нийслэлийн ерөнхий боловсролын 97 дугаар сургуулийн 12-ын “е” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Багш, сурагч нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье.

97 дугаар сургууль миний 1-ээс 5 дугаар ангидаа сурч байсан сургууль байна. Манай сургууль шүү. Тийм. 97 дугаар сургуулийнхандаа, багш нартаа, сурагч нартаа сурлагын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Баянзүрх дүүргийн 97 дугаар сургуулийнхан. П.Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа дарга аа.

Би хариултаас бодлоо. Мэдээж сая Д.Бум-Очир гишүүн ч хэлж байна. 16 хоног нийтээр амрах баярын өдрүүд тохиож байгаа боловч яг бодит амьдрал дээр 9, 10 хоног амардаг. Энэ нь хувийн хэвшилд тодорхой хэмжээний санхүүгийн дарамт болж очиж байгаа. Ялангуяа цагаан сар, наадмын өдрүүд жоохон урт болдог. Энэ нь ч зөв байх.

Тэгэхдээ нөгөө талаараа жижиг аж ахуйн нэгж байгууллагууд руу, ялангуяа үйлчилгээний салбарынхан түрээсийн дарамтад яг үеэр ордог.

Тэгэхээр ядаж энэ зүйлүүд дээр харгалзаж үзэх нөхцөлүүд байвал их зүгээр. Ерөнхийдөө сарынхаа бараг урт амралт болоод LONG WEEKEND болоод 5-аас долоо хоног амрах юм бол сарынхаа бараг дөрөвний нэг дээр нь үндсэндээ түрээсийн орлогогүй, ингээд жижиг аж ахуйн нэгж байгууллагуудад ийм дарамттай зүйлүүд байдаг.

Тэгэхээр нөхцөл байдлуудыг уг нь бодолцож энэ зүйлүүдийг хийх ёстой болов уу л гэж бодоод байгаа. Тодорхой саналууд гарсан юм байна. Үүнийгээ хэлэлцээд явна биз. Ер нь аль... /минут дуусав/

Н.Учрал: А.Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Хуулийн төслийг ер нь дэмжихгүй байгаа юм.

Тэгээд яагаад дэмжихгүй байгаа вэ гэхээр Хөдөлмөрийн сайдаар ажиллаж байхад Хөдөлмөрийн тухай хууль яг чуулганаар хэлэлцэж байсан. Тэгээд манай Ц.Мөнх-Оргил гишүүн тухайн үед ажлын хэсгийг ахалж байсан.

Хөдөлмөрийн тухай хууль дээр Засгийн газар “өдөр зөөх” боломжтой байсныг тухайн үедээ энэ заалтыг больж байсан. Хүчингүй болгож байсан гэсэн үг.

Тэгээд яагаад вэ гэхээр Засгийн газар “өдөр зөөх” эрхээ хэтэрхий тулгаж, хэтэрхий замбараагүй, хэтэрхий уймраа хэрэглэж байсан учраас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүндрэл учруулж байсан юм.

Тэгээд календарийн оногдсон өдөртөө тухайн баяр нь болдгоороо болоод, тэгээд хүмүүс ажлаа төлөвлөдөг байг гэдэг ийм үндсэн зарчмаар тухайн үед тэр заалтыг хүчингүй болгож байсан.

Яах вэ, амьдрал баян юм чинь магадгүй зөөвөрлөх эрхийг Засгийн газарт эргүүлээд өгөх шаардлагатай байх. Гэхдээ ингэхдээ жилийнхээ эхний долоо хоногтоо. Тухайн жилийн календарийн хоног өөрчлөгдөхгүй шүү дээ.

Тэгэхээр тэр өдрүүддээ жилийнхээ эхний долоо хоногт нь тухайн жилийн амралтын өдрүүд, баярын өдрүүд хэрхэн ямар байх вэ гэдгийг эртнээс төлөвлөгөөгөө гаргаад, түүнийгээ хөдөлгөдөггүй байх юм бол уг нь зохистой юм гэж.

Б.Уянга, О.Батнайрамдал гишүүд нарын өргөн барьсан хууль нь өөрөө юу юм бэ гэхээр нэг жоохон нөгөө монжуулсан сэтгэлгээн дээрээ гэдэг юм уу, хагас, бүтэн сайнд бүх нийтийн амралтын өдөр таарахаар уг нь ажлын өдөр байсан бол би амрах байсан шүү дээ гэдэг сэтгэлгээн дээр суурилж өдрийг шилжүүлэх гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр яах вэ, магадгүй иргэд, ажилтнаа бодсон нөгөө амрах байсан шүү дээ гэдэг тэр сэтгэл ханамж дээр нь суурилсан байдлаар авч үзье гэх юм бол дэмжиж болох юм. Гэсэн хэдий ч уг нь тухайн календарийн хоногтоо л оногдсоноороо байвал илүү зохистой.

16 хоног гэдэг бол дэлхийн дундаж. Манайхтай адилхан Марокко, Казахстан, Япон, Индонез, Тайвань, Тайланд, Танзания гэх зэрэг улсууд байдаг.

- Хамгийн багадаа –
 - › Америк - 6 хоног,
 - › Вьетнам - 6 хоног,
 - › Англи - 8 хоног,

- Нидерланд - 7 хоног,
- Серби - 9 хоног,
- Мексик - 8 хоног байдаг.

- Хамгийн олон –
 - Непал - 35 хоногтой,
 - Мьянмар - 25 хоногтой,
 - Иран - 26 хоногтой гэх мэтчилэн.

Бүх нийтээр амарч тэмдэглэх өдрүүдийн тоо манай улсын хувьд дэлхийн дундажид ордог.

Тэгэхээр хэтэрхий их ч юм уу, хэтэрхий бага ч юм уу гэсэн маргаан байх ёсгүй. Байнгын хороон дээр Засгийн газрын дэвшүүлсэн нэг бодлого нь өөрөө зөвхөн цагаан сар, наадмаар л энэ хоногийг зөөж болох юм гэдэг саналыг өгсөн юм шиг байна лээ. Тэгээд Байнгын хороон дээр санал нь харамсалтайгаар унасан.

Тэгэхээр ер нь энэ хуулийг аль нэг гишүүд гэхээсээ илүүтэй Засгийн газар өөрөө л бодлогоо гаргамаар байгаа юм.

Уг нь Хөдөлмөрийн тухай хуулиар сая цагаан сарын үеэр нэлээд маргаан, уймраа шийдлүүд гарсан. Хөдөлмөрийн тухай хуулиар болоод нийтээр тэмдэглэх өдрүүдийн хуулиар цагаан сар жишээлбэл билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3 гэж томьёолсон байдаг юм л даа. Тэгээд яах вэ 3 хоног гэдэг үндсэн концепц явдаг атал яах вэ 2 нь алгасаад ч юм уу, давхцаад ч юм уу яваад ирэхээр 3 хоног амрах юм уу, шинийн 2, 3 гээд хоёр хоног амрах юм уу гээд ер нь жоохон ойлгомжгүй байдаг.

Тэгэхээр энэ дээр... /минут дуусав/

Н.Учрал: Д.Энхтүвшин гишүүн. Б.Уянга гишүүн хариулья.

Б.Уянга: Засгийн газрын саналыг сая А.Ариунзаяа гишүүн асуулаа.

Хуулийн төсөл 2022 онд Засгийн газар өдөр шилжүүлэх боломжтой байсан тэр заалтыг нь өнөөдөр буцаж эргэж оруулж ирж болох юм. Гэхдээ ер нь хэн нэгэн тулгаж. Уймраа гэж түрүүн хэллээ. Тийм байдлаар шийдвэр гаргахгүйгээр хууль дээр тодорхой.

Энэ тохиолдолд яах вэ гэсэн тийм зохицуулалтыг нь суулгая гэдэг дээр. Нийтээр тэмдэглэх баяртай л давхцах юм бол хойш нь шилжүүлдэг байхаар ийм саналыг томьёолж оруулж ирсэн юм.

Энэ хуулийн төслийг түрүүн чуулганы үеэр хавар өргөн барьсан.

Засгийн газрын санал 2025 оны 6 сарын 25-ны өдөр орж ирсэн. Засгийн газрын санал дээр нийтээр тэмдэглэж өнгөрүүлэх 9 баярын зөвхөн үндэсний хэмжээгээрээ бид уламжлалынхаа дагуу ёслол хүндэтгэлтэйгээр тэмдэглэн өнгөрүүлдэг цагаан сар, наадам дээр л авч үзье гэж санал ирүүлсэн байгаа юм.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ долоо хоногийн хоёр дахь өдөр хэлэлцэгдэх үеэр цагаан сар болон үндэсний баяр наадам, яг энэ хоёр баяраараа хэрвээ давхцах юм бол хойш нь шилжүүлнэ гэсэн зохицуулалтыг зарчмын зөрүүтэй саналаар оруулж ирсэн.

Тэгээд энэ нь Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжигдээгүй санал байгаа. Хуулийг өнөөдөр бид хэлэлцэж байна. Тэгээд цаг үе нь эдийн засгийн хүндрэлтэй байх үеэр давхцаад ороод ирлээ. Хэлэлцэж байх үед бид энд 126 л байгаа. Тэгээд аливаа асуудлыг олуулаа хэлэлцвэл мэдээж олонхоо дагаад л шийдвэр нь зөв гарах байх.

Тэгэхээр сайхан хэлэлцэж байгаад яг яаж оруулах юм бэ гэдэг дээрээ гишүүд яг өөрсдийнхөө итгэл үнэмшлээр өгөхөөр тэгээд нэг шийдэл гарах байх гэж найдаж байна.

Түрүүн А.Ариунзаяа гишүүний асууснаар Засгийн газрын санал нь ирэхдээ зөвхөн наадам болон цагаан сарыг дэмжье гэсэн байгаа.

Н.Учрал: А.Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Тийм. Тэгэхээр миний санал бол ер нь хуулийг уг нь дэмжихгүй байх. Дэмжлээ гэхэд Б.Уянга гишүүний өөрийн Төрийн байгуулалтын байнгын хороон дээр гаргасан зарчмын зөрүүтэй санал буюу Засгийн газрын ирүүлсэн саналыг дэмжиж өгөх хүсэлтэй байна.

Ер нь Засгийн газар өөрөө энэ асуудлаа гартаа авахгүй бол ер нь л их замбараагүй болоод байна шүү.

Тэгээд л хувь гишүүд бүгдээрээ л нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийг нэмэх хууль санаачлаад яваад байх юм бол тэгээд л ер нь иргэддээ таалагдах л шийдвэр гаргахыг бодно шүү дээ. Хэн ч. Тийм биз дээ.

Гэтэл цаана нь эдийн засгийн агуулгаараа Засгийн газар өөрөө энэ бодлогоо авч явах ёстой шүү дээ. Тэгээд үүнийгээ жоохон хариуцлагатайгаар байхгүй бол наадмаар 9 хоног амрах хуулийн төсөл бас явж байгаа шүү дээ. Хуулийг нь хэлэлцээд 9 хоног амардаг болох юм бол одоо энэ амралтын

өдрүүдийг нэмээд бараг 14 хоног наадмаар амрах нөхцөл байдал ер нь үүснэ шүү. Тэгэхээр Засгийн газар жоохон хариуцлагатай байгаач гэж хүсэж байна.

Н.Учрал: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Би зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа. Тэгээд энэ нь илүү нэр томьёо найруулгатай холбоотой зарчмын зөрүүтэй санал байгаа.

Өргөн барьсан төслөөр “нийтээр тэмдэглэх баярын өдөр нийтээр амрах өдөртэй давхацсан бол” гэж байгаа юм.

Одоогийн мөрдөгдөж байгаа хуулиар харахаар “нийтээр амрах өдөр” гэдэг нь болохоор “нийтээр тэмдэглэх баярын өдөр” болчхож байгаа юм.

Тэгэхээр хоёр өөр огтлолцохгүй олонлогийг хэлээд хэрвээ хоёр огтлолцвол гэдэг ийм хуулийн найруулгатай, нэр томьёотой болсон байгаа учраас “нийтээр амрах” гэдгийг нь, өөрөөр хэлбэл цагаан сар, наадам хоёр давхацвал гэдэг ийм агуулгатай болсон байгаа. Нэр томьёог нь харвал.

Тэгэхээр үүнийг нь засах нь зөв байх гэж үзээд зарчмын зөрүүтэй санал дээр **“нийтээр амрах”** гэдгийг **“долоо хоног бүрийн амралтын”** гэж илүү тодотгож өгсөн санал оруулсан байгаа.

Тэгээд Байнгын хороон дээр дэмжигдсэн санал байгаа.

Б.Уянга гишүүний хувьд дэмжигдээгүй санал дээр наадам, цагаан сарыг илүү бусад баяруудыг биш энэ хуулийг хэрэглэх тохиолдол нь зөвхөн наадам, цагаан сараараа гэсэн ийм санал байна гэж ойлгосон.

Тэгэхээр миний хувьд яг энэ нэр томьёог нь тодотгосон ийм санал байгаа гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Н.Учрал: Санал хэллээ. Чинбатын Номин гишүүн.

Ч.Номин: Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Хуулийн санаа нь зөв боловч нөлөө нь бодитой хууль байгаа гэдгийг Та бүхэн ойлгоорой. Бид өнөөдөр амралт, баярын өдрийг илүү шударга, зохистой болгох, иргэдийнхээ баярын өдрийг алдахгүй байх ёстой гэдэг санааг хэлэлцэж байгаа боловч энэ нь нөгөө талдаа шууд бизнес эрхлэгчдэд нөлөөлж байгаа ийм хууль байгаа.

Би зарчмын хувьд хуулийг нь ерөнхийдөө дэмжиж байгаа. Хэдий тийм боловч бид шууд аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч нар дээрээ нөлөө үзүүлж байгаа гэдгийг танхимд байгаа гишүүд маань ойлгоорой.

Бид хууль дээрээ харахаар нийтээр тэмдэглэн өнгөрүүлж байгаа баярын өдрүүд нэмэгдэхгүй юм шиг боловч амралтын өдрийн нөлөөлөл жилд дунджаар 2-оос 3 өдрөөр нэмэгдэж байгаа буюу ажил хийхгүй өдөр манай улсад 2-оос 3 өдрөөр нэмэгдэж байгаа. Энэ нь шууд манай Монгол Улсын бүтээмжид нөлөөлнө.

Цаашлаад жижиг, дунд бизнес эрхлэгч нарт, нэн ялангуяа үйлчилгээний салбарынханд, аялал жуулчлалын салбарынханд, уул уурхайн салбарынханд нөлөөлнө. Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярын өдрүүдийг хэрвээ амралтын өдрүүдтэй давхацвал дараагийн ажлын өдөр лүү шилжүүлж байгаатай холбогдуулан жижиг, дунд бизнес эрхлэгчид түрээс төлдөг аж ахуйн нэгжүүд тухайн өдрийнхөө түрээсийг төлөөд л явна. Тэгсэн мөртөө орлого нь тэг байна.

Нөгөө талдаа хэрвээ зогсох боломжгүй аж ахуйн нэгжүүд байлаа гэж бодоход жишээ нь уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа үргэлжлүүлээд хийнэ. Ингээд хийснийхээ төлөө хоёр дахин буюу гура дахин цалингаа нэмэгдүүлж төлнө. Зардал нь нэмэгдэнэ гэсэн үг.

Тэгэхээр нэг талдаа зогсвол орлого нь зогссон мөртөө зардал нь үргэлжлээд явна. Эсвэл үргэлжлээд тогтмол үйл ажиллагаатай явах шаардлагатай газрууд нь үргэлжлээд явахад зардал нь нэмэгдэнэ.

Ингэснээр дэлхий дахинаа хийсэн судалгаан дээр тодорхойлоод үзэхэд жилд 2-оос 3 өдрийг улсынхаа хэмжээнд баярын өдрөө шилжүүлж амралтын өдөр болгосноор манай улс нэг хүртэлх хувийн бүтээмжийг алдаж байгаа ийм нөхцөл байдал үүсэж байгаа гэдгийг бид бодох хэрэгтэй.

Бид нэг талдаа иргэдийнхээ ашиг сонирхлыг дэмжих нь зөв. Гэхдээ нөгөө талдаа бизнесийн орчныг бас зөрчилдүүлэхгүй аль алинд нь тэгш, шударга зарчмыг бий болгох нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд ч утгаараа баярын өдрүүдийг шилжүүлж байгаа.

Нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярын өдрүүдийг хэрвээ амралтын өдөртэй давхцаж байгаа тохиолдолд ажлын өдрүүдийг амралтын өдөр болгож шилжүүлж байгаа энэ хуулийг бид тооцож үзэхдээ зарим нэг баярууд дээр тооцож үзэх нь зүйтэй. Нэг ёсондоо цагаан сар, наадам гэх мэтчилэн уламжлалаа хадгалсан, нөгөө талдаа урт үргэлжилсэн баярууд дээрээ үүнийгээ тооцож үзээд бүх 16 нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярын өдөр дээрээ биш тодорхой баяр дээрээ байлгах дээр анхаарна уу гэж хэлмээр байна.

Ийм учраас Б.Уянга гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжээд, нэг ёсондоо Байнгын хороон дээр унасан зарчмын зөрүүтэй саналыг бид энэ дээр харгалзаж үзээд явах юм бол нэг талдаа бизнесээ ч бодсон, нөгөө талдаа бид бас иргэдээ бодсон ийм санал болно гэдгийг тодотгож хэлмээр байна.

Энэ дээр би нэмээд хэлэхэд өнөөдөр манай эдийн засаг, төсөв дээр өчигдөр Төсвийн байнгын хороон дээр Сангийн яамныхантай уулзсан. Сангийн яамныхнаас гаргасан дүгнэлтүүд дээр хэлэхэд манай төсвийн орлого 2.2 их наяд төгрөгөөр тасарсан явж байгаа шүү. Бид эдийн засгаа бодсон шийдвэрүүдийг гаргаж явахгүй бол сэтгэл хөдлөлөөр шийдвэр гаргах нөхцөл цаг хугацаа биш байгаа шүү гэдгийг би Та бүхэндээ хэлмээр байна.

Тэгээд үүнээсээ болоод буцаад л нөгөө хувийн хэвшил, аж ахуйн нэгж дээрээ татварын дарамтууд, бусад дарамтууд... /минут дуусав/

Н.Учрал: Гишүүд асуулт асуугаад байна. Ж.Энхбаяр сайд хариулах юм уу, Сангийн сайд хариулах юм уу? Тийм. Тэр компаниудын дансыг хаагаад байна. Та нар ажлаа хий л дээ. Би та нарт долоо хоног гэж хэлсэн шүү дээ. Одоо орж ир. Ажлаа хий. Сангийн сайд хаана байна. Гишүүд асуулт асуугаад байна шүү дээ.

Ямар Б.Уянгаа гишүүн наад асуултад чинь хариулах юм уу? Ч.Номин гишүүн асуугаад байна. Ч.Номин гишүүний асуултад хэн хариулах юм? Б.Уянгаа гишүүн хариулах юм уу? Сайд нар хуралдаа орж ир.

Би сайд байхдаа энд орж ирээд суудаг байсан шүү дээ. Та нар мэднэ дээ. Тийм. Бби энд сууж байдаг байсан. Л.Мөнхбаатар гишүүний оронд яг ингээд суудаг байсан шүү дээ. Тийм шүү дээ. Орж ир л дээ. Сууж байгаа нь байна.

Г.Дамдинням сайд байна, Ж.Энхбаяр сайд байна, Б.Чойжилсүрэн сайд байна. Гурван сайд байна.

Би сайд нарыг ойлгож байна. Зарим хэлэлцэж байгаа асуудал дээр холбогдох албан тушаалтнуудаа суулгаад оролцохгүй байх нь байх ёстой. Яагаад гэхээр чинь Засгийн газрын ажил өдөр тутмынх байдаг.

Тэгээд ядаж байхад нөгөө дэд сайд гэж байхгүй учраас чинь сайд ер нь тэгээд л чуулган дээр нэг байна, ажлын хэсэгт нэг байна, гадаад нэг явна, дотоод нэг байна гээд л байдалтай байна.

Гэхдээ Их Хурлын гишүүд асуулт асуугаад байна. Түрүүн Б.Пүрэвдорж гишүүн асуулаа. Ч.Номин гишүүн асуулаа. Эдийн засаг дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Асуултад хариулах хүн алга байна.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууя.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе.

Хуулийн төслийг дэмжихгүй байгаа. А.Ариунзаяа гишүүнтэй санал нэг байгаа.

Засгийн газрын зохицуулах асуудал байгаа юм. Засгийн газар ямар бодлого барьж байгаа юм. Түүгээрээ явж байх ёстой зүйл.

Хоёрдугаарт, хуулийн төсөлтэй холбогдуулаад тандан судалгаа гэж ямар газраар хийлгүүлсэн юм бэ? Б.Уянга гишүүн.

Ямар ч үнэн бодитой юм байхгүй. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө гэсэн чинь ерөөсөө нөлөөлөхгүй гэсэн. Аж ахуйн нэгжүүдэд ямар ч нөлөө байхгүй гэсэн ийм судалгаатай хуулийн төсөл орж ирсэн байна.

18 амралтын өдрүүд чинь аж ахуйн нэгжүүдийг ажил хийлгэдэггүй. Хийх боломжгүй болгодог. Хил, гааль нь амраад алга болдог. Төрийн албан хаагчид нь амраад алга болдог.

Тийм учраас би ямар саналтай байгаа вэ гэхээр цагаан сар, наадам хоёроо авч үлдээд бусад бүх тэмдэглэлт амралтын баярын өдрүүдээ амрахгүй болгоё. Харин зөрүүлээд ямар юу хийх ёстой вэ гэхээр ялангуяа өвлийн улиралд 25 градусаас дээш хүйтэн өдөр өдрүүдэд орон нутгийн засаг захиргаа шийдвэр гаргаад автоматаар амрааж байдаг тийм зохицуулалт руу явсан нь дээр байх гэж бодож байна.

Тэгэхгүй одоо ингээд амрахаас өөр юм байхгүй. Хувийн хэвшлийнхэн чинь ажлаа хийх гээд байдаг. Энэ амралтаар чинь төрийн албан хаагчид л амраад явчхаж байгаа шүү дээ. Амралтуудаар чинь. Тэгээд энэ зохицуулалтыг өөрөөр хийх ёстой.

Тийм учраас хуулийн төслийг дэмжихгүй байгаа. Цаг нь ч биш байна. Ийм юм яриад сууж баймааргүй. Өдийд Сангийн сайдтайгаа жинхэнэ эдийн засгаа яах вэ гээд ярьж баймаар ийм л цаг болоод байх шиг санагдаад байгаа юм.

Н.Учрал: Тийм. Р.Эрдэнэбүрэн гишүүн. Зөвлөл санаачилга зөв л шаардлага тавьж байна.

- Ирэх долоо хоногт ач холбогдолтой хуулиуд оруулж ир.
- Тэр нийгмийн даатгалын тэр 8 хуулийг ирэх долоо хоногт оруулж ир.
- Тэр Арилжааны хууль, Эдийн засгийн эрх чөлөө, Хөрөнгө оруулалт, Ашигт малтмал, одоо нээрээ арай дэндлээ.

— Ач холбогдолтой хууль оруулж ир.

Ирэх долоо хоногт би Засгийн газарт үүрэг өгч байна.

Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолыг өнөөдөр хэлэлцэнэ.

— Тэр чиглэл дээр наад Хөрөнгө оруулалтын хуулиа оруулж ир.

Наад давхардсан хяналт шалгалтаа бууруул. Их Хуралд ач холбогдолтой хуулиуд оруулж ир л дээ.

- Тэр Эдийн засгийн эрх чөлөө,
- Хөрөнгө оруулалтын хууль.

Ж.Энхбаяр сайд аа, ирэх долоо хоногт оруулж ирье. Хэлэлцэх асуудалд оруулъя.

— Тэр Нийгмийн даатгалын хууль хаана байна. Хэдэн арван жил ярилаа шүү дээ.

— 2021 оны 10 сарын тэр Хувийн нэмэлт тэтгэврийн хууль хэлэлцэх эсэх дэмжсэн. Түүнээс хойш 5 жил болж байна шүү дээ. Тэр хуулийн хэлэлцэх эсэхээ дэмжсэн хууль байгаа юм билээ шүү. Хуулиараа зөвшөөрөгдсөн юм билээ.

Болохгүй бол Хувийн нэмэлт тэтгэврийн миний анхны санаачилсан хуулийн 10 сарын 03-нд баталсан хэлэлцэх эсэхийг дэмжсэнээр би өнөөдөр анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ажлын хэсэг байгуулна шүү.

Тэгээд одоо ингээд нийтээр тэмдэглэх баяр яриад сууж байна шүү дээ, бид нар. Үгүй чинь тэгээд хуулиар зохицуулагддаг харилцаа. Үүнийг өөрчлөхгүйгээр дахиад л нөгөө цагаан сар шиг юм болно гээд Их Хурлын гишүүд үүнийг санаачлах нь буруу биш шүү дээ. Тэгэхдээ Засгийн газрын ажил шүү. Одоо хуулийг тэгээд дэмжээд явахаас өөр гарц байхгүй. Нэгэнт хуулиараа харилцаа зохицуулагдаж байгаа учраас.

Өнөөдөр санал хураалтууд явагдана. Гишүүд орж ир. Санал хураалтдаа оролц л доо.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 4 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга. Санал хураалт.
/алх цохив/

31 гишүүн зөвшөөрч, 38.3 хувийн саналаар зөвшөөрлөө буюу санал дэмжигдсэнгүй.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийн “нийтээр амрах” гэснийг “долоо хоног бүрийн амралтын” гэж өөрчилж, “давхацсан бол” гэсний дараа “давхацсан өдрийг” гэж нэмж, төслийн тайлбарыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт.
/алх цохив/

24 гишүүн зөвшөөрч, 29.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай санал Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх.

Санал гаргасан Болдын Уянга гишүүн. Санал хураалт. /алх цохив/

51 гишүүн татгалзаж, 63 хувиар санал дэмжигдсэнгүй.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар тухайн долоо хоногийн гийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга. Санал хураалт.
/алх цохив/

74 гишүүн татгалзаж, 90.2 хувиар санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалд орёё.

Хоёр. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төсөл. Эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан танилцуулна.

Индэрт урья. Төсвийн байнгын хорооны дарга Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урья.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нараас гаргасан тогтоолын хэрэгжих хугацааг ердийн журмаар мөрдөх буюу төслийн 5 дахь заалтыг хасах болон найруулгын шинжтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед –

- Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Баруун бүс нутгийн өвөлжилтийн нөхцөл байдал, улсын нөөцөд авсан өвс, тэжээлийн үнийн мэдээлэл болон цаашид албан татварын хөнгөлөлтөд нэг удаагийн зохицуулалт хийхээс зайлсхийх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан албан татварын хөнгөлөлтийн асуудлыг ган, зудын нөхцөл байдалтай уялдуулан урьдчилан зохицуулах, Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд хэрэгжихээр төлөвлөсөн усалгааны систем суурилуулах ажлын явцын талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр гурил, тэжээлийн үйлдвэрлэлийн хэрэгцээ шаардлагыг харгалзан татварын хөнгөлөлт үзүүлэх боомтыг нэмэгдүүлэх боломжтой эсэх,
- Улсын Их Хурлын гишүүн С.Замира улаан буудайн гурил болон малын тэжээл, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний гаалийн албан татварын тухай хувь хэмжээг тогтоох асуудлын хэрэгжих хугацааны талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах хүсэлтийг Улсын Их Хурлын Тамгын газарт гарган Тамгын газраас тогтоолын төсөлд хууль зүйн зөвлөмж гаргасан.

Уг зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлтээ холбогдох Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хүргүүлснийг хамтарсан хуралдаанд танилцуулсан.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасныг үндэслэн тогтоолын төслийн 5 дахь заалтыг хасах зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй санал, төслийн эцсийн хуулбар болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Н.Наранбаатар гишүүнд Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын урилгаар “Монгол хурандаа” нийгэмлэгийн Багануур дүүрэг дэх салбар зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Ажлын хэсгийг танилцуулъя.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Ажлын хэсгийг Та бүхэнд танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа.

Энэ ямар ч байсан зуншлага муу байсан аймгуудыг тодорхой дэмжих, эргээд өмнөх жилүүдэд болсон хамгийн ойрын зуднаар л гэхэд бид чинь 8 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий мал сүргээ алдсан байгаа. Эдийн засаг болон өрхийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгааг бид мэдэж байгаа.

Тэгэхээр үүнээс урьдчилан сэргийлэх ажлыг уг нь цаг алдалгүй л хиймээр байгаа юм. Энэ дээр санаачилж оруулж ирсэн Х.Жангабыл гишүүндээ талархал илэрхийлье.

Ерөнхийдөө баруун 5 аймгийн тодорхой боомтуудаар өвс тэжээл, гурил, эргээд хорголжин тэжээлүүдийг оруулж ирэх бололцоо бүрдэж байх шиг байна.

Тэгэхээр ажлын хэсгээс яг аж ахуйн нэгж, байгууллага, иргэддээ мэдээллийг өгөх үүднээс энэ индрийг ашиглаач гэж байгаа юм. Үүгээр ямар боломжуудыг малчид, аж ахуйн нэгж байгууллагууддаа Улсын Их Хурал гаргаж өгч байгааг тодорхой тайлбарлаж, хэрэгжих хугацаа, эргээд аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаа хийхдээ анхаарах ямар зүйлүүд байна гэдэг зүйлийг яг салбар хариуцсан сайд тодорхой олон нийтэд мэдээлэл өгөөч гэж нэгдүгээрт хүсэж байна.

Хоёрдугаарт, уг асуудалтай холбоотойгоор нэг зүйл байгаа. Засгийн газар газрын харилцаатай холбоотой хууль тогтоомжуудыг боловсронгуй болгооч ээ. Газрын төлөвлөлтийг маш сайтар хиймээр байна.

Өнөөдөр газрын харилцаа бараг 7, 8 яаманд байгаа.

- ▶ Ерөнхий сайдын дэргэд газрын харилцаа ерөнхийдөө байна.
- ▶ Уул уурхайн яаманд газрын харилцаа байна.
- ▶ Барилгын яаманд газрын харилцаа байна.
- ▶ Зам, тээврийн яаманд газрын харилцаа байна.
- ▶ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд газрын харилцаа байна. Бэлчээрийн асуудал талаасаа байгаа.
- ▶ Хууль зүй, дотоод хэргийн яаманд газрын харилцаа байна.

Хууль зүй, дотоод хэргийн яаманд газрын эрхийн бүртгэлд бүртгэхээсээ гадна Хил хамгаалах ерөнхий газрын зурвас газар дээр хадлан тэжээл хийлгэнэ, хийлгэхгүй гээд яваад өгдөг.

- ▶ Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тусгай хамгаалалттай газар нутаг гээд явдаг.

Тэгэхээр газрын харилцааг зөв эдийн засгийн эргэлтэд оруулж ашиглахын тулд нэгдсэн бодлого, зохицуулалтын хууль тогтоомжуудаа эргэж хараад, ган зудын үед газрыг хэрхэн яаж ашиглах вэ гэдэг бүх зүйлээ тодорхой болгомоор байна. Аль хэсэгтээ эрчимжсэн мал аж ахуй, аль хэсэгтээ хадлан тэжээлийн бүс, аль хэсэгтээ уул уурхайгаа явуулах ч гэдэг юм уу ийм зүйлүүдийг зайлшгүй хиймээр байна.

Тэгээд энэ бол ерөөсөө л бид хэд ган зудыг даван туулах асуудал чинь газрын менежментийг хэрхэн явуулах вэ, газраа яаж нөхөн сэргээж зөв эдийн засгийн эргэлтэд оруулах вэ гэдгээс л их шалтгаалж байгаа.

Тэгэхээр нэг удаагийн өвс тэжээлийг оруулж ирэх гэхээсээ илүүтэйгээр аль аль бүс нутгуудад мал аж ахуйн онцлогт нь таарсан газар тариалан, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэх юм бэ гэдэг л зүйл байгаа.

Тэгэхээр үүнийг Засгийн газар анхаараач ээ. Газрын харилцаа чинь маш олон сайдуудын дунд ойлгомжгүй болоод байна. Тэгээд яг өвөлжилт хүндрэхээр отрын бүс гээд л зарлана. Х.Ганхуяг сайд л үүнийг зохицуулна л даа. Тэгээд чинь өөрөө нөгөө иргэдийн дунд ингээд үл ойлголцол үүсдэг. Энэ аймгийн иргэд малтайгаа ороод ирлээ гээд л явдаг.

Тэгэхээр бид хэд энэ асуудлыг зайлшгүй шийдээд, ойлгомжтой болгоод явах зайлшгүй шаардлага байгаа шүү гэдэг зүйлийг би энэ индэр дээрээс хэлмээр байна.

Тэгээд М.Бадамсүрэн сайд л хариулах байх. Ер нь энэ тогтоолын ач холбогдол, эргээд үүнийг хэрэгжүүлэхээр импортоор оруулж ирэх гурил тэжээл, өвс оруулж ирэх аж ахуйн нэгж, байгууллага юуг анхаарах ёстой гэдэг зүйл дээр товч тодорхой мэдээллийг олон нийтэд өгөөч ээ гэж хүсэж байна.

Н.Учрал: М.Бадамсүрэн сайд хариулъя.

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлын 1999 оны тогтоолд заасны дагуу Засгийн газарт тодорхой эрх өгөх зохицуулалт байгаа. Энд тухайн боомт зааж болно. Мөн татварыг “тэг” хүртэл тогтоох эрхийг түр хугацаанд Засгийн газарт өгч байгаа зохицуулалт.

Тэгэхээр аж ахуйн нэгж, иргэдийн хувьд анхаарах зүйл нь баруун бүсийн 5 боомтоор гурилыг импортоор оруулж ирэх, мөн малын тэжээлийг импортоор оруулж ирэхэд Засгийн газраас тогтоосон тэр хэмжээгээр хөнгөлөлт, чөлөөт эдэлнэ гэсэн үг.

Манай яамны зүгээс хэрвээ энэ тогтоол өнөөдөр батлагдсан тохиолдолд ирэх долоо хоногийн гурав дахь өдөр хоригийн хугацааг тооцоод аль болох

хурдан хугацаанд Засгийн газарт тогтоолын төслийг бид танилцуулна. Ингээд Засгийн газраас шийдвэр гарна. Эрх авсан тохиолдолд Засгийн газарт бид өгөх санал маань тэжээлийн одоо байгаа “5” хувийг “0” хувиар, гурилын импортын “15” хувийн татвар байгааг “0” хувиар гэж манай яамнаас саналаа Засгийн газарт оруулна.

Тэгээд Засгийн газар эцсийн шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл баруун бүсийн нэр заасан 5 боомтоор импортын татваргүй малын тэжээл болон гурил оруулж ирэх боломж бүрдэнэ гэдгийг аж ахуйн нэгжүүдэд мэдээлж байна.

Хугацааны хувьд 4 дүгээр сарын 15 хүртэл хугацааг гэж бид тооцож оруулж байгаа. Өөрөөр хэлбэл яг энэ өвөл, хаврын хүндрэлтэй цаг нөхцөлд гэж тогтоож байгаа. Тэгээд энэ хугацаанаас хойш эргээд 15 хувийн татвар, гурил, тэжээлийн 5 хувийн татвар эргэж сэргээд явна гэсэн мэдээллийг аж ахуйн нэгж, иргэддээ өгье.

Газрыг ашиглах төлөвлөгөөний хувьд П.Сайнзориг гишүүнтэй санал нэг байна. Цаашид бэлчээрийн доройтол, мах их хэмжээгээр нэмэгдэж байгаа. Төрөөс хийж хэрэгжүүлж дэмжиж чадах гол ажил экспортыг бүх талаар дэмжих. Манай яам экспортод квот тогтоодог байсныг квотгүй болгосон. Мөн гадаад яриа хэлэлцээрийг аль болох нэмэгдүүлэхийг зорьж байгаа.

Цаашид олон худалдааны хэлэлцээрүүд байгуулагдаж нэмэгдвэл үүн дээр олон боломжууд нэмэгдэх. Малчдын хувьд бидэнд олон төрлийн дэмжлэг гэхээс илүүтэй мах, түүхий эдийг үнэтэй болгох, экспортлох боломжийг төр бүрдүүлж өгөөч гэдэг хүсэлтийг л их тавьж байгаа.

Тэгэхээр малын тоо толгойноос илүү чанарт шилжүүлж, малчдын орлого болох мах, түүхий эдийг нь нэмэгдүүлэх нь бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх эдийн засгийн гол хөшүүрэг, арга болно.

Малчид малаа олон болгоё гэж айхтар зорихоос илүүтэй амьжиргаанд нь хүрэлцэх... /минут дуусав/

Н.Учрал: Хариулт болсон уу? Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Татварын асуудал дээр бид их сайн анхаарах ёстой юм шиг байгаа юм. Тогтоолын төслийг яах вэ, зудын нөхцөл байдлыг харгалзан үзэж дэмжиж байгаа.

Тэгэхдээ бид байн байн энэхүү тогтоолын төслийг өөрчлөх, бизнес эрхлэх гэж байгаа, ялангуяа тэжээл, гурилын үйлдвэрийн чиглэл дээр бизнес эрхэлж байгаа хүмүүсийн тодорхой санал асуултуудыг бид бүхэн хэрхэн тусгаж, яаж явж байгаа билээ гэдэг дээрээ жоохон дүгнэлт хийх ёстой байх гэж бодоод байгаа юм.

Ер нь татварын асуудал дээр өөрчлөлт оруулаад явж байгаа асуудал нь асуудлыг сууриар нь шийдэхгүй байгаа юм.

Тэгэхээр үүнийг тогтоол батлагдаж, эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байгаатай холбогдолтой хэд хэдэн саналуудыг тэмдэглэлд үлдээж, цаашдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, шинэ сайд маань анхаарал хандуулж ажиллаасай гэж бодож тодорхой асуултуудыг асууж, саналаа хэлье.

Үндсэндээ малын тэжээлтэй холбогдолтой асуудал. Цаашдаа цаг уурын нөхцөл байдал улам л хүндрэх нөхцөл байдлууд байна. Мөн дээрээс нь малчид өөрсдөө бие дааж тэжээл тариалах боломжийг олгох гэдэг суурь асуудал байгаа юм.

Тэгэхээр чиглэл дээр яг тодорхой асуудлуудыг бид хийхгүйгээр уламжлалт мал аж ахуй дээр суурилсан зудын эрсдэлийг даван туулах чадвараа бид өсгөхгүйгээр явж байгаа нөхцөл байдлыг татвар бууруулах хэлбэрээр аргацааж шийдэл гаргаад явах нь зохимжгүй байдал руу очиж байна.

Тэгэхээр аль болох тодорхой суурь асуудлууд руугаа анхаарах нь зөв байна гэдгийг тодотгож хэлье.

1999 онд батлагдсан энэхүү тогтоол, тэр дундаа баруун бүс дээр ялгамжтай хандаж өөрчлөлт оруулж байгаа агуулга хэдэн удаа өөрчлөгдсөн бэ? Өмнөх өөрчлөлтүүдээр ямар үр дүнгүүд гарсан бэ гэдэг дээр тодорхой дүгнэлт, саналууд хийсэн үү? Энэ байдлаараа бид үргэлжлээд явах уу гэдэг эхний асуулт байна.

Хоёрт, суурь асуудал болсон малчдын орлогыг нэмэгдүүлэх чиглэл дээр явж байгаа “Шинэ хоршоо” хөдөлгөөн тэргүүтэй хөтөлбөрүүдийг илүү эрчимжүүлэх, малчид өөрөө өөрсдөө зудын эрсдэлийг даван туулах чадварыг сайжруулах чиглэл дээр М.Бадамсүрэн сайд өөрөө ямар бодлоготой байх вэ?

Мөн дээрээс нь малчдыг хоршиж нэгдээд, хамтраад тодорхой хэмжээнд 5 га газрыг авах боломжийг олгож байгаа. Үүнийг цаашдаа нэмэгдүүлж, өөрөө өөрсдөө тэжээлээ тариалах, тэжээлийн түүхий эдээ бэлтгэх чиглэл дээр томоохон компанит ажлыг хийлгэх боломж байна уу? Энэ ажлыг тодорхой өрнүүлэх хэрэгтэй байна.

Малын тоо, чанарыг цаашдаа анхаарах ёстой гэсэн агуулга бүгд л ярьж байна. Энэ жилийн улсын аваргаасаа эхлүүлээд тоо, чанараас илүүтэй хамгийн үржил шимтэй мал үржүүлж байгаа малчдаа шагнаж урамшуулдаг, түүний хийж бүтээсэн зүйлийг нь алдаршуулдаг ийм хэв маяг руу орох байдлаар энгийн ийм асуудлуудаас тодорхой гарц шийдлүүдээ хайвал яасан юм бэ. Үүнийг ер нь хийх боломжтой юу?

Улсын аваргуудыг, шилдэг малчдыг яг энэ зудын эрсдэлийг хамгийн өндөр түвшинд даван гарч чадаж байгаагаар нь, хамгийн үржил шимтэй малыг үржүүлж байгаагаар нь тодруулдаг зохион байгуулалт руу оруулахад тийм хэцүү биш. Гэх мэтчилнээр тодорхой саналуудыг дэвшүүлье.

Үүнээс гадна татвараар зохицуулахаас гадна суурь асуудлыг шийдэх ямар боломжууд байх вэ? Дараа дараагийн түвшинд анхаарч ажиллах ямар бодлого байгаа вэ гэсэн асуултыг асууя.

Н.Учрал: Ц.Сандаг-Очир гишүүн дахиж танилцуулмаар байгаа юм уу? Ц.Сандаг-Очир гишүүний урилгаар “Монгол хурандаа” нийгэмлэгийнхэн ирсэн байна.

Та бүхэндээ аз жаргал сайн сайхныг хүсье.

Багануур дүүрэг дэх салбар зөвлөлийн гишүүд Та бүхэнд аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсье.

Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн хариулна.

М.Бадамсүрэн: Нэгдүгээрт, мэдээж төрийн бодлого тогтвортой байх ёстой. Тантай санал нэг байна.

Тэгэхдээ Монгол Улсын хувьд өргөн уудам нутагтай. Зүүнээс баруун тийш асар олон мянган километр үргэлжилдэг. Бид нэгдмэл улс гээд нэг хуультай.

Тэгэхээр зарим тохиолдолд бүсийн ялгавартай бодлогыг цаашид, ялангуяа хөдөө аж ахуйн салбарт зайлшгүй хэрэгжүүлж шаардлагатай юм билээ.

Тэгэхээр эндээс ямар үр дүн гарах вэ гэдгийг гишүүнд тодорхой танд танилцуулга өгье. Цаашид таны санал дээр анхаарна.

Хоёрдугаарт, тэжээлийн хувьд тантай 100 хувь санал нэг байна. Ер нь малд нэгдүгээрт тэжээл, бэлчээрийн хомсдолтой холбоотой гол асуудал үүсэж байгаа

Хоёрдугаарт, аль болох малын тавлаг байдлыг хангах гэдэг зорилтыг бид анхаарахгүй бол үндсэндээ хашаа хороо нь тийм битүү биш, тэгээд мал өвлийн хүйтэнд даарснаас болж маш их хэмжээгээр эцэж турдаг. Ийм асуудал байгаа учраас тэжээл болон битүү хашаатай болгох гэдэг хоёр асуудал дээр цаашид малчидтай хамтарч ажиллахаар бид том зорилт дэвшүүлж байгаа.

Энэ хүрээнд газрыг бэлчээр газраас тариалангийн газарт шилжүүлэхэд тариалангийн тухай хуулиар Засгийн газар эцсийн шийдвэр гаргадаг. Сум, аймаг саналаа ирүүлээд саналыг Засгийн газар шийддэг.

Тэгэхээр цаашдаа тэжээл тариалах талбайг нэмэгдүүлэх бодлогыг баримтална. Мөн одоо байгаа талбайг эргэлтэд оруулах бодлого дээр онцгой анхаарна.

Өмнөх сайд болон Засгийн газраас 200 мянган га-д эргэлтийн талбайг нэмэгдүүлнэ гэж байгаа. Одоогоор 70 мянган га нэмэгдсэн.

Тэгэхээр тэжээл тариалахад туршлагатай, өмнө тариалан эрхэлж байсан иргэдэд 100 хүртэлх га-г үнэ төлбөргүй нэг удаа эзэмшүүлэх эрхтэй. Гэхдээ үүнийг цааш нь зарах, газраа борлуулах, эрхийг нь шилжүүлэх байдлыг хязгаарлаж тодорхой болзолтойгоор аль болох тариалан бүхий иргэд.

Таны хэлдгээр “Шинэ хоршоо”, дундын хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох бодлогыг томоохон аж ахуйн нэгжид олгохоос гадна давхар барьж явах нь зүйтэй гэдэг бодлого байгаа.

Энэ дээр тэжээл тариалах зүйл дээр тодорхой саналуудыг Засгийн газартаа манай яамнаас оруулна гэж төлөвлөж байгаа.

Улсын аварга малчны хувьд 100 хүртэл аварга малчныг жилдээ шалгаруулах Засгийн газрын журамтай. Гэхдээ бодит байдал дээр энэ нь нэмэгдээд байдаг юм билээ.

Тийм учраас би Улсын Их Хурлын гишүүдэд энэ ташрамд хэлэхэд Та бүхэн маань бүсээс сонгогдсон гишүүнийхээ хувьд яг энэ тоо, журамдаа нийцүүлж 100 малчин дотор багтааж шалгаруулахад улс төрийн дэмжлэг үзүүлж өгөөрэй гэж би Та бүхнээсээ хичээнгүйлэн хүсэж байна. Тэгэхгүй бол аварга массын тоо үндсэндээ маш их хэмжээгээр нэмэгдэж байгаа. Тэгэхээр бид энд нь бариулах нь зөв.

Таны хэлдэг ашиг шимийг харахаас гадна нэгдүгээрт малаасаа хэдэн төгрөгийн орлого олсон бэ, хэдэн төгрөгийн татвар төлсөн бэ гэдгийг гол үзүүлэлт болгоно. Өөрөөр хэлбэл “Монголын топ-100” аж ахуйн нэгжийг татвар төлөлтийн идэвхээр шалгаруулдаг.

Тэгэхээр цаашдаа эдийн засгийн үр ашиг чиглэл рүү нь... /минут дуусав/

Н.Учрал: Б.Пүрэвдорж гишүүн. М.Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Хариултуудыг авлаа. Жоохон тодруулаад асууя.

1999 онд батлагдсан тогтоол бүсчилж өмнө нь хэчнээн удаа өөрчлөгдсөн бэ? Өөрчлөлтийн тодорхой үр дүнгүүд нь ямар байсан. Энэ өөрчлөлт орсноороо орж ирж байгаа импортын хэмжээ ямар хэмжээнд өсөх вэ гээд жоохон нарийн тооцооллуудыг дэлгэрүүлээд хэлээч ээ гэж хэлэх байна.

Малчдын орлогыг нэмэгдүүлэх чиглэл дээр “Шинэ хоршоо” хөдөлгөөний гол зорилтууд явж байгаа. Зудын эрсдэлийг бууруулах чиглэл дээр ажлууд нэлээн үр дүнгээ өгөөд явах ёстой.

Тэгэхээр хөтөлбөрийг цаашдаа илүү сайжруулаад, малчдыг сургах тодорхой түвшинд хөгжүүлэх чиглэл дээр ажиллах нь зүйтэй байгаа гэдгийг би нэмж хэлье.

Н.Учрал: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Х.Жангабыл нарын гишүүдийн өргөн барьсан хуулийг дэмжиж байгаа.

Үүний үр дүнд ялангуяа баруун бүсэд улаан буудай ургадаггүй, үйлдвэр байхгүй бүс нутгийн иргэд хямдхан гурил хэрэглэх боломжийг нээж өгч байгаа.

Өнөөдрийн байдлаар Алтайн сайн чанартай нэгдүгээр зэргийн гурил 27 рублиэр тээврийнхээ хөлстэйгөө Баян-Өлгий аймаг хүртэл ирж байгаа. Дээрээс нь 26.5 хувийн гааль, НӨАТ-ыг нэмэхээр ойролцоогоор 80 мянган төгрөгөөр л Баян-Өлгий аймагт бууж байгаа юм л даа. Х.Жанганбыл гишүүн ээ. Тэгж байгаа. Тийм ээ.

Гэтэл өнөөдөр тэнд 115 мянган төгрөгөөр ард иргэдэд борлуулж байгаа. 115, 120 мянгаар. Ашиг нь 50 мянга. 40 хувиас илүү гараад явчхаж байгаа байхгүй юу даа. 50 хувиас илүү гараад явчхаж байгаа.

Энэ дээр ямар асуудал байна гэхээр яамнаас өгдөг **“импортын зөвшөөрөл”** гэдэг нь авлига юм биш биз дээ.

→ Үүнээс нь болоод гурилын үнэ өсөөд байгаа юм биш биз дээ.

- “Импортын зөвшөөрөл” гэдэг чинь болохгүй, бүтэхгүй гээд буцаадаг зүйл болсон.

→ Үүнээс нь болоод гурилын үнэ өсөөд байгаа юм биш биз дээ.

Эсвэл тэр бизнес эрхэлж байгаа хүмүүс ард иргэдээсээ 50 хувийн ашиг хийж өндөр үнэтэй гурил борлуулдаг хоёр зүйл байна.

- Импортын зөвшөөрлийг яаж өгч байгаа юм?
- Яам ямар учраас олгодоггүй юм?
- Яагаад чөлөөтэй болгодоггүй юм?

Энэ талаар тодорхой хариултыг авъя гэж бодож байна.

Хэрвээ гаалийн татварыг тэглэх дээр 15 хувийн татвар багасна. Ингэсэн тохиолдолд гурил Баян-Өлгий аймагт бүх зардлаа төлөөд 70 мянган төгрөгөөр ирэх боломжтой.

Тэгэхээр импортын зөвшөөрлийг нь асуудалгүй болгосон тохиолдолд ард иргэддээ бизнес эрхлэгч нар багахан шиг ашиг хийгээд борлуулаач ээ л гэдэг зүйлийг хэлмээр байна.

Яагаад гэвэл төр, засгаас татварыг багасгах ажлуудыг тодорхой хэмжээгээр хийж байна. Гишүүд санаачлаад хийж байна. Х.Жангабыл гишүүндээ баярлалаа. Ингээд хийж байгаа тохиолдолд дахиад хэтэрхий их өндөр ашиг хийж ард иргэдээ тодорхой хэмжээгээр санхүүгийн хохирол учруулдаг энэ зүйлээ багасгах нь зүйтэй шүү гэж хэлмээр байна.

Н.Учрал: М.Бадамсүрэн сайд хариулъя.

М.Бадамсүрэн: Өнөөдөр энэ тогтоолыг Улсын Их Хурал эцэслэн баталбал ирэх долоо хоногт “Засгийн газарт эрх өгөх тухай” тогтоолын төслийг бид өргөн мэдүүлээд тэгээд маш хурдан хугацаанд үүнийг батлуулаад Засгийн газарт эрх олгогдсоны дараа Б.Пүрэвдорж даргын хэлдгээр үнэ буурах нөхцөл бүрэн бүрдэнэ.

Өөрөөр хэлбэл 15 хувийн гурилын татвар 5 хувийн тэжээлийн импортын татвар байгаа.

Импортын мэдэгдлийн хувьд манай Ургамал хамгааллын газраас буюу яамны харьяа Засгийн газрын агентлагаас олгогддог. Импортын мэдэгдлийг ялангуяа орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд түлхүү олгох, саадгүй олгох бодлогыг баримталж ажиллана гэж төлөвлөж байна.

Тэгэхээр яаралтай маш хурдан хугацаанд импортын мэдэгдлийг саадгүй, ил тод, нээлттэй олгох бодлогыг баримтална. Үүнийг танд албан ёсоор хэлье. Баярлалаа.

Н.Учрал: Ж.Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Татварын зохицуулалт эцсийнх байгаасай гэж би найдаж байна. Өмнө нь 8 удаа хийсэн. Дандаа баруун бүс нутагт ган, зуд боллоо гэдэг.

Яагаад гэвэл тэнд тэжээлийн үйлдвэрлэл, гурил үйлдвэрлэл явагдахгүй байна. Татвар, тарифын хамгаалалтыг нь буулгаад хаяхаар тэнд хөрөнгө оруулж үйлдвэрлэл явуулах сонирхол төрөхгүй байна.

“Атрын-IV” аяны зорилгоор 200 мянган га талбайд тэжээлийн таримал нэмэгдүүлэх томоохон бодлого явж байгаа. Аймгуудад 3-аас 4 удаа бичиг очсон.

- Баруун бүс нутгийн аймгуудаас –
 - газраа тэлье,
 - тариагаа тарья,
 - ногоогоо тарья,
 - тэжээлээ тарья гэдэг санаачилга одоо хүртэл алга байна.

Бид чинь маш их хүч хөрөнгө зарж байж дотоодоосоо улаан буудайгаар 100 хувь хангаад, гурил үйлдвэрлээд 100 хувь хангаж чадсан. Гурил үйлдвэрлэл явна гэдэг маань тэжээлийн үйлдвэрлэл дагаж гарч байгаа. Улаан буудай үйлдвэрлэлийн 30 хувь тэжээл болж байдаг. /минут дуусав/

Н.Учрал: Ж.Энхбаяр гишүүн 1 минут.

Ж.Энхбаяр: Их Хурал хуулийн бодлогод өөрчлөлт оруулсан.

- Гурил үйлдвэрлэл унасан.
- Газар тариалан унасан.

Үр дагавар одоо энэ. Бид ашигт малтмалаа ухаж зараад валют олж авдаг ажил руугаа буцаж орж байна.

Тэгэхээр тогтвортой, хатуу, үндэсний дотоодын үйлдвэрлэл аж ахуйг нь дэмжсэн бодлогыг тууштай явуулах хэрэгтэй.

Баруун бүс нутагт дахиж малын тэжээл, гурилын асуудалд орохгүйн тулд дотоод тариалалт дээр онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна. Гишүүд ээ. Түүнээс гаалийн татвараар зохицуулалт хийгээд байвал энэ зовлон чинь дуусахгүй.

- Нэгэнт бэлчээрийн даац хүрэхээ больсон.
 - Мал сүрэг, сүргийн бүтэц эвдэрсэн.
-

Яаралтай малын ашиг шимт байдлыг дээшлүүлэх, бүс нутагт малын тэжээлийн таримлыг эрс нэмэгдүүлэхгүйгээр цаашдаа нүүдлийн мал аж ахуйг эрсдэлгүй өвөлжүүлэх, он давуулах асуудал хүнд болно.

Иймд баруун бүс нутагт тэжээлийн үйлдвэрлэл, газар тариаланг, усалгаатай газар тариаланг хөгжүүлэхэд бодлогын дэмжлэг... /минут дуусав/

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ухнаагийн Отгонбаярт төрсөн өдрийн мэнд дэвшүүлж, амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Байнгын хороодоос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд ээ, ирцээ бүрдүүлээрэй.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хамтарсан байнгын хорооны хуралдаанаас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2 дахь заалтыг үндэслэн хурааж дэмжсэн.

1.Төслийн 5 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

49 гишүүн дэмжиж, 55.1 хувиар санал дэмжигдлээ.

Гишүүдэд баярлалаа. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Батлах санал хураалт явуулна биз дээ.

Гишүүд танхимд цуглая. Санал хураалтад бэлтгэе.

Хураалаа шүү. Одоо хэн нь хэнийгээ гуйх вэ дээ. Тэгээд орж ирээд санал хураавал хураагаад, унавал унаад, тэгээд дэмжигдвэл дэмжигдээд явна биз. Тийм биз дээ.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

49 гишүүн дэмжиж, 54.4 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархаж байна. Баярлалаа.

Дараагийн асуудалд орно.

**Гурав.Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо,
түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг
соёрхон батлах тухай хуулийн төсөл**
/Засгийн газар 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн,
соёрхон батлах/

Дараагийн асуудалд орох гэж байна. Их Хурлын гишүүдийг танхимд урья.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна.

Индэрт урья.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Та бүгдийн өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улс 2024 онд нийт 162 оронтой гадаад худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүнээс экспорт 15.8 тэрбум ам.доллар, импорт 11.6 тэрбум ам.доллар болж худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна.

2024 оны байдлаар Оросын Холбооны Улстай хийсэн худалдаа 2.7 тэрбум ам.долларын алдагдалтай байна.

Сүүлийн 10 жилд Оросын Холбооны Улс руу экспортлох хэмжээ төдий л нэмэгдээгүй бөгөөд шатахууны эрэлт нэмэгдсэнтэй холбоотой импорт өсөж, худалдааны бүтэц бүхэлдээ тэнцвэргүй болсон байна.

Оросын Холбооны Улс нь Евразийн эдийн засгийн холбооны гишүүн тул холбооны бусад гишүүн орнуудтай адил нэгдсэн гаалийн тарифын бодлого хэрэгжүүлдэг.

Монгол Улсаас Евразийн эдийн засгийн холбоонд экспортлох барааны 15-аас 50 хувийн гаалийн тариф ноогдуулж, эрүүл ахуй, хорио цээрийн өндөр шаардлага тавьж байгаа нь экспортын боломжийг хязгаарлаж байна.

Мөн нийт экспортын 91.2 хувь, уул уурхайн бүтээгдэхүүний 94.7 хувь, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний 82.7 хувийг зөвхөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсад экспортолж байна.

Энэ нь нэг улсын зах зээлээс хэт хамааралтай болж, эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө учруулах хэмжээнд хүрээд байна.

Оросын Холбооны Улс нь Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орон тул тус холбооны дүрэмд заасны дагуу холбооны 5 гишүүн орон нэгдсэн татварын тогтолцоотой, бусад гадаад улс орнуудтай хийх худалдаанд нэгдсэн нэг бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд импортоор орж ирэх бүтээгдэхүүнд 15-аас 50 хувийн татвар ногдуулахаас гадна эрүүл ахуй, хорио цээр, техникийн өндөр шалгуур, шаардлагыг тавьдаг тул Монгол Улсаас экспорт хийх бололцоо хумигдмал байж ирсэн.

Иймээс гол түнш орнуудтай хийх худалдаанд тулгарч буй тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, харьцангуй давуу талтай бүтээгдэхүүнээ саадгүй экспортлох, дотоодын үйлдвэрлэлд шаардлагатай орц, түүхий эд, тоног төхөөрөмжийг хямд өртгөөр импортлох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Үүнийг хэрэгжүүлэх гол нөхцөл нь чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах явдал юм.

Тус хэлэлцээр нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэх бөгөөд хөрөнгө оруулалт, үйлчилгээний, худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлыг тусгаагүй. Зөвхөн 367 барааны хүрээнд харилцан тохиролцсон.

Мөн хэлэлцээр 3 жилийн хугацаатай бөгөөд талууд өөрөөр тохиролцоогүй бол хугацааг сунгасанд тооцно.

Хэлэлцээрийн хүрээнд хоёр талаас ижил тооны барааг тодорхойлох кодчлолын уялдуулсан систем буюу БТКУС¹-ын 6 оронтой кодоор 367 нэр төрлийн бараанд –

- ▶ Тарифыг шууд тэглэх;
- ▶ Тарифыг бууруулах;
- ▶ Тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх;
- ▶ Тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх –

зэрэг үндсэн 4 төрлөөр тарифын саад тотгорыг бууруулахаар тохиролцлоо.

Түүнчлэн улаан буудай, өндөг зэрэг манай улсын стратегийн болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний импортын нөлөөллийг бага байлгахад онцгойлон анхаарсан бөгөөд тоо, хэмжээний хязгаарлалт тогтоох, зарим барааг хасуулах замаар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохицуулалтыг хэлэлцээрийн төсөлд тусгуулсан.

Олон улсад чөлөөт худалдааны хэлэлцээр хийхэд түгээмэл ашигладаг ерөнхий тэнцвэрийн загварын тооцооллоор хэлэлцээр хэрэгжсэнээр манай улсын –

▷ дотоодын нийт бүтээгдэхүүн	- 0.02 хувь,
▷ хөрөнгө оруулалт	- 2.57 хувь,
▷ Евразийн эдийн засгийн холбоо руу хийх экспорт	- 24.1 хувь

өсөх боломжтой байна.

Тухайлбал, мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолуур, нэхмэл, сүлжмэл болон арьс, шир зэрэг боловсруулах үйлдвэрийн гол бүтээгдэхүүний экспорт 42-оос 152 хувиар нэмэгдэж Монголын бүтээгдэхүүн гаалийн татваргүйгээр өргөн зах зээлд нэвтрэх нөхцөл бүрдэнэ.

Мөн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр байгуулах асуудал нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилт 4.4-т, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал үзэл баримтлалын 3.2.5.1, 3.2.5.3, 3.2.5.4, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2-т тус тус тусгагдсан болно.

¹ Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Систем.

- ▶ “Цагаан алт”,
- ▶ “Хүнсний хувьсгал”,
- ▶ “Атрын IV”,
- ▶ “Шинэ хоршоо” хөдөлгөөн

зэрэг төрийн бодлогын хүрээнд хөдөө аж ахуйн салбарыг дэмжих ажил идэвхтэй өрнөж буй энэ үед тус хэлэлцээр нь дотоодын боловсруулах үйлдвэрлэл болон нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлж, малчин өрх болон үйлдвэрлэгч, экспортлогчдын орлогыг өсгөх, ажлын байрыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Мөн дээр дурдсан Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бүс нутгийн интеграцид нэгдэх, нэг эдийн засгаас хараат байдлыг бууруулах экспортын зах зээлийг тэлж төрөлжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих ач холбогдолтой юм.

Экспортын үйл ажиллагааг хөнгөвчлөх чиглэлээр ахиц гарч, зардал буурах боломж бүрдэх бөгөөд орц, материалыг экспортын барааны өртгийн 50 хувьд тооцон тарифын хөнгөлөлт эдлэх, барааг 4 цагийн дотор олгох, гарал үүслийн гэрчилгээ нөхөн гаргах бололцоотой болгох, эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан гаалийн шалгалтын шинэ зохицуулалт хэрэгжих, 5 мянган еврогоос бага үнийн дүнтэй бараанд гарал үүслийн гэрчилгээ шаардахгүй байх зэрэг өөрчлөлт нь бизнесийн орчныг сайжруулах юм.

Энэхүү хэлэлцээр нь олон улсын хэлэлцээрийн гэрээний тухай хуулийн дагуу заавал Улсын Их Хурлаар соёрхон батлах олон улсын гэрээ тул асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир танилцуулна. Индэрт урья.

Д.Бум-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасныг үндэслэн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хэлэлцээрийг хэрэгжүүлснээр уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн зах зээл, үнийн хэлбэлзэлд тэсвэртэй байдал бий болох, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэж, гадаад худалдааны зах зээлийг тэлэх, эдийн засгийн хараат байдлыг бууруулах, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, хувийн хэвшил жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, экспортын зах зээлийг тэлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг хэрэгжүүлэх талаар хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Д.Энхнасан тус хэлэлцээрээр тамхины гаалийн тарифыг тэглэснээр худалдааны тэгш бус байдал үүсэх эсэх, үүнийг онцгой албан татварын дагуу зохицуулах боломжтой эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Тус хэлэлцээрийг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа бөгөөд гадаад худалдааны тэнцлийн алдагдал дотоодын үйлдвэрлэлээ хамгаалсан хууль тогтоомжийн төслийг боловсруулж хамтад нь хэлэлцэх боломжийн талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл авто бензин, дизель түлшинд ноогдох гаалийн татварыг тэглэснээр улсын төсөвт үүсэх алдагдлыг тооцоолсон эсэх, уг алдагдлыг онцгой албан татвар татвараар нөхөх эсэх, үүнийг 2026 оны төсөвт хэрхэн тусгасан талаар, тус хэлэлцээрийн хэрэгжиж эхлэх хугацааны талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим өөрийн салбаруудаар дамжуулан хувийн хэвшлийн болон бусад холбоодын саналыг авсан эсэх, хэлэлцээр батлагдсанаар тэдгээрийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ямар ажлууд хийж байгаа талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн хэлэлцээр байгуулагдсанаар гуравдагч орнууд, ялангуяа Япон улс болон Бүгд Найрамдах Солонгос Улстай хийх худалдаанд өөрчлөлт гарах эсэх, ямар чиглэлээр хаанаас хөрөнгө оруулалт оруулалт татах талаар асуулт асууж хариулт авсан болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа тамхины онцгой албан татварын асуудал, тамхины хэрэглээнд хяналт тавих болон хэлэлцээрийн биелэлтэд 3 жил тутамд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үнэлгээний тайланг

Улсын Их Хуралд танилцуулах агуулга бүхий “Хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж, батлуулах тухай саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлт, саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Тэгээд дэлхийн 5 улсын парламент хэлэлцээрийг хэлэлцэж эхэлж байна. Ингээд батлагдсаны дараа түр хэлэлцээр албан ёсоор байгуулагдана. Ингээд цаашдын ажлууд хийгдэнэ.

Манай хөдөө аж ахуй, тэр дотроо малын гаралтай бүх түүхий эдийн гаалийн татвар 50-иас 10 хувиар буурч байгаа. Олон жил эдийн засгаа төрөлжүүлэе гэж ярьсан. Уул уурхайн бус экспортоо нэмэгдүүлэе гэж ярьсан.

Тийм учраас энэ асуудал дээр гишүүдийг анхааралтай оролцож, ач холбогдол өгөхийг хүсэж байна. Энэ чинь 5 улсын парламент дээр хэлэлцэж байгаа асуудал.

Тэгээд мэдээллүүдийг сайн авахын тулд Та бүхэнд би амласныхаа дагуу наад хэлэлцэх асуудал дээр дэлгэцэн дээр чинь документ байрласан байгаа. Сургаар ярьж болохгүй сэдэв. Дэлхий нийт харж байна. Дээрээс нь Евразийн эдийн засгийн холбооны түр хэлэлцээр 400 гаруй. Энэ чинь бараг 100-н хэдэн бүтээгдэхүүн билээ? Ж.Энхбаяр сайд. 367 бүтээгдэхүүн шүү дээ.

Тамхины хуулийн хэлэлцүүлэг биш шүү гэдгийг гишүүдэд хэлье. Одоо ингээд тамхи тойроод яриад дуусаж болохгүй шүү. Тэр тамхины асуудлыг чинь би энэ дээр Эдийн засгийн сайд байхдаа очиж зурсан. Л.Гантөмөр сайд хэлэлцээрийг эхлүүлсэн. Үр дүнд хүргэсэн. Нэлээн харилцан буултуудыг хийсэн юм билээ. Тэгээд би өөрөө гарын үсэг зурсан.

Тэгэхээр тамхины бүтээгдэхүүн дээр гаалийн татвар буурсан хэдий ч онцгойгоор нэмэгдүүлэе гэдэг саналаа тавиад харилцан тохирсон. Энэ бол

Монголын дотоодын асуудал. Тэгээд онцгой нэмэгдүүлээд явна. Үүнийг бүр захиагаар авсан. Танай дотоод асуудал учраас онцгойгоо нэмэгдүүлье гээд.

Дээрээс нь өндөг. Зарим бүтээгдэхүүн дээр Хүнс, хөдөө аж ахуйн яам өөрөө квотоо тогтооно. Түүнээс илүү гарвал зогсоно гэсэн үг. Тэгэхээр дотоодын зах зээлээ хамгаална.

Манай Б.Лхагважав Ерөнхийлөгч тэнд ирсэн байна. Б.Лхагважав Ерөнхийлөгч бид хоёр хамт хэлэлцээрт гарын үсэг зурсан. Хувийн хэвшил, бизнесийнхэн оролцсон байгаа. Цаашдаа танхимын манлайлж явах ёстой чухал хэлэлцээр юм.

Тийм учраас би гишүүдийг анхааралтай, идэвхтэй оролцохыг хүсэж байна.

Дээрээс нь төр улс байна. Телевизээр, олон нийтээр харж байна.

Тийм учраас 5 улсын парламентаар орж байгаа ийм сэдэв учраас бүгдээрээ ажил хэрэгч байдлаар хандаж өгөөсэй гэж хүсэж байна.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Баасангийн Лхамсүрэн Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын зөвлөх, Энхтайваны Нямбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын зөвлөх, Эрдэнэбаатарын Бүжинлхам Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын зөвлөх, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Даваажавын Бат-Өлзий Гадаад харилцааны яамны Гэрээ, эрх зүйн газрын дэд захирал, Одгэрэлийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын Олон улсын арбитрын хэлтсийн дарга, Сангийн яамны Татварын бодлогын газрын төслийн зөвлөх Чимэдийн Мөнхшүр, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Баатаржавын Лхагважав Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч, Эрдэнэчулууны Бадамхорол Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Гадаад худалдааны бичиг баримт, баталгаажуулалтын газрын дарга гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Ж.Алдаржавхлан гишүүнээр тасаллаа. Н.Номтойбаяр гишүүнийг нэмье. Б.Жаргалан гишүүн, Л.Мөнхбаясгалан гишүүн, Ж.Золжаргал гишүүн.

Өөр хэн байсан бэ? Ч.Номин гишүүн. Чинбатын Номин гишүүн.

Энэ хэлэлцүүлэг олон нийтэд зөв мэдээлэл өгөх ажил хэрэгч хэлэлцүүлэг байх болно.

Тийм учраас сайд нар. Ж.Энхбаяр сайд байна, М.Бадамсүрэн сайд суугаарай. Хүнс, хөдөө аж ахуйн сайд суу.

Ингээд салбарынхаа асуудал дээр нэг бодитой, дорвитойхон шиг хариулт өгөөд олон нийтэд нь мэдээллээр хангамаар байна. Сая манай Аюулгүй байдлын байнгын хороон дээр Евразийн аюулгүй байдлын хэлэлцүүлэг болсон. Тэнд эрдэмтэн, судлаачид маш үнэтэй санал, дүгнэлтүүд хэлж байна. Манай Аюулгүй байдлын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн гишүүн маш санаачилгатай ажиллаж олон нийтэд мэдээллийг их сайн өгсөн. Эрдэмтэн, судлаачид маш зөв дүгнэлтүүд өгсөн.

Тийм учраас өнөөдрийн хэлэлцүүлэг олон нийтэд зөв мэдээллээр хангахад чиглэгдэнэ гэдгийг хэлье. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Баярлалаа.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хооронд худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах асуудлыг бид хэлэлцэж байна.

Бид зарчмын хувьд Монгол Улс үүнийг дэмжээд явах ёстой. Бид энэ хэлэлцээрийн хүрээнд үүсэх харилцаан дээр боломжийг ашиглаж чадвал их том боломж байгаа. Харин бид хоорондоо ойлголцохгүй удаашраад, бэлтгэл ажлаа хангаж чадахгүй, үндэсний үйлдвэрлэлээ бодлогын болоод хууль, эрх зүйн талаас нь зохицуулалтын хувьд дэмжиж өгч чадахгүй бол бид энэ дээр мэдээж хохиролтой гарна.

Тийм учраас энэ дээр зайлшгүй төрөөс хариуцах ажлуудыг яг үүрэгжүүлж, эзэнжүүлж, цаг хугацаатай дэс дараатайгаар бид асуудлыг шийдэх ёстой юм. Энэ хүрээндээ ер нь цаашдаа гадаад худалдааны асуудал дээр ямар бодлого барих гэж байгаа талаар холбогдох сайдуудаас асууя гэж бодож байна.

Гадаад худалдааны хууль гэж ярих уу, эсвэл Худалдааны хууль гэж ярих уу? Уг нь олон жил Засгийн газрын түвшинд яригдаж байсан юм. Тэгээд яам яам дамжаад л яваад байсан.

- Нэг хэсэг Гадаад харилцааны яам гадаад худалдааны асуудлыг хариуцдаг байхад байлаа.
- Сүүлд Эдийн засаг, хөгжлийн яам руу явж байлаа.
- Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр байсан уу, яасан.

Тэгэхээр цаашдаа Засгийн газар худалдааны ерөнхий хуультай болох. Энэ нь өөрөө эргээд Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад зах зээл дээр гарах бодлогын дэмжлэг үзүүлэх зохицуулалтууд ордог.

Хоёрдугаарт, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудаа хэрхэн яаж Дэлхийн худалдааны байгууллагад элссэн гишүүн орны хувьд дүрэм журмын хүрээнд дэмжих үү гэдэг бодлогыг шийдсэн.

- ▷ **Нэгдүгээрт**, Монгол Улсад DUMPING² хийхээс урьдчилан сэргийлсэн ч гэдэг юм уу энэ чиглэлийн хууль, эрх зүйн орчныг боловсруулах чиглэл дээр ямар байр суурьтай байгаа вэ? Энэ хүрээнд хариулж өгөөч.
- ▷ **Хоёрдугаарт**, Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудад ажиллаж байгаа, Монгол Улсаас тус улсад сууж байгаа Элчин сайдууд Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа хэлэлцээрийн хугацаанд маш ойрхон ажилламаар байна. Бараг удирдлага дээр нь.

Өөрөөр хэлэх юм бол эдгээр Элчин сайдуудын ажлыг Монголын аж ахуйн нэгж, байгууллагуудын бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ тус улс орны зах зээл дээр хэрхэн яаж амжилттай гарснаар нь, амжилттай гарахад нь хэрхэн яаж дэмжлэг үзүүлснээр нь үнэлдэг болмоор байна.

Цаашдаа гадаад харилцааг эдийн засагжуулах хэрэгтэй. Ялангуяа ерөөсөө л улс орнуудын гадаад харилцаа эдийн засаг, эдийн засаг, эдийн засаг байгаа шүү дээ. Тэгээд Элчин сайдууд маань ч гэсэн яг чиглэл рүү анхаармаар байна.

Нэг аж ахуйн нэгж, байгууллагынхаа нэгж бүтээгдэхүүнийг ч гэсэн гаргахад ямар бодлогын болоод хуулийн хүрээнд тус тусдаа лобби хийж зөв ажиллав гэдгээр нь дүгнэмээр байна. Элчин сайдуудыг. Ингэж шалгуурыг тавимаар байна. Эдгээр улсууд дээр магадгүй.

² Бараа, бүтээгдэхүүнийг өртгөөс доогуур үнээр экспортлох.

Энэ дээр ямар бодол байгааг анхаараач ээ гэдэг зүйлийг хэлж байгаа юм.

Хоёрдугаарт, танхим ямар байр суурьтай байгаа вэ? Албан ёсоор байр сууриа хэлээч. /минут дуусав/

Н.Учрал: Б.Лхагважав Ерөнхийлөгч. Ж.Энхбаяр сайд хариулах уу? Ж.Энхбаяр сайд. Дараа нь Б.Лхагважав Ерөнхийлөгч хариулна.

Ж.Энхбаяр: Худалдааны хуулийг өргөн барих бэлтгэл ажил үндсэндээ хангагдаж байна.

Нийтдээ 9 бүлэг, 60 заалт бүхий худалдаанд зохицуулалтын хуулийг бэлдээд олон нийтэд хэлэлцүүлэг, санал авах ажлыг Их Хурлын хуралдааны завсарлагааны цагаар гүйцэтгэх болно.

Үнэхээр Евразийн эдийн засгийн холбоо гэдэг маань сэрүүн бүсийн 5 орон, 200 сая хүн амтай том зах зээл. Ялангуяа бидний тохиролцсон 367 төрлийн барааны 97 хувь нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн бараа байгаа. Манай экспортлох бараа буюу бидэнд өргөн зах зээл нээгдэнэ.

Эдгээр орнууд 10 тэрбум долларын импорт яг манай ижил төстэй бараан дээр хийдэг. Тэгэхээр бид тэр зах зээл рүү тэмүүлнэ гэсэн үг.

Нөгөө талаар бид энд удаан бэлдсэн. “Хүнсний хувьсгал”, “Атрын IV”, “Цагаан алт” хөтөлбөр үндсэндээ гадаад зах зээлд үндэсний аж үйлдвэрүүдээ бэлдсэн.

Бид сав, баглаа боодлынхоо чанарыг дээшлүүлсэн. Сав, баглаа боодлынхоо үйлдвэрүүдийг бүр кластер болгож бий болгосон. Үйлдвэрүүддээ хөрөнгө оруулалт хийсэн, шинэчилсэн, тоног төхөөрөмжөө сайжруулсан, олон улсын олон стандартуудыг үйлдвэрүүд маань нэвтрүүлсэн.

Засгийн газар, Их Хурлын баталсан олон бодлогын хүрээнд хөнгөлөлттэй зээл, эргэлтийн хөрөнгөөр дэмжсэн. Одоо том зах зээлд гарах цаг болсон. 3.5 сая хүнтэй зах зээл биш бидэнд 200 сая хүнтэй хүйтэн сэрүүн бүсийн зах зээлд гарах, шинэ өрсөлдөөнд бид орох цаг нь болсон гэж үзэж гэрээг хийж байгаа.

Мэдээж эрсдэлүүд үүснэ. Бидэнд үйл ажиллагаа сайжруулах олон сорилт тулгарах нь тодорхой. 3 жилийн түр гэрээний үр дүнд манай үндэсний үйлдвэрлэлүүд нэлээн чадавхжиж, шинэ зах зээлд өөрийн байр сууриа эзэлж гарч чадна гэдэгт итгэлтэй байгаа.

Тийм болохоор боломжийг бид маш сайн ашиглаж аж ахуйн нэгжүүдээ, үйлдвэрлэгчдээ дэмжих, эдийн засгаа тэлэх. Хамгийн гол нь эдийн засгаа тэлэх

гол боломж. Экспорт гарч байж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортод гарч байж л малчин, тариаланчдын орлого тогтвортой болж, мал аж ахуй, газар тариалан эрхлэх дур сонирхол, аж ахуй хөтлөх тэр боломж төгс утгаараа бүрдэх юм. Ийм зорилгын үүднээс гэрээг бид байгуулж байгаа.

Нөгөө талаар гадаад худалдааны тэнцэл хэтэрхий алдагдсан. 90 гаруй хувь зөвхөн нэг хөршөөс хамааралтай. Уул уурхайгаас хэт хамааралтай. Энэ бол үндэсний аюулгүй байдалд ноцтой сөрөг нөлөөлж байгаа гэдэг нь тодорхой.

Иймд олон тулгуурт эдийн засаг бий болгох бодлого, арга хэмжээний хүрээнд хөдөө аж ахуйн салбарт өнгөрсөн 3 жилийн хугацаанд хийсэн үр дүнг нь үзэх цаг болсон. Бодлогын хүрээнд гарч байгаа шинэ зах зээл, үйл ажиллагаа юм шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Н.Учрал: Ажлын хэсгээс хариулъя. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгч Б.Лхагважав.

Б.Лхагважав: Баярлалаа.

Их Хурлын гишүүд өдрийн амрыг айлтгая. П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Евразийн гэрээтэй холбоотойгоор хэлэлцүүлэг танхим дээр 7 удаа явагдсан. Ялангуяа өнгөрсөн жил 2024 оны 12 сарын 09-нөөс өмнө 4 хэлэлцүүлэг явагдаж, тухайн үедээ 700 гаруй бүтээгдэхүүн гэж орж ирж байсан. Тэгээд 12 сарын 09-нд танхимын удирдах зөвлөл дээр асуудал яригдаж тухайн үедээ эсэргүүцлийн асуудал тавигдаж байсан.

Тэгээд үүний дараа дараагийн 5 сар хүртэлх хугацаанд 3 хэлэлцүүлэг явагдаж, нийтдээ 400 гаруй аж ахуйн нэгж оролцож, тухайн үеийн бараа, бүтээгдэхүүнийг 367 нэгж дээр очих. Үүн дотроо Монгол Улсын өөрийн үйлдвэрлэж байгаа, ялангуяа хүнсний бүтээгдэхүүнүүд дээр квот тогтоох, тодорхой хязгаар тогтоох асуудлуудыг хоёр талаасаа тохиролцсон.

Тэгээд энэ бүх ажлыг тухайн үеийн Л.Гантөмөр Тэргүүн Шадар сайд буюу тэр үеийн Засгийн газрынхан нэлээн базаж хийсэн байсан. /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

Тийм. Н.Учрал сайд бид хоёр тухайн үед Минск хотод очиж зурж байсан.

Ер нь Ж.Энхбаяр сайд агуулгыг тодорхой тайлбарласан байгаа. Үүнтэй холбоотойгоор сая Монгол Улсын Ерөнхийлөгч хэд хэдэн айлчлал саяын бүс нутгуудаар явагдсан. Энэ дээр Танхимуудын гол очиж хийгдсэн ажил Евразийн

гэрээг хамгийн сайн ашиглаж байгаа Беларусь, Киргиз гэдэг улсуудаас танхим туршлага судлах тэр асуудлууд дараа дараагийн шатад хийгдэж яваа. Баярлалаа.

Н.Учрал: Тодруулъя. П.Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Б.Батцэцэг сайд байсан хариулах л байсан байх.

Элчин сайдуудын ажлын үр дүнг эдийн засгийн агуулга талаас нь анхаардаг байгаасай. Ерөнхийдөө танхимын төлөөлөл Монгол Улсаас тодорхой улсад сууж байгаа эдийн засгийн атташей гэдэг юм уу, худалдааны атташейн дээр танхим санал болгодог байгаасай гэж хүсдэг. Ингэж байж бизнесийн орон зайг олж ирнэ.

Хоёрдугаарт, би үүнийг маш олон жил ярьж байгаа юм. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд Женевт байгаа Дэлхийн худалдааны байгууллага хариуцаж байгаа хүнийг тусдаа төлөөлөгчийн газар гаргамаар байгаа юм. Жижиг орон гээд эндээс Элчин сайдын яамнаас давхар хавсраад ингэж ач холбогдол өгмөөргүй байгаа юм.

Бид хэд тодорхой тооны хүмүүс ажиллаад яг дээр Дэлхийн худалдааны байгууллага нь гишүүн орнуудын хооронд үүсэж байгаа маргаанаас суралцаж байх ёстой байхгүй юу. Норм стандартуудаас суралцаж байх ёстой.

Дээрээс нь Дэлхийн оюуны өмчийн байгууллага байна. Энд заавал төлөөлөгч томилох ёстой байсан. Бид хэд Ази, Номхон Далайн бүсийг тэргүүлэх боломж энэ жил байсан байх. “М” үсгийн дарааллаар ирсэн чинь төсөв мөнгө байхгүй гээд... /минут дуусав/

Н.Учрал: П.Сайнзориг гишүүн их чухал асуудлыг хөндөж байгаа. Тэгээд Засгийн газрын гишүүд анхаарна биз. Гол нь хэлэлцээр батлагдсаны дараа нөгөө хорио цээр, гаалийн хамтын ажиллагаа, танхим хоорондын нэмэлт хэлэлцээрүүдийг байгуулна. Тийм ээ.

Тэр талаар Б.Лхагважав Ерөнхийлөгч хэлээдхээч.

Нэмэлт хэлэлцээрүүдийг цаашдаа байгуулж ажиллана. Б.Лхагважав Ерөнхийлөгч.

Б.Лхагважав: П.Сайнзориг гишүүний саналд маш их талархаж байгаа. Урьд нь тиймэрхүү жишиг байсан. Социализмын үед гэж ярьж болно. Сүүлийн үед Элчингүүдийн хажууд сууж байгаа ялангуяа эдийн засгийн төлөөний хүнийг танхимын төлөөний хүн та хэд маань томилж өгөх юм бол, тэр механизм ажиллавал бид дуртай хүлээж авна.

Түрүүн таны нэг асуулт дээр Худалдааны хууль яригдаж байсан. Одоо Их Хурлын эрхэм гишүүд маань ойрын үед орж ирэх Арилжааны хууль байгаа. Арилжааны хууль дотор ерөнхий агуулгаараа бүгд суусан байгаа шүү. Тэрийг сайн дэмжиж өгөөрэй гэж бодож байна.

Тэгээд Их Хурлын даргын асуултад хариулахад, яг үүнтэй холбоотой дараагийн техникийн асуудлууд байгаа. Хил, гаалийн, хорио цээрийн. Энэ бүх асуудал дээр танхим хамтран ажиллаж байгаа. Ялангуяа Ж.Энхбаяр сайд сая долоо хоногийн өмнө очсон. Эрхүү хотод буюу Оросын Холбооны Улсын хойд талын муж нутгуудын танхимуудтай бид маш сайн харьцаатай байдаг. Энэ харьцааны дагуу ялангуяа танхимуудаар дамжиж хийгдэх ажил тэнд их хүлээгдэж байгаа.

Н.Учрал: Тийм. Олон нийтэд ингээд зөв мэдээллийг өгөөд явъя.

Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Манай хойд хөрш Оросын Холбооны Улстай манай гадаад худалдаа 2024 оны хувьд ямар байсан бэ гэвэл 2.9 тэрбум долларын харилцаа үүссэн байна.

Худалдааны тэнцэл хасах 97 хувь. Би энгийнээр хэлье. Оросын Холбооны Улс биднээс 100 сая долларын бараа худалдан авсан байна. Бид Оросын Холбооны Улсаас 2.8 тэрбум долларын худалдан авалт хийсэн байна буюу бид Оросоос л бараа худалдаж авч манай валют Орос руу явж байгаа. Гэтэл Орос маань эргүүлээд биднээс 100 сая долларын л бараа, бүтээгдэхүүн худалдаж авч байна.

Тэгэхээр энэ маш ашиггүй наймаа, маш ашиггүй харилцаа гэсэн үг. Тэгээд дөнгөж 2024 онд л ийм байгаа юм уу гэхээр үгүй. Ер нь үргэлжид ийм харилцаатай байсан.

Тэгээд бид өөрсдөө Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын бизнес эрхлэгчид өөрсдөө Оросын Холбооны Улсын үе үеийн удирдлагуудад ямар хүсэлт хэлдэг байсан бэ гэхээр биднээс юм худалдаж аваач ээ. Бид бараагаа гаргая гэхээр маш өндөр татвартай байна. Биднийг эдийн засгийн хоригт та нар оруулсан юм биш үү. Энэ татварын орчноо эргэж хараач ээ гэж бид Оросоос маш олон жилийн хугацаанд гуйсан.

Тэгээд 2020 онд Евразийн хэлэлцээрт, бүс нутгийн хэлэлцээрт оруулах боломж бүрдэх юм байна. Энд нэгдэх юм бол Монгол Улсад ашигтай нөхцөл байдал үүсэх юм байна гэдэг хэлэлцээрийг анх эхлүүлсэн.

2020 онд ажлын хэсэг байгуулагдаад Ч.Хүрэлбаатар сайд тухайн үедээ ахлаад ажиллаж байсан. Ингээд явсаар байгаад сая 2024, 2025 оны. 2025 он шүү дээ. 2025 оны 4 сард Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор энэ хэлэлцээр ороод байгуулах зөвшөөрлийг нь олгоод Н.Учрал дарга сайд байхдаа өөрөө 6 сард очиж яг 6 орны түвшинд гэрээг үзэглэсэн. Одоо соёрхон батлах эцсийн үе шат явж байгаа буюу бид ямар нэгэн байдлаар гэрээг өөрчилье, буцъя, цуцалъя гэдэг нь өөрөө маш ёс зүйгүй. Монгол Улс өөрөө хэлсэн үгэндээ хүрдэггүй гэсэн ийм асуудал үүснэ.

Ийм учраас яг одоо Улсын Их Хурлын гишүүд маш хариуцлагатай байж энэ хэлэлцээрийг соёрхон батлах хэрэгтэй.

Би дэмжиж байгаа гэдгээ хэллээ. Нөгөө талдаа яалт ч үгүй Н.Учрал дарга түрүүн тамхины хэлэлцүүлэг биш шүү гэж хэлсэн боловч тамхитай холбоотой бидний санаа зовнил байгаа нь илэрхий байна. Гаалийн татварыг, тамхины татварыг бид анзааралгүй өмнөх хэлэлцээрүүдийг явуулжээ, хоцоржээ. Үүнийг манай О.Номинчимэг гишүүн маш сайн хэлж байгаа. Тийм ээ. Би 1 минутаа авъя дарга.

Тэгэхээр үүн дээр яг энэ тамхитай холбоотой асуудлыг онцгой албан татвараар зохицуулна гэсэн зохицуулалтаа оруулж ирэхийг Улсын Их Хурлаас давхар даалгамаар байна. Ингэж байж магадгүй... /минут дуусав/

Н.Учрал: 1 минут нэмж өгье.

А.Ариунзаяа: Магадгүй санаа зовж байгаа гишүүд маань ямар ч байсан Засгийн газрыг бид тогтоолоор үүрэгжүүллээ. Яаралтай онцгой татварын асуудлыг оруулж ирнэ гэсэн ийм ойлголттойгоор ямар ч юу гэдэг юм сөрөг бодолгүйгээр Евразийн хэлэлцээрийг соёрхон батлах боломжтой байх гэж үзсэний үндсэн дээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр тогтоол дагаж гаргах зарчмын зөрүүтэй саналыг гаргасан. Үүнийг гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

Мөн түүнчлэн хугацаатай холбоотой 3 жилийн түр хэлэлцээр гэж байгаа боловч 3 жилийн дараа автоматаар сунгагдаад явах юм.

Тэгэхээр автоматаар сунгагдах учраас 3 жилийн дараа зайлшгүй үнэлгээг Улсын Их Хурлаар оруулж үргэлжлүүлэх үү, үгүй юу гэдэг асуудлыг тогтоолоор даалгахыг хүссэн байгаа. Ийм учраас тогтоолын ач холбогдлыг сайн ойлгож Улсын Их Хурлын гишүүд гэрээг соёрхон баталж, мөн түүнчлэн тогтоолыг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Н.Учрал: Евразийн эдийн засгийн холбоонд гишүүнээр элсэх гэж байгаа юм шиг ярьж болохгүй шүү. Гишүүдэд ойлголт өгье. Энэ бол түр хэлэлцээр. 5 улстай худалдаа л хийх гээд байгаа ойлголт шүү.

Тэгэхээр гишүүнээр элсэж байгаа гэсэн огт ойлголт байхгүй гэдгийг Та бүхэнд хэлье. Холбоонд нэгдэж байгаа биш, зөвхөн 5 улстай худалдаа л хийх гэж байгаа. Худалдааны л түр хэлэлцээр.

Тэгэхээр тухайн улс болгонтой, энэ 5 улстай хэрвээ худалдааны гэрээ хийгээд ажиллая гэвэл нэг улстай нь тухайлан хийх эрх зүйн боломж байхгүй. Заавал Евразийн эдийн засгийн холбоотой хэлэлцээр хийж байж. Жишээ нь, Оросын Холбооны Улстай худалдаа эрхэлнэ гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр өмнө нь манай малчид, манай хөдөө аж ахуйн салбарынхан мах Орос руу гаргахад квоттой байсан. Энэ хэлэлцээр байгуулагдсанаар квотгүй болж байгаа. Тэгээд бид сайн ажиллаж чадвал түүнийгээ дагаад боломж байна гэсэн үг. Тэгэхээр худалдаагаа эрчимжүүлэх чиглэл.

Тэгэхээр А.Ариунзаяа гишүүний түрүүний хэлсэн тогтоолыг бид ирэх долоо хоногт оруулж ирээд зарчмын зөрүүтэй саналыг дэмжээд, тогтоолоор Засгийн газарт үүрэг өгөөд явах нь цаашдаа ажил хийхэд маш амар хялбар болно. Яагаад гэхээр хүнс, хөдөө аж ахуйн квотоо тогтооно. Дээрээс нь онцгой татвараа нэмэгдүүлээд дотоодын зах зээлээ хамгаална.

Тэгэхээр А.Ариунзаяа гишүүний зарчмын зөрүүтэй саналыг гишүүд дэмжих нь зүйтэй юм байна гэж би өөрөө хувийн зүгээс өөрөө дэмжиж байна гэдгээ илэрхийлж байгаа.

Та санал хэлсэн. Тийм ээ? Тийм. Одонгийн О.Цогтгэрэл дарга.

Би өмнө нь Ж.Золжаргал гишүүний.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Оюуны ундраа” сургуулийн 12-ын “г” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Худалдааг хөнгөвчлөх, харилцан худалдааг чөлөөлөх гэдэг зарчмын хувьд зөв зүйтэй зүйл ээ. Евразийн хэлэлцээр дээр анхаарах хэдэн зүйл, тодруулах зүйл байна.

Яг одоогийн нөхцөл байдал дээр харахад Оросын Холбооны Улс, Монгол Улсын хооронд худалдааны экспорт, импортын харьцаа 25:1 байна уу харьцаатай. Манайхаас гарч байгаа зүйл гэвэл жонш моншхон болсон. 100 сая долларын зүйл байдаг.

Яг энэ хэлэлцээрийн дараа, 3 жилийн дараа тодорхой. Би Ж.Энхбаяр сайдыг бүр албан ёсоор микрофонд үлдээгээч ээ гэж хүсэж байна.

Энэ харьцаа болоод гадаад худалдааны дүн, тэгээд харьцааг яаж төсөөлж байгаа вэ?

Эдийн засаг юм чинь үр дүнгийн асуудал тоогоор, мөнгөн дүнгээр яригддаг байх ёстой байх.

- Хэлэлцээрийн хувьд цаг хугацааг ер нь оновчтой гэж бодож байгаа юу?
- Цаг хугацаа нь зөв үү, мөн үү?
- Манайхан бэлэн байгаа юу?
- Үнэхээр таны хэлээд байгаа тэр экспортод бэлэн байгаа гэдэгт итгэлтэй байгаа юу?

Таныг хүнс, хөдөө аж ахуйн сайдын ажил хийж байхдаа хэлэлцээрийг дэмжихгүй байгаа гэж тухайн үед би ойлгож байсан. Өнөөдөр өөр ажилд орохоор зөв болдог. Өмнө нь өөр салбар хариуцаж байхад буруу болдог. Тэгээд энэ дээрээ нэг тайлбар хэлээч.

Цаг хугацааны хувьд гэдэг нь өнөөдөр дотоодын нийт аж ахуйн нэгжүүдийн 70 хувь нь экспорт хийх чадавх нь байна уу? Бараг 70 хувь нь татварын өрөнд орсон, үйл ажиллагаа нь доголдсон. Одоо тэгээд он гарангуут гаднаас хямд бараа, бүтээгдэхүүн ороод ирэхэд тэр их сайхан өрсөлдөөн олон зүйл чинь, экспортоо хийгээд явах чинь амьдрал дээр ямар байна вэ? Энэ нэлээн тийм өндөр төлбөртэй хичээл болоод хувирах юм биш биз дээ. Сургалт болоод хувирах юм биш биз дээ гэж зүгээр санаа зовнил талаасаа асууж байгаа юм.

Түүнээс миний хувьд аль болох асуудлыг чөлөөлөх, либералчлах, өрсөлдөөн нэмэгдэх олон олон зүйлүүдийг урт хугацаандаа зөв зүйтэй зүйл л гэж боддог.

Харин богино хугацаанд, үр дүнгийн хувьд, цаг хугацааны хувьд наадах чинь хэр зэрэг оновчтой зүйл вэ гэдэг дээр л таныг тодорхой тодруулга өгөөч.

Тэгээд тэр 25:1 экспорт, импортын харьцаа дээр 3 жилийн дараа ер нь мөнгөн дүнгээрээ болоод энэ харьцаан дээр та нар ямар тооцоолол хийж байгаа вэ?

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Нэгдүгээрт, таны байр суурь.

Гэрээний хэлэлцээрийн явцад хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар зарчмын 23 төрлийн бараан дээр маргаан үүсгэсэн юм. Энэ яагаад гэвэл Их Хурлаар батлагдсан “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд бодлогоор дэмжиж байгаа салбаруудтай холбоотой гааль, тарифын асуудал туссан тул гэж.

Үүний үр дүн гарсан. Бид –

- 8 бараан дээр асуулга саналыг зөвшөөрүүлсэн.
- 11 бараан дээр нь буулт хийлгэсэн.
- 4 төрлийн барааг чадаагүй.

Тэр ямар 4 төрлийн бараа байна гэвэл “йогурт”, “амтат жигнэмэг”, “өрмөнцөр”, “эрдэст ус” гэсэн 4 төрлийн бараан дээр тарифын хамгаалалтаа бид авч чадаагүй.

Гэхдээ гол үндсэн бараан дээрээ бид хамгаалалтуудаа хийж, ялангуяа –

- Өндөгний асуудал их хурц байсан. Зохион байгуулж, зохицуулж чадсан.
- Улаан буудайн квотын асуудал байсан. Зохион байгуулж, зохицуулж чадсан.
- Архины асуудал байсан.
- Пивоны асуудал байсан

Гэх мэтчилэн дотоодын үйлдвэрлэл нэлээн бэхэжсэн салбаруудынхаа гол гол хамгаалалтаа авч чадсан.

Нөгөө талаас цаг хугацаа бэлэн үү? Яг одоо цаг хугацаа нь ирж байна гэж бодож байна. Өнгөрсөн 3 жилийн олон их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт, бодлогын дэмжлэг 3.5 сая хүнийхээ зах зээлд ханаж эхэлж байгаа.

Монголын аж ахуйн нэгжүүдэд шинэ зах зээл хэрэгтэй. Тэр зах зээлээ нээж байна. 200 сая хүний зах зээл нээгдэнэ. Уламжлалт 90 оноос өмнөх манай гол эдийн засаг, худалдааны 90 хувийн харилцаа явж байсан гол түнш орнууд буюу сэрүүн бүсийн 200 сая хүний зах зээл. 10 тэрбум долларын манай ижил төстэй барааны импорт хийж байгаа зах зээл.

Өнөөдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 1 тэрбум долларын экспорт хийдэг болсон.

- Ноолуур 500 сая гарах байх.
- Мах 300 сая даваад гарч байна.

Бусад төрөл нь ороод 1 тэрбум руу тэмүүлж байгаа.

Бид тэр 10 тэрбумын зах зээл дээр л өрсөлдөнө. Харьцангуй үндэсний үйлдвэрүүд шинэчлэл, технологийн өөрчлөлт, олон улсын чанар стандартыг нэвтрүүлэх, сав, баглаа боодлоо өөрчлөх гээд цогц асуудал үндсэндээ богино хугацаанд бид хийсэн. Одоо зах зээл рүүгээ тэмүүлнэ. Өрсөлдөөнд орно. Энэ зах зээл дээр бид өрсөлдөж гарч чадахгүй бол дараагийн бусад зах зээлд гарахад хэцүү.

Тэгэхээр зайлшгүй өрсөлдөөн буюу нэг талаасаа өргөн боломж гэж үзэж байгаа. Энд нийт гарч байгаа 367 төрлийн барааны 97 хувь нь манай хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн бидний хийх ёстой бараа гарч байгаа шүү.

Нөгөө талаас импортын 367 төрлийн барааны 62.7 хувь буюу 230 ширхэг бараа нь хүнд үйлдвэрийн бараа. Бидэнд хэрэгтэй машин механизм, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, эрчим хүчний олон нэр төрлийн бараа буюу бидний үйлдвэрлэдэггүй бараагаа хямдруулах бодлого.

Хөнгөн үйлдвэрийн химийн бүтээгдэхүүн 43 ширхэг бараа байгаа. Газар тариаланд өргөн хэрэглэж байгаа бордоо, тэсрэх бодис, малын вакцинууд, эрүүл ахуй, эмнэлгийн салбарт хэрэглэж байгаа шингэн витаминууд, тэгээд Монгол Улсад үйлдвэрлэдэггүй өртөг нөлөөлж байгаа бараануудыг нэлээн оруулж өгсөн.

- Нөгөө талдаа бид боломжоо олж авна.
- Нөгөө талдаа бид үнийг бууруулна.

Хүнсний төрлийн 94 ширхэг бараа байгаа. Ийм л өрсөлдөөн болно. 94 төрлийн бараа нь Монголд тарьдаг, ургуулдаггүй, бий болдоггүй элсэн чихэр мэтийн бараанд бид зах зээлээ тавьж өгнө.

- Ингэснээр барааны сонголт нэмэгдэнэ.
- Үнийн өсөлт багасна.
- Инфляц буурна.

Н.Учрал: О.Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл:

- ▷ **Нэгдүгээрт**, Тэр 25:1 харьцаа буюу 2.5 тэрбум долларын гадаад худалдаа маань хэд болж өсөх юм бэ? Үүнээс 25:1 харьцаа маань яаж өөрчлөгдөх юм бэ гэдэг дээр Та 3 жилийн дараах тодорхой таамаглал, тодорхой тоог хэлж өгөөч.
- ▷ **Хоёрдугаарт**, энэ 5 улс дотроос яг манайтай Оросын Холбооны Улс, Казахстан, Беларус, Киргиз, Армен гэхээр ойролцоо нь бараг Киргиз, Армен хоёр байх шиг байна.

Ер нь Киргиз, Армен Улсууд хэлэлцээрт нэгдсэнээрээ ямар үр дүнтэй, бодит үнэлгээ, гүйцэтгэл нь ямар байдаг юм? Анх орохдоо ямар байсан, одоо энэ нөхцөл байдал дээр энэ улсын бизнес эрхлэгчид, энэ улсын экспорт яг ямар үр дүнтэй байдаг гэсэн үнэлгээ, дүгнэлт гарсан байдаг юм бол?

Н.Учрал: Тэр бүтээгдэхүүн болгон дээр нь өсөлтийн тоо, хэмжээг тавьсан байгаа шүү дээ. Тэр слайд яриадах л даа. Ажлын хэсгээс. И.Батхүү дарга.

Тэр GTAP шинжилгээ гээд эдийн засгийн өсөлтийг нь бүгдийг нь хэмжээ биз дээ. Бүтээгдэхүүн болгон дээр тэр тоонуудыг хэл л дээ.

4 дүгээр микрофон.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулья.

GTAP (Global Trade Analysis Project) гээд худалдааны хэлэлцээр байгуулах үед бүх олон улсын хэлэлцээ хийж байгаа багууд, эрдэмтэн, судлаач ашигладаг загвар (GTAP computable general equilibrium (CGE) model) байгаа.

Үүний хамгийн сүүлийн үеийн датагаар дэлхийн 160 гаруй улс орнуудын хоорондын экспорт, импортын нэг төлвөөс нөгөө төлөвт шилжиж байгаа дээр манай худалдааны нөлөөллийг тооцсон.

- ➔ Экспортын хэмжээ нийт дүнгээр - 24 хувиар өснө.
- ➔ Дотоодын нийт бүтээгдэхүүн - 0.02 хувиар нэмэгдэнэ.
- ➔ Хөрөнгө оруулалт - 2.37 хувиар нэмэгдэнэ.

Энэ тооцоолол маань өөрөө ерөнхий загвар дээр тооцдог нийт тэнцлийг нь харуулж байгаа. Салбар бүрээр одоо жишээ нь манайхаас экспорт хийх потенциалтай салбаруудын тоог нь хэлэх юм бол жишээ нь –

- үхрийн махны экспорт - 125 хувиар нэмэгдэнэ,
- хонь, ямааны махны экспорт - 120 хувиар нэмэгдэнэ.

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

И.Батхүү: Арьсан гар цүнх, үүргэвчний экспорт жишээ нь 152 хувиар нэмэгдэнэ гээд ийм төсөөллүүд өөрчлөлтүүдийнх нь таамаглалууд гарч ирдэг.

Энэ бол цэвэр загвар дээр хийгдэж байгаа тооцоолол.

Цаанаа хөрөнгө оруулалт нэмэгдээд, хөрөнгө оруулалтыг дагасан шинэ технологи, “know-how” орж ирнэ. Олон улсын зах зээлд тэнцсэн, стандартад нийцсэн ажлууд хийгдэнэ.

Дотоодын одоо хийгдээгүй байгаа мал аж ахуйг эрүүлжүүлэх, вакцинжуулах, ургамал, хорио цээрийн асуудлыг шийдвэрлэх, гаалийн хүндрэлийг шийдвэрлэх, дээр нь нэмээд жижиг, дунд бизнесийг дэмжих 6 мянган еврогоос доош худалдаа хийж байгаа тохиолдолд татваргүй шууд гаргах.

Дээр нь нэмээд гарал үүслийн гэрчилгээ нэг жилийн дотор нөхөж олгох, хилээр гарсан тохиолдолд 4 цагийн дотор асуудлыг шийдвэрлэх гээд маш олон арга хэмжээ зэрэг явагдаж байгаа учраас загварт тусгагдаагүй үр дүнгүүд гарч ирнэ.

Дээр нь хувийн хэвшил маань өөрсдөө борлуулалт, маркетинг худалдан авагч талтай хийж арилжааны нөхцөлөө өөрсдөө хамгийн сайн хийдэг. Энэ тал дээр анхаарч ажиллах юм бол... /минут дуусав/

Н.Учрал: Тийм. Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Бид Евразийн холбооны гишүүн 5 оронтой доорх байдлаар бид 2024 оны байдлаар гадаад худалдаанд, харилцаанд орсон.

- Армен Улсаас бид - 12 төрлийн бараа импортолж байна.
- Беларус Улсаас - 92 төрлийн бараа импортолж байна.
- Казакстан Улсаас - 99 төрлийн бараа импортолж байна.
- Киргиз Улсаас - 27 төрлийн бараа импортолж байна.
- Оросын Холбооны Улсаас - 306 төрлийн бараа импортолж байгаа.

Ийм эдийн засгийн харилцаанд орж байна.

Хүрэх үр дүн манай дотоодын үйлдвэрүүд, ялангуяа хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр дээр манай гарч байгаа барааны 97 хувь нь чиглэж байгаа буюу бодлогыг үргэлжлүүлэх.

Манай экспорт 42-оос 152 хувиар энэ салбарын экспорт нэмэгдэнэ гэсэн үг. Экспорт 24.1 хувь нэмэгдэнэ гэсэн үг. Үүнийгээ дагаад хөрөнгө оруулалт 2.57 хувиар нэмэгдэнэ гэсэн үг. Ийм л тоонууд байна.

Н.Учрал: Ж.Энхбаяр сайд нэмэлт 1 минут.

Ж.Энхбаяр: О.Цогтгэрэл гишүүн ээ, бид үндэснийхээ үйлдвэрлэлдээ зах зээлийг нь л нээж өгч байна. Бид өрсөлдөнө.

Манай уламжлалт бараа 10.0 тэрбум долларын импорт энэ бүс нутаг хийж байна.

Тэгэхээр бид тэр 10.0 тэрбумын зах зээлд л нэвтрэх бодлого шүү дээ. Тийм. Үүнийг аль болох алдагдалгүй болгохын төлөө л Монгол Улс зорьж байгаа. Гол хөгжлийн бодлого маань энэ шүү дээ. Аюулгүй байдлын бодлого маань энэ шүү дээ.

Та бизнес хийдэг хүн. Тийм үү? Үйлдвэрлэл явуулдаг хүн. Таны бараа тэр зах зээлд өрсөлдөх чадавхтай бол хязгааргүй үйлдвэрлэлээ нэмэх орон зай л бид нарт байна. Өрсөлдөж чадахгүй бол бид өөрсдийгөө сайжруулах ажил эхэлнэ шүү дээ. Тийм байна.

Монгол Улсын бодлого үүнийг л тэнцвэртэй болгох л бодлого шүү дээ. Бид тэнцвэрийн төлөө л явж байна.

Н.Учрал: Худалдааны тэнцэлд ямар эерэг нөлөө үзүүлэх вэ? Ажлын хэсгээс нэмж хариул.

Саяын тэр ГТАР шинжилгээ гээд хийсэн байхгүй юу. Бүтээгдэхүүн болгон дээр. Ер нь Эдийн засаг, хөгжлийн яам маш сайн тооцоолол хийсэн. Эд нар их сайн ажилласан байхгүй юу. Наадхаа нэг тайлбарлаадах даа.

Б.Лхагважав Ерөнхийлөгч.

Б.Лхагважав: Би гишүүний асуултад хариулъя. Б.Лхагважавын танхимийн Ерөнхийлөгч.

Манай 25:1 харьцаа байгаа. Үүний 25-ын гол агуулга нь шатах тослох материал, дизель бензиний асуудал байгаа.

Манайх 2027 оноос өөрийн гэсэн дизель бензинээ үйлдвэрлээд эхэлнэ. Тэр үед би дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 40 хувийг хангах юм. Саяын 25-ын бараг 30-аад хувь нь тэндээс авахгүй гэсэн үг.

Бид шатах тослох материалын буюу Оросын Холбооны Улстай хийгдэж байгаа гол асуудал 25 хувь чинь шатах тоссон материал байгаа. Дээр нь цахилгааны асуудал байгаа.

Сүүлийн үед хийгдэж байгаа цахилгааны эх үүсвэрийг өргөжүүлснээрээ Оросын Холбооны Улсаас авах жилдээ 300-аад сая долларын цахилгааны асуудлыг бараг 50 сая руу оруулна гэж төлөвлөгөө гарсан байгаа шүү дээ.

Энэ харьцаагаар наад 25:1 чинь тэр л харьцаа байгаа байхгүй юу. Гол авдаг юмаа багасгах юм бол манай бусад харьцаа чинь өсөөд явах юм. Тийм.

Н.Учрал: 4 дүгээр микрофон. Тийм. Японы хэлэлцээр чинь 60:40 байхгүй юу.

Б.Лхагважав: Одоо тэгээд тэр чинь 96:4 гэсэн харьцаа байгаа шүү дээ. Тэгэхдээ тухайн үедээ манайх 40.0 сая ам.доллар болсон байгаа. Тийм.

Уучлаарай. Энэ асуудлыг Л.Гантөмөр сайдаас тодорхой асуугаарай. Тэнд загварыг нь гаргасан байсан.

Н.Учрал: Ажлын хэсгээс хариулъя. Нэмж хариулах уу? Тийм. Наадах чинь худалдааны алдагдалд ямар нөлөө үзүүлэх вэ гэж асууж байна. Энэ чинь хоёр өөр өөр асуудал ярьж байна шүү дээ.

Тэр гарал үүслийн дүрэм бол тусдаа. Тэр 60:40. Худалдаанд ямар алдагдал, ямар өөрчлөлт өгөх вэ гээд. Экспорт жил бүр хэдэн хувиар өсөх вэ гээд байгаа шүү дээ. Тийм биз дээ.

Саяын тэр шинжилгээнүүдээ хэл л дээ. Энэ чинь 24 билүү? Жил болгон экспорт 24 хувиар нэмэгдэнэ гээд тооцсон биз дээ. И.Батхүү ярь л даа.

4 дүгээр микрофон.

И.Батхүү: О.Цогтгэрэл гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Түүрүүн дурдсан ГТАР яриад гаргадаг нөгөө загварынх нь үзүүлэлтүүд нь өөрсдөө тийм байгаа.

Манай экспорт 24.2 хувиар жилд өснө гэж тооцох юм бол 2024 оны суурь түнштэй харьцуулахад 215.0 сая ам.доллароор худалдааны алдагдлын зөрүү багасна гэж байна.

Сая Б.Лхагважав Ерөнхийлөгчийн хэлээд байгаа санаа нь худалдааны харьцаа нь экспорт, импорт хоёр зэрэгцүүлж харьцуулж байгаа. 2.8 тэрбум долларын импортын 2.2 нь бензин, дизель гээд шатах тослох материал байгаа. Энэ нь өөрөө эдийн засгийн өсөлтийг дагаад өсдөг тийм үзүүлэлт байгаа. Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын өсөлтийг дагаад хэрэглэгддэг материал юм.

Тэгэхээр энэ асуудлаа газрын тосны бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болоод, энэ үйлдвэр маань ашиглалтад ороод, дотоодоосоо 50 хувийн дизель түлш ашиглах юм бол энэ харьцаа дахиад сайжирна.

Н.Учрал: Евразийн тэр 5 гишүүн улстай чинь хэдэн 3 тэрбум долларын ч юм уу барааны эргэлттэй. Тийм ээ. Түүний чинь хэд нь орсон юм гээд хүмүүст ойлгомжтой яриадах л даа. Тэгээд жилд 24 хувь гэх юм бол наадах чинь сая хэд гэсэн. 215 юм уу. Тийм ээ. 15 сая доллар нэмэгдэнэ л гэж хэлмээр байна шүү дээ. Тоогоор. Тийм.

Буруу ойлголт өгч болохгүй шүү. Наадах чинь бүтээгдэхүүн болгон дээрээ.

Дээрээс нь айлын тал чинь тариф чөлөөлөгдөөд орж ирэхээр наад малын тэжээл, бордоо, дизель түлш чинь бас хямдарна биз дээ. Энэ хэлэлцээр байгуулагдах юм бол наад дизель түлш чинь 10 хувь хямдарна гэж ойлгож байгаа шүү дээ. Тийм л тохироо хийсэн биз дээ. Тийм. 5 хувь.

Тэгээд наад малын тэжээл ч байна уу, бордоо ч байна уу, орц болоод байгаа бүтээгдэхүүнүүд чинь хямдарна шүү дээ. Тийм биз дээ. Энэ талаараа ашигтай.

Тоотой, тооцоотой тод тодорхой яриарай. Энэ удаан хугацаанд ажилласан ажил юм билээ. Ч.Хүрэлбаатар сайдын үед, Л.Гантөмөр сайдын үед.

Л.Гантөмөр сайд маш олон бүтээгдэхүүнүүдийг бүлгээр эхэлж оруулсны дараа хасуулсан юм билээ. Тэгээд онцгойг нэмэгдүүлье гээд. Дараа нь би гэрээнд гарын үсэг зурахдаа үүнийг албажуулсан байхгүй юу.

Ж.Энхбаяр сайд Хөдөө аж ахуйн сайд байсан хүн учраас хэрэгжилт дээр би илүү амьтай хэрэгжих болов уу гэж бодоод байгаа юм. Яг энэ салбарынх нь сайд байсан хүн учраас. Тийм. Тэгж л яриад байна шүү дээ.

О.Цогтгэрэл гишүүн яг л бодитой юм. Одоо ингээд тоогоор ярина шүү. Яг саяынх шигээ. Тийм.

4 дүгээр микрофон дээр И.Батхүү дарга нэмэлт 1 минут. Тодорхой хэл.

И.Батхүү: Их Хурлын даргын асуусантай холбоотой Евразийн эдийн засгийн холбооны 5 гишүүн улс орон хамтарсан байдлаар хэлэлцээ хийх эрх зүйн зохицуулалттай учраас л зэрэг яриад байгаа юм.

- ▶ Худалдааны гол түнш нь Оросын Холбооны Улс байна.
- ▶ Худалдааны эргэлтийн 97.2 хувь нь байна.
- ▶ Манай экспортын хэмжээ жил тутам 24.2 хувиар нэмэгдэх боломжтой.

Энэ боломжийг нь хангахын тулд дотооддоо 11 чиглэлээр 95 зүйл, заалттай Засгийн газар, дотоодын яам, агентлагууд, холбогдох мэргэжлийн байгууллагуудын шийдвэрлэх ёстой асуудлыг заасан бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаад ажиллаж байгаа.

Мөн айлын талтай хамтарсан төлөвлөгөө гаргахаар тохиролцоод хоёр долоо хоног тутам цахимаар хуралдаад ажиллаж байна.

Сая дурдсан импортоор оруулах боломжтой бараа, бүтээгдэхүүний гаалийн импортын татварын зөрүүгөөр дотоодын инфляцад эергээр нөлөөлнө. Үйлдвэрлэл явуулж байгаа аж ахуй... /минут дуусав/

Н.Учрал: Сая төсвийн хүрээг боловсруулахад “Евразийн хэлэлцээр байгуулагдвал” гэж, төсвийн төсөөлөл дээр тодорхой нэгж хувиар эдийн засгийн өсөлт нөлөөлнө гэж тооцсон шүү. Хүнс, хөдөө аж ахуйн яаманд тодорхой үүргүүдтэй. Энд хүрэхгүй бол тэр тооцсон эдийн засгийн өсөлт байхгүй шүү.

Тийм учраас л Хүнс, хөдөө аж ахуйн яам өөрсдөө асуудалдаа анхаарах ёстой гээд байгаа байхгүй юу. Хэрэгжилтээсээ гол асуудал нь шалтгаална.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагийн урилгаар Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсье. /алга ташив/

Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат.

Ц.Идэрбат: Гишүүдийн өдрийн мэндийг хүргэе.

Нэлээн сайн судалж оруулж ирж байгаа гэж харж байгаа. Урьд өмнө нь байгуулагдсан олон гэрээнүүдийн алдаа оноо одоо яг шүүгдэж байгаа шүү дээ.

Тэгэхээр ер нь алдааг давтахгүй байх л ийм нарийн судалгаанууд хийсэн юм болов уу гэж харж байгаа. Тэр утгаараа дэмжиж байгаа. Дараагийн нэг

шалтгаан бол ялангуяа мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарт малчид ер нь ноолуур, махнаас бусдыг нь хаяж байгаа шүү дээ. Энэ маань эдийн засгийн эргэлтэд орох нь гэдэг ийм том хүлээлт манай хөдөө аж ахуйн салбар, малчдад гарч ирж байна гэж харж байгаа.

Жилдээ бид 20-иод сая арьсныхаа 7, 8 саяыг нь боловсруулаад үлдсэн бараг 12 саяыг нь хаяад 10 жил болж байгаа улс шүү дээ.

Энэ дээр би ахиц гарах юм байна гэж харж байгаа. Энэ дээр ялангуяа Та бүхэн бас нэг тайлбар хэлээрэй гэж нэгдүгээрт хүсье.

Хоёрдугаарт нь, хоёр асуулт байгаа юм. Яах вэ, Евразийн хэлэлцээрт орсноороо бидэнд давуу талууд гарч ирэх юм байна. Ялангуяа инфляц буурах тал руугаа нэлээн байх юм байна.

Үүнийг би юу гэж харж байна вэ гэхээр ер нь Та бүхэн яаж тооцсон. Ер нь жилийн инфляцыг тооцохдоо хэрэглээний сагсны 400-аад бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс инфляцыг гаргаж ирдэг. Инфляц хэрвээ өндөр байх юм бол тэгээд л Монголбанкны бодлогын хүү өндөр болоод л, тэрийгээ дагаад арилжааны банкны хүү өндөр болоод л ингээд маш их сөрөг үр дагаврууд гардаг.

Монгол Улс инфляцаа тодорхойлдог 400 гаруй бараа, бүтээгдэхүүн байдаг шиг би санаж байна.

- Түүнтэй хэр давхцаж байгаа вэ?
- Инфляцад ямар нөлөө үзүүлнэ гэж тооцож байгаа вэ?

Инфляцаа бид барьж чадах юм бол өнөөдөр 10 хувийн цалингийн нэмэгдэл байдаг юм уу, энэ бүхэн маань яг иргэндээ нэмэгдэл гэдэг жинхэнэ утгаараа үлдэх юм. Тэгэхгүй инфляци тавиад алдаад л байх юм бол бид татвар төлөгчдөөс мөнгө оруулж ирээд нэмээд л байдаг, нэмээд л байдаг. Инфляцтай идэгдээд ийм л байгаа юм.

Тэгэхээр би инфляцын эсрэг их том арга хэмжээ авах гээд байна уу даа гэж харж байгаа. Үүнийг яагаад хэлж байна гэхээр амьдрал дээр ярихад Сэлэнгийнхэн хойшоо гараад хямдхан бараа, бүтээгдэхүүн аваад ороод ирдэг гээд ярьдаг шүү дээ. Манай Хэнтийнхэн ч Оросоос юм зөөдөг. Хилийн хойно 4500 байгаа наранцэцгийн тос өнөөдөр Улаанбаатарт 13, 14 мянгаар зарагдаж байна гээд. Ялангуяа үнэ дээр нэлээн өөрчлөлт гарах юм уу гэж харж байгаа.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн ямар тооцоолол хийсэн?

Хоёрдугаарт, тамхины асуудал дээр Та бүхэн нэлээн анхаараарай. Тамхи нийгмийн нэлээдгүй анхаарсан сэдэв болж байгаа. Тамхины хууль өнөөдрийн

Евразийн хэлэлцээр хоёр агуулгын хувьд мөргөлдөж байгаа. Нэг нь татварыг нь нэмнэ. Одоо байхгүй болгох ийм юм руугаа орж байгаа.

Тэгэхээр Та бүхэн онцгой албан татварынхаа асуудал дээр Их Хурлын тогтоол хэрвээ дагалдаад гараад ирвэл хэзээ оруулж ирнэ гэж төлөвлөж байгаа вэ?

Н.Учрал: Жадамбын Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Инфляцыг ашиглаж байгаа өрхийн хэрэглээний бүтээгдэхүүн сагсанд нийт 430 орчимд бүтээгдэхүүн байгаа. Үүнээс 239 нь импортын бүтээгдэхүүн байгаа. Импортын хамаарал өндөр гэсэн үг шүү дээ. Инфляцад нөлөөлнө. Импортын нөлөөлөл.

Евразийн холбоотой хийж байгаа хэлэлцээрийн хүрээнд инфляц тооцоход ордог 42 бүтээгдэхүүн байгаа. Үүний тариф “тэг” болно гэсэн үг. Гаалийн татвар.

Тэгэхээр энэ нөлөөгөөр инфляцын дарамт нэг хувиар буурах орон зай үүснэ гэсэн үг. Ингээд хэлэлцээрт хамрагдаж байгаа инфляцад тооцогдох 42 бүтээгдэхүүний тарифаас нэг өрхийн зардалд тооцоход 193 мянган төгрөгөөр бууруулах өрхийн хэрэглээнд нөлөөлөл гарна. Ингээд энэ чинь Статистикийн хорооноос манай 2024 оны жилийн эцсээр 997 мянган өрх байна. Өрхийн зардлаа 193 мянгаар үржүүлэхэд бид 192.0 тэрбум төгрөгийн өрхийн зардал энэ худалдааны нөлөөгөөр буурна гэдэг тооцоо гарч байгаа юм.

Нөгөө талаар тамхины хууль гаалийн татвар буюу тарифын чөлөөлөлт Евразийн орнуудын бараа, тамхи хамрагдаж байгаа боловч онцгой албан татварын зохицуулалт Монгол Улсын дотоодын бүрэн эрх байгаа.

Тэгэхээр бид Онцгой албан татварынхаа хуулиар зохицуулалт хийгээд худалдааны тэгш байдлыг хангаад явах бүрэн бололцоотой.

Энэ Евразийн гэрээ үндсэндээ олон жилийн хэлэлцээр, олон жилийн үр дүн. Ч.Хүрэлбаатар сайд, Л.Гантөмөр сайд, Н.Учрал сайд ингээд 4 Тэргүүн Шадар сайд дамжиж хийгдэж байгаа ажил. Тамхины асуудал сая гарч ирсэн асуудал. Гэхдээ дотооддоо зохицуулах бололцоо бүрэн байгаа гэдгийг яг асуудал хариуцаж байгаа сайд. Гишүүд маань ойлгоорой. Тэгээд тамхины хууль зэрэгцээд хэлэлцэж байгаа. Тэр тамхины хууль дотроо бид Онцгой албан татварынхаа зохицуулалтыг хийгээд батлаад явах бүрэн бололцоотой.

Н.Учрал: Баярлалаа. Арьс, ширтэй холбоотой асуудал дээр хариулт хийх үү? Хүнс, хөдөө аж ахуйн яам.

3 дугаар микрофон.

Ц.Болорчулуун: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Ц.Идэрбат гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Тэгэхээр Монгол Улс жилдээ 15-аас 20 сая толгой малыг дотоодын болон экспортод эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа. Тэгээд мэдээж боловсруулалтын түвшин бид арьсаа бүрэн боловсруулж чадахгүй байгаа. Евразийн хэлэлцээр батлагдаад явснаар экспортлох арьс, шир болон арьс, ширээр хийсэн бүтээгдэхүүнийг экспортлох том боломжууд гарч байгаа. Нөгөө талдаа бид гол нь стандартын шаардлагыг хангасан түүхий эдийг нийлүүлэх л гол зорилго байгаад байгаа.

Тэгэхээр бид арьс, ширээ малын эрүүл мэндээсээ, үүлдэр угсаанаасаа өгсүүлээд түүхий эдийн стандартын шаардлага хангах том боломжуудыг яриа хэлэлцээрүүдийг үүсгэж энэ шаардлагад нь нийцсэн бүтээгдэхүүн нийлэх тал дээр л онцгой анхаарч ажиллана гэдгийг хэлье.

Дээрээс нь арьс, ширгээс... /минут дуусав/

Н.Учрал: Баярлалаа. Цэвэгдоржийн Туваан гишүүн. Ц.Идэрбат гишүүн тодруулах юм байна. Ц.Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Хэлэлцээр маань түр хэлэлцээр. 3 жилийн хугацаатай.

Сая Ц.Болорчулуун даргын хэлж байгаагаар бэлтгэл ажил хангана гэнэ. Хэзээ хангаж, хэзээ нийлүүлэх юм бэ? Эдийн засаг, хөгжлийн яамны танилцуулга дээр арьс, арьсан бүтээгдэхүүний борлуулалт илүү нэмэгдэнэ гээд.

Евразийн хэлэлцээрийн миний гол дэмжих гээд байгаа шалтгаан ялангуяа хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүн. Өнөөдөр мах. Ламаз гэж ярьдаг. Ноолууртай ямааны арьс. Адууны шир дуртай дургүй авч байгаа. Тэгээд хонь, үхэр хаягдаж байгаа шүү дээ.

Тэгэхээр дээр ийм бүдүүн тоймын хариулт өгмөөргүй байна. Хугацааг нь жоохон тавьж өгөөд яг юу гэж төлөвлөж байгаа юм? Эдийн засаг, хөгжлийн яам хариулах юм уу, хэн хариулах юм. Энэ дээр тодорхой хариулж өгөөч ээ.

Хоёрдугаарт, тэр тамхины О.Номинчимэг гишүүн нарын өргөн барьсан хуультай энэ асуудлыг холимооргүй байгаа юм. Засгийн газар Евразийн хэлэлцээрээр оруулж ирж байгаа бол үүнийгээ дагалдуулаад оруулаад ирэх хэрэгтэй. Одоо надад тамхи эрхлэгчдийн... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Манай уламжлалт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт дээр арьс, ширний зах зээл хүнд байгаа. Дэлхий нийтээрээ материалын сонголт их өөр болоод, нано хөнгөн зөөлөн шинэ үеийн технологи нэвтэрсэн материал хэрэглэдэг болоод байгаа.

Хамгийн гол нь Евразийн эдийн засгийн холбооны орнууд маань сэрүүн бүсийн орнууд буюу уламжлалт манай барааг хэрэглэж байсан зах зээл байгаа юм. Уламжлалт манай савхи өмсөж байсан, арьс, ширэн хувцас хунар дээр их таатай ханддаг ийм зах зээл байхгүй юу.

Тэгэхээр энэ зах зээл рүү л бид тэмүүлж арьс, ширний салбарынхаа өнгөрсөн хугацаанд хийсэн бодлогын хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлийг зах зээлд гаргаж дэмжихгүй бол яг ийм байдалтай л байгаа юм. Хаясан хэвээрээ л байна.

Тэгэхээр бидэнд юу хэрэгтэй байна гэвэл зах зээл хэрэгтэй байна. Энэ орнууд 10 тэрбум долларын хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг импортолж байгаа зах зээл. Тэр 10 тэрбумын зах зээл дээр л манай арьс, шир ноос ноолуур орно л гэсэн үг. Өрсөлдөнө.

Н.Учрал: Цэвэгдоржийн Туваан гишүүн. Хоёр тодруулсан биз дээ?

Ц.Идэрбат гишүүн нэг тодруулъя. Нэмэлт 1 минут.

Ц.Идэрбат: Үгүй. тэгээд яг ноолуур яах вэ? Тэртээ тэргүй эзэнтэй. Яг арьс, ширтэй холбоотой юм асуухад гол юм нь энэ байгаа юм байна. Сэрүүн бүс рүүгээ арьс, ширээ гаргах гээд байгаа юм байна гэхээр. Би тоо хэлээд байгаа шүү дээ. 20 саяынхаа 7, 8 сая, 10-аад саяыг нь боловсруулж байгаа. Үлдэж байгаа 10 саяыг нь хаяж байгаа. Хаяж байгаа 10 саяасаа хэдийг нь боловсруулах, ийш нь гаргах гэдэг төлөвлөгөө байгаа юм бэ гэхээр яам нь бэлтгэл ажил хангана гээд. Эдийн засаг, хөгжлийн яам болохоор бас л бүрхэг юм яриад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр.

Хоёрдугаарт, тамхины хууль дээр Та бүхэн хоёр хуулийг холиод байх хэрэггүй. Засгийн газар хэрвээ Евразийн хэлэлцээрээр 6 улсын тамхины гаалийн татвар тэглэж орж ирж байгаа бол тэрийгээ онцгой татвар дээрээ нэмээд балансыг нь бариулна л гэж байгаа бол яг одоо энэ хөндсөн асуудлаараа тогтоолын төсөл оруулж ирээд тэр ном журмаараа яваад, тэрний ар дээр тамхины энэ хууль нь ажиллах хэрэгтэй байх. Тэгэхгүй бол энэ олон бичиг, энэ олон... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Засгийн газар Евроазитай хийх гэрээ тамхины хууль хоёрыг хольж байгаа зүйл байхгүй.

Нэг нь, Засгийн газраас өргөн барьж байгаа. Нөгөөх нь, гишүүдийн өргөн барьж байгаа хууль. Яг энэ асуудал дээр л давхцаж байгаа зүйл гараад байгаа.

Хэрвээ гэрээ эцэслэн соёрхон батлагдсан нөхцөлд гишүүдийн өргөн барьсан тамхины хуультай холбоотой зохицуулалтын асуудал байна. Тийм орон зай нь бидэнд байна. Онцгой албан татвараа зохицуулах бололцоотой тул үүнийг энэ гэрээтэй хольж асуудалд хандаж болохгүй гэдгийг дахин хэлье.

Арьстай холбоотой энэ байгаа юм. Арьсны зах зээл дээр бид –

- ноолуур шийдсэн,
- ноос шийдэгдсэн,
- тэмээний ноос шийдэгдсэн,
- сарлагийн хөөвөр шийдэгдсэн.

Хонины ноосоо бид хаяхаа больсон. Үйлдвэрийн өргөтгөлүүд. Одоо арьс, шир дээр ноолууртай ямааны арьс асуудалгүй явж байна. Үхрийн шир, адууны шир, тэмээний ширний асуудал шийдэгдэж байгаа.

Одоо Дархан-Уул аймагт коллагенийн /gelatin/ том үйлдвэр орж байгаа. Энэ бол манай дотоод жилдээ гарч байгаа... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: 400-аас 500 мянган ширхэг бодын ширний асуудлыг тэнд шинэ төрлийн бүтээгдэхүүн рүү оруулна. Уламжлалт бүтээгдэхүүнээс гадна шинэ төрлийн бүтээгдэхүүн хийх тэр зах зээл рүү явна.

Хамгийн асуудал бол хонины нэхий байгаа. Хонины нэхийгээр зөөлөн савхи хийдэг. Тэгэхээр савхин эдлэлийн гол зах зээл маань хойд сэрүүн бүс байхгүй юу.

Тэгэхээр тэр сэрүүн бүс рүү бид энд амжилттай гарах суурь боломж байна. Манай савхи зөөлөн савхин эдлэл буюу хонины арьс бүтээгдэхүүн болж тэр зах зээлд гарах гол бололцоотой байгаа юм.

Н.Учрал: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Монгол Улс Евразийн эдийн засгийн холбоо хоорондын худалдааны түр хэлэлцээрийг дэмжиж байгаа. Дэмжихээс ч өөр арга байхгүй.

Яагаад гэхээр эдийн засгийн нөхцөл байдал хүнд байна. Иргэдийн орлого хүнд байна, аж ахуйн нэгжүүдийн орлого хүнд байна. Төсөв тасалдах ч асуудал яригдаж байна.

Тэгэхээр дээр бид бүхэн хүндрэлтэй нөхцөл дээр тэсэж үлдэх гэдэг асуудал, амьд үлдэх гэдэг асуудлаа л яримаар байгаа юм. Зарж болдог юм байвал маш хурдан зараад борлуулаад, экспортлоод орлого олж мөнгөтэй байх гэдэг л асуудлыг яримаар байгаа юм.

Түүнээс биш ийм асуудлууд дээрээ соёрхон батлах гэрээ хэлэлцээрийн асуудлууд дээрээ улстөржөөд унагаагаад, цаг хугацаа алдуулаад баймааргүй байгаа юм. Энэ аль хэзээ яригдаад шийдэгдээд яв байсан. Тэгсэн бол өдийд чинь цэгцдээ ороод гэрээ хэлцлүүд л хийгдэх ажил нь явж байх байсан. Баталж өгөөгүй. Энэ бол манай Улсын Их Хурлын алдаа байгаа.

Мөн онгоцны түлшний асуудал. Мөн л бид хэд юу ярьж байлаа. Тэгээд өнөөдөр нөгөө хоёр газрын тосны бүтээгдэхүүний болон онгоцны түлшний хэлэлцээрүүдээ батлаагүйгээс болоод л өнөөдөр шатахууны асуудалтай болоод төрийн өндөрлөгүүд нь очоод л тэндээс манайд шатахуун өгөөч ээ гээд яваад байгаа шүү дээ. Ач холбогдол бүхий зүйлүүдээ хугацаа алдалгүй доор доор нь баталж өгөөд явъя гэдэг л асуудал.

Худалдааны асуудал яригдаж байгаа. Худалдааны асуудал эрхэлсэн төрийн байгууллага ер нь хаана юм бэ? Түүрүүн гишүүд асууж байна лээ. Гадаад хэргийн яаманд явж байх шиг байна. Тэгээд танхим руу нэг чихэж байх шиг байна.

Тэгэхээр энэ асуудлаа нэг тодорхой болгоод барьж авч явахгүй бол энэ чинь эзэнгүй байна шүү гэдэг зүйлийг хэлмээр байна.

367 нэр төрлийн бүтээгдэхүүн гээд байгаа. Энэ дундаас бусдыг нь ч яриад яах вэ. Ц.Идэрбат гишүүний яриад байгаа арьс, ширэн бүтээгдэхүүн.

Монгол Улс өмнөх үедээ ч тэр, сүүл үедээ ч тэр хойшоо Орос руу л савхи, нэхий, дублёнкоо зарж орлого олдог л байсан шүү дээ. Тэр сэрүүн бүс гээд байгаа чинь энэ.

Харин энэ асуудал хариуцаж байгаа яам нь арьс, ширний асуудлаа ерөөсөө хаядаг. Улстөржүүлээд хаядаг. Нэгнийхээ хийсэн зүйлийг хэн эхэлсэн гэдгээс нь шалтгаалаад улстөржүүлж хорлосоор байгаад одоо арьс, ширний асуудал. Тэр Дарханы арьс, ширний цогцолбор юу болсон. Мэдэхгүй. Одоо харин яам нь Дарханд байгаа энэ үе дээрээ энэ асуудлаа цэгцлээд хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүнээ гялс үйлдвэрлэх асуудлаа яримаар байна. Тэгэхгүй бол бид

нөхцөл гараад хэлэлцээрээ зурдаг. Экспортод гаргаж орлого олох бүтээгдэхүүнүүд маань бэлэн байгаа шүү.

Тэгэхээр энэ дээрээ ямар ахицтай явж байна гэдгийг асуумаар байна. 1 минутаа авъя.

Н.Учрал: Ц.Туваан сайдад 1 минут өгье.

Ц.Туваан: Тодорхой нэг асуулт асууя.

Бид бүтээгдэхүүнээ Монгол Улс Оросын Холбооны Улс, Евразийн бүс рүү экспортод гаргах гэхээр гаалийн тариф, худалдааны тариф маш өндөр байдаг. 40, 40-өөс дээш, 60 хүртэл гээд.

- Тарифын асуудлууд хэлэлцээр соёрхон батлагдсанаар хэд болох вэ?
- Ямар хөнгөлөлт эдлэх вэ?
- Тодорхой тоо хэлээд өгөөч. Хэдэн хувь байгаа юм?
- Одоо энэ хэдэн хувь болж буурах юм бэ?

Бид бодитой зүйл ярихгүй бол сая О.Цогтгэрэл дарга бодитой тоо асуусаар байгаад л гарлаа.

Тэгэхээр яг энэ дээр –

- хэдэн хувь байгаа,
- хэдэн хувь болж буурах вэ,
- тоо, хэмжээ нь хэд хэд болж нэмэгдэх вэ

гэдэг дээр нэг тодорхой хариулт авмаар байна.

Мэдээж яах вэ бид газрын тосны бүтээгдэхүүний импорт, цахилгааны импортоос болоод харьцаа алдагдсан. Үүнийгээ багасгахад хэлэлцээр тус болох байх л гэж бодож байгаа.

Н.Учрал: Жадамбын Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Манай уламжлалт бараа энэ нэр орсон 367 бараан дээр тавьж байгаа гааль болон тарифын хязгаарлалт 15-аас 50 хувь байгаа. Энэ тэглэгдэж байгаа. Зөвхөн өнөөдрийн гарч байгаа экспортын 100 сая доллар дээр харахад бид 16.9 сая долларын хөнгөлөлт авна гэсэн үг. Шууд татварын хөнгөлөлт.

Энэ хэлэлцээр маань ерөөсөө л гол зорилго нь үйлдвэрээ л нэмэх. Үйлдвэрлэлийг болон экспортын бизнесийг л дэмжих явдал буюу эдийн засаг. Энэ хүрээнд юу үүсэх вэ гэвэл эдийн засгаа тэлэх.

Тэгэхээр таны яриад байгаа эдийн засаг хүндэрч байгаа, төсөв хүндэрч байгаа, орлого хүндэрч байгаагаас гарах гол гарц үйлдвэрлэлээ тэлээд, шинэ зах зээл, экспортын зах зээлд л өөрийн байгаа нөөц бололцоо түүхий эдээ боловсруулаад гаргах ажил. Энэ хүрээнд хийгдэж байгаа.

Дагаад ингээд ложистикийн асуудал, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрүүд, хил орчмын дэд бүтцийн хөгжил гээд олон салбарыг хамарсан хөдөлгөөн орно.

Сая Оросын Холбооны Улстай хийгдэх таван жилийн хамтын ажиллагааныхаа төсөл, хөтөлбөр дээрээ санал солилцоод сууж байхад Оросын Холбооны Улс 50 мянган тонн махыг яаралтай авъя л гээд байна лээ. Жил болгон авъя. Урт хугацааны гэрээ хийгээч ээ.

Манай гишүүд яриад байгаа гадаад худалдаа. Энэ худалдааны хуулийг яаралтай хийгээд нэг цонхны худалдааны бодлогыг бид яаралтай хэрэгжүүлэхгүй бол олон чиглэлээр зохион байгуулалт муутай бид гадаад худалдаанд бодлогын боломж алдаж байгаа олон асуудал байгаа. Тэгээд үүнийг зайлшгүй шийдэх асуудлыг бид хаврын чуулган гэхэд Худалдааны хуулийг өргөн барих ажлыг хийнэ.

Н.Учрал: Ц.Туваан гишүүн тодруулна.

Ж.Энхбаяр: Тоон дээр нь яриад, тоонууд хэлээд байгаарай. Ажлын хэсгээс.

Ц.Туваан: Харин тийм. Тоонуудаа. Тодорхой энэ улсууд дээр тариф, ялангуяа бид бэлэн бүтээгдэхүүн дээр, арьс, ширэн бүтээгдэхүүн дээр асуусан.

- Энэ асуудал хэдэн хувь байгаа юм?
- Хэд болох юм?
- Мөнгөн дүн нь яаж нэмэгдэх юм?

Түрүүний тэр нэг асуулт. Энэ арьс, ширний цогцолборын асуудал хаана явна? Энэ ер нь ямар бодлоготой. Зогссон уу? Нэг хэсэг явж байгаад гацаагаад дэргэд нь дахиад нэг жижигхэнийг байгуулах шийдвэр гараад ингээд хоёрдуулаад орхисон. Одоо яг ямар шатдаа явж байна? Үүнийг нэг хэлээдэхээч. Энэ экспортыг чинь нэмэгдүүлэхэд бараа байхгүй бол бид хэд хэдий гоё хэлэлцээр батлаад нэмэргүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хариулт авъя.

Н.Учрал: М.Бадамсүрэн сайд хариулъя.

М.Бадамсүрэн: Ц.Туваан гишүүний асуулт. Тийм. Асуултыг маш сайн ойлгож байгаа.

Арьс, ширний хувьд хамгийн хүндрэлтэй л байгаа юм билээ. Ер нь бодлогын хувьд эхлээд богийн арьсаа боловсруулах үйлдвэр лүүгээ онцгой анхаараад, тэгээд шат дараатай явбал илүү оновчтой болов уу гэж урьдчилсан байдлаар үзэж байгаа.

Н.Учрал: Ц.Болорчулуун дарга. 3 дугаар микрофон.

Ц.Болорчулуун: Ц.Туваан гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Тэр Евразийн 367 бүтээгдэхүүнээс 71 төрлийн бүтээгдэхүүн буюу арьс, арьс, ширэн бүтээгдэхүүн 71 ширхэг бүтээгдэхүүн буюу нийт бүтээгдэхүүний 19.3 хувь нь гарахаар ингэж тусгагдсан байгаа.

Дархан-Уул аймагт яригдаж арьс, ширний цогцолбор гээд хувийн хэвшлийн компани, хувийн компани Дархан-Уул аймгийн Тамгын газрын хувьцааны оролцоотойгоор энэ хоёр байгууллагын хооронд ингэж хэлэлцээрт арьс, ширний цогцолборын үйл ажиллагаа эхэлсэн. Энэ дээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зүгээс эхнээсээ ямар нэгэн оролцоо байгаагүй. Бодлогын хувьд тэнд арьс, ширний цогцолборыг байгуулъя гэдэг бодлогын хувьд дэмжиж ажиллаж байсан.

Ингээд сүүлдээ тухайн үйл ажиллагаа явуулж байгаа компани, тэгээд Хөгжлийн банкн дээр асуудалтай болоод энэ нь хууль хяналтын байгууллагаар яваад одоохондоо ажил нь зогссон.

Н.Учрал: Жадамбын Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Ц.Туваан гишүүний асуултад хариулаадахъя. Ингэнэ.

- ▶ Мах, махан бүтээгдэхүүний тариф 15-аас 50 хувийн босготой байгаа. “Тэг” болно. Ингэснээр экспорт 125-аас 140 хувь нэмэгдэнэ гэж тооцож байна.
- ▶ Ноос ноолуур, арьс, ширний тариф 10-аас 18 хувь байгаа нь “тэг” болно. Энэ нь экспортыг 55-аас 152 хувиар өсгөнө гэж байгаа.

Арьс, ширний салбартай холбоотой асуудалд хариулт өгье.

Монгол Улсад 27 арьс, шир боловсруулах үйлдвэр байгаа.

- 24 нь нийслэл Улаанбаатар хотод байгаа.
- 2 үйлдвэр Дархан хотод байна.
- 1 үйлдвэр Өвөрхангайд байна.

Их Хурлаас барьж байгаа бодлогын хүрээнд Ховдын арьс, ширний үйлдвэрийн цогцолборыг бариад үндсэндээ хөрөнгө оруулалт нь шийдэгдээд 2026 онд дуусна.

Тэнд нэлээн цэвэрлэх байгууллага, дэд бүтэц, эрчим хүч, зам, харилцаа холбоо гээд олон хөрөнгө оруулалт хийсээр байгаад дуусаж байна. Одоо баруун бүсийн арьс, шир боловсруулах гол бодлого Ховд дээр төвлөрнө.

Нийслэл хоттой юу тохирч байгаа гэвэл Эмээлт арьс, ширний үйлдвэрийн парк буюу “Эмээлт аж үйлдвэрийн парк” дээр арьс, шир боловсруулах нийслэл хотын суурьшлын бүсэд орсон 20... /минут дуусав/

Н.Учрал: Ж.Энхбаяр сайд нэмэлт 1 минут.

Ж.Энхбаяр: Улаанбаатар хотын хэрэгжүүлж байгаа “Эмээлт аж үйлдвэрийн парк” дээр Улаанбаатар хотын суурьшлын бүсэд байгаа 24 арьс, ширний үйлдвэрийг шилжүүлэхээр тохиролцож, тэнд үйл ажиллагаа явж байгаа.

Нийслэл өөрөө энэ дээр 200 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр гаргаад тэнд дэд бүтэц, эрчим хүч, дулаан, цэвэрлэх байгууламж гээд дэд бүтцийн хийгдэх ажлууд хийгдэж байгаа. Энэ дэд бүтцийн ажил хийж дуусангуут аж ахуйн нэгжүүд шилжин суурьших ажил хийнэ.

Үүнтэй холбоотойгоор нийслэл шинээр манайд Америкийн мянганы сорилын сангаар шинэ цэвэрлэх байгууламж, усны хангалтын асуудал хийж байгаа. Саарал ус ашиглалт. Үүнтэй холбоотойгоор арьс, ширний үйлдвэрүүд хөрөнгө оруулалт хийх ажил хязгаарлагдаад байгаа юм. Одоо байгаа байран дээрээ хөрөнгө оруулж болдоггүй. Хязгаарлагдаад. Өргөтгөхгүй.

Тэгэхээр шинэ Эмээлт бүсийн суурьшлын бүс рүүгээ очоод тэнд дэд бүтэц нь дууссаны дараа нүүнэ гэсэн ийм л байдалтай боловсруулалтын түвшин байгаа. Суурилагдсан хүчин чадал хангалттай. Хамгийн гол асуудал зах зээл дээрээ байгаа юм шүү.

Тэгээд Евроази бол сэрүүн бүсийн зах зээл нээж өгч байгаа юм. Энэ манай арьс, ширний салбарынхны... /минут дуусав/

Н.Учрал: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Их Хурлын дарга аа, 5, 6 орны парламент харж байна шүү. Та нарыг харж байгаа шүү гээд загнаад ч байгаа юм шиг, дарамтлаад ч байгаа юм шиг. Энэ хэлэлцээрийг Их Хурлаар хэлэлцүүлмээргүй байна.

Харж л байг л дээ. Харахаараа яадаг юм. Бид яах ёстой юм. Үсээ самнах юм уу. Ойлгохгүй байна наадхыг чинь.

Дээрээс нь Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж байхад тэр хүнээсээ асуу гээд суудаг Урбанек Б.Лхагважав нар ингэмээргүй байна.

Ардын намын даргад өрсөлдөөрөө томордог юм уу? Их Хурал дээр ер нь намынхаа Их Хурал дээр сууж байна гэж бодоод байгаа юм уу? Өөрсдийнхөө харилцааг жоохон анхаармаар байх юм.

Тэгээд олон гоё олон улсын хэлэлцээр, зээлийн гэрээ соёрхон батлаад л байдаг. Одоо жишээ нь газрын тосны боловсруулах үйлдвэр чинь хэцүү байдалд байгаа шүү дээ. Бид ноднин цагаан сарын өмнө Энэтхэгээс авсан зээлийг дахиад нэмж соёрхон батлах ёстой. Бид ёстой амжуулна гээд л авсан. Өнөөдөр зээлийн зарлага нь шаардагдах хэмжээндээ хүрэхгүй байгаа байхгүй юу.

Дээрээс нь хайгуул байхгүй. Хайгуулын ажил нь үндсэндээ зогссон. Одоо энэ Засгийн газарт орсон М.Бадамсүрэн гишүүн манай ажлын хэсэгт ажиллаж байсан болохоор энэ асуудлыг сайн мэдэж байгаа.

Дээрээс нь Оюу Толгойн гэрээ. Оюу Толгойн гэрээг Хянан шалгах түр хороо хэлэлцээд бөөн юм болж байна шүү дээ. Санжийн Баяр юу гэж ярьж энэ гэрээг соёрхон батлуулж байлаа. Өнөөдөр өөрөө байхгүй.

2051 он гэхэд Монгол Улс Рио Тинтод өртэй л хэвээрээ байна. Тэгээд тэр Санжийн Баяр нь би толгойгоороо хариуцна. Энэ бол ёстой дэлхий нийт харж байна. Монгол Улсыг харж байна гээд л батлуулсан. Одоо тэр Санжийн Баярын толгой хэнд ч хэрэггүй л байгаа байхгүй юу.

Яг түүн шиг одоо энэ бидний хэлэлцээд байгаа асуудал чинь хариуцах хүн нь тухайн үед яг гараад ирэхээр байхгүй.

Ж.Энхбаяр сайд аа, таны яриад байгаа наад арьс, ширний үйлдвэрүүд чинь богийнх юм уу, бодынх юм уу? Сая М.Бадамсүрэн сайд эхлээд богийн арьс, ширээ, богийнхоо арьсыг боловсруулна. Дараа нь тэр бодынхоо асуудлыг хэлэлцвэл болно гэсэн.

Ц.Болорчулуун дарга болохоор Дарханд арьс, ширний үйлдвэр барьж байсан тэр хувийн хэвшлийн залууг барьж аваад шоронд хийгээд л хамаг юмыг нь дампууруулсан шүү дээ. Тэгээд одоо өөрсдөө чадахгүй л байгаа шүү дээ. Танд

бэлтгэл ажил гэж бараг байхгүй дээ. Ц.Болорчулуун дарга аа. Та сая үг хэлж чадахгүй байгаа байхгүй юу.

Эхлээд энэ асуудлаа ярихдаа нэг их гоё гоё юм ярьдаг. Экспорт тэдэн хувиар нэмэгдэнэ, эдэн хувиар нэмэгдэнэ, ийм гоё сайхан болно гээд бэлтгэл ажил нь үнэндээ байхгүй л байна гэж харж байна шүү дээ. Тэгээд үүнийгээ яравчлуулаад л, ямар нэгэн баяр ёслолын өмнө нэг ийм гэрээ соёрхон батлуулдаг. Тэгээд цөөнхдөө бүр үл хүндэтгэж байгаа. Бид Монгол Улсын Их Хурал дээр сууж байгаа цөөнхийн гишүүд.

Түүнээс биш Ардын намын бүлэг дээр ч юм уу, хурал дээр нь суугаагүй. Яагаад ингээд асуулт асуухаар... /минут дуусав/

Н.Учрал: Энэ бол зээлийн хэлэлцээр биш, хөрөнгө оруулалтын гэрээ биш. Тийм. Энэ бол Евразийн эдийн засгийн холбооны түр хэлэлцээр буюу 5 оронтой худалдааны боломж нээх асуудлыг л хэлэлцэж байгаа юм. Тийм.

Түүнээс биш би ямар нэгэн байдлаар Их Хурлын гишүүдийн тэр бүрэн эрхэд халдаагүй. Гэхдээ 5 улсын парламент хэлэлцэж байна гэдэг бол өөрөө дэлхий дахинд 5 улсын хүрээнд энэ асуудал ярилцаж байгаа учраас бид илүү мэдээлэлтэй, шинжлэх ухаанд суурилсан тооцоотой ярилцаад олон нийтдээ зөв ойлголт өгөөд Их Хурал өөрөө эцэслээд энэ түр хэлэлцээрийг батлах эсэхээ шийднэ.

Энэ түр хэлэлцээрийг байгуулах гэж үе үеийн Засгийн газар хичээж ажилласан юм байна лээ. Үе үеийн Засгийн газар. Тэгээд бүтээгдэхүүнээ харилцан буулт хийгээд тохироод өмнө нь хоёр намын бүлэг дээр Л.Гантөмөр сайдын үед бид оруулаад тэгээд нэлээн гишүүдийн санал шүүмжүүд гараад үүнийх нь дагуу Эдийн засаг, хөгжлийн яам ажиллаад нэлээн олон бараа, бүтээгдэхүүнийг хасуулсан юм билээ.

Хамгийн сүүлд тэр тамхитай холбоотой асуудал дээр Их Хурлын тогтоол гаргаад албажуулаад явъя. Онцгойгоо нэмэгдүүлээд зах зээлээ хамгаалъя гэж шийдсэн байна.

Мэдээж нөгөө айлын талын бараа, бүтээгдэхүүний жагсаалт дээр түрүүн ярьсан онгоцны түлш ч тэр, дизель түлш ч тэр, манай хөдөө аж ахуйн салбарын гол түүхий эд болоод байгаа тэр малын тэжээл, бордоо бүгдээрээ багтаж байгаа нь өөрөө дотоодын зах зээлтэй бас дотоодод одоо жишээ нь дизелийн түлшний үнэ буурах ч юм уу нөхцөлүүд бүрдэнэ.

Дээрээс нь түрүүн Ж.Энхбаяр сайд хэлж байсан. Тэр инфляц тооцдог сагсны бүтээгдэхүүнд байгаа 42 бүтээгдэхүүний үнэ буурвал нөхцөл дээрдэнэ гэдэг.

Тийм учраас Л.Мөнхбаясгалан гишүүн үүнийг зөвөөр хүлээж авахыг хүсье.

Тэгээд би Их Хурлын гишүүдийн, мэдээж Та бүхний өөрсдийн чинь үзэл бодол, итгэл үнэмшил. Гол нь бид нийгэмд ч бай, олон нийтэд ч бай, олон улсад ч бай энэ хэлэлцээрийг илүү үндэслэлтэй, шинжлэх ухаанч байдлаар явуулаад өгвөл эцэслээд шийдэхэд бас их том дөхөм болно. Гишүүдэд болоод нийгэм олон нийтэд зөв ойлголт өгөх мэтгэлцээнийг өрнүүлье гэж үзэж байна.

Тэгээд хөдөө аж ахуйн салбар, малчид, манай томоохон махны компаниуд, арьс, ширний компаниуд гээд олон компаниуд экспорт хийхэд дэм болох зорилгоор л ингэж хэлэлцээр явж байгаа шүү гэдгийг Та бүхэнд хэлье.

Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад. Бэлтгэл ажил хэр хангасан бэ? Махан дээр тэр нэг ложистик төвүүд байгуулах асуудлууд байна. Арьс, ширэн дээр ямар бэлтгэл ажил хангасан.

Харьцангуй Ж.Энхбаяр сайд өөрөө хөдөө аж ахуйн сайд байсан учраас бэлтгэл ажил дээр харин одоо яг ирлээ. Тэгээд би бас арай ирлээ үр дүн гарна гэж үзээд байгаа шүү дээ. Ж.Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Өнгөрсөн 3 жил бид ерөөсөө л яг үүнийг л зорьж бэлдсэн. Зах зээлээ тэлэх, үйлдвэрлэлээ дэмжих, экспортыг нэмэгдүүлэх.

Экспортолж байж л манай хөдөө аж ахуйн салбар босно, үйлдвэрлэл босно. Нэг зүйл.

Махан дээр гэхэд бид 300 сая доллароос буухаа больчихлоо. Олон жил ярьсан. 30 жил ярьсан шүү. 10, 20 саяас хэтэрдэггүй. Ингээд зориод, тэмүүлээд олон улсын стандартыг нь аваад, тоног төхөөрөмж шинэчлээд, хөнгөлөлттэй дэмжлэг үзүүлсэн.

Махны экспорт 3 жил дараалаад 300 сая доллар луу. Одооны байдлаар 305 гарсан явж байна. Дөхөөд ирлээ. Тэгэнгүүт бид үйлдвэрийн аргаар нядалдаг арьс, шир түүхий эдтэй болоод ирж байна. Үйлдвэрийн аргаар нядалгаанд орсон малаас гардаг арьс, шир чинь гэмтэлгүй үйлдвэрлэлд шилжиж, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн болж эхэлж байна.

Зүгээр байгаа үед ч мал аж ахуйгаа сайжруулах ашигт мал сүргийнхээ тоог нэмэх гээд үржил селекцийн бодлого дээр, мал эмнэлгийн бодлого дээр энэ өнгөрсөн 3 жилийн парламент их том алхам хийсэн байхгүй юу. Мал эмнэлгийн салбарт. Вакцинжуулалт хийхтэй холбоотойгоор энэ махны экспорт чинь гараад ирж байгаа юм. Бүтээгдэхүүний түүхий эдийн чанар сайжирч байгаа.

Тэгэхээр бидний гол зорилго зах зээлээ л тэлэхийн тулд сая энэ “Цагаан алт” хөтөлбөр дөнгөж нэг жил болж байна. Хурдтай ажилласан манайхан.

Ноос, ноолуурын салбар технологийн шинэчлэлт, угаах, самнах, ээрэх сүлжих лүү технологийн шинэчлэлт нэлээн хийсэн. Махны үйлдвэрүүд тэр мах боловсруулах, хөргөх агуулах зоорины ажлууд нэлээн явсан. Тасралтгүй ажиллаж байгаа. Арьс, шир дээр голлох одоо байгаа суурилагдсан үйлдвэрүүд маань нэлээн бодлогын чанарын өөрчлөлт ороод технологийн шинэчлэлтүүдийг хийсэн явж байна. Одоо зах зээлээр нь яг дэмжээд өгмөөр байна. Энэ сэрүүн бүсийн зах зээл рүү.

Ингээд саяын өнгөрсөн хугацаанд манай Их Хурлын Та бидний хийсэн бодлогын үр дүн гарч ирж байгаа нь энэ жилийн гуравдугаар улирлын эдийн засгийн мэдээгээр эдийн засгийн өсөлтийн 60 хувийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар чинь хангаад гараад ирлээ шүү дээ. Энэ чинь сүүлийн жилүүд дандаа хасах, 10-аас 20 хувийн хасах байсан салбар 35, 36 хувийн өсөлт үзүүлээд гараад ирж байгаа маань энэ бодлого үр дүнд хүрээд үйлдвэрлэл хөдлөөд эхэлж байгаагийн шинж. 48 мянган ажлын байр бий болоод байна. Яг дээр нь л одоо бид дэмжээд л зах зээлийг нь л нээж байна.

Сэрүүн бүсийн 200 саяын зах зээлийг нээх нь л бидний л үүрэг. Энэ дээр манай аж ахуйн нэгжүүд өрсөлдөнө. Ийм л хуулийн бодлого шүү дээ.

Түүнээс төр арьс элдэхгүй, ноолуур самнахгүй, угаахгүй шүү дээ. Зах зээлийг нь нээх, тарифыг нь тэр цаад тотгорыг нь арилгах, хил, гаалийн хүнд суртлыг нь арилгах, техникийн зохицуулалтыг нь тохирох энэ ажлууд л хийгдэх ёстой юм байна.

Үүнийг нь төр ажлаа хийвэл мах бараг 30 дахин экспорт нэмэгдсэн шиг манай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гарна. Нэг үе манай хөнгөн үйлдвэрийнхэн чадавхажсан, технологийн шинэчлэл хийгдсэн, өөрийн ажлын туршлагатай, хүний нөөцтэй болоод байна. Тэгэхээр Евразийн зах зээл бидэнд зайлшгүй.

Монгол Улс маань дэндүү нэг улсаас хамааралтай болсон гэдгийг гишүүд маань сайн ойлгомоор байна. 91.2 хувь. Нийт экспорт нэгхэн улсаас. Гарч байгаа бүтээгдэхүүн маань 94.7 хувь нь уул уурхай. Үйлдвэрлэл дутуу байна. Үйлдвэрлэл хийх бид нарт бололцоо маань хөдөө аж ахуй дээр суурилсан хөнгөн хүнсний үйлдвэрүүдээ босгоно.

3.5 саяын зах зээл чинь багадаад байна. Үндсэндээ. Одоо экспорт руу гаргая.

Зөвхөн хүнс дээр гэхэд бид 1000 гаруй төрлийн барааг шинэчилж, сав, баглаа боодолтой нь солиод олон улсын стандарт гаргалаа шүү дээ. Маргааш

тав дахь өдөр энэ хажуу талын галерей дээр ойрхон бид 1000 төрлийн барааг дэлгэнэ, танилцуулна. Энэ чинь үйлдвэрүүд хөдлөөд урам зориг ороод байгаа энэ үед бид улс төрийн шийдэл гаргаад зах зээлийг нь нээж өгөх нь манай парламентын их том ажил болно. Өнгөрсөн хугацаанд хийсэн хөтөлбөрүүдийн чинь үр дүнгээ бид дараагийн түвшинд гаргаж байгаа л үйл явдал шүү дээ. Гишүүд ээ.

Н.Учрал: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулна.

Л.Мөнхбаясгалан: Ж.Энхбаяр сайд аа, наад асуудлыг чинь маш сайн ойлгоод байгаа.

Нэг улсын хараат байгаа гэдэг дээр би бараг насаараа л ярилаа, нэвтрүүлэг хийлээ, мэдэж байгаа. Би бас дээрээс нь хөдөөгөөс сонгогдсон гишүүн. Наад малаас гарч байгаа бүтээгдэхүүн чинь үнэгүй хаягдаад байгаа, малчид орлогогүй байгаа гэдгийг хамгийн сайн мэдэрч байгаа.

Сая тойргоор яваад ирлээ. Малын гаралтай бүтээгдэхүүн үнэгүй байна гээд малчид тэнд туйлдаж байна.

Тэгээд миний асуулт энэ шүү дээ. Тантай би ерөөсөө мах, сүү яриагүй байхгүй юу.

71 төрлийн арьс, ширний бүтээгдэхүүн гарна гээд сая хэллээ шүү дээ. Энэ 71 төрлийн арьс, ширний бүтээгдэхүүнийг чинь хаана боловсруулаад, хаана тэр бэлтгэл ажил нь хангагдсан юм уу л гэж асуугаад байгаа шүү дээ. Та тэгэхээр өмнөөс мах тэгээд байна, сүү тэгээд байна, манай хөнгөн үйлдвэр гээд өөр юм яриад байх юм. Наад асуудлуудыг чинь мэдэхгүй биш. Хөдөөгөөс сонгогдсон гишүүн шүү дээ. Би.

Н.Учрал: Л.Мөнхбаясгалан гишүүн санал хэллээ. Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Л.Мөнхбаясгалан гишүүн ээ, одоо байгаа манай хуучнаар арьс, ширний үйлдвэрийн нэгдэл, түүний харьяа байсан 26 үйлдвэр байсан. Өвөрхангайд сүүлд нээгдсэн. Энэ үйлдвэрүүд маань тэр хуучин суурилагдсан хүчин чадал нь байгаа юм. Дэд бүтэц нь байгаа юм. Бас зогсчоогүй үйл ажиллагаа яваад тодорхой боловсруулалт хийгээд байгаа юм.

Тэгээд зах зээлийг нь нээгээд өгвөл үйлдвэрлэлээ нэмээд л, түүхий эдийнхээ худалдан авалт нэмэгдээд л явна. Асуудал зах зээл. Тэр зах зээлийг л бид нээж байгаа юм. Сэрүүн бүсийн орнууд 200 сая хүний уламжлалт манай зах зээлийг нээгээд өгөхөөр манай үйлдвэрүүд хөдөлнө.

Сая “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд чинь нэлээн олон үйлдвэрүүд технологийн болон үйлдвэрлэлийн шинэчлэлээ хийлээ.

Тэгэхээр одоо энд нь бид дэмжлэг үзүүлнэ. Манай ноосны үйлдвэрийн нэгдлийнхэн шинэчлэлүүд хийсэн. Ноос, хивс, даавуу, ноолуур, ээрмэл, угаах, сүлжих, самнах гээд. Одоо зах зээлийг нь л тэлээд байх хэрэгтэй байна.

Тэгээд эд нартаа боломж олгоод бүгдээрээ дэмжээд өгье л гэж байгаа юм.

Н.Учрал: Өнөөдөр Их Хурлын тогтоолоор үүрэг өгнө. Түрүүн яригдсан асуудлуудаар Засгийн газар ирэх долоо хоногт оруулж ирээд асуудлыг хамтад нь шийдээд явах ёстой.

Ц.Идэрбат гишүүний тамхины хуулийн ажлын хэсэг ч гэсэн энэ хуультай уялдуулж, Засгийн газраас өргөн мэдүүлэх Онцгой албан татварын хуультай уялдуулж хуулиа боловсруулах ёстой.

Ирэх долоо хоногт мөн тэтгэвэртэй холбоотой нийгмийн даатгалын хуулиудыг Засгийн газар оруулж ирэх хэрэгтэй байна. Ирэх долоо хоногт хэлэлцье. Оруулж ир. Тэр суурь углуургаар нь авч үзэхгүй бол цаг хугацаа алга.

Монголбанк арилжааны банкнуудтай уулзалт хийсэн. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо өнөөдөр хуралдаад тэтгэврийн зээлийн эрсдэлээр жигнэсэн хувийг 100 хувь болгож бууруулаад, эргэн төлөлтийн хугацаа 36 сар болгосон. Ингэснээрээ мэдээж сард ирэх ачаалал нь бууж байна. Заавал байлгах нөөцийг тэтгэврийн зээлээс хассан шийдвэрийг Монголбанкны Мөнгөний бодлогын хороо гаргасан байна.

Гэхдээ энэ бол бүх асуудлыг шийдэж байгаа хэлбэр биш. Гэхдээ мэдээж шинэ оны босгон дээр, сар шинэ болох гэж байгаа энэ цаг үед сар болгон ирэх ачаалал нь буурна. Ахмадуудын. Энэ цаг үед тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх хуулиудаа хэлэлцэж эхэлье. Тэр хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг баталъя. Олон давхаргад тэтгэврийн тогтолцоо руу шилжье.

Тийм учраас ирэх долоо хоногт энэ хуулиа оруулж ирэхийг Засгийн газарт даалгаж байна.

Дараагийн долоо хоногт дахиад баяр ёслолын өдөр хоног сунгах чуулган хийхгүй шүү.

Өнөөдрийн Евразийн хэлэлцээр чинь бас нэг ажил хэрэгч байна шүү дээ. Ингээд өдрийн 13 цаг болсон байна. Өдрийн цайны цаг. 14.00 цагаас чуулган үргэлжилнэ. Чуулганы хуралдаан түр завсарлаж байна. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгээ дуудаарай. 2025 оны 12 сарын 11-ний өдрийн үдээс хойших чуулганы хуралдаан эхэлж байна.

Чуулганы хуралдаанаар Евразийн эдийн засгийн чөлөөт хэлэлцээрийг соёрхон батлах тухай асуудал хэлэлцэгдэж байгаа. Асуултад хариулах сайд нар болон ажлын хэсгийнхнийг урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн Хөхүүгийн Болормаагийн урилгаар Сүхбаатар дүүргийн иргэд Их Хурлын чуулганы танхимд зочилж байна.

Та бүхэнд ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Хүнс, хөдөө аж ахуйн сайдыг дуудаарай. Одоо Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ түр хэлэлцээрийг дэмжиж байгаагаа хэлье. Ер нь экспортыг нэмэгдүүлэхийн тулд аж ахуйн нэгжүүдэд үүсэх тэр том босго өөрөө амаргүй байдаг учраас энэ улс орнуудтай хийх түр хэлэлцээр өөрөө чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа.

Тэгэхдээ энэ хуулийн үзэл баримтлал болон үр нөлөөний тайланд тайлангаас тодруулах зүйл байна. Энэ хэлэлцээр батлагдсанаар аж ахуйн нэгжүүдэд ерөнхийдөө дараах хүндрэлүүд үйл ажиллагаанд нь эрсдэл учрах талаар тусгасан байна лээ. Жишээлэх юм бол зах зээлд нэвтрэхэд стандартын шаардлага хангах, хорио цээрийн шаардлагыг дагаж мөрдөх ч гэдэг юм уу. Магадгүй тодорхой хугацаанд экспортод тэр зөвшөөрөл стандарт шаардлагыг нь хангах хугацаа алдсантай холбоотойгоор зөрүүлээд бизнесийнх нь ашиг буурах ч гэдэг юм уу иймэрхүү эрсдэлүүд харагдаж байгаа.

Тэгээд ер нь аливаа том хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлахдаа хариу арга хэмжээ авах төлөвлөгөөгөө танилцуулж хамтад нь ер нь батлуулж байх шаардлагатай гэж харж байгаа. Энэ дээр болохоор аж ахуйн нэгжүүдэд ер нь тодорхойгүй байгаа учраас аж ахуйн нэгжүүд бас эрсдэл дааж энэ хэлэлцээрт идэвхтэй оролцох эсэх нь өөрөө үүнээс хамаараад шалтгаална.

Тэгээд одоогийн байдлаар статистикаас харах юм бол экспортын чиг баримжаатай уул уурхайн бусад 600 аж ахуйн нэгж байдаг гэдэг тоо байдаг. Дунджаар 30 ажилтантай гэж тооцох юм бол 15-аас 20 мянган ажлын байр бүрдүүлж байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр энэ хариу арга хэмжээ тодорхойгүй байсантай холбоотойгоор эргээд 15-аас 20 мянган ажлын байранд эрсдэл үүсэх эрсдэлтэй.

Тэгэхээр хоёр асуулт асууя л даа. Дотоодын зах зээл дээр дотоодын үйлдвэрлэлийг хамгаалахын тулд яг ийм зэргийн санал шийдэл, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэзээ боловсруулж батлуулах вэ гэдэг асуулт байна.

Хоёрт нь, экспортын зах зээл дотоодын үйлдвэрлэлийг дэмжихийн тулд гаалийн татвараас гадна нөгөө тарифын бус татвар, НӨАТ-ын татвар, тэгээд нөгөө стандарт, техникийн зохицуулалт, зөвшөөрөл гээд гэх мэтчилэн энэ босгыг өөрөө бууруулах, мөн хугацааг нь хэмнэх шаардлага хэрэгцээтэй болдог.

Тэгэхээр үүнтэй холбоотой ямар арга хэмжээ энэ хэлэлцээрт тусгагдаж орж байгаа вэ гэдгийг асууя. Тэгээд дараа нь тодруулъя.

Б.Пүрэвдорж: Асуултад Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон. Эрсдэлээ тооцоод ямар хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ гэж ойлголоо.

Тэгэхээр Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 20 дугаар зүйлд энэ хэлэлцээрт үл хамаарах нөхцөлүүд байдаг.

Ер нь худалдааны байгууллагын гишүүн улс орон өөрийнхөө хүн, амьтны эрүүл мэндийг хамгаалах зэрэг нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор худалдаанд тодорхой хязгаарлалт тогтоох хэрэгтэй. Үүнээс гадна үндэсний аюулгүй байдлыг хангах болон төлбөрийн тэнцлийг хамгаалах зорилгоор худалдааны хязгаарлалт тогтоох эрхтэй.

Нөгөө талаар энэ худалдааны хэлэлцээрт манай онцгой албан татвар нэмэх хасах, импортын лицензийн квот тогтоох асуудал хамаараагүй буюу эдгээр бодлогоор бид эрсдэлийг тооцож, хамгаалалтыг хийж хариу арга хэмжээг төллөх бүрэн бололцоотой.

Нөгөө талаар Дэлхийн худалдааны байгууллагын хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх журамтай байдаг.

Үүнийг Монгол Улсын Засгийн газар 2021 онд баталсан. Үүгээр мөн дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учрах, эсвэл учирч болзошгүй гэж үзвэл хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Хамгаалалтын арга хэмжээ нь гаалийн тариф, эсвэл импортын тоо хэмжээний хязгаарлалт буюу квоттой хосолсон хэлбэртэй байж болно гэсэн гээд. Ийм мэтийн нэг арга хэмжээнүүдийг

хийх нь дэлхийн худалдаан байгууллагын гишүүн орнуудад дотор байдаг бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авна.

Нөгөө талаас хамтарсан ажлын хэсэг хоёр талаасаа гарна буюу хэлэлцээрийг байнга дүгнэнэ. Жилийн бүтэн үйл явцаар нь дүгнэнэ. Шаардлагатай барааны нэмэлт хасалтыг тухайн үедээ хийгээд хийгээд Улсын Их Хуралдаа өргөн бариад зөвшилцөөд явна.

Тэгээд энэ бол 3 жилийн хугацаатай. Бид зах зээлд шинэ зах зээлээ нээнэ. Монголын аж ахуйн нэгжүүд өрсөлдөөнд орно. Ялангуяа ахиад хэлэхэд сэрүүн бүсийн 200 сая хүн амтай 90 оноос өмнөх манай уламжлалт гол худалдаа, эдийн засгийн 90 хувь явж байсан зах зээлд бид дахин эргэн ирэлт хийж байгаа юм. Одоо бид тэр бүс нутагтаа манай гадаад худалдааны 10 хүрэхгүй хувь явж байгаа.

Тэгэхээр энэ орон зайд энэ том зах зээл рүү манай уламжлалт аж үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэл, экспортын чиг баримжаатайгаар өрсөлдөнө өө л гэж хэлэхийг хүсэж байна. Мэдээж стандарт, зөвшөөрөл, хорио цээрийн гэрээ, протоколуудыг хийхийн тулд энэ байгууллага хооронд төрийн байгууллагууд ажлаа хийнэ.

Сая Оросын Холбооны Улсын бүс нутгийн хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийг байгуулах хүрээндээ бид очиж энэ стандарт зөвшөөрөлтэй холбоотой, хорио цээр, дэглэмтэй холбоотой асуудлуудаа цэгцлэх, энэ худалдаанд оролцогч байгууллагуудынхаа хийх ажлуудыг нэлээн хоёр талаасаа харилцан тодорхойлсон. Тэгээд гэрээ соёрхон баталбал одоо бид энэ Их Хурлын чөлөө цагт Засгийн газар харьяа байгууллагууд энэ худалдаанд бэлтгэх энэ ажлуудаа хийж гүйцэтгэнэ.

Б.Пүрэвдорж: Мэндбаярын Мандхай гишүүн нэмж тодруулъя.

М.Мандхай: Эндээс ажлын хэсэг нэмээд хариулах уу? Энэ үр нөлөөний тайлан дээр үүсэж болох эдийн засгийн үр нөлөөг тооцсон юм байна. Эдийн засаг, хөгжлийн яам. Гэхдээ ер нь юу хийх шаардлагатай вэ гэдгийгээ оруулсан байгаад байгаа. Ямар арга хэмжээ тодорхой тооцоогүй вэ? Одоо өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, стандарт, техникийн зохицуулалтыг уялдуулах ч гэдэг юм уу, хөрөнгө оруулалт бизнесийн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн байгаа боловч энэ хуулиа соёрхон батлахдаа хариу арга хэмжээ авах төлөвлөгөөгөө ерөөсөө эцэслээгүй.

Энэ тайлан дээр чинь оруулахдаа өөрсдөө энэ төлөвлөгөөг холбогдох байгууллагууд хамтран боловсруулж батлуулж хэрэгжүүлэхээр ажиллаж байна гэж байгаа байхгүй юу.

Ерөнхийдөө энэ түр хэлэлцээрийг батлахдаа хэлэлцээрийг нь хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ямар байх вэ гэдгийг эхлээд аж ахуйн нэгжүүд чинь сонирхож байж энд оролцох эсэхийгээ шийдэх гээд байгаа юм.

Тэгэхээр энэ ямар арга... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Нэрээ хэлээд хариулаарай.

И.Батхүү: М.Мандхай гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү

Тэгэхээр таны дурдсан бэлтгэл ажлын төлөвлөгөө, аж ахуйн нэгжүүдэд зориулсан дотоодын төлөвлөгөө боловсруулсан байгаа. Яг одоо энд би гартаа бариад байж байна.

11 бүлгээр 95 арга хэмжээг –

- ямар байгууллага үндсэн хариуцагч нь байх вэ,
- хамтран хариуцагч нь хэн байх вэ,
- ямар үр дүн гаргах вэ

гэдэг тал дээр эзэнтэй төлөвлөгөө гаргасан байгаа.

Энэ төлөвлөгөөнийхөө талаар боловсруулах явцдаа яг энэ Евразийн эдийн засгийн холбооны зах зээл рүү бодитой экспорт хийж үзсэн, худалдаа хийж үзсэн 70 аж ахуйн нэгжтэй нэг бүрчлэн саналыг нь авч тусгасан.

Ирэх нэг дэх өдрөөс ажлын хэсэг маань үргэлжилж ажиллаад эдгээр аж ахуйн нэгжүүдтэй гаргасан төлөвлөгөөгөө яаж ашиглах вэ гэдэг талаар үргэлжлүүлж ажиллана.

Түрүүн сайд дурдаж байсан. Эрхүү хотод болсон Бүс нутгийн хамтын ажиллагааны анхдугаар чуулга уулзалтын үеэр хэлэлцээний нөгөө талын холбогдох сайдтай уулзалт хийгээд хоёр талын хамтарсан төлөвлөгөө боловсруулаад хоёр улс... /минут дуусав/

Н.Учрал: Нэмж 1 минут тодруулъя.

И.Батхүү: Нөгөө талын, айлын талын холбогдох эрх бүхий байгууллагууд, гаалийн байгууллага, хорио цээрийн байгууллага, мал эмнэлгийн байгууллага гээд холбогдох бүх байгууллагатай яаж хамтарч ажиллах вэ гэдэг дээр хамтарсан төлөвлөгөө гаргуулахаар тохироод он гарангуут хоёр долоо хоног тутам

цахимаар айлын талтай энэ асуудлаа ярилцаж эзэнжүүлж хэрэгжүүлэхээр тохирсон байгаа.

Тэгэхээр энэ тал дээр бид арга хэмжээ аваад бэлдээд эхлүүлсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: М.Мандхай гишүүн ээ. Энэ хариу арга хэмжээ болон энэ гэрээний хэрэгжилт, үр дүнг хянах энэ ажил Засгийн газрын түвшинд төрийн байгууллага хооронд хийгдээд явна. Их Хурал бол энэ 5 орны парламентад ерөнхий хэлэлцээрийг нь соёрхон батлаад, тэгээд хэрэгжүүлэх үүрэг даалгавар нь Засгийн газар дээр ногдоод, тэр хүрээндээ бид гэрээний хэрэгжилт хангахын тулд төрийн байгууллага хоорондын гэрээ хэлэлцээрүүдээ хийгээд тэр тарифын болон бусад саад тотгороо арилгах, цэгцлэх, хил гаалийн нэг системээ уялдуулахаас авхуулаад олон зүйлүүд бид хийх ажлууд байгаа.

Б.Пүрэвдорж: Сүүлийн тодруулга. М.Мандхай гишүүн.

М.Мандхай: Яах вэ, ерөнхийдөө л тодорхой хариулт яг авч чадахгүй байна гэж харж байна л даа.

Тэгээд энэ дээр ер нь одоо энэ экспортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт, зөвшөөрөл гээд стандартыг босгыг давах өөрөө хугацаа их алддаг. Энэ хугацаанд зөрүүлээд импортоор орж ирж байгаа яг мөн адилхан хүнс болон эм гээд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд адилхан орж ирж байгаа.

Тэгэхээр айлын талаас орж ирэхэд манай өөрийн НӨАТ болон бусад босго шаардлага Оросын Холбооны Улс ч гэдэг юм уу, манайх 92.7 хувь нь Оросын холбооны зах зээл рүү экспортлох байгаа.

Тэгэхээр манай дотоодод орж ирсэн босго бага учраас импортын бизнесүүд дэх зах зах зээлийг хурдан хугацаанд эзлэх эрсдэл байгаа.

Тэгэхээр бид дотоодынхоо зах зээлийг хэрхэн хамгаалах вэ? Энэ төр хэлэлцээр хэрэв... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 367 бараа орж ирнэ. Үүний 230 төрлийн бараа нь хүнд аж үйлдвэрлэлийн бараа байгаа буюу манайд үйлдвэрлэдэггүй машин тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, эрчим хүчний тоног төхөөрөмж гээд ажлууд байна. Хүнсний 94 төрлийн бараа байна. Энэ мөн адилхан импортоос.

Өнөөдөр манай дотоод импортын хамаарал ихтэй болохоор инфляцад тодорхой хэмжээнд дандаа сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа бараануудыг оруулсан. Дотооддоо үйлдвэрлэдэггүй. Дотооддоо тарьдаг, ургуулдаг, үйлдвэрлэдэг бараануудаа бид хэлцлийн явцад нийт 23 төрлийн барааг гаргаж ирээд бид харилцан тохиролцсон.

Хөнгөн үйлдвэрийн буюу химийн үйлдвэрлэлийн 43 ширхэг бараа. Нөгөө тэсрэх бодис, бордоо, антибиотик, малын вакцин буюу манайд үйлдвэрлэл явуулахад гол орц болдог бараануудаа бид... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганмаа: Ер нь хэлэлцээрийг дэмжиж байгаа.

2018 онд баталсан Хүнсний баяжуулалтын хууль нөгөө суурь судалгаа, бүх судалгаануудыг хийхэд нэг хийгдсэн тэр ажлын нэг томоохон хэсэг нь 2017 онд одоо яг энэ Евразийн улс орнуудын бодлого гаргагч нар, парламентын гишүүд, эрдэмтэн судлаачид, профессоруудыг нэгтгээд Монголдоо би том хурал хэлэлцүүлгийг зохион байгуулж байсан юм.

Тэр үед яг энэ өвчлөлийн хувьд ч гэсэн зүрх судасны өвчлөл хамгийн өндөртэй, яг Монголтой адилхан байдаг юм билээ. Бусад Евразийн энэ саяын нэрлэгдсэн улс орнууд. Нас баралтын шалтгаантай, зохисгүй хоол гээд маш адилхан юмнууд ихтэй. Адилхан системтэй явж байсан ойролцоо эсгий туургатнууд гэж явж байсан улс орнууд ч энд байдаг учраас. Тэр утгаараа.

Тэгэхдээ энд тодруулахгүй бол зайлшгүй шаардлагатай гурван асуулт байна.

- ▷ **Нэгдүгээрт,** 367 нэр төрлийн бүтээгдэхүүн багтсаныгаа гурав ангилаад, тэр дотор нь химийн буюу “эрдсийн” гэж байсан тийм бүлэг байна. Түүн дотор яг чухалд тооцогдох витамин, вакцин, тэгээд шингэн антибиотик гээд ороод ирсэн байгаа.

Энэ хэлэлцээрийн дагуу эдгээр эм, эмнэлгийн бүтээгдэхүүнүүд нь гаалийн татварыг бүрэн тэглэх юм байна. Үүнтэй холбоотой жишээлбэл одоо бидний хэрэглээ заншсан харьцангуй өндөр стандарттай GMP³-тэй /Good Manufacturing Practice/, эмийн чанар сайтай Америк ч юм уу, Герман ч юм уу, Япон, Европын улс орнуудын импортолдог бусад ижил төрлийн эм. Энэ нь би ямар нөхцөл байдалд очих вэ? Давуу байдал болгох нь байна шүү дээ. Нөгөө Евразийн улсууд чинь. Тийм ээ. Өрсөлдөөний тэгш бус байдал бий болно.

³ Зохистой үйлдвэрлэлийн дадал.

Тэгэхээр өндөр чанарын хяналттай эмүүд нь зах зээлээс шахагдах уу, үгүй юу? Үүнтэй холбоотой тооцоо, тайлбар байсан уу, үгүй юу гэдэг нэг асуулт байна.

Мэдээж үүнийг дагаад дотоодын эм хангамжийн төрөл ч юм уу, тэр нь буурах уу, үгүй юу гэдэг бас нэг дагавар маягийн асуудал байна.

▷ **Хоёрдугаарт**, түрүүн би нэрлэж байсан энэ хүнсний баяжуулалттай холбоотой юм.

Бид нэлээн олон хүнсийг импортлох тухай ярьж байгаа. Тийм ээ. Энэ дээр. Тэгэнгүүт витамин D-ээр баяжуулсан сүүг жишээлбэл баяжуулаагүй сүүтэй харьцуулахад, эсвэл гурилын баяжуулалтыг бид хийсэн. Тийм үү.

Тэгэхээр баяжуулсан гурилыг баяжуулаагүй гурилтай импортын татвар нь ямар байх юм? Энэ хүнсний баяжуулалт гэдэг чинь өөрөө яг нөгөө тэгш бус байдлыг хамгийн хурдан арилгадаг. Хүүхдэд, жирэмсэн эхчүүдэд эрүүл саруул байх, боловсрол эзэмшүүлэх, тэгш байдлыг бууруулах хамгийн том хөрөнгө оруулалтын нэг учраас үүнийг чухалчлан асууж байна.

▷ **Гуравдугаарт**, тэр түлшний асуудлыг би дараагийн минут дээрээ асууя.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг хариулъя.

И.Батхүү: Д.Ганмаа гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Таны дурдаж асуусан тэр бүлэг бараа бол импортын одоо байгаа тариф нь 5 хувь байгаа.

Тэгэхээр дотоодын зах зээл дээр нийлүүлэгдэж байгаа эмийн өөрийнх нь үнэ тогтож байгаа хэлбэлзэлтэй харьцуулахад 5 хувь нь их бага дүн.

Тэгэхээр яг үнийн хямдралаас шалтгаалаад үүгээрээ дотоодын зах зээл өрсөлдөх чадвар дээр нөлөөлөл нь харьцангуй бага. Тэгээд эм, эмийн төрлийн бүтээгдэхүүн нь өөрөө тусгайлсан зөвшөөрлийг холбогдох яам, холбогдох агентлагуудаасаа давхар авч явдаг учраас энэ дээр харьцангуй гайгүй гэж хэлж болно.

Баяжуулах гурилтай холбоотой асуудал. Энэ хэлэлцээрт гурил нь угаасаа ороогүй байгаа. Тэгэхээр яг одоо байгаа зохицуулалтаар явна гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Д.Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Таны асуусан бүтээгдэхүүн гэнгүүт би гурван юм ярьсан. Тийм ээ. Эм, вакцин, тэгээд шингэн антибиотик буюу тэр антибиотикийг асууж байсан. Витаминуудтай холбоотой. Тэгээд дотоод биш. Эдийн засгийн хамтын улс орнууд байна шүү дээ. Тийм ээ. Харьцангуй чадалтай Герман ч гэдэг юм уу, яг эмийн чанараа хангадаг GMP-г авдаг тусгай pharmасороеia⁴-гаар яваад бусад бүх дэлхийн улс орон хуулж авдаг.

- ▷ **Нэгдүгээрт,** эдгээр улс орнуудын бидэнд оруулж ирж байсан зах зээлд ямар нэгэн байдлаар эрсдэл гарах вий дээ гэсэн асуудлыг асуугаад байгаа юм.
- ▷ **Хоёрдугаарт,** хүнсний баяжуулалт дээр зөвхөн гурил гэхээсээ илүү сүүн дээр ч юм уу, өндөг дээр ч юм уу, эд нар чинь бүгдэд нь баяжуулалт явж байгаа учраас энэ дээр ямар нэгэн туссан юм байгаа юу, эсвэл огт хамааралгүй байгаа юу? Энэ хэлэлцээртэй.

Бензинээ дараачийнх дээрээ л асуухаас.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг.

И.Батхүү: Таны дурдсан бүтээгдэхүүнүүдийн бусад төрлийн тавигдах шаардлагууд энэ хэлэлцээрийн хамрах цар хүрээнд байхгүй.

Тэгэхээр дотоодын тавьдаг мэргэжлийн байгууллагуудын хяналт зохицуулалт нь яг хэвээрээ үйлчилнэ гэсэн үг.

Тэгэхээр таны дурдаж байгаа барууны эмийн хяналт, шалгалт, зохицуулалт өндөртэй байгаа орнуудын эмийг илүү дотооддоо авч хэрэгжүүлэх талаар салбарынх нь бодлого нь угаасаа тэр чиглэлд явж байгаа гэж ойлгож байгаа. Чанартай, хямд эмийн нийлүүлэлтийг оруулж ирэх тэр тал дээрээ явж байгаа.

Түрүүчийн хэлсэн энэ БТКУС_[Барааг Тодорхойлох, Кодлох Уялдуулсан Систем] гэж ярьдаг. Олон улсын хэллэгийн HS (Harmonized System Code) гээд код 6 оронтой. Энэ гаалийн ангилал дээрээ байгаа юун дээр таны дурдсан тэр баяжуулсан гэдэг юмнууд маань гурилан дээр ороогүй байгаа.

Шингэрүүлсэн сүүн дээр түрүүн сайдын дурдсан хэлэлцээ хийх явцад хасуулах бараан дотроос тэрийг хасуулсан тийм тохиолдол байгаа. Энэ жагсаалтад оруулахгүй хассан тохиолдол байгаа.

Б.Пүрэвдорж: Д.Ганмаа гишүүн дахиад нэмж тодруулъя.

⁴ Эмийн стандарт, баталгаажсан найрлага, хэрэглээ, чанарын шалгуурыг агуулсан албан ёсны баримт бичиг.

Д.Ганмаа: Би стандартыг нь ойлгоод байна. Эм дээр. Миний асуугаад байгаа юм нь нэгнийх нь Евразиас орж ирж байгаа улс орнуудынхыг нь тэглэнэ шүү дээ. Тийм ээ. Импортын татвар нь. Нөгөөдөх нь тэглэгдээгүй байгаа.

Тэгэхээр гарааны гэдэг шиг тэгш бус байдал үүсээд байгаа учраас шахагдах вий дээ. Тэр хөгжилтэй сайн чанарын эмүүд. Энэ дээр тооцоолсон юм байгаа юу л гэдэг асуудал нь тодруулбал сайн байгаа юм.

Бас л эрүүл мэнд, нийгэмтэй холбоотой нэг асуудал нь тэр бензин байна. Тийм ээ. Бид орж ирэх гэж байгаа нефть, нефтийн бүтээгдэхүүн дээрээ Евро стандартын 5 ч юм уу, эсвэл евро 92-ыг илүү оруулах тал дээр энэ хэлэлцээр дээр ямар байдлаар тусгасан бэ? Зүгээр түргэн уншаад үзэхээр яг тэр нарийвчилсан стандартууд нь ороогүй юм шиг санагдаад байна л даа.

Тэгээд бид мэдэж байгаа шүү дээ. Нөгөө агаарын бохирдолд хамгийн их нөлөөлж байгаа. Тийм ээ. Түүнээсээ болоод эрүүл мэндэд давхар нөлөөлж байгаа нэг бодис маань тэр юм чинь.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Эм, эмнэлгийн хэрэгсэл дээр 5 хувийн хөнгөлөлтийг бид Евразийн эдийн засгийн холбооны орнуудад олгоно.

Тэгэхээр 5 хувийн нөлөөлөл зах зээл дээр нөлөөлөл үзүүлнэ л гэсэн үг. Түлш дээр мөн гаалийн 5 хувийн татвар тэглэгдэнэ. Ингэснээр бензин шатахууны үнэ хямдрах нэлээн боломж үүснэ. Нөгөө талаар А92 буюу энэ түлш зөвхөн Монгол Улсад зориулж Оросын Холбооны Улсад үйлдвэрлэж байгаа. Ганцхан газар л үйлдвэрлэж байгаа.

Оросын талд тавьж байгаа ер нь ойрын үед технологийн шинэчлэлүүд хийгдээд ер нь цаашдаа 92 биш 95 евро стандарт түвшин рүүгээ шилжилт хийж байгаа л гэж байгаа юм.

Нөгөө талаар манай дотоодын парк шинэчлэлт тасралтгүй тэр тал руугаа нэлээн тэмүүлж байгаа. Ингэснээр ер нь ирэх 5 жилийн дотор бид Евро стандартын шатахуун түлш рүү бүрэн шилжинэ. Гэрээн дээр... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэг зүйлийг нэмж хэлэхэд нь 3 жилийн өмнө байна уу, 4 жилийн өмнө Б.Чойжилсүрэн сайд Оросын Холбооны Улсад айлчилж тэр Ачинскийн нефть баазын нэг шугамыг нь 92 үйлдвэрлэхэд, өөрөөр хэлбэл Монголын шатахууны үнэ өсөх гээд байна, хэрэглэгчдэд дарамт болоод байна, евро шатахуун руу орох боломжгүй байна гэж хүсэлт тавиад тэгээд тэр шугамыг нь үлдээсэн юм.

92 бол зөвхөн Монголд л зориулж хямд үнэтэйгээр Оросын Холбооны Улс хийдэг ийм шатахуун шүү гэж тодруулж хэлье.

Чинбатын Номин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Номин: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Би энэ хэлэлцээрийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Манай Монгол Улс экспортын хувьд бараг 93 хувь нь нэг улсаас хамааралтай. Цаашлаад бүр нэг бүтээгдэхүүнээс хамааралтай.

Тэгээд энэ хэлэлцээр хийгдсэнээр бидний хувьд эдийн засгаа төрөлжүүлэх, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ олон улсад гаргах, экспортлох боломж нээгдэж байгаа. Боломж нээгдэж байгаа гэж харж байгаа.

Эндээс ингээд харахад 367 төрлийн бүтээгдэхүүнийг бид экспортлох юм байна гэж харагдаж байгаа. Бүр цаашлаад мах, арьс шир, ноос, ноолуур гэх мэтчилэн бүтээгдэхүүнүүд дээр 10-аас 15 хувь буурч байна.

Дахиад дээрээсээ томоохон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжүүдийг бид хямдралтай үнээр авах юм байна.

Дээрээс нь энэ ложистик стандартын хаалтууд болон хүндрэлтэй нөхцөлүүд буурах юм байна, багасах юм байна гэдэг зүйлүүд харагдаж байгаа. Эдгээр зүйлүүд бүгдээрээ боломж. Бид энэ боломжийг ашиглаж чадахгүй бол энэ зүгээр л алдагдсан боломж болоод өнгөрнө.

Олон улсын түвшинд орчин цагийн дипломат харилцаа бол дан ганц хоёр улсын хоорондох уулзалтаар зогсохгүй цаашлаад эдийн засгийн харилцаа болсон. Олон улсад шинэ цагийн дипломат харилцааг эдийн засгийн өгөөжөөр дүгнэдэг болсон.

Тэгэхээр эдгээр боломжуудыг үнэхээр бодит ажил хэрэг болгоход би Монгол Улсын Гадаад харилцааны яам, цаашлаад тухайн улс орнуудад байгаа Элчин сайдын яамдыг маш чухал үүрэгтэй гэж үзэж байгаа.

Дэлхийн улс орнууд өөрийнхөө Элчин сайдын яамдыг эдийн засгийн томоохон бааз, хүч суурь болгож олон улсад экспортоо нэмэгдүүлэх, худалдаагаа нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг татах энэ чиглэлд ашигладаг. Энэ чиглэлээр илүү “Кэй Пи Ай” үнэлгээ өгч тухайн албан хаагчдыг дүгнэдэг.

Сая үндсэн чиглэл буюу 2025-2030 оны үндсэн чиглэл дээр бас манай ажлын хэсгээс Гадаад хэргийн яаман дээр ийм чиглэлээр дүгнэдэг болохоор оруулж ирсэн байгаа гэж харж байгаа.

Тэгэхээр одоо миний асуух гээд байгаа гол зүйл юу вэ гэхээр манайд Гадаад харилцааны яамныхан энэ 367 бүтээгдэхүүнүүдээсээ энэ 5 оронд тэнд байгаа Элчин сайдын яамдаараа дамжуулан бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдээ дэмжиж,

- яаж бүтээгдэхүүнээ тухайн улсуудад таниулах гэж байгаа юм бэ?
- аль бүтээгдэхүүнүүдээр илүү тэр улсад орох гэж байгаа юм бэ?
- яаж худалдааг нэмэгдүүлэх гэж байгаа вэ?
- Ийм төлөвлөгөө гаргасан уу?

Хүнс, хөдөө аж ахуйн яам болон юу гэдэг юм? Эдийн засаг, хөгжлийн яам дотооддоо бүтээгдэхүүнээ бэлдээд байдаг юм байж. Харин яаж худалдааг нэмэгдүүлэх тал дээр гадаад харилцаа талдаа бид ямар ажлуудыг хийж байгаа вэ? Ямар төлөвлөгөө гаргасан бэ? Үүнийг мэдмээр байна. Ямар бүтээгдэхүүнүүдээр энэ улсуудыг penetration⁵ хийх буюу анх байрших гэж байгаа вэ?

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Гадаад яам байна уу? Алга байна уу?

Энд гэрээ байгуулах нь нэг хэрэг. Энэ боломжийг бүрэн ашиглах нь гол зорилт.

Энэ хүрээнд бид худалдаа идэвхжүүлэлтийн олон арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага үүснэ. Гадаад сурталчилгааны ажлыг нэлээн сайн хийнэ. Дипломат корпус, эдийн засгийн төлөөлөгч нарыг нэлээн идэвхжүүлнэ. Бусад гол чиглэсэн зах зээлдээ зориулсан үзэсгэлэн худалдаа, экспо, сурталчилгааны таниулах ажлуудыг Худалдаа, аж үйлдвэрийн танхим болон дэргэдэх олон салбарын холбоодтойгоо хамтарч зохион байгуулах, сурталчилгааны зах зээлд нэвтрэх томоохон маркетингийн ажлыг бид өрнүүлэх шаардлага үүснэ. Энэ түвшинд л ажиллана.

Энэ дээр бид Гадаад харилцааны яам энэ бодлогын хүрээнд бүрэн дэмжиж хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байгаа. Гол ачааллыг манай Хөдөө аж ахуйн яам хариуцна. Яагаад гэвэл гарч байгаа бүтээгдэхүүний 95 хувь, 97 хувь нь үндсэндээ хөдөө аж ахуйн гаралтай аж үйлдвэрлэлийн түүхий эд бүтээгдэхүүнүүд

⁵ Зах зээлийн нэвтрэлт.

байгаа. Тэнд тодорхой хэмжээний үзэсгэлэн худалдаа, экспо, сурталчилгааны зардлууд төсөв дээр нь сууж явдаг.

Тэгэхээр энэ зохион байгуулалттай арга хэмжээн дээр л Хөдөө аж ахуйн яам нэлээн идэвхтэй оролцох байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Чинбатын Номин гишүүн нэмж тодруулъя.

Ч.Номин: Засгийн газрын тухай хуулиараа Монгол Улсыг гадаадад төлөөлөх газар Гадаад харилцааны яам.

Миний голд тодорхойлж хэлээд байгаа зүйл бид Гадаад харилцааны яам маань гэрээ хэлэлцээр хийгдээд зогсдог биш цаашлаад яаж эдийн засгийн өгөөжийг. Ерөөсөө үр дүн юугаар тодорхойлогдох вэ гэхээр Монгол Улсынхаа иргэдэд ямар эдийн засгийн өгөөжийг энэ олон улсын хэлэлцээрээр дамжуулж бий болгож оруулж ирсэн бэ гэдэг л дүгнэлт шүү дээ.

Тэгэхээр уг нь энэ дээр цаашдаа Элчин сайдын яамдын ажлын үр дүн дээр оруулж ирж байгаа экспортын нийт хэмжээ, дээрээс нь татсан хөрөнгө оруулалтын нийт хэмжээ гэх мэтчилэн ийм бодитой үр дүнгээр дүгнэдэг байх хэрэгтэй.

Хөдөө аж ахуйн яам бүтээгдэхүүнээ бэлэн болгож болно. Олон улсын зах зээлд гаргаж таниулж борлуулна гэдэг чинь бэлэн болсон бүтээгдэхүүнийг хүмүүс шууд авна гэсэн зүйл биш шүү дээ.

Тухайн улс орныхоо байгууллагуудтай хамтарч ажиллана. Тухайн улс орондоо өөрийн улс орноо зөвөөр таниулна. Цаашлаад тухайн бүтээгдэхүүнүүдээ зөв сонгож, тухайн бүтээгдэхүүнээ зөв борлуулах асуудлууд гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр экспортыг нэмэгдүүлнэ гэдэг бол тусдаа... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Санал нэг байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Лувсанжамц: Зарчмын хувьд энэ хэлэлцээрийг дэмжиж байна.

Бид уул уурхайн бүтээгдэхүүнээс өөр бүтээгдэхүүнийг илүү экспортолдог болох хэрэгтэй байна. Үйлдвэржсэн улс болох хэрэгтэй. Тэр хэрээрээ ажлын байр нэмэгддэг, иргэдийн орлого сайжирдаг, хөдөө аж ахуйн салбар хөгждөг.

Нөгөө талдаа Засгийн газар үндэсний аж ахуйн нэгжээ, үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж хамгаалах ёстой. Тийм үүрэгтэй.

Евразийн эдийн засгийн холбооны энэ худалдааны хэлэлцээрийн агуулгаас доорх зүйлсийг тодруулъя.

- ▷ **Нэгдүгээрт**, мах, махан бүтээгдэхүүн зэрэг 367 нэр төрлийн барааг татваргүйгээр экспортлох боломж нээгдэх юм байна. Үүнийг үндэсний үйлдвэрлэгчид маань бодитоор ашиглаж чадах уу? Оросын Холбооны Улс Беларусь, Казахстан, Армен, Киргиз. Эдгээр 5 улсын стандартыг нь хангах чадамжийг нь үнэлсэн үү? Энэ бүтээгдэхүүний жагсаалтыг боловсруулахдаа үндэсний аж ахуйн нэгжийн оролцоог хэрхэн хангасан бэ?
- ▷ **Хоёрдугаарт**, махны экспортын квотын бодлого гэж байгаа. Цаашид энэ хэрхэн өөрчлөх талаар салбарын яамнаас нь байр суурийг мэдмээр байна.
- ▷ **Гуравдугаарт**, Гаалийн тухай хуулийн 29.1.10-д зааснаар итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүд энэ хэлэлцээрийг ашиглах боломжтой юм байна. Гаалийн цахим хуудаснаас харахаар үүнийг нь 2 хоногийн дотор олгодог гэж байна. Гэхдээ ажлын байрны шалгалт хийх зэрэг их олон шат дамжлагатай юм байна. Яг энэ 2 хоногтоо багтдаг уу? Одоогийн байдлаар хэдэн аж ахуйн нэгж энэ итгэмжлэлийг авч чадсан байгаа вэ?

Тараг, зөгийн бал, төмс, янжуур тамхи, саван, шампунь, дээрээс нь нэмээд цемент, хаалга, цонх зэрэг барилгын материалын бүтээгдэхүүнүүд энэ гаалийн татваргүйгээр хөнгөлөгдөж орж ирэх юм байна.

50 хувийн хөнгөлөлттэйгөөр бяслаг, тодорхой квоттойгоор өндөг, улаан буудай зэрэг дотоодод үйлдвэрлэх боломжтой бараанууд дээр импортын гаалийн татварын хөнгөлөлт үзүүлэх нь.

Үүнийг үндэсний үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварт хэрхэн нөлөөлөхийг яаж тооцсон бэ? Хүнсний хувьсгал, Хөгжлийн банкны зээл, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан гээд баялаг бүтээж байгаа энэ хүмүүсийг бид сүүлийн жилүүдэд дэмжиж ирсэн. Энэ бүтээгчдээ дэмжсэн бодлого энэ хэлэлцээр хэрхэн нөлөөлөхөөр байгаа вэ гэдгийг үнэлсэн үү?

Энэ холбооны 5 улстай хийж байгаа худалдааны алдагдал 97 хувьтай байгаа. Тэгээд цаашдаа бид 3, 6 жилийн хугацаанд алдагдлаа яаж буурахаар тооцож байгаа юм бол оо? Гэрээгээ дүгнэхдээ 3 жилийн дараа биш 1 юм уу, 2 жилээр дүгнээд Эдийн засгийн байнгын хороонд энэ хэлэлцээр хийсэн үр дүнг мэдээллийг нь хүргүүлж өгөх боломжтой юу?

Хамгийн сүүлийн асуулт. Татвараа хөнгөлж байгаа болохоор манай гаалийн орлого буурна байх. Энэ эрсдэлийг хэрхэн тооцож байгаа вэ?

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд ээ, нөгөө “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд нэлээн олон 100 тэрбум төгрөгийн дэмжлэгийг хүнсний салбарын компаниудад өгч байгаа. Үйлдвэрлэлийг нь дэмжиж байгаа. Энэ дэмжсэний хүрээн дээр экспортоо нэмэгдүүлнэ гэж байгаа. Энэ тал дээр нэмж тодруулаад хариулчхаарай.

Ж.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Үйлдвэрлэл ер нь нэмж байж л инфляц ч тэр, төгрөгийн худалдан авах чадвар ч тэр, олон юм үйлдвэрлэж байгаа улс орнууд л тогтвортой байгаад байгаа.

Бидний хамгийн том алдаа үйлдвэрлэлгүй цэвэр худалдаан дээр тулгуурласан эдийн засагтай яваад байгаа. Хэт хамааралтай байдал.

Энэ алхам их томоохон үүнийг өөрчлөхөд нэмэр болно. Ялангуяа манай уламжлалт хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг шинэ түвшинд гаргахад нэмэр болно.

Нийт 367 мөр шугам жагсаасан бараа байна.

➔ 97.5 хувь нь хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн байна.

- 29 мөр шугам жагсаасан мах, махан бүтээгдэхүүн байна.
- 60 мөр шугам жагсаасан арьс, ширэн бүтээгдэхүүн байна.
- 204 мөр шугам жагсаасан ноос, ноолуур бүтээгдэхүүн байна.

Бусад хайлуур жонш, давс... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут. Бусдад нь буюу жонш, давс, зэс гээд 9 бараа байна.

Ер нь нийт 99.1 хувь буюу 364 мөр барааг бид шууд 15-аас 50 хувийн татварыг нь тэглүүлж байгаа юм. Шууд үр дүн.

Тэгэхээр махан дээр ялангуяа та асуусан. Махан дээр манайх бэлэн байдал хадгалагдсан. Зах зээлийн эрэлт өндөр. Саяын уулзалтаар Орос Холбооны Улсын Шадар сайд жилдээ 50 мянган тонноос буулгахгүйгээр махны нийлүүлэлтийг тогтвортой хангаж өгөөч ээ гэж байна. Одоо бид 100-аад мянган тонныг хийж байна. 50 мянгыг бид дахин нэмж экспортлох бололцоотой байгаа. Ингэх юм бол одоо гарсан 300 сая долларын махны экспорт маань 500 хүртэл

сая долларыг бид манай мал аж ахуйн салбараас гаргах бололцоотой буюу зөвхөн махан дээр ерөнхийдөө ийм том орон зай нээгдэж байна.

Гэрээг яаж дүгнэх вэ гэдэг дээр жил болгон байнгын дүгнэлт хийгээд, хяналт хийгээд хэрэгжилт дээр явах ийм хамтарсан хороод ажиллаж эхэлнэ.

Гаалийн орлого... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя.

Ж.Энхбаяр: Гаалийн орлогод яаж нөлөөлөх вэ гэж байна.

Манайх энэ Евразийн эдийн засгийн холбооноос импортолж байгаа 367 бараа. Одоо яг орж ирэх бараа. Үүнд бид 109 сая ам.долларын чөлөөлөлт өгнө гэсэн үг. Евразийн эдийн засгийн холбоо 109 сая долларын боломж авна гэсэн үг.

Эсрэгээр нь харин бид 15-аас 50 хувь дээр манай орж байгаа орон зай боломж илүү нэмэгдэх болов уу гэж.

Нөгөө талаар бусад төрлийн манай үйлдвэрлэл явуулдаг гол түүхий эд, машин механизм, эрчим хүчний болон олон тоног төхөөрөмж суурь зардлууд хямдрах, инфляцад эерэгээр нөлөөлөх сайн тал гарч ирнэ.

Нөгөө талаар хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүн буюу хөнгөн үйлдвэрлэлийн салбар үндсэндээ энэ том өрсөлдөөнд орох бэлтгэлээ сая өнгөрсөн 2 жил нэлээн сайтар базаасан. Одоо ингээд энэ том зах зээлийн өрсөлдөөнд орно.

Бусад тоо, итгэмжлэгдсэн гаальтай холбоотой тэр... /минут дуусав/

Н.Учрал: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон. 3 дугаар микрофон. Алдар нэрээ хэлээд. 3 дугаар микрофон.

Г.Энхтайван: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван.

Гаалийн байгууллага худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам батлагдсан байгаа.

Энэ журам дээр бид бүгд ярьж байгаа. Итгэмжилсэн аж ахуйн нэгжийн журам. Энд өнөөдрийн байдлаар 6 аж ахуйн нэгж итгэмжлэл авсан байгаа. Үндэсний хэмжээнд. Анхны үйлдвэрлэгч анхны экспорт импортын компани

Эрдэнэт үйлдвэр. Сүүлдээ бид бүхэн “Тод оймс”, “Говь” компани гэх мэтчилэн үндэсний үйлдвэрүүдэд тодорхой экспортыг дэмжсэн бодлогоор эдгээр аж ахуйн нэгжүүдэд итгэмжлэл олгосон байгаа.

Итгэмжлэлийг бид бүхэн тухайн улс оронд хөнгөлөлт эдлэх журам нь тухайн улс оронтой харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсны үр дүнд хөнгөлөлт эдлэх боломжтой байдаг. /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минутаар тодруулъя.

Г.Энхтайван: Тэгэхээр бид энэ хэлэлцээрийн хүрээнд ямар ч аж ахуйн нэгжүүд энэ төрлийн бизнесийг эрхлэхэд тухайн улс оронд хөнгөлөлт эдлэх бүрэн боломжтой.

Дээрээс нь бид бүхэн харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг тухайн улсуудын гаалийн байгууллагатай нь байгуулсан бол бусад бараан дээр хөнгөлөлт эдлэх бүрэн боломж нээгдэх юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаагийн урилгаар Сүхбаатар дүүргийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. /алга ташив/

М.Бадамсүрэн сайд тодруулж хариулъя.

М.Бадамсүрэн: Махны экспортод квот хязгаарлалт тавихгүй байх бодлогыг цаашид хэрэгжүүлнэ. Яагаад гэвэл малчид мах үнэтэй байх, түүхий эд үнэтэй байх энэ боломжийг л бүрдүүлж өгөөч ээ. Бусад нь бид ажиллаж хөдөлмөрлөө гэдэг зүйлийг хэлж байгаа.

Тэгэхээр одоогийн үргэлжилж байгаа энэ бодлогыг цаашид үргэлжлүүлж ажиллах болно. Баярлалаа.

Н.Учрал: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Их том боломж нээгдэж байгаа юм байна.

Нөгөө талдаа итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүд 6-хан байгаа юм байна. Үүнийгээ бид бараг жилийн дотор 100 хувь хүргэнэ гэсэн зорилтуудаа тавих ёстой гэж бодож байна.

Гадаад хэргийн яам энэ дээр нягт хамтарч ажиллах ёстой. Бид Японтой эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээр хийгээд 10 жил болж байна. Худалдааны алдагдал нь 99 хувьтай байгаа. Үндэсний аж ахуйн нэгжүүд маань

экспортолж чадахгүй байгаа. Бүтээгдэхүүнээ сурталчилъя гэхээр Элчин сайдын яамд нь бүрэн дүүрэн ажилладаг эсэхийг сайн мэдэхгүй байна.

Тэгэхээр энэ зүйлүүд дээрээ аль аль яамд нь анхаараад явах ёстой гэж бодож байна.

М.Бадамсүрэн сайдад баярлалаа.

Экспорт хийх боломжийг нь нээж өгөөд махны үнэ өссөн болохоор экспортлохыг квот тогтоолоо гээд өөрсдийнхөө бодлогоос ухарсан шийдвэрүүд гаргаад байдаг зүйл сүүлийн жилүүдэд байсан болохоор үүнийгээ тууштай байгаасай гэж хүсэж байна.

Үндэсний аж ахуйн нэгжүүдийн оролцоог хэрхэн хангасан бэ гэдгийг манай Худалдаа үйлдвэрийн танхимаас хариулах болов уу.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Б.Лхагважав дарга хариулъя.

Б.Лхагважав: Асуудал бол энэ гэрээг соёрхон баталсны дараа Засгийн газар хооронд, танхим хоорондын техникийн асуудлууд яригдана.

Дараа нь аж ахуйн нэгжүүд өөрсдийн зах зээл дээр ажиллах нь тэр аж ахуйн нэгжүүдийн өөрсдийн ажил байгаа юм. Нэгдүгээрт.

Ерөнхийдөө би гаднын туршлагаас зах зээл рүү гарах дээр ялангуяа хүнс дээр брэнд бүтээгдэхүүнийг нэг нь нөгөөгөө дагаж гардаг тэр механизмыг би ашиглавал сайн болов уу гэж боддог юм. Одоо жишээ нь мах консервлосон бүтээгдэхүүн 18 хувийн татвартай байгаа шүү дээ. Оросын Холбооны Улс руу.

Тэгэхэд манай “Тайж трейд” гээд компани тасралтгүй сүүлийн хэдэн жил экспортыг хийж чадаж байгаа. Одоо бид нэг гарч чадсан тэр сувгаа ашиглаж бусад мах консервын компаниуд нэг шугамаар гарвал брэндийн талаасаа ч хэмнэлттэй, нэг болсон брэндээрээ бүрэн цаашаа... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Г.Лувсанжамц гишүүн нэмж тодруулъя.

Г.Лувсанжамц: Б.Лхагважав дарга аа, миний асуусан асуулт болохоор энэ 397 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн. Тийм ээ. Манайхаас гаргах.

Импортоор айлаас орж ирэх гэж байгаа бүтээгдэхүүнүүд. Үүнийг боловсруулахдаа үндэсний аж ахуйн нэгжүүдийнхээ оролцоог яаж хангасан бэ? Хэдэн аж ахуйн нэгжээс хэдэн удаа санал аваад, хэдэн удаа хэлэлцүүлэг хийгээд тэгж сайжруулсан гэсэн тийм агуулгыг асууж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Лхагважав: Нийт 7 удаагийн хэлэлцээ хийгдсэн. Ялангуяа өнгөрсөн 2024 оны 12 сарын 09-нөөс хойш нэлээн хурц асуудлууд тавигдаад энэ дээр дахин 3 том хэлэлцүүлэг явагдсан байгаа.

Тэр үедээ 400 аж ахуйн нэгжийг хамруулсан байгаа. Ялангуяа хүнснийхэн бүгд хамрагдаж, тэр 20 хэдэн бүтээгдэхүүний квот тогтоох нь дандаа манай хүнсний компаниудаас гарсан саналууд байгаа юм. Тэрийг тухайн үеийн яам, Тамгын газар үндэслэж хийгдсэн байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд нэмж тодруулъя.

Ж.Энхбаяр: Махны экспорт дээр сүүлийн жилүүдэд экспортыг нэмэгдүүлэх бодлогыг л авч явуулсан. Ямар нэгэн хязгаарлалтын бодлого яваагүй. Г.Лувсанжамц гишүүн ээ.

Бид үндсэндээ экспортыг 3 жилийн дотор бараг 20 дахин, сайн яривал 30 дахин нэмж чадсан.

Дэлхийн 17 оронд гарч байна. Өнөөдөр –

- Вьетнам,
- Ойрх Дорнод,
- Иран,
- Ирак,
- Сири,
- Азербайжан,
- Казакстан,
- Узбекистан –

гээд зах зээлийг сайн тэлсэн шүү.

Олон жил Монголын төр засаг мах гаргахыг мөрөөдөж байсан, хүсэж байсан.

10, 20 сая доллароос хэтэрч үзээгүй байхгүй юу. Одоо 300 сая доллароор тогтмол хийдэг болоод байна шүү дээ.

Одоо Оросын Холбооны Улс 50 мянгаас доошгүй авъя гэж байна. Манай махны экспорт 500 сая доллар луу очно. Энэ маань өөрөө нөгөө сүргийн бүтцийг цэгцлэх, бэлчээрийн даацыг тааруулах, мөн мал аж ахуйг хөгжүүлэх, нөгөө сонирхлыг, малчдын орлогыг дэмжих бодлого чинь л экспорт дээр л явж байгаа. Ийм ажлууд хийгдсэн.

Б.Пүрэвдорж: Тодорхой тоо хэлэх юм бол яг өнөөдрийн байдлаар Оросын Холбооны Улс –

- үхрийн махан дээр 50 хувийн татвар тавьж байгаа.
- адуу, хонь, ямааны махан дээр 18 хувийн татвар тавьж байгаа.

Энэ бүх зүйл чинь бүгдээрээ тэглэгдэнэ гэсэн үг.

Өөрөөр хэлбэл өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Бразил, Аргентин болон Австралиас импорт хийдэг тэр олон компаниудын лоббигоор манай татварыг ийм өндөр хэмжээнд болгож санкцын хэмжээнд аваачсан гэсэн үг.

Тийм учраас энэ хэлэлцээрийн хүрээнд манай уламжлалт махны зах зээл илүү сайн түвшинд хүрэх, өөрөөр хэлбэл тэр санитарно-ветеринарний⁶ ажлууд бүгдээрээ илүү хурдан шуурхай хийгдэх боломж нь бүрдэж байгаа гэдгийг хэлье.

Ингээд Далайн Батбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Батбаяр: Өдрийн мэндийг хүргэе.

Евразийн эдийн засгийн холбоо болон гишүүн орнуудтай хийх түр гэрээний талаар яригдаад нэгэнт жил болсон байна.

Л.Гантөмөр сайд Эдийн засаг, хөгжлийн сайд байхдаа энэ ажлыг анх эхлүүлсэн. Маш эрчтэй явж байна гэж харж байгаа. Бэлтгэл ажил ч гэсэн тодорхой түвшинд сайн хангагдаж байгаа байх гэж ойлгож байгаа. Үндсэндээ гуравхан жилийн хугацаатай. Тэгээд дотоодын зах зээл мөн гаднын 3 сая 500 хүнтэй зах зээлээсээ гадна 300 хүнтэй зах зээлд Монголын бизнес эрхлэгчид маань хэрхэн ажиллах вэ гэдэг энэ бэлтгэл ажлыг хийх ёстой байсан гэж би харж байгаа.

Монголын бизнес эрхлэгчид анх удаагаа тэгвэл Оросын Холбооны Улс, Казакстан гээд энэ 5 орны зах зээл дээр өрсөлдөх шаардлага гарч ирж байгаа.

Тэгэхээр харьяа байгууллагууд, Засгийн газрын харьяа байгууллагууд, Улсын Их Хурлын харьяа байгууллагуудын бэлтгэл ажлуудаа нэгэнт хангасан байх гэж би харж байна. Статистикийн газрууд жишээлбэл аль хэдийн мэдээллээ хангасан байгаа байх. Бизнесийн байгууллагуудад мэдээллээр хангах тэр боломжоо хангасан байгаа байх гэж би харж байна.

⁶ Ариун цэвэр-мал эмнэлгийн хяналт. Мал эрүүл байх (Ветеринар). Орчин цэвэр байх (Санитар)

Өнөөдөр Улаанбаатар хотод талх, нарийн боов үйлдвэрлэдэг компаниуд, жижиг аж ахуйн нэгжүүд хойшоогоо гараад Эрхүүд ямар хэмжээгээр савласан, ямар найрлагатай боов, боорцог, гурилан бүтээгдэхүүн нийлүүлэх вэ гэдэг дээр аль хэдийн мэдээллээ авах боломжтой болсон байх гэж би хараад байна.

Мөн түүнчлэн төмөр зам байна. Улаанбаатар хотоос, Дархан-Уул аймгаас хойшоогоо бүтээгдэхүүнүүдээ гаргалаа гэхэд ачих терминалууд, буулгах терминал, тээврийн асуудлууд нь шийдэгдэх гээд явж байгаа байх гэж харж байна. Гуравхан жилийн хугацаа чинь дороо өнгөрнө.

Мөн татварын бодлого байна. Яг энэ гэрээний хүрээнд энэ 5 улстай ямар нэгэн байдлаар бизнес хийсэн тохиолдолд орж байгаа орлого дээр нь ялгаатай бодлого, дэмжсэн бодлого хэрэгжих учиртай байх гэж харж байгаа.

Ингэж дэмжиж байж яг жинхэнэ үр ашиг нь аж ахуйн нэгжүүд дээр, иргэд дээр бууж байж энэ гэрээний жинхэнэ үр дүн гарна гэж харж байгаа.

Тэгэхээр Та бүхнийг бүтэн жил нэгэнтээ өнгөрсөн учраас бэлтгэл ажлаа хангасан байх гэж би найдаж байгаа юм. Тэгээд жилийн хугацаанд гишүүд маань бүгдээрээ судалсан байгаа учраас маш олон зүйлийг ерөнхийд нь асуулаа. Дурдагдаагүй байгаа хоёр зүйл дээр би ажлын хэсгийнхнээс асууя.

- ▷ **Нэгдүгээрт нь,** Реекспорт. Оросын Холбооны Улсаас, Казакстанаас бид бүтээгдэхүүн аваад, модон бүтээгдэхүүн юм уу, тамхи юм уу аваад үүнийгээ дэлхийн хамгийн том зах зээл Хятад руу гаргалаа гэхэд ямар нэгэн хязгаарлалт байгаа юу? Хэмжээний хувьд, татварын хувьд.
- ▷ **Хоёрдугаарт нь,** яг энэ 5 улстайгаа адилхан ижил төстэй бүтээгдэхүүнүүдийг бид борлуулдаг. Нэг ёсондоо энэ зах зээл дээр бид өрсөлдөгч нар болдог.

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут Д.Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Тэгээд ижил төстэй бүтээгдэхүүнийг бид бас экспортолдог. Жишээлбэл, нүүрс байгаа.

Тэгэхээр бид Хятад Улс руу нүүрс гаргалаа гэхэд Оросын Холбооны Улс бидний бизнесийн хувьд өрсөлдөгч болдог. Ямар нэгэн байдлаар нэг цонхны бодлогоор гэдэг юм уу, адилхан татвартай байна, адилхан хэмжээтэй байна, адилхан үнэтэй байна гэсэн гэрээгээр хүлээсэн үүрэг үүсэх үү? Хориглолтод орох уу гэдгийг ажлын хэсгийнхнийгээс асууя. Баярлалаа.

Н.Учрал: Эхлээд Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ 367 төрлийн бараанд уул уурхайн гаралтай бараан дотроос нүүрстэй холбоотой ямар нэгэн үүрэг хүлээсэн, зохицуулсан зүйлүүд байхгүй. Энд эрсдэл үүсэхгүй гэсэн үг.

Нөгөө талаас бусад 5 орны парламентаар энэ хэлэлцээр мөн хэлэлцэгдээд, батлагдаад, тэгээд харилцан солилцоод үндсэндээ 2026 оны 8 сард л үйл ажиллагаа эхлэх болов уу.

Энэ хугацаанд бид бэлтгэл ажлыг л хангах учиртай. Гэрээ соёрхон батлагдаагүй болохоор бид мэдээллийг нийгэмд хамаагүй гаргаж болохгүй байгаа. Хэрвээ өнөөдөр соёрхон батлагдсан нөхцөлд бид энэ 8 сар хүртэл бүхий л төрлийн бэлтгэл ажлыг хийнэ.

Юу хийх вэ гэдгийгээ тодорхойлсон. Гол одоо нөгөө Евразийн талтайгаа хийх ажлуудаа тодорхойлоод, ямар ямар зүйл дээр ямар хөнгөлөлт тариф, хорио цээр, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, нэвтрэх боомт, боомтын үйл ажиллагааг хялбаршуулах, горимоо уялдуулах, мэдээлэл солилцох гэх мэтийн хийх ажлууд үндсэндээ бэлдсэн байгаа.

Тэгэхээр улам шуурхай ажиллах цаг, боломж үүснэ.

Нөгөө талаар таны чухал санал дотооддоо бэлтгэл ажлыг, аж ахуйн нэгжүүдээ улам дэмжих бодлогыг, “Хүнсний хувьсгал”, “Цагаан Алт”-ыг үргэлжлүүлэх ёстой. Энэ хөтөлбөрүүд 2028 он хүртэл тууштай яваад, Евразийн гэрээн дээр үүсэж байгаа үр дагавар, боломжоо тулгуурлаад бид дэмжлэгийн бодлогыг заавал хийж, тохиргоо хийж, Их Хуралд танилцуулж явах учиртай.

Ялангуяа жил жилийнхээ төлөвлөгөөндөө нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил жилийн төлөвлөгөөндөө яг таны агуулгаар бодлогыг шигтгээд яваад байх хэрэгтэй байна.

Тэгээд бид үүнийг дээд зэргээр ашиглаж чадвал үнэхээр манай эдийн засгийн бүтэц ч тэр, аж ахуйн нэгжүүд томрох, тэгээд инфляц, төгрөгийн ханш, валютын нөөц гээд олон төрлийн эерэг үр дагаврууд үүснэ.

Реэкспорттой холбоотой манайхан мэдээлэл өгөөдхөөч.

Б.Пүрэвдорж: Индэрийн 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг

И.Батхүү: Д.Батбаяр гишүүний асуултад нэмэлтээр мэдээлэл өгье.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

Евразийн эдийн засгийн холбоотой хийж байгаа чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулсны нэг давуу тал нь барааны гарал үүслийг тооцохтой холбогдуулаад илүү боломжуудыг нээж өгсөн байгаа. Дотооддоо үйлдвэрлэж байгаа сав, баглаа боодлын тооцогдох хувь хэмжээ харьцангуй давуу талтай байгаа.

Дээр нь эдгээр улсуудаасаа орж ирсэн бараа, материалыг ашиглаад Монголдоо үйлдвэрлэл явуулаад буцаагаад эдгээр орнууд руу экспорт хийхэд Монголын талын гарал үүслээр тооцогдох нэг давуу тал байгаа.

Тэгээд дээр нь түрүүн дурдсан таны мод, модон материалтай холбоотой импортын асуудал дээр ямар нэг хориг саад байхгүй. Энэ хэлэлцээрийн агуулга нь хоёр талын хоорондын худалдааны асуудал байгаа. Транзит тээвэр бусад улс орнуудтай хийх худалдаанд ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээлт байхгүй байгаа.

Б.Пүрэвдорж: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Золжаргал: Энэ 3 жилийн хугацаатай гэрээний ерөөсөө бүр анхнаасаа л гол яригдаж байсан асуудал нь манайхны үйлдвэрлэлд эрсдэл учрах л асуудал байсан шүү дээ. Эрсдэл байна. Нөгөө талдаа бидэнд худалдааны орон зайг нэмэгдүүлж байгаа, экспорт нэмэгдэнэ гээд эерэг дүн нь бас байна. Давамгайлах юм л гэж дүгнэлт тайлбарлаад байгаа.

Тэгээд миний ойлгож байгаагаар худалдааны тэр эдийн засгийн ашгаасаа гадна олон улсын харилцагчдын тоог нэмэгдүүлэх бодлогын шийдэл байна. Түрүүн Ж.Энхбаяр сайд хэлсэн.

Тэгэхээр нэгэнт бодлого юм бол. Тэгвэл Монголоос гаргаж байгаа масс бүтээгдэхүүнийг. Одоо бид жижиг, дунд үйлдвэрлэл хэдийгээр өндөр эрсдэлтэй гэж үзсэн боловч бодлогын шийдвэр гаргаж байгаа учраас бодлогоор Та бүхэн аваач ээ гэдэг асуудлыг тавимаар байгаа юм.

Монголын масс бүтээгдэхүүнүүд юу байх вэ? Бид байгалийн эрдэс чулуу ихтэй газар, цементийн үйлдвэрлэл, базальт, циолет, ийм эрдсээс үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн яваандаа тэгээд төмрийн бэлдэц байна. Эд нар маш өндөр өрсөлдөх чадвартай, өртөг багатай, өндөр чанартай евро стандарттай.

Үүнийг хойш нь гаргах гэхээр лабораторийн, хил гаалийн процедур яриад ерөөсөө болдоггүй. Тийм хүнд суртлын юутай. Зүгээр техник стандартын юм шиг шалтгаанаар миний харж байгаагаар хориг тавиад байдаг.

Тэгэхээр энэ дээр Эдийн засаг, хөгжлийн яам, хариуцсан хүмүүс энэ дээр бүр ийм бодлого тавиад, бодлогоор хамтарч ажиллаж байгаа бол Та бүхэн энэ процедурыг судал.

Одоо Оросын Холбооны Улс жишээ нь Беларусаас, Казахстанас цемент аваад тэгээд л Европын хэсэгтээ хэрэглэхээд хөдөө аж ахуй, байсан Сибирь лүү зөөгөөд. Өнгөрсөн жил цементийн хэрэглээ нэлээн өндөр өссөн юм билээ.

Тэгэхээр энэ бүс нутагт нь ядаж ойрхон хажууд нь байгаа юман дээр Монголын бүтээгдэхүүнүүдийг оруул гэдэг ийм зүйлийг тавимаар байгаа юм. Ингэж байж л бодлогын хувьд жинхэнээсээ хэрэгжих байх.

Тэгэхээр ийм масс материал, барилгын материал, эрдэс чулуулгийн хийц, төмөрлөг, хар төмөрлөг. Энэ рүү ерөөсөө Монголчууд өөрсдийгөө голох хэрэггүй. Энэ тэртээ тэргүй –

- суурь нь бий болсон,
- хүчин чадал нь илүүдсэн,
- цаашдаа нэмэгдэнэ,
- технологи нь өндөр,
- өртөг нь бага,
- Оросын өөрсдийнх нь хамтарсан төмөр замтай.

Тэгээд бодлогоор хамтрах гээд байгаа бол үүнийгээ бас зөрүүлж оруулах. Тэгээд масс экспорт хийх нь манай үндсэн чиглэл байна гэж бодож байгаа юм.

Тэгээд ийм ажил хэрвээ энэ 3 жилд хийгдэхгүй бол цаашаа үргэлжлүүлэх нь ач холбогдолгүй гэж бодож байна. Зөвхөн жижиг дунд, хөнгөн үйлдвэрлэл, хүнсээр манай талд хүртэх ашиг нь урт хугацаандаа тийм өндөр биш л байх гэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Номтойбаяр: Энэ хэлэлцээр үндсэндээ энэ чинь 4 Засгийн газар.

Ч.Хүрэлбаатар сайд, Лу. Гантөмөр, Н.Учрал сайд, одоо Ж.Энхбаяр сайдын үед ирж байна.

Зарчмын хувьд дэмжиж байгаа. Бид ер нь аливаа ажил асуудлыг эхлэхдээ бэлтгэлээ их сайн базаадаг. Тэгээд би бэлтгэл хараахан сайн базаагдаагүй гэж үзэж байгаа.

Яагаад гэхээр манай нэгж бүтээгдэхүүний өртөг их өндөр. Өртөгт юу нөлөөлдөг вэ гэхээр татвар. Одоо ингээд 22 мянга, 23 мянган аж ахуйн нэгжийн дансыг хаасан. Төрийн сан нь үндсэндээ улайсан гэдэг мэдээлэлтэй.

Энэ нь үндсэндээ татварын буруу бодлого байгаа учраас л ийм асуудал байна л даа.

Товчхон дүгнэх юм бол бид чинь өөрөө өөрсдөө төр нь аж ахуйн нэгж хийж бүтээж байгаа улсууддаа хориг тавиад байдаг. Тэгээд уг нь асуулт маань Сангийн сайд Б.Жавхлангаас асуулт байгаа юм. Тэгээд харамсалтай нь алга.

Нэг талаараа маш гэгээлэг зүйл нь юу вэ гэхээр хүнс, хөдөө аж ахуйн салбарт томоохон эдийн засгийн эргэлт хийх маш том боломж. Үүнийгээ бид малгай бодлого болгож, үүнтэй уялдсан нэлээн томоохон эдийн засгийн болон нийгмийн реформыг төлөвлөх хэрэгтэй байна.

- Юунаас эхлэх вэ гэхээр “татварын бодлого”, дээрээс нь “стандарт”.

Монгол Улсад мөрдөгдөж байгаа нийтдээ 6800 орчим стандартын дийлэнх хувь нь Хүнс, хөдөө аж ахуйн салбарт харьяалагдаж байгаа. Гэтэл үүний 80 орчим хувь нь 1970, 1980-аад оны үеийн стандарт явагдаад байгаа юм.

→ Стандартын шинэчлэл хийгдэхгүйгээр бид гадаад улс орны зах зээлд өрсөлдөх хэмжээний бүтээгдэхүүн нийлүүлэлт хийж чадахгүй.

→ Стандартын шилжилт хийе гэхээр стандарт бусаас стандарт бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд санхүүгийн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байгаа юм. Үүнийг бид ерөөсөө ярихгүй байна.

→ Боловсон хүчний бодлого.

→ Өнөөдөр Хүнс, хөдөө аж ахуйн их сургууль, мөн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн чадамж, чансаа ямар байгаа билээ. Үндсэндээ төрийн бодлогоос орхигдсон байгаа. Бид чадварлаг боловсон хүчний үр дүнд л үндсэндээ чанартай өрсөлдөж чадах бүтээгдэхүүн л үйлдвэрлэнэ.

→ Дэд бүтцийн асуудал.

Ерөөсөө уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг дэмжсэн дэд бүтцийн бодлого бариад байдаг. Хүнс, хөдөө аж ахуйн яамтайгаа ерөөсөө уялдаж өгдөггүй.

Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих дэд бүтцийн бодлогыг бид шинэчилж харах хэрэгтэй. Сая 5 жилийн үндсэн төлөвлөгөө батлахдаа энэ талыг бид... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж авах юм уу? Нэмж 1 минут тодруулъя.

Н.Номтойбаяр: Тэгээд дэд бүтцээ бодох хэрэгтэй байна.

Сүүлд нь хэлэхэд санхүүгийн зардал маш өндөр. Банкны энэ арилжааныхаа зээлийн хүүг хар.

Гэх мэтчилэн цогц арга хэмжээ авмаар байна л даа.

Дээрээс нь нэг чухал зүйл энд юу вэ гэхээр одоо энэ Худалдаа, аж үйлдвэрийн танхимын шинэ ерөнхийлөгч Б.Лхагважав захирал томилогдсон юм байна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай холбоотой эрх зүйн орчныг бид эргэж харахгүй бол аливаа улс төрийн асуудал гараад ирэхээр танхимыг халхавч байдлаар ашигладгаа болимоор байна.

Энэ танхимын нэгдсэн бодлого, байр суурийг төр нь сонсдог, Засгийн газар нь хэрэгжүүлдэг, хамтарч ажилладаг, харилцан бие биеийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээдэг шинэ түвшинд авчрахгүй бол асуудал гарахаар л танхимыг ашигладаг байдлаа болимоор байгаа юм.

Нөгөө талдаа танхим ч гэсэн нэг иймэрхүү байдлаар улс төрийн дохио зангаагаар хөдөлдгөө болимоор байна. Тэгээд энэ дээр Б.Лхагважав... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Алдаржавхлан: Асуулт асуусан юм биш үү?

Б.Пүрэвдорж: Уучлаарай. Жадамбаагийн Энхбаяр гишүүн хариулъя.

Ж.Энхбаяр: Н.Номтойбаяр гишүүнтэй олон зүйл дээр санаа нийлж байна.

Үнэхээр нэг талдаа боломж нээгдэж байна. Нөгөө талдаа бид бэлэн байна уу. Бэлэн байхын тулд, энэ боломжийг ашиглахын тулд бид иж бүрэн цогц бодлогын арга хэмжээнүүдийг холбоотойгоор авч явах ёстой.

Тэр стандартаас авхуулаад. Бизнесийн өртөг, санхүүгийн үйлчилгээ гээд олон зүйлүүдийг энд ярьж болно.

Тэгэхээр удахгүй Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулаад дуусаж байна. Энд эдийн засаг дахь төрийн оролцоо, бизнест учирч байгаа гох дэгээнүүд, зөвшөөрлийн системүүд, олон асуудал тусгасан

хуулийн төслийг чуулган тарахаас өмнө бид өргөн барьж хэлэлцэх эсэхээ шийдүүлэхээр бэлдэж байна.

Тэгээд энэ хүрээнд өнгөрсөн 35 жилийн бизнесийн үйл ажиллагаагаа дүгнэж дараагийн шинэ түвшинд Монголын эдийн засгийг яаж хэрхэн тэлэх вэ, бизнесийг яаж дэмжих вэ, хувийн хэвшлээ яаж дэмжих вэ гэсэн эрх зүйн өөрчлөлтийг оруулж ирнэ.

Тэр үед таны ярьж байсан олон зүйлийг бид тусгаж оруулж ирнэ.

Б.Пүрэвдорж: Сангийн сайдаас Н.Номтойбаяр гишүүн тодруулж асууна.

Н.Номтойбаяр: Нэгж бүтээгдэхүүний өртөг зардалд хамгийн гол жин дарж байгаа зүйл юу вэ гэхээр татвар.

Яг үнэндээ Монголын төр хийж бүтээж байгаа аж ахуйн нэгж, хувийн иргэддээ бид чинь нэг ийм хориг тавьж байгаа юм шиг л ийм л бодлого л явуулаад байгаа шүү дээ. Одоо нөгөө татварын реформоо хэзээ оруулж ирэх юм бэ? Хэдэн жил дамнаад л ярилаа.

Тэгээд энэ аж ахуйн нэгж, компаниудын дансыг хааж байхаар бид энэ татварын реформынхоо асуудлуудыг яаралтай оруулж ирмээр байна шүү дээ.

Энэ ташрамд хэлэхэд тэр нэг Өршөөлийн тухай хууль гэдгийг дэмжиж болохгүй. Энэ “өршөөл” гэдэг үг, томъёолол нь өөрөө угаасаа буруу. Энэ эдийн засгийн алдаатай бодлогын үр дүнд л аж ахуйн нэгж компаниуд чинь татвараа төлж чадахгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр хохирлыг нь барагдуулах зарчмаар яримаар байна. Энэ дээр энэ Евразийн хэлэлцээрийг соёрхон батлахтай холбогдуулаад татварын ямар реформууд хийгдэх юм бэ? Тэгэхгүй бол бид гаднын зах зээл дээр өрсөлдөж чадахгүй. Өртөг зардал маань дэндүү өндөр. Энэ дээр байр суурийг нь нэг сонсмоор байна.

Б.Пүрэвдорж: Б.Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя.

Өршөөлийн татварын асуудлууд яригдаад байгаа. Энэ дээр арай болохгүй гэдэг дээр ийм байр суурь илэрхийлж байгаа гишүүнд баярлалаа. Талархлаа.

2015 онд хийгдсэн Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулиас болоод 2019 онд Монгол Улс хар жагсаалтад орсон. Энэ балаг нь одоо хүртэл арилаагүй байгаа.

1990 оноос бид татварын шинэ тогтолцоонд ороод 2015 онд буюу 25 жилийн дараа нэг ийм хууль гаргаад түүгээрээ 34 их наяд төгрөгийн далд татвар мэдүүлсэн байдаг юм. Хэд нь өршөөгдсөн нь нууцын нууц.

Авлигатай тэмцэх газар болон бусад хүчний байгууллагуудын хэрэг зөрчлүүдийн мөнгөний үзүүрээр нь барьж аваад л тэнд очоод л зогсдог. Маш олон хэрэг түвэгүүд. Үүнээс болж бид хар жагсаалтад орсон.

Энэ алдааг бид дахиж хэзээ ч давтаж болохгүй.

Тийм учраас татварын өршөөлийн хууль буюу үндсэндээ шударга татвар төлж байгаа аж ахуйн нэгж, иргэд нь... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минутаар тодруулъя.

Б.Жавхлан: Тэгье. Өршөөлийн хууль дээр ийм байр суурьтай байгаа. Санал нэг байна. Баярлалаа.

Татварын реформ хийгдэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан. 2026 оны төсвийг бид өнгөрсөн 9 сарын 01-нд өргөн барихтай зэрэгцээд багц хуулийнхаа өөрчлөлтийг d-parliament дээр тавиад хуулийн хугацаа нь дууссан. Энэ ондоо багтаад ирэх долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар өргөн барих асуудал Засгийн газар дээр шийдэгдээд өргөн барина.

Намрын чуулган, хаврын чуулган дамнаад бүгдээрээ татварынхаа реформыг олон нийтэд ил тод хэлэлцээд явна. Тийм. Тэр үед илүү их тодорхой детальчилж ярилцацгаая.

Б.Пүрэвдорж: Одоо Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Алдаржавхлан: Яах вэ, зарчмын хувьд дэмжиж байгаа. Хэлэлцээр ер нь хийгдээд явсан учраас. Гэхдээ болгоомжлох хэдэн зүйл байгаа юм.

Сая Эдийн засгийн сайд нэг ийм үг хэлж байна. Оросын Холбооны Улсаас 50 мянган тонн мах авахад бэлэн байгаа гэж байна.

→ Дотоодынхоо махны үйлдвэрлэл дээр энэ хэр яаж нөлөөлөх вэ?

→ Хэдэн жилийн дараа мах маш их хэмжээгээр Оросын Холбооны Улс руу гараад, тэгээд дотооддоо махаа олж чадахаа болиод ард түмэн бухимдах юм биш биз дээ?

- Жинхэнэ инфляц өсөх юм биш биз дээ?
- Энэ дээр манайхан тооцоолол, хамгаалалтыг юм бодож байгаа юу?

3 жилийн дараачийг бүтэн зураглалаар харж байгаа хүн байхгүй. 367 төрлийн бүтээгдэхүүн орж ирнэ. Гаалийн тарифгүйгээр.

- Монголын хүнсчид эд нартай өрсөлдөхөд бэлэн байгаа болов уу?
- Та юу гэж бодож байна?

Би өнөөдөр 2025 оны 12 сарын 11-ний өдрийн энэ үгийг протоколд оруулж байгаа шүү.

Монголчууд бид махаа гадагшаа чөлөөтэй гаргаад өөрсдийнхөө дотоодын хэрэглээн дээр хүнд байдалд орох юм биш биз дээ гэж байгаа юм.

Манай Ерөнхийлөгч чинь ковид үед нэг чухал үг хэлсэн шүү дээ.

Бид өөрсдөө л хүнсээ үйлдвэрлэх ёстой л гэж. Ямар ч үед. Тэгээд гаднаас ийм их олон төрлийн бүтээгдэхүүн гаалийн тарифгүй орж ирээд эцсийн байдал ямар үр дүнд хүрэх юм бол доо гэсэн болгоомжлол байна.

Хамгийн сүүлчийнх. Ж.Энхбаяр сайд аа. Хэрвээ нөхцөл байдал яг бидний хүссэн шиг болохгүй бол бид хэлэлцээрээс гарах тийм хугацаа, гарц байгаа юу гэж. Ийм гурван асуултыг асууя. Эхлээд.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулья.

Ж.Энхбаяр: Эрх зүйн хувьд бидэнд ямар хамгаалалттай арга хэмжээ хэрэгжүүлэх бололцоо байна вэ гэж.

Бид Дэлхийн худалдааны байгууллага гишүүн хорооны хувьд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрт заасан заалтын дагуу бид дотооддоо ард түмнийхээ эрүүл мэндийг хамгаалах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах хүрээнд тодорхой хязгаарлалт тогтоох хэрэгтэй.

Мөн үндэсний аюулгүй байдал хангах болон төлбөрийн тэнцлийг хамгаалах зорилгоор худалдааны хязгаарлалтуудыг тогтоох хэрэгтэй.

Дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учирсан, учирч болзошгүй гэж үзвэл хамгаалалтын арга хэмжээг авах, хэрэгжүүлэх ийм эрхүүд энэ дүрмээр олгогдсон гэрээнд туссан. Тэгээд гарах хэрэгтэй гэж үзвэл бид мэдэгдлээ өгнө. Түүнээс хойш тодорхой хугацаа өнгөрөөд бид гарна.

Тийм болохоор энэ 3 жил тун хариуцлагатай 3 жил. Бид өөрсдийгөө сорьж байна. Дээрээс нь уламжлалт зах зээлдээ эргэн очилтыг хийж байгаа. Энэ бололцоог бид ашиглана. Мэдээж гэрээ хоёр талын харилцан ашигтай байж гэрээ болдог. Тэр хүрээнд бидний зарим төрлийн бараан дээр дотоодын зах зээлд өрсөлдөөн нэмэгдэнэ. Нөгөө талаар хэрэглэгч энд хожно. Өрсөлдөөн нэмэгдэхийн хэмжээнд үнэ унах, сонголт нэмэгдэх том өргөн бололцоо байгаа.

Та махан дээр ярьж байна.

Өнөөдөр Монгол Улсын мал сүрэг бэлчээрийн даацаасаа 20-иос 25 сая тоо толгой хэлбэлзэлтэйгээр ачаалал нь нэмэгдээд яваад байгаа юм.

Монгол Улсын мал аж ахуйн талаар баримтлах бодлого бид үхэр, тэмээгээ өсгөх, нөгөө 3 төрлийнхөө малын тоог зохистой хэмжээнд шат дараатай буулгах шаардлага байгаа. Учир юу вэ гэвэл одоо байгаа тоо толгой бэлчээртээ ахадсан. Үүнийгээ дагаад мал аж ахуйн өгөөж буурч байгаа. Эрсдэл нэмэгдэж байгаа. Мал тарга тэвээрэг авах, нэг малаас авах ашиг шим тасралтгүй буурч байгаа ийм тоо гараад байгаа.

Сүүлийн 3 жил гэхэд мал давжаарах байдал хүчтэй явагдсан. Бод дээр ч тэр, бог дээр ч тэр жингийн давжааралт үүссэн.

Тэгэхээр үүнийг бид яаж шийдэх вэ гэвэл өнгөрсөн жилүүд болсон ган зудын асуудал бол үндсэндээ байгаль, цаг уурын бэрхшээлийг бэрхшээлийг нүүдлийн мал аж ахуй маань давж чадахгүй байна, эрсдэл өндөр байна.

Тэгээд үүнийг зохицуулах гол юм бол экспорт. Экспорт дээр бид зохистой тоон дээр экспортыг урамшуулаад, сүргийн бүтцээ зөв болгоод, тоогоо зөв зохистой бэлчээр даацад нь нийцүүлээд. Энэ хугацаандаа малынхаа ашиг шимийг сайжруулах, малын үржлийн болон мал эмнэлгийн бодлогоо хүчтэй явуулаад мал аж ахуйгаа сайжруулах бололцоо энэ экспортоор бүрдэнэ.

Оросын Холбооны Улсад нийлүүлэх 50 мянгаас доошгүй махыг жил болгон бид тогтвортойгоор авъя гэдэг санал их том бололцоо гэсэн үг.

50 мянган тонн мах гэдэг хонин толгойд шилжүүлэх юм бол 2.5 сая хонь, ямааг экспортод гаргаад байх боломж энэ худалдааны хэлэлцээрээр зөвхөн Оросын холбооны зах зээл гэхэд өсөж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ тоогоо, бэлчээрийн даацаа яг экологийн тэнцвэрт байдлаа хадгалаад л явна. Яагаад гэвэл мал аж ахуйн нөлөөлөлтэй холбоотой цөлжилтийн сөрөг нөлөөлөл их өндөр гараад, бүх гадна талын сигналууд ингэж гарч ирээд болохгүй байгаа юм. Малынхаа тоо толгойг зохицуул. Даац хэтрээд

байна. Нөгөө эдмэл сайтай ургамлын гарц чинь багасаад байна. Ургамлын бүрхэвч чинь багасаад байна гэдэг зүйл байгаа юм.

Тэгэхээр экспортын бодлогоор л зохицуулж байгаа.

Б.Пүрэвдорж: Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан: Ер нь ойлголоо. Хариултыг.

Гэхдээ Ж.Энхбаяр сайд аа, дотоодын махны үнэ чинь хэлбэлздэг.

→ Дотооны дотоодынхоо махны үнийг ер нь яаж хамгаалах вэ? 50 мянган тонн мах гарна гэдэг чинь Оросууд мэдээж үхэр голдуу л авах байх.

Тэгээд үхрийн махны олдоц багасаад дотоодын махны асуудал хүндрэх юм биш биз дээ? Энэ дээр яаж үнийн тарифын зохицуулалт хийх вэ? Инфляцад нөлөөлөх юм биш биз дээ л гээд байгаа юм.

Бидэнтэй худалдаа хийх гээд байгаа улсууд чинь доллартой орнууд биш шүү дээ. Ер нь олон улсын хоригт орсон орон байгаа. Беларус, Орос. Тэндээс дандаа бартераар л бүтээгдэхүүн орж ирэх байх.

Тийм учраас шууд тэндээс валютын эх үүсвэр нэмэгдэнэ гэхэд хэцүү болов уу л гэж би бодож байна. Тэр дотоодын махны үнийн зохицуулалт дээр хариулж өгөөч.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд асуултад хариулъя.

Ж.Энхбаяр: Мах буюу махны нөөцийн бодлогыг Засгийн газраас байнга авч хэрэгжүүлж байгаа. Нөөц бэлтгэх үүргийг орон нутгийн удирдлагууд өөр өөрийнхөө хэмжээнд зохион байгуулалтыг хангадаг. Эх үүсвэр нь улсын төсөвт нь суугаад явдаг болсон.

Жишээлбэл, 2026 оны хаврын үед нөөцийн махаар хэрэглээг хангах бодлогын үүднээс 8 мянга орчим тонн махыг нийслэл Улаанбаатар хотын төсөвт эх үүсвэрийг нь суулгаад нийслэл Улаанбаатар хот бэлдэж байгаа. Сүүлд авсан мэдээгээр нөөц бэлдэх ажил явж байна.

Энэ бол ингээд тогтвортой байдлаа. Бид ямар ч байсан ойрын 10 жилд Монгол Улсын мал сүрэг дотоодын махныхаа хэрэглээг хангалттай хангаад экспорт хийгээд байх чадавхтай. Өнөөдөр бид дэлхийд махны хэрэглээгээрээ нэгд яваа үндэстэн. Хамгийн их мах идэж хэрэглэж байгаа.

Б.Пүрэвдорж: Одоо Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улс Евразийн эдийн засгийн холбооны гишүүн улс орнуудтай худалдааны гэрээ хэлэлцээр байгуулах гэж байна. Үүгээр экспортыг нэмэгдүүлэх, бүс нутгийн интеграцад харилцан тэнцвэртэй оролцох талаар хэлэлцэж байгаа юм.

Хэрвээ энэхүү гэрээг бид соёрхон батлах юм бол одоо хөрш зэргэлдээ улс орныхоо 180 гаруй сая хүн амтай 5 улс орнуудтай ийм том зах зах зээл нээж байна л гэсэн үг. Үүгээр дамжиж Монгол Улс маш олон бүтээгдэхүүн экспортод гаргана. Мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуур, арьс шир.

Тэгээд хөрш улс орнуудаас ч гэсэн нөгөө талаасаа нэлээн их бүтээгдэхүүн орж ирж байгаа. Бас ижилхэн. Тоног төхөөрөмж, энэ модон эдлэл гээд л эхэлнэ. Гол нь бид энэ гэрээнээс нэг зорьж байгаа юм нь гадаад худалдааны тэнцэл маань ашигтай гарах хэрэгтэй. Үгүйдээ алдагдалгүй гарах хэрэгтэй гэдэг нь экспорт нь импортоосоо давах ёстой байхгүй юу. Монгол талаасаа. Үгүйдээ тэнцэх ёстой. Үүний төлөө л бид зорьж байгаа.

Үүний тулд энэ гэрээ хоёр зүйлийг тусгаж байгаа. Тарифын болон тарифын бус саад тотгорыг арилгасан буюу гадна талаасаа болохоор энэ олон татваруудыг бууруулж өгсөн. Хуучин 30, 40 хувийн татвартай байсан. Маш олон бүтээгдэхүүнүүдийг “тэг” болгож байгаа. 360 гаруй бүтээгдэхүүн дээр.

→ Тэгвэл тарифын бус саад тотгор дээр яаж ажиллах ёстой юм бэ?

Тэгэхээр тарифын бус саад гэхээр орон болгон өөр өөрийн гэсэн стандарттай байгаа. Энэ стандартыг хангах тухай л бид ярьж байгаа.

Тэгэхээр энэ стандартын тухай бидэнд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүд, өндөр эрсдэлтэй, бага эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүнүүд гээд техникийн үзүүлэлтийн ойлголтуудын талаар маш олон зүйлүүдийг энэ гэрээн дээр тусгаж өгсөн байгаа.

Хожмоо энэ гэрээ батлагдсаны дараа ч гэсэн маш олон компаниудын эрх ашиг яригдаад, тэр олон асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй болно.

Энэ үед өнөөдөр ажиллаж байгаа яам, агентлагуудын аль хэсэг дээрээ төвлөрүүлэх юм? Энэ олон аж ахуйн нэгжүүдийн олон асуудал, олон талт зүйлүүдийг бид шийдвэрлэх хэрэгтэй.

- ▶ Тэр аж ахуйн нэгжүүдийн эрх ашгийг хамгаалах хэрэгтэй.
- ▶ Техник, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.
- ▶ Тэр компаниудыг тэр улс орных нь стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх ёстой.

→ Энэ нэг агентлаг хэсэг нь манай дээр хаана зангидагдах юм бэ?

Үүнийгээ бид зангидаж, нэгтгэж харахгүй юм бол нэг мэдсэн чинь нөгөө асуудлууд нь талаар нэг тарж явчхаад худалдааны гэрээ хэлэлцээр маань алдагдалтай гарвал яах юм.

→ Энэ тал дээр манай яам, агентлагууд ер нь яаж ажиллаж байна вэ?

Энэ бол манай улсын хувьд маш том гэрээ л дээ. Үүгээр дамжиж манай Монгол Улсын уул уурхайн бус үйлдвэрлэл хөгжих, эдийн засгийн дараачийн түвшиндээ гарах ийм түүхэн боломжит гэрээ хийгдэж байгаа.

Тэгэхээр энэ үе дээрээ манай яам, агентлаг Засгийн газар маш ухаалаг...
/минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулъя. Одоохон. Байж байгаарай.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгын урилгаар Өмнөговь аймгийн Социал-демократ Монголын залуучуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд ажлын амжилт хүсье. /алга ташив/

Б.Пунсалмаа гишүүний асуултад Ж.Энхбаяр сайд хариулна.

Ж.Энхбаяр: Б.Пунсалмаа гишүүнтэй санал нэг байна.

Үнэхээр Монголын үндэсний үйлдвэрлэлд томоохон боломж том зах зээл нээгдэнэ.

Бидний зорилго худалдаанд учирч байгаа тэнцлийг нөхөх, аль ашигтай худалдаа руу тэмүүлнэ. Стандарт, техникийн шаардлага гээд 40 гаруй техникийн шаардлага, стандартын ажлууд байгаа.

- Гаалийн байгууллага хооронд.

Гаалийн бүрдүүлэлт, боомт нэвтрэх горимыг уялдуулах, мэдээлэл солилцохоос авхуулаад.

- Чанар стандартын байгууллага хооронд.
- Мал эмнэлгийн байгууллага хооронд.
- Ургамал хамгааллын байгууллага хооронд.

Ийм олон зохицуулалтуудыг энэ хугацаанд бид хийх ёстой.

Хамгийн сайн зүйл нь хэлэлцээрт оролцож байгаа нөгөө тал өөрөө энд маш өндөр ач холбогдол өгч, дотоод зохион байгуулалт, төрийн байгууллагуудаа өгөөд явж байгаа.

- ▶ Шадар сайдын түвшинд хоёр талаасаа хийх ажлуудаа тохирсон.
- ▶ Хаана аль байгууллага юу хийх вэ гэдгээ тохирсон.
- ▶ Хаана ямар хүндрэл гарч байна гэдэг дээр зураг авалтуудыг хийгээд, түүнийгээ хоёр талаасаа шийдвэрлэе гэж тохирсон.

Хоёр улсын төрийн тэргүүний өндөр дээд түвшинд тохиролцсон төрийн айлчлалын хүрээнд Худалдаа, эдийн засгийн яамтай хөгжүүлэх тэр хүрээнд ажлууд эхэлж байна.

Сая би Оросын Холбооны Улстай бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх яг энэ бодлогын хүрээнд бид бас яг энэ гаалийн болон бусад тариф, тарифын бус хориг саадыг хэрхэн арилгах вэ гэдэг чиглэл дээр ажлуудаа хоёр талаас ойлголцолд хүрсэн.

Үндсэндээ хийх юмаа бид тодорхойлсон. Одоо хууль соёрхон батлагдлаа л бол бид ажилдаа орно. Засгийн газар зохион байгуулалтынхаа арга хэмжээг авна. Холбогдох яам, газрууд, агентлагуудад үүрэг даалгаврууд өгөгдөнө.

Ингээд 8 сар гэхэд хэлэлцээр хэрэгжихэд Монгол Улс бэлэн болсон байх ёстой. Ийм л томоохон хүрээг хамарч ажлыг зохион байгуулалт эхэлнэ.

Тэгээд хаана зангигдах вэ гээд асуудлууд байгаа. Худалдааны хуулийг яаралтай оруулж ирэх зайлшгүй шаардлага үүсэж байгаа.

Худалдаа өнөөдөр тодорхойгүй. Монгол Улс худалдааны хуульгүй. Худалдааны эрх зүйн зохицуулалтгүй яваад байгаа. Худалдаан дээр ялангуяа нэг цонхны бодлого баримтлах зүйл. Олон зүйл дээр бид анзаарагдаж байгаа.

Үүнийг хаврын чуулган гэхэд бид бэлдэж оруулах зорилготой ажиллана. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалан: Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум доллар байгаа. Үүний 93 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн, 7-хон хувь нь уул уурхайн бус бүтээгдэхүүн байгаа нь манай эдийн засгийн гол сорилт болоод байна.

Цаашид бид энэ уул уурхайн бус экспортыг яаж дэмжих вэ, яаж эдийн засгаа тэлэх вэ гэдэг сорилт бидний өмнө зүй ёсоор тулгарч байгаа.

Тийм ч учраас олон улсын зах зээлийг эрэлхийлэх, шинэ зах зээлүүдийг нээх явдал яах аргагүй чухал.

Нөгөө талаасаа Евразийн эдийн засгийн холбоотой түр хэлэлцээр байгуулах асуудал дээр би өмнө нь ч гэсэн энэ асуудал анх орж ирэхэд удаа дараа болгоомжлонгуй байр суурийг илэрхийлж байсан. Яагаад вэ гэхээр яах аргагүй геополитикийн хувьд онцлог нөхцөл байдалтай байгаа.

Тэр утгаараа энэ түр хэлэлцээр цагаа олсон уу, үгүй юу гэдэг асуудал зайлшгүй тулгарч байгаа. Анх энэ асуудал оны эхээр орж ирсэн байгаа. Тэгээд тэр цаг хугацаанд миний хувьд ямар байр суурийг илэрхийлж байсан бэ гэхээр нэгэнтээ хэлэлцээр хийхийг зориод явж байгаа бол бэлтгэл ажлуудаа маш сайн хийх хэрэгтэй.

Бэлтгэл ажлууд гэдэг нь –

- ▶ **Нэгдүгээрт**, дотоодын аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр сайн хангах ёстой.
- ▶ **Хоёрдугаарт**, тээвэр ложистикийн дэд бүтэц.
- ▶ **Гуравдугаарт**, экспортод бараа нийлүүлэх чадавхыг эзэмшүүлэх хэрэгтэй.

Тэр чиглэлээр бэлтгэл ажлаа маш эрт хийж эхлэхгүй бол энэ чинь гуравхан жилийн түр хэлэлцээр байгаа.

Тэр хугацаанд бид хил нээгдлээ л бол асуудлуудаа шийдсэн. Шууд бараагаа экспортод гаргаж байх ийм нөхцөл байдалтай болох ёстой л гэдгийг тухайн үед нэлээн их хэлсэн.

Тэгсэн чинь сая яригдаж байгаа зүйлүүд дээр бас ийм ирээдүй цаг дээр яриад байна. Их Хурал, Засгийн газарт хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг аль хавар олгосон байгаа шүү дээ. Тийм ээ. Гарын үсэг зурагдсан. Өнөөдөр соёрхон батлах шат явж байна.

Тэгээд ийм ирээдүй цаг дээр яриад баймааргүй байна. Бэлтгэл ажлууд чинь маш их цаг хугацаа авна. Тэгээд иргэдийг, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангах явдал маш дутмаг байдаг.

Тийм ч учраас бид анх Японтой хэлэлцээр байгуулах үед энэ дээр маш их алдаанууд гарч байсан. Тэрийг ч гэсэн тухайн үед хавар нэлээн ярьсан.

Тэгэхээр бэлтгэл ажлын хүрээнд нэн ялангуяа аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангах, өрсөлдөөнд бэлтгэх, тэр экспорт руу чиглэсэн зүйл дээр Худалдаа, аж үйлдвэрийн танхим юу хийж байгаа вэ?

Төрөөс яг ямар арга хэмжээ авч байгаа вэ? Яг өнөөг хүртэл хийсэн ажлаа яримаар байна. Ирээдүй цаг дээр биш. Тэр хавраас хойш ер нь Та бүхэн ямар ажил хийсэн бэ гэдгээ яримаар байна. Тэгээд Б.Лхагважав Ерөнхийлөгч... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч Б.Лхагважав.

Б.Лхагважав: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя.

Мэдээллийн асуудлаар хэд хэдэн үе шаттай арга хэмжээнүүд тавигдсан байгаа. Энд танхим ба Эдийн засаг, хөгжлийн яам нийтдээ ойрын хугацаанд хийгдэх 8 зүйлийн мэдээллийн асуудал байгаа. Энэ шат дараалалтай программ гаргасан байгаа.

Энэ дээр би нэмээд нэг зүйл хэлье. Гишүүний тавьж байгаа асуудал зөв л дөө.

Манайх Японтой эдийн засгийн түншлэлийн гэрээ хийсэн. 10 жил болж байгаа.

Тэгээд сая Төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлийн форум Японд хийгдсэн. Тэгэхэд бид өөрсдөө энэ бий болсон гэрээгээ ашиглах тэр менежментийн асуудал нь өөрөө их дутуу байсан. 10 жилийн өмнө яг гэрээ байгуулагдахад би өөрөө тэнд байж таарч байсан. Тэгэхэд тэр үеийн 40 япон мэргэжилтэн одоо 40-үүлээ байж байгаа. Тэгэхэд манай Гадаад хэрэг, худалдааны яаман дээр тэр үед 20 хүн бэлдсэн. Өнөөдөр нэг ч хүн нь байхгүй байгаа.

Тэгээд өнөөдөр Япон, Монголын түншлэлийн гэрээн дээр хариуцсан мэргэжилтэн, төрийн тасралтгүй институт ажиллах тэр процесс байхгүй болсон. Манай танхим дээр энэ гэрээн дээр аль алин дээр нь яг өөрсдийн талаасаа үйлчилгээний хэсгүүд оролцдог. Зарим бүлэг хэсэгт. Тэр бол манай танхим дээр тасралтгүй явагдаж байгаа. Тийм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Б.Жаргалан гишүүн нэмж тодруулъя.

Б.Жаргалан: Тэгэхээр ирээдүй цаг дээр ярих биш яг одоогоос авхуулаад иргэдээ мэдээлэлжүүлэх, аж ахуйн нэгжүүддээ мэдээлэл хүргэх, чадавхжуулах энэ ажлыг манай танхим бөгөөд бусад бизнесийн холбоодууд маш сайн ажиллах хэрэгтэй байна.

Эс бөгөөс бид бэлтгэлгүй сууж байгаад нөгөө 3 жилийнхээ хугацааг өнгөрөөгөөд дахиад яг нөгөө Япон шиг юм болох магадлалтай гэж хараад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр маш яаралтай л зохион байгуулалтад орох хэрэгтэй харагдаж байна даа. Ж.Энхбаяр сайд аа.

Энэ ташрамд бас нэг зүйлийг хэлэх гэж байгаа нь Европын Холбоотой манайх **GSP+ Plus**⁷ (Generalised Scheme of Preferences Plus) гээд хөнгөлөлттэй тарифын хэлэлцээртэй байгаа. Зарим барааны зүйл анги дээр хэлэлцээрийн хугацаа дуусаж байгаа гэсэн ойлголттой байгаа. Энэ тал дээр ямар ажлууд хийгдэж байгаа вэ гэдэг нэг асуулт байна.

Тэгээд Европын холбоо руу ч гэсэн бид уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх тал дээр маш их анхааралтай ажиллах хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээр байгаа зурагдсан... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Б.Лхагважав дарга.

Б.Лхагважав: Тэр үед 7200 бараа, бүтээгдэхүүний бизнес хийж байсан. Гэхдээ яг тэр үеийн цаг хугацаанд манай аж ахуйн нэгжүүд Европын стандартыг хангах тийм бараа, материал үйлдвэрлэх бололцоо бага байсан юм.

Одоо үүнийг манайх ялангуяа тэр ноолуур, арьс шир, зарим нэг төрлөөрөө хангаж байгаа юм. Жишээ нь, сая Итали Улсад хийсэн айлчлал. Итали Улстай хийж байгаа худалдааны харилцаа ер нь 60:40 байгаа шүү дээ. Энэ маш амжилттай явагдаж байгаа. Энэ бол манай ноолуур, арьс ширэн дээр байгаа юм шүү.

Гэхдээ бидний өөрийн бэлтгэл талаасаа манай аж ахуйн нэгжүүд тэнхрэх. Ялангуяа түрүүн хэд хэдэн гишүүний тавьж байсан татварын бодлогоор, төрийн бодлогоуд байх ёстой.

Нөгөө талаас энэ гэрээ үзэглэлээ гэхэд миний танхимын Ерөнхийлөгчйн хувьд хамгийн их айж байгаа асуудал нөгөө санхүүгийн төлбөр тооцооны асуудал

⁷ Тарифын хөнгөлөлт үзүүлэх ерөнхий систем.

байгаа. Энэ гэрээнд тусгаагүй. Өнөөдөр яг энэ улсуудтай, ялангуяа Оросын Холбооны Улстай санхүүгийн төлбөр тооцооны асуудлыг Монгол... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Д.Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Энэ хэлэлцээрийн асуудлыг оны эхэнд хэлэлцэж байсан. Тэгээд тэр үед аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл уулзаж санаа бодлоо илэрхийлж байсан.

Тэгэхээр “Хүнсний хувьсгал” гээд зарим нэг чухал хүнсний бүтээгдэхүүнүүдээ өөрсдөө хийдэг болъё гэдэг бодлогоор дэмжиж байгаа. Аж ахуйн нэгжүүд ч олон зээл авсан. Тэгээд үйлдвэрүүдээ дөнгөж нээж байгаа. Тэгээд яах вэ, одоо яг энэ аж ахуйн нэгжүүдийн хувьд бас дахиад эрсдэлтэй хэвээрээ байна гэсэн асуудлууд байна л даа.

Тэгэхээр Ж.Энхбаяр сайдаас “Хүнсний хувьсгал”-д хамрагдаад том зээл авсан аж ахуйн нэгжүүд.

- ▷ **Нэгдүгээрт,** ямар ямар аж ахуйн нэгжүүдийн хувьд нэлээн эрсдэлтэй дүр зурагтай, илүү өрсөлдөөний орчинд орохоор байна. Тэр талаар нэг мэдээлэл хийж өгөөч.
- ▷ **Хоёрдугаарт нь,** гол экспортын бүтээгдэхүүн мах, махан бүтээгдэхүүн байгаа.

Тэгэхээр Оросын Холбооны Улсад ямар хэмжээний үнийн дүнгээр мах, махан бүтээгдэхүүн экспортолж байна. 3 жилийн дараа гэхэд хэдийг экспортолдог болохоор байгаа тоог зүгээр Та протоколд үлдээх үүднээс багцаа тоо хэлж өгөөч?

Дээр нь мах, махан бүтээгдэхүүн дээр хорио цээртэй холбоотой бэлтгэл ажлууд нэлээн байгаа.

Тэгэхээр манай талаас шууд гэрээ соёрхон батлагдахаар экспортолно гэж хүмүүс бодож байж магадгүй.

Тэгэхээр хорио цээртэй холбогдолтой ямар ямар бэлтгэл ажлууд бид хийх ёстой вэ? Тэр нь ямар хугацаанд хийхээр төлөвлөж байгаа вэ? Энэ талаар мэдээлэл өгөөч.

- ▷ **Гуравдугаарт нь,** түрүүн Б.Лхагважав ерөнхийлөгчийн ярьсан төлбөр тооцоотой холбоотой асуудал байгаа юм. Бид бензин, шатахууныхаа төлбөрийг арай гэж зохицуулалт хийж байгаа.

Цаашдаа худалдаа хийхээр аж ахуйн нэгжүүд маань төлбөр тооцоогоо яаж авахаар төлөвлөж, төсөөлж байгаа вэ? Энэ талаар мэдээлэл өгөөч? Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Бид энэ хэлэлцээртэй холбоотойгоор хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар дотоодод хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн үр дүнг унагаахгүй үүднээс бид 23 нэр төрлийн бараан дээр асуудал тавьж маргаан үүсгэсэн.

Тэгээд хэлэлцээрийн явцад 8 нэр төрлийн бараан дээрээ бид хэлэлцээрээс хасуулсан. Энэ маань бидний дотооддоо хийж байсан “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд байсан дотооддоо тарьдаг, ургуулдаг, үйлдвэрлэж байгаа шингэн сүү, өтгөрүүлсэн сүү, шар сүү, цөцгий, даршилсан ногоо, сонгино, төмс, лууван, манжин гэх мэтийн 8 бараагаа хасуулсан.

11 бараан дээр нь харилцан буулт хийсэн.

Жишээлбэл, нэлээн асуудал болж байсан дотоодын нийт хэрэглээний 90 хувь хүртэл хангаж байгаа “өндөг” дээр бид 90 сая ширхэг хүртэл квоттойгоор нэвтрүүлэх, бусад нь татварын босготой, хязгаарлалттай байхаар тохирсон. Үүнийгээ хийхийн тулд өндөг үйлдвэрлэгчдийн холбоотойгоо хамтарч бид хамт бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хатуу, зөөлөн улаан буудайн дээр жилдээ 50 мянган тонн хүртэл квот авна. Бусдыг тарифын татварын хязгаарлалттайгаар нэвтрүүлнэ гэдэг дээрээ тохирч бас тодорхой хэмжээний буултууд хийгдсэн.

Шар айраг дээр манайх 25 хувийн татварын босготой. Энэ дээрээ тохиролцоод бид 18.75 дээр тохирсон.

Архи дээр 40 хувийн босгыг бид 30 хувь болгож тодорхой хэмжээнд буулт хийж тохирсон.

Тохирч чадаагүй 4 бараа үлдсэн.

- Йогурт,
- амтат жигнэмэг,
- өрмөнцөр,
- эрдэст ус –

-гэсэн 4 төрөл дээр бид хамгаалах ажил. Үүнийг чадаагүй буюу “тэг” татвартайгаар Монгол Улсад нэвтрэхээр болсон.

Ийм мэтээр үндсэндээ гол ажлуудынхаа ард гарсан. “Хүнсний хувьсгал”, “Атрын IV”, “Цагаан Алт” аяны хүрээнд хийгдэж байгаа, дэмжиж байгаа салбаруудаа хамгаалалтаа хийсэн. Хамгаалалтынх нь зохицуулалт дээр нэр тохирсон. Жишээлбэл, гишүүд хөндөөд байгаа тамхины асуудал дээр гэхэд бид онцгой албан татвараараа дотоод зохицуулалтаа хийнэ гэдэг зүйлүүд байгаа.

Нөгөө талаас Дэлхийн худалдааны байгууллагын дүрмийн дагуу бид хамгаалалтын арга хэмжээнд авах эрхээ харилцан тохиролцсон.

Бидэнд боломж их гарах байх л гэж байна. Илүү. Яагаад гэвэл энэ нийт гарч байгаа барааны 95 хувь нь, бараг 97 хувь нь хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт байгаа.

Энэ хэрэгжүүлсэн том бодлого, хөтөлбөрийнхөө үр дүнг л зах зээлд сорино л гэсэн үг шүү дээ буюу бидэнд байгаа түүхий эд нь хямд байгаа. Бидний үйлдвэрлэж байгаа манай аж үйлдвэрлэлийн гол суурь болсон хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарынхаа бүтээгдэхүүний зах зээлийг тэлнэ гэдэг л бодлого.

Мах, махан бүтээгдэхүүн дээр ямар нэгэн чанар стандартын хүндрэл үүсэхгүй. Хорио цээрийн хэлэлцээрүүд, протоколуудыг үндсэндээ байгуулсан. Хоёр талын эрх бүхий байгууллагууд юу юу ярихаа нэлээн сайн тохирсон. Ялангуяа мал эмнэлгийн байгууллага хооронд харилцаа их сайн. Ургамал хамгааллын байгууллага хоорондын харилцаанууд, гэрээнүүд үндсэндээ хийгдсэн. Хийх ажлууд нь нэлээн тохирсон. Ялангуяа мал, махны экспортоор вакцинжуулалтын ажил их чухал.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд мал эмнэлгийн салбарт Их Хурлаас дэмжлэг үзүүлсэн үр дүнд бидний нөгөө вакцинжуулалтын хүрээ, тоо нэлээн сайн нэмэгдсэн. Энэ маань өөрөө экспортыг өдөөх гол суурь болсон. Энэ бодлогоо бид үргэлжлүүлээд явахад боломж нэлээн өндөр байна.

Тэгээд мах, махан бүтээгдэхүүний экспортын тоог хэлээдхээрэй. Саяын уулзалтаар 50 мянган тонныг нэмж байнга урт хугацаанд гэрээ хийж, тогтмол нийлүүлэлтийг авах бололцоотой байна. Шаардлагатай байна. Дотоодын хэрэглээ үүсэж байна гэдгээ Оросын Холбооны Улсын тал мэдэгдэж байна лээ.

Төлбөртэй холбоотой. 1 минут нэмээд авъя.

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж өгье.

Ж.Энхбаяр: Гэрээ бол 367 бараан дээрээ л тохиролт хийсэн. Ямар нэгэн худалдааны нөхцөл, санхүүгийн асуудал дээр яваагүй.

Гэхдээ мэдээж эрсдэл үүснэ. Бид Оросын Холбооны Улсаас импортолж байгаа шатах, тослох материалтай холбоотой бүх төлбөр тооцоог ямар нэгэн хориггүйгээр хийж чадаж байгаа.

Энд 5 гишүүн орон байгаа. 5 гишүүн орон гэдэг маань өөрөө бидний төлбөр тооцоог бусад бараан дээр хийх боломжийг нэлээн өргөтгөх байх. Энд зохион байгуулалтын арга хэмжээ аваад байна.

Нэгэнт манайх худалдааны тэнцэл алдагдалтай. Бид дандаа бэлэн валютаар төлбөр төлж байгаа тул бид нийлүүлж байгаа бараагаа аль болох нэмэх, эргээд тооцоо хийхэд аль ч хэлбэрийг бид тооцох орон зай байгаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддоржийн урилгаар Өмнөговь аймгийн 9 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Индрийн 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг хариулна.

Б.Лхагважав: Баярлалаа. Д.Энхтүвшин гишүүн буюу Ерөнхийлөгчийн асуултад хариулъя. Тийм.

2023 оны байдлаар бид 46.9 тонн мах экспортолсон. Нийт дүн нь 171.8 сая ам.доллар болж байсан. Үүнд:

- ✧ Оросын Холбооны Улс руу 1.9 сая ам.доллар,
- ✧ Казахстан Улс руу 3.0 сая ам.доллар,
- ✧ Киргиз Улс руу 0.1 сая ам.доллар,
- ✧ Армен Улс руу 0.1 сая ам.доллар байгаа.

Б.Пүрэвдорж: Наадах улс улсууд руу чинь ерөнхийдөө махан бүтээгдэхүүн явж байгаа.

Б.Лхагважав: Тэгж байгаа. Тийм.

Б.Пүрэвдорж: Мах сүүлийн хувьд бараг гараагүй. Киргизстан руу харин гарсан байж магадгүй.

Оросын Холбооны Улс руу ерөнхийдөө махан бүтээгдэхүүн явж байгаа. 5 мянган тонн адууны махны квот аваад түүнээсээ өөдтэй гаргаж чадаагүй.

Тийм учраас энэ юунаас болж байна вэ гэхээр ерөөсөө хэтэрхий их өндөр тарифтай болж байна. Өөрөөр хэлбэл үхрийн махан дээр 50 хувь, адуу, хонь, ямааны махан дээр 18 хувийн тарифтай учраас экспорт ерөөсөө явахгүй байгаа.

Энэ тэглэсний үр дүнд уламжлалт зах зээл илүү сайжирна гэсэн ийм төлөв харагдаж байгаа. Махан бүтээгдэхүүн дээр 18 хувийн татвартай байдаг юм шүү дээ.

Гаалийн мэдээ байна уу? Бараагаар нь кодолж ангилсан. Г.Энхтайван дарга аа. Индрийн 3 дугаар микрофон.

Г.Энхтайван: Д.Энхтүвшин гишүүний асуултад хариульъя.

Махан бүтээгдэхүүн 10-аад улс руу 2025 онд экспортолсон байна. Тодорхой мэдээллүүдэд танд албан бичгээр гаргаж өгье гэж бодож байна. Яг тодорхой мэдээлэл гаргах гэхээр энд сүлжээний асуудлаас болоод жоохон гацлаа. Тэгээд танд бичгээр гаргаж өгье.

Б.Пүрэвдорж: Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Бейсен: Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

Гэхдээ хэд хэдэн асуудал асууя. Энэ гурил, тэжээл чинь одоо тэгээд чөлөөт орох юм байна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр өнөөдөр яригдсан Ж.Энхбаяр сайд аа, М.Бадамсүрэн сайд аа.

Ер нь баруун бүс гурил, тэжээлээс хуучин Баруунтурууны гурил, тэжээлийн аж ахуй гээд байсан. Увсад. Баян-Өлгийн Ногоон нуурын тэжээл аж ахуй гээд байсан. Бүр малын тэжээл үйлдвэрлэж байсан.

Тэгээд Эрдэнэбүрэнгийн усалгаатай тариалангийн талбай. Эд нарыг одоо тэгээд яах юм? Хөгжүүлэх юм уу, хөгжүүлэхгүй юм уу? Тэгээд гадаадаас авч байх юм уу? Байнга валют гадагшаа урсах асуудал гарч байна.

Хоёр дахь асуудал. Махны экспортын асуудал байна. Хуучин соц нийгмийн үед Цагааннуурын мал бааз гээд байсан. Малыг нядлаад ч, амьдаар нь ч гаргадаг байсан. Тэгээд Цагааннуурын хорио цээрийн эрүүлжүүлэх бүс гээд байгуулах юм уу? Зураг төсөв нь гарсан байгаа. Цаашдаа дундад Азийн орнууд, станы орнууд, Оросын Холбооны Улс мах их хэмжээгээр авах юм байна.

Квот тогтоох юм уу, үгүй юм уу?

Дөрөв дэх асуудал. Энэ эмийн асуудал байгаа. Хуучин Цагааннуур боомтоор эм ордог байсан. Оросын Новосибирск, тэгээд станы орнуудын үйлдвэрүүд байгаа. Ойрхон. Гэтэл тойроод Забайкальскаар, Наушкаар орж ирж байгаа. Үнэтэй. Дахиж баруун аймгууд руу очиход нэлээн үнэтэй очдог.

Тэгэхээр энэ асуудлыг яах вэ? Эрүүл мэндийн яам хил гаалийнхантай ярьж байна уу? Энэ талын асуудал дээр. Үнэхээр баруун аймгийнхан өндөр үнээр авна шүү дээ. Үнэтэй. Энэ талаар асууж дараа тодруулъя.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Улаан буудай манай Евразийн холбоотой харилцан буулт хийсэн бараанууд дотор хатуу болон зөөлөн улаан буудай орсон.

Нийтдээ 50 мянган тонныг л бид квотоор авна. Бусдыг нь татварынхаа уламжлалт босгоо тавьсан. Яагаад гэвэл бид дотооддоо “Атрын IV” аяны хүрээнд улаан буудайгаар дотоод хэрэглээ хангах том ажил явагдаж байгаа. Тийм болохоор импортын хамаарлаа бууруулах тэр бодлогын хүрээнд энэ бодлого цаашдаа үргэлжилнэ.

Саяын чуулганаар ордог баруун бүстэй холбоотой Их Хурлын тогтоолын төсөл байгалийн эрсдэлийг давах түр зуурын яаралтай зохицуулалтын арга хэмжээ авах эрхийг Засгийн газарт олгож байгаа. Тэр хүрээндээ бид үнэ, барааны гурил, тэжээлийн нийлүүлэлтийг харж байгаад бид хурдан шуурхай арга хэмжээ аваад тэнд хүндрэл үүсгэхгүйгээр зохион байгуулна.

Тэгэхээр урт хугацаандаа бид газар тариалангийн салбараа хамгаалсан бодлогыг, цаашдаа хөдөө аж ахуйгаа хамгаалсан бодлогыг авч хэрэгжүүлнэ. Тэр юун дээр эм, мах, экспортын асуудал дээр ажлын хэсгээс хариулах хүн байна уу?

Б.Пүрэвдорж: Хариулах хүн байхгүй байна даа.

Б.Бейсен гишүүн яах юм? Нэмж тодруулъя.

Ж.Энхбаяр: Тодруулаад танд өгье дөө.

Эм, эмийн бэлдмэл, нийлүүлэлтийн талаар.

Б.Пүрэвдорж: Б.Бейсен гишүүний микрофон.

Б.Бейсен: Тэр гурилын асуудал дээр 4 сарын 16-нд квот тогтоох уу? Яаж өгөх юм? Оруулж ирэх тэжээл, гурилын асуудал дээр. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Увсын Баруунтурууны гурил, тэжээлийн аж ахуйг, мөн Ховдын Эрдэнэбүрэнгийн усалгаатай тариалангийн талбай, тэгээд Ногооннуур сумын Ачит нуурын сав газарт түшиглэсэн Ногооннуурын тэжээлийн аж ахуй гээд байсан. Үүнийг сэргээх ямар боломж байна? Цаашдаа хөгжүүлэхгүй бол болохгүй л байх.

Б.Пүрэвдорж: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Баруун бүсийн газар тариалан тэжээлийн хангамжийг сайжруулах зорилго тавиад ажлын хэсэг байгуулагдаад, газар дээр нь судалгаа хийгээд, үнэлгээ хийгдээд, ер нь хэчнээн мянган га талбайг эргэлтэд оруулах вэ, ямар тоног төхөөрөмж шаардлагатай, ямар боловсон хүчнийг бэлдэх вэ гээд бид тооцоо, судалгааг бэлэн болгосон.

Харамсалтай нь, 2026 онд хэрэгжүүлэх төсөлд тусгаад өгсөн хөрөнгө оруулалтын зардлууд үндсэндээ Их Хурал дээр хасагдсан. Ер нь цаашдаа бид баруун бүс нутгийн тэжээлийн чадавхыг, хангалтын чадавхыг нэмэхгүйгээр өвөлжилт, байгаль цаг уурын эрсдэлийг даван туулахад нэлээн хүндрэл учирна буюу зардал их гарна.

Тэгэхээр “Атрын IV” аяны хүрээнд олгогдсон тэр 200 мянган га талбайгаас манай баруун 5 аймаг, удирдлага сонсож байгаа онцгой анхаарч тэр тэжээлийн тарих талбайгаа Засгийн газрын хуралд хурдан оруулж ирж аваач ээ.

Энэ дээрээ дэмжсэн орон нутгийнхаа бодлогыг давхар явуулаач ээ л гэж хэлэхийг хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг түр хойшлуулъя. Дараагийн асуудалдаа орно.

Дөрөв.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга Ренчинбямбаагийн Сэддорж танилцуулна.

Индэрт урьж байна.

Эхлээд энэ танилцахыг уншъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын урилгаар Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын цэцэрлэгийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурган хүмүүжүүлэх ажилд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе.
/алга ташив/

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед –

- Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ болон бүтээгдэхүүн нөөцлөх байгууламж, дэд бүтцийг шинээр барих, өргөтгөхөд шаардагдах хөрөнгийн дүн, мөн хууль хэрэгжих хугацааны талаар,
- Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг газрын тосны бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүдийн нөөц бүрдүүлэлт, бүтээгдэхүүний борлуулалтад төрөөс хяналт тавих нь зохистой эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Банкны тухай хуульд тусгагдсан Монголбанкны үйл ажиллагаанд хориглосон зохицуулалтыг хэрэгжүүлэх нь зохистой эсэх, мөн Дорноговь аймагт баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явц болон газрын тосны бүтээгдэхүүний үнийг чөлөөлөхөд төрөөс баримтлах бодлогын талаар,

- Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн стратегийн бүтээгдэхүүний үнийг төрөөс тогтоож, бүтээгдэхүүн борлуулалт эрхэлдэг цөөхөн аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлөөр давуу байдал олгож байгаа нь зохистой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т заасны дагуу хуулийн үйлчлэх хугацааны талаар Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн зөвлөмжийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн болно.

Уг зөвлөмжтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооноос ирүүлсэн санал, дүгнэлт болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу бэлтгэсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг Та бүхэнд тараасан болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийг танилцуулъя.

Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дунхүүгийн Аюуш Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Чулуунбаатарын Чулуунбат Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос, бүтээгдэхүүний хэлтсийн дарга.

Манай Ч.Чулуунбат хуурамч шатахууны эсрэг 6 жилийн турш тэмцэж байгаа. Төрийн албан хаагчдаас энэ муухай зүйлийн эсрэг зүтгэсэн хүн байгаа.

Олон хуулийн байгууллага хууль бусаар шалгаж зовоож, тэр компанийн нөхдүүдийн балгаар их асуудалд орсон. Үнэн мөн нь тогтоогдож гарч ирсэн. Танд талархаж байгаагаа илэрхийлье.

Даваахүүгийн Даваабаяр Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс Ж.Ганбаатар гишүүн. Алга байна.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Яах вэ, одоо тэгээд нийгэмд үүсэж байгаа нөхцөл байдал дээр яаралтай бодлогын гэдэг юм уу, зохицуулалтын хариу арга хэмжээ авах гээд Засгийн газраас ийм хууль орж ирлээ гэж харж байгаа.

Тэгэхдээ нэрнээсээ эхлээд ерөөсөө томдоод байгаа юм. Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн гээд 5.1 дээрээ стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн гэдэг нь зүгээр газрын тосны бүтээгдэхүүн, бүх төрлийн шатахуун л гэж байгаа юм.

Нэрийг нь ядаж зөв л өгмөөр байгаа юм. Зүгээр ерөөсөө газрын тосны бүтээгдэхүүн, бүх төрлийн шатахууны хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай гээд.

Тэгээд стратегийн ач холбогдолгүй бүтээгдэхүүн гэдэгт бид шатахуун, бензин тосноос гадна хэд хэдэн юм байдаг юм шүү дээ. Нэр нь томдсон. Тэгээд томдсон дээлтэй хүүхэд чинь нэг их хол гүйж чаддаггүй юм даа. Ингээд харахаар 6 дугаар зүйл, 7 буюу Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бүрэн эрхүүд чинь яг өдөр тутам хийдэг л ажлууд байгаа байхгүй юу.

Тэгээд гол руу нь оронгуут л ерөөсөө Монголбанкны бүрэн эрх дээр л байгаа. Репо арилжаа хийх нөхцөлтэй зээл олгох. Ерөөсөө л үүнийг хийх гэж л ийм юм орж ирсэн.

Тэгээд энэ нь яах вэ, хоёр талтай байх. Эрсдэлийг ер нь хаах чиглэл дээр ямар бодлого барих вэ? Г.Дамдинням сайд аа. Энэ нөхцөл байдал буюу таны авч хэрэгжүүлэх гэж байгаа хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ эрсдэлд орвол Засгийн газар хариуцах юм уу, эсвэл Монголбанк хариуцах гээд байна уу?

Үүний үр дүнд татвар төлөгчдийн гэдэг юм уу, ийм зүйлүүд дээр эрсдэл учирвал яах вэ?

Хоёрдугаарт, зах зээлийн зарчмаар явах юмнууд дээр бид чинь ойлгож байгаа боловч хүчээр зохицуулалт гэдэг юм уу, ийм зүйлээр явлаа. Аж ахуйн нэгж, байгууллагууд хамтран ойлголцож ажиллах тал дээр хэр байх бол? Эд нарын бэлтгэл ажил хэр байгаа юм? Зэрэгцүүлээд баахан сав суулга барина гэдэг. Яг чадах болов уу? Би хоёр, гурван компанийн лобби болох вий гэж айгаад байгаа юм.

Дээрээс нь би зөвхөн бензин шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг гадаад, дотоод нөхцөл байдлууд байгаа гэдгийг ойлгож байгаа. Тэгэхдээ нэг зүйл ерөөсөө тэр шатахууны нөөцлөх савнаас гадна төмөр замын тээвэрлэлтийн хүчин чадлыг хэрхэн яаж нэмэгдүүлэх. Ялангуяа урд талаасаа. Тийм ээ. Замын-Үүд дээр ачиж буулгах терминал чинь ерөөсөө болохгүй байгаа шүү дээ. Энэ терминал чинь аюултай байдалд ороод байна. Энэ бодлогын арга хэмжээ чинь ч гэсэн нөлөөлнө.

Юу вэ гэхээр Замын-Үүдээр бид хүнээ ч авч байгаа, хүнсний бүтээгдэхүүнээ ч авч байгаа, аюултай ачаа бараагаа ч авч байгаа.

Одоо Монгол Улсын олон улсын зах зээл рүү ганц нэвтэрч байгаа гэж хэлж болох Замын-Үүдийн боомт дээрээ цаашдаа зөв менежмент хийхгүй бол улсаараа аюултай ачаа бараа авч байгаад бүр балрах вий гэдэг зүгээр миний хувь болгоомжлол байдаг.

Тэгээд илүү их цаашдаа аль боомтуудыг энэ чиглэлийн бодлогоор төрөлжүүлж хөгжүүлэх ёстой юм бэ? Үүнийг танай яамнаас юу гэж харж байгаа юм оо? Тодорхой байр сууриа хэлээч.

Зах зээлийн зарчмаар нь л явуулах бодлого. Болдог бол уг нь хүссэн хүн нь л шатахууны импортыг стандартаа нийцүүлээд л оруулаад ирэх тэр бодлого руу хэдэн жил яваад үзэх байсан юм уу? Тэгэхгүй бас нэг тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд авлаа. Тэгээд эд нар нь баахан зовлон ярьдаг юм байна. Нөөцлүүрийн сав байхгүй.

Тэгэхдээ яг эцсийн дүндээ нөөцлүүрийн сав гэхээсээ илүүтэй татан авалтыг хэт шуурхай хийж чадвал урд хөршөөс ч юм уу, бусад орноос байж болно шүү дээ.

Тэгээд хамгийн эцэст нь Энэтхэгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрээ л яаралтай хиймээр байна. Төсвийн тэр тусгай шаардлагатай уягдаад зээлийн ашиглалт муу байна. Тэгэхдээ

үүнийг Засгийн газар зохицуулалт хийж байгаа гэж байгаа боловч энэ удаашрах тусам жилд 1.8 их наяд доллар бензин шатахуунд гарна.

Эдийн засаг угаасаа тэлж байна. Уул уурхай эрчимжихийн хэрээр бидэнд энэ нөхцөл байдлууд угаасаа хүндэрнэ.

Тэгэхээр энэ дээр цаашдаа тогтвортой тоймтой л... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Хосбаярын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургуулийн ахлах ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурган хүмүүжүүлэх болон сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

П.Сайнзориг гишүүний асуултад Г.Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Нэрний тухайд нэг тийм байгаа юм. Удахгүй бид Шатахууны аюулгүй байдлын тухай хууль гээд хууль бэлтгэж байгаа. Шатах тослох материал, тэслэх материалуудын аюулгүй байдлын тухай хууль гээд бэлтгэж байгаа. Энэ бол удаан хугацаанд үйлчлэх хууль.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль бол хугацаатай хууль. 5 жилийн хугацаанд хэрэгжээд хүчингүй болох зохицуулалттай. Байдал хэрвээ хэвийн болбол бид энэ хуулиа хүчингүй болгоё гэж төлөвлөж байна.

Монголбанканд эрсдэл учрах зүйл байхгүй. Зээлтэй холбоотой асуудлыг Монголбанкнаас репо санхүүжилтад зориулан гаргана. Үүнийг арилжааны банкнуудад өгнө. Монголбанк шууд өөрөө зээл гаргахгүй. Арилжааны банкнууд аж ахуйн нэгжүүдэд тавьдаг шалгуурынхаа дагуу үнэлгээ хийж, зохицуулалт хийж гаргана.

Монголбанк Мөнгөний бодлогын хороогоороо “хэмжээ”, бусад асуудал дээр нь шийдвэр гаргаж зохицуулна гэж бидэнтэй ярилцсан.

Монголбанкны тухайд өмнө нь ийм нэг удаагийн хууль ковидын үед хэрэгжүүлээд бид 3 сарынхаа хэрэгцээний шатахууныг нэг доор 400 тэрбум төгрөгийн репо санхүүжилт гаргаж захиалж байсан удаа бий. Тэр хуулийг л ер нь жоохон уртхан хугацаанд хэрэглэх гэж оруулж ирж байгаа юм.

Ер нь нөхцөл байдал эргэн тойронд бидний хэрэглээ ч нэг талдаа өсөөд байдаг, нөгөө талдаа орж ирэх нөхцөл байдлаа урт хугацаанд нь тогтвортойгоор том хэмжээгээр захиалж үнээ тогтвортой барих чиглэлд энэ хууль нэлээн том өөрчлөлт оруулна.

Аж ахуйн нэгжүүдийн тухайд үндсэндээ Монгол Улсад өнөөдөр хэдхэн том аж ахуйн нэгжүүд гэж болгоомжлох нь зүйтэй. Тэгэхдээ ер нь манай улсад бүх төрлийн шатахуун –

- ✧ импортын тусгай зөвшөөрөлтэй - 151,
- ✧ бөөний худалдаа эрхлэх зөвшөөрөлтэй - 173,
- ✧ жижиглэнгийн тусгай зөвшөөрөлтэй - 181 –

-аж ахуйн нэгжүүд байж байгаа юм. Яг энэ шатахуунтай холбоотой.

Одоо тэгээд аж ахуйн нэгжүүд байнгын л хүсэлт өгч байгаа. Манай яам болон миний зүгээс шалгуур хангасан, бүрдэл хангасан бүхий л хүсэлтийг зөвшөөрч байгаа. Эрчимтэй ч нэмэгдэж байгаа. Ард иргэдийн дунд тусгай зөвшөөрлөөсөө болоод болдоггүй юм байна гэсэн ойлголт байх шиг байна лээ. Нээлттэй. Бүгдэд нь өгч байгаа. Оруулж ирж чадах болгон нь аваач ээ л гэж байгаа юм.

Төмөр замын шилжүүлэн ачуулах байгууламжтай холбоотой асуудал урд хөрш дээр яригддаг.

Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хиллэж байгаа Шивээхүрэн боомт дээр 6 мянган метр кубын багтаамжтай шилжүүлэн ачих байгууламж ер нь баригдаад ашиглалтад ороход бэлэн болж байна.

Цаашдаа бид Гашуунсухайт, Хангина-Мандалын боомтууд дээр агуулах бариад авах тухай асуудал ярина. Иргэдийн боомттой хамт байх нь зүй зохисгүй юм гэдгийг манай талаас ч, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас ч тавьж байгаа. Энэ үнэн. П.Сайнзориг гишүүн яг л тэр гол асуудлыг нь авч хэллээ.

Бид бусад боомтууд дээр авах асуудлуудаа... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Ж.Батэрдэнэ гишүүн алга байна.

Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

А.Ариунзаяа: Дэмжихэд хэцүү, дэмжихгүй байхад бүр ч хэцүү ийм асуудлыг оруулж ирж байна л даа.

Шатахуун түлш нийлүүлэлт хүнд байна уу. Хүнд байна. Бүгдээрээ л мэдэж байгаа. Тэгээд энэ хууль чинь аж ахуйн нэгж, байгууллагуудад ер нь давуу байдал үүсгэж байгаа л хууль шүү дээ.

Хөнгөлөлттэй зээл олгох гэж байна. Эх үүсвэр бий болгох гэж байна. Май, чи эргэлтийн хөрөнгө ав. Май, чи хөнгөлөлттэй зээл аваад саваа барь. Нөөц саваа барь. Май, чи хэмжих ямар төхөөрөмжүүдийг шинээр авах ёстой юм, стандартаа яаж нийлүүлэх ёстой юм. Үүнийгээ ав гэж шатахуун түгээх ч гэдэг юм уу, энэ компаниудад л давуу байдал үүсгэж байна шүү дээ. Ер нь бол.

Ийм ч учраас Монголбанк бид өөрсдөө үүнийг зохион байгуулж болохгүй ээ. Тусгайлсан хууль Их Хурлаар гарга гэдэг байдлыг шаардаж, хүсэлт гаргаж бид энэ хуулийн төслийг хэлэлцээд байна.

2031 он хүртэл арай удаан биш үү? 2 жилээрээ байгаад тэгээд шаардлагатай сунгадаг ч юм уу, нэг жилээрээ байгаад сунгадаг ч юм уу, нэг ийм асуудлаар хандаж болоогүй юу? 5 жилийн хугацаанд эдгээр байгууллагуудад давуу байдал үүсгэх гээд байна л даа.

Тэгэхээр өөрөө энэ нь хэр зохистой юм? Би тухайн компаниудыг нэг их тийм айхтар хүндрэлд ордог маш хүнд аж ахуйн нэгжүүд гэж уг нь бодохгүй байгаа. Маш их ашиг олдог шүү дээ. Ер нь тухайн эзэмшигчдийг ч харахад, гэр бүлийг нь ч харахад, хэрэглээг нь ч харахад нэг их тийм айхтар. Харин ч ашгаа өөртөө илүү аваад байдаг болохоос биш яг компанидаа хөрөнгө оруулдаг юм уу, үгүй юм уу гэдгийг бас асуух ёстой асуулт мөн болов уу гэж бодож байна.

Энэ ч яах вэ, одоо давуу байдал үүсгээд баталдаг юм байж. Түлш тогтвортой нийлүүлэх нөгөө гэрээ Монгол Улсад агаарын хөлгийн түлш нийлүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах асуудал орхигдсон байгаа. 4 сард орж ирсэн. Хос гэрээ шүү гэдгийг Оросын Холбооны Улсаас сануулж 2 гэрээг оруулж ирээд нэгийг нь бид батлаад, нэгийг нь батлахгүй гээд гэдгийгээ суусан байгаа. Гэтэл хосоороо байж байж хүчин төгөлдөр шүү гэдгийг Оросын Холбооны Улсын зүгээс байнга сануулж хэлж байгаа.

Тэгээд Монгол Улс өөрийнхөө дотоодынхоо асуудлаа шийдвэрлээд, орчуулгын алдаа байсан үүнийгээ засаж залруулаад, ямар асуудал байна вэ гэдгийгээ шийдвэрлээд соёрхон баталж эцэслэх үүргээ хүлээнэ үү гэдгийг бүтэн жилийн хугацаанд сануулсан.

Б.Пүрэвдорж гишүүнтэй хамт бид Оросын Холбооны Улсад ажлын айлчлал хийхэд Улсын Их Хурлынх нь Думын дарга нь, Засгийн газрын тэргүүн нь бүгдээрээ л энэ асуудлыг хэлж байна лээ шүү дээ.

Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын дарга Швейцарт парламентын холбооны уулзалтад оролцоход бас л Матвиенко /Валентина Ивановна Матвиенко/ яг энэ асуудлыг хэлж байсан.

Энэ гэрээгээ яагаад соёрхон батлах асуудлыг оруулж ирэхгүй удаад байна вэ? Хоёр долоо хоногийн өмнө саналаа явуулсан гэсэн. Хариу ирсэн үү? Чуулган хаалаа, Г.Дамдинням сайд аа.

Тэгээд одоо ингээд 3 сар хүртэл дахиад л гацах уу? Бид хэлсэн үгэндээ хүрч чадахгүй байна гээд Оросын Холбооны Улсаас манай дотоод асуудал хүнд байна. Тогтвортой түлш нийлүүлэх гэрээ угаасаа танайх хос гэрээгээ соёрхон батлаагүй юм чинь бид үүргээ хүлээхгүй. Бас бид өөрсдийгөө бодлоо гэсэн асуудал дэвшүүлбэл яах вэ? Ямар ажил хийгдэж байна вэ? Хэр удах вэ?

Н.Учрал: Г.Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Давуу байдлын тухайд бид 100 хувь гаднаас хамааралтай байгаа юм.

Түрүүн П.Сайнзориг гишүүн асууж байгаад минут амжсангүй. Газрын тосны боловсруулах үйлдвэр 2028 онд ашиглалтад орно. Ашиглалтад ороод бид одоогийн өсөн нэмэгдэж байгаа хэрэглээнийхээ байдлыг харахад хэрэглээнийхээ 50 хувийг тэр үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангах чадалтай болох юм.

Дахиад л бас үлдсэн 50 хувийг нь бид гаднын эх үүсвэрээс авдаг болж байгаа учраас аль болох дотоодын импортлогч компаниудынхаа хүчин чадлыг нэмэгдүүлж, хувийн хэвшлийнхээ нуруун дээр хүчин чадлыг нь даах хэмжээнд хүргэж байж л бид энэ хүнд байдлаас харьцангуй гайгүй гарах нөхцөлтэй.

Ний нуугүй хэлэхэд шатахуун хариуцаж байгаа уул уурхайн аж үйлдвэрийн сайд нарын хамгийн том. Бүгдээрээ л энэ зовлонг туулцгаасан байдаг. Бүгд л энэ асуудлыг үүрцгээсэн байдаг.

2031 он хүртэл 5 жил гэдэг бидний импортын 95 хувийг Оросын Холбооны Улс хойд хөрш маань нийлүүлдэг. Хойд хөршид нөхцөл байдал зарим үед бэрхшээлтэй байгаад байгаа. Геополитикийн нөхцөл байдал тогтворжих хүртэл 5 жил байх юм байна гэсэн олон улсын судлаачдын тооцоолол байгаа учраас бид 5 жилийн хугацаанд тавьсан.

Мэдээж нөхцөл байдал хэвийн болбол энэ хуулийг хүчингүй болгоод асуудалгүй.

А.Ариунзаяа гишүүндээ маш талархалтай байгаа. Агаарын хөлгийн түлшний асуудал дээр их анхаарал тавьж ярьж байгаа. Агаарын хөлгийн түлшний

асуудал өмнө нь орж ирэхдээ орчуулгын алдаа болон бусад хамт орж ирсэн асуудлуудаасаа шалтгаалаад яваагүй. Энэ бол хоёр орны төр засгийн хүрээнд агаарын хөлгийн түлшний гэрээнээс гадна Оросын Холбооны Улсаас Монгол Улсад тогтвортойгоор нефтийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх гэрээ гэсэн ийм хоёр гэрээ нийлсэн хос гэрээ байгаа юм.

Тэгээд агаарын хөлгийн түлштэй холбоотой гэрээ нь 8 асуудал Байнгын хорооны хуралдааны үеэр гишүүд ярьсан. Энэ асуудал дээр ажил авснаас хойш нэлээн эрчимтэй ажиллаад сая ШХАБ-ын уулзалтын үеэр Оросын Холбооны Улсын Эрчим хүчний сайд Цивилевтой /Сергей Евгеньевич Цивилев/ би хэлэлцээр хийж 8 асуудлын 7 асуудлыг Монголын талын томъёоллоор шийдье. Нэг асуудлыг Та бүхэн Улсын Их Хурлаараа оруулж шийдэж өгөөч ээ гэдэг ийм хүсэлт тавьсан.

Ингээд манай ажлын хэсгүүд ажиллаад 12 хоногийн өмнө, 11, 12 хоногийн өмнө эцсийн байдлаар томъёоллоо онлайнгаар тохиролцоод Оросын Холбооны Улсын Эрчим хүчний яам руу явуулсан.

Өчигдөр би Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суух Элчин сайдтай уулзаж энэ гэрээний төслийг яаралтай баталгаажуулж ирүүлээч ээ. Чуулган завсарлахаас өмнө би бас энэ агаарын хөлгийн түлшний хэлэлцээрийг чуулганд оруулмаар байна гэдэг хүсэлтээ тавьсан явж байгаа явж байгаа.

Тэгээд энэ хэлэлцээр чуулганд удахгүй орж ирнэ. Бид бэлтгэл ажлаа хангасан байна. Оросын Холбооны Улсаас баталгаажуулж ирэхийг хүлээж байгаа. Тийм.

Н.Учрал: А.Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Ер нь бид хүнээс хамааралтай байгаагаа хүлээн зөвшөөрөөд аль болох үндэснийхээ аюулгүй байдлыг хангах тал дээр нь ажиллахгүй бол Г.Дамдинням сайд аа, одоо хөдөө суманд нэн ялангуяа ямар хэцүү байгаа билээ.

- Нөхцөл байдал ер нь ямар байна вэ?
- Нөөц хэд хоног байна вэ?
- Өөр юунд анхаарах вэ?
- Эсвэл иргэдийг тайван байхыг уриалах уу?
- Ямар асуудлууд байх вэ гэдгийг нэг тодорхой хэлж өгөөч.

Дээрээс нь 2028 оноос манай Монгол Улс чинь ер нь Оросын Холбооны Улс өөрсдөө дотооддоо хэрэглэдэггүй түлшийг авдаг шүү дээ.

Тэгээд 2028 оноос тэр түлшийг бүр үйлдвэрлэхээ больж байгаа. Болино.

Тэгэхээр бид аргагүйн эрхэнд евро стандарт руу шилжинэ. Энэ цаг үед яг одоо энэ компаниудад давуу байдал олгоод байгаа ач тусыг тухайн үед компаниуд нь бодох ёстой шүү гэдгийг та хэд хэлэлцээртээ оруулах хэрэгтэй шүү. Гэнэт үнэ... /минут дуусав/

Н.Учрал: Г.Дамдинням сайд тодруулъя.

Г.Дамдинням: Одоо орон нутгуудын нөхцөл байдал бас зарим үед бэрхшээлтэй байна, зарим үедээ гайгүй байна.

- ▶ Дизель түлшний хувьд 12 хоногийн нөөцтэй байна.
- ▶ Аи-92 авто бензиний хувьд 10 орчим хоногийн нөөцтэй байна.

Оросын Холбооны Улсаас бидэнд амласан ёсоороо хангалттай нийлүүлж байна. Эрчимтэйгээр нийлүүлэлт явагдаж байгаа. Дизель түлшний тухайд бөөний худалдаа руугаа аж ахуйн нэгжүүд хэтэрхий түлхүү анхаарч, жижиглэнгийн худалдаанд бага анхаарсан асуудал үүссэн.

Өнгөрсөн нэг дэх өдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын зөвлөлийн хурал хийж аж ахуйн нэгжүүдэд хугацаатай үүрэг өгсний үр дүнд өнөөдөр өглөөний байдлаар бүхий л сумдад хүрсэн байгаа.

Нийт хэрэглээний евро түлш 40 хувийг нь хангаж байна.

А.Ариунзаяа гишүүн үнэнийг хэлж байна. Ер нь биднийг Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас евро стандарт руу шилж гэдэг шаардлагыг удаа дараа тавьдаг. Бид Евро-2 стандарттай явж байгаа.

Н.Учрал: Нэмж тодруулах уу? Ажлын хэсгээс хариулах уу?

Г.Дамдинням сайдад 1 минут өгье.

Г.Дамдинням: Тийм. Евро стандарт бол яг ийм юм байгаа юм. Одоо ний нуугүй хэлэхэд Ангарский үйлдвэр болон Яйскийн үйлдвэр гэсэн 2 үйлдвэрт л нэг үйлдвэрлэж байгаа юм. Монгол Улс л ер нь авч байгаа.

60 мянган тонн ая 92 авто бензин тэндээс тогтмол үнээр авдаг. Энэ нь Евро-2 стандартынх.

Энэ 2 үйлдвэр ер нь цаашдаа Евро-5 стандарт руу шилжинэ. Бүгд Найрамдах Хятад Ард Улс бүр Евро-6 руу шилжсэн байна. Одоо бид ний нуугүй хэлэхэд шатахууны маань одоогийн байдлаар 12 сард орж ирж байгаа нийт шатахууны дизель түлшний 40 хувь нь евро стандарт руу байна. Улаанбаатар хот

2027 он гэхэд евро стандарт руу шилжинэ гэж байгаа. Энэ Евро-5 стандарт гээд байгаагийн гол шалтгаан нь –

- Нэгдүгээрт, машин тэргэнд ээлтэй.
- Хоёрдугаарт, байгаль орчинд ээлтэй.
- Хамгийн чухал нь хүний эрүүл мэндэд ээлтэй ийм л стандарт юм.

2 мянга дахин илүү хүхрийн хүчлийн хэмжээ нь бага ийм л шатахуун л даа. Тэгээд бид олон улсын жишиг рүү явахаас өөр аргагүй... /минут дуусав/

Н.Учрал: Одонгийн Цогтгэрэл гишүүн шатахууны хангамж тасраад яг одоо авч байгаа арга хэмжээ нь яг үнэнийг хэлэхэд уламжлалт гал унтраах арга хэмжээ.

Яагаад гал унтраах арга хэмжээ гэж байна гэхээр ер нь энэ салбараа аваад үзэхэд Засгийн газраас Роснефттэй үнийг тохирдог. Тэрийг компаниуд нь авчирдаг юм шиг байна. Авчирсан хойно нь тэр 92 бензинийг ер нь хэдээр зарахыг нь яам тогтоож өгдөг.

Тэгэхээр хэдээр авахыг нь төрөөс тогтоож өгдөг, хэдээр зарахыг нь төрөөс тогтоож өгдөг. Дунд нь том тусгай зөвшөөрлийг нь хянадаг.

Тэгэхээр бүтээгдэхүүний хангамжийн тогтолцоо чинь юун нөгөө либералчлал, чөлөөт зах зээл. Аль нь ч байхгүй. Яг нөгөө социализмаараа. Тэр социализм чинь яадаг билээ. Яг социализмын зохицуулалтын үр дүнд дандаа байнгын хомсдол гардаг шүү дээ.

Хомсдол. Хомсдолыг дагаад хар зах, далд зах, хуурамч бүтээгдэхүүн. Яг л энэ схем уламжлалаараа явж байна. Гэтэл энд Г.Дамдинням сайд та зүгээр гал унтраах л гэж байх шиг байна. Шийдэл нь төрөөс оролцоод тэнд нэг банкнаас хөнгөлөлттэй зээл өгүүлье гэж байх шиг байна.

Уг нь саяын тэр шат шатанд оролцоод байгаа гадаадад очиж гэрээлж байгаа, дотоодод үнэ тогтоож байгаа энэ бүгдийгээ харьцангуй чөлөөтэй болгоод.

Сая Та хэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй маш олон компани байдаг гэж байна. Эдгээрт зөвхөн тэр нэг галын аюул болоод бусад тэр аюултай холбоотой стандартуудаа тавиад, тэр тусгай зөвшөөрөл элдэв зүйлээ багасгаад чөлөөт өрсөлдөөнийг нь нээгээд өгвөл аян эндээ наадах чинь бараг сар хүрэхгүй хугацааны дотор хангамж чинь өөрөө өөрөө эрүүлжээд явах юм биш үү.

Тэгэхээр бид эсрэгээр нь одоо дахиад хөнгөлөлттэй зээл ч гэнэ үү, элдэв юм өгнө гээд яриад байна. Яг үнэндээ тэр зээлийн асуудлыг ч гэсэн би сонирхож судалж үзсэн.

Яг таны өгч байгаа зээлийг аваад тэр аж ахуйн нэгжүүд чинь наад савыг чинь барих юм уу даа. Монголбанкнаас түрүүн хүн ажлын хэсэгт байх шиг байна лээ. Тэр хариулаад өгөөрэй.

Миний ойлгосноор Монголбанкнаас репо санхүүжилт өгнө гэж байна. Тэр репо санхүүжилт чинь бодлогын хүүн дээр нэмэх нь 2.5 гэж би санаж байна. Өнөөдөр 12 байгаа. 14.5. Арилжааны банк 3-аас 4 хувь хүү нэмнэ. 18 хувийн хүүтэй мөнгө аваад тэгээд тэр сав ёмкостой яг үнэндээ барих юм уу даа. Та түүн дээр юу гэж бодож байна? 18 хувийн хүүтэй зээл аваад.

Ингэсэнд орвол Та тэр зах зээлийг нь саяын тэр оролцоонууд, үнэд оролцоо. Бүр бодитоороо бид нэг либералчлал, чөлөөлөлт гээд ерөнхийд нь яриад байдаг. Гэтэл Роснефтьтэй Засгийн газар нэгдсэн гэрээ хийдэг. Бүх гэрээг худалдан авалтын үнийг та нар тогтоож өгдөг. Монголын колонк дээр ямар үнэтэй байхыг Та нар яг хатуу үнэ тогтоож өгдөг. Энэ бүгд дээрээ жаахан уян хатан өөрчлөлт, алхам алхмаар өөрчлөлт оруулаад өгвөл аяндаа наадах чинь өөрсдөө хийх юм биш үү?

Та энэ дээр байр сууриа илэрхийлж өгөөч. Энэ нэг л жоохон буруу зүгт яваад байгаа юм биш үү? Ер нь.

Н.Учрал: Г.Дамдинням сайд.

Г.Дамдинням: О.Цогтгэрэл гишүүнтэй зарчим хувьд санал нэг байдаг юм.

Тэгэхдээ бид дотооддоо үйлдвэрлэдэггүй учраас тэр болтол хөөрхий үндсэндээ энэ 35 жилийн хугацаанд энэ салбарыг хариуцаж байсан сайд нар тэгээд нэг аргалаад л явсан юм билээ.

Яах вэ, энэ удаад л анх удаагаа нэг сав барья гээд л зориглож байна. Бариулья гэж зориглож байна.

Манай улсын эдийн засаг өнгөрсөн 4 жилийн хугацаанд бараг 4 дахин томорсон. Уул уурхайн үйлдвэрлэлийн эрчимжилт нэмэгдээд явж байгаатай холбоотойгоор үндсэндээ жилдээ манай шатахууны хэрэглээ 20-иос 25 хувь өсөж байна. 20-оос 25 хувь өсөж байна.

Тэгэхээр аж ахуйн нэгжүүдийн маань орлого, тэгээд санхүүгийн хүчин чадал, зээл авах боломж, барьцаа хөрөнгө буюу зээлийн зохист харилцааны хэмжээ нь гүйцдэггүй юм билээ. Хэн ч тэгээд том хэмжээний юм руу асар их мөнгө хийгээд гацаа вэ дээ. Яг үнэндээ.

Тэгэхээр үндсэндээ бид аж ахуйн нэгжүүддээ тусгайлсан зээл, тусгай нөхцөлтэйгөөр ковидын үед хэрэглэж байсан аргачлалаар л өгье гэж байгаа. Аж ахуйн нэгжүүд зээл авна, сав барина гэсэн маш их хүсэлтүүдээ өгч байна. Барина л гэж байгаа. Бид аж ахуйн нэгжүүд болон Монголбанк, арилжааны банкнуудтай хамтарсан төслүүдээ санал болгож байж л явуулна гэсэн бодолтой байна. Төр аль болох орхолцохгүй байхыг хичээнэ.

Үүнтэй холбоотой асуудал дээр О.Цогтгэрэл гишүүн ээ, манай улс зөвхөн 2025 оны 12 дугаар сарын байдлаар нийт –

- 83 мянга 600 тонн А-92 авто бензин орж ирнэ,
- 134 мянга 240 тонн дизель түлш орж ирнэ,
- 1560 тонн А-95 бензин орж ирнэ.

Энэ чинь ингээд 220, 230 мянган тонн байгаа юм. Үүний 60 мянган тонн К2 стандартын буюу хуучин стандартын АИ-92 бензин дээр л бид 705 доллароор 1 тонныг нь авах урт хугацааны гэрээтэй. Оросын Холбооны Улсаас.

Энэ дээр л бид үнийн асуудал ярьж байгаа. Бусад 160 мянган тонн бүтээгдэхүүн дээр ямар нэг үнийн асуудал бид ярьдаггүй. Гэхдээ төрийн зохицуулалт ер нь манай нефть боловсруулах үйлдвэр ашиглалтад орсны дараа л ер нь бүрэн хэмжээнд либералчлаад л чөлөөлөөд явуулах ёстой юм байна лээ гэж харж байгаа. Аж ахуйн нэгжүүдийн маань санхүүгийн чадавх бол энэ саваа барих хэмжээнд арай дийлэхгүй байгаа юм. Өөрсдөө ч бүх санхүү юмнуудыг нь харахад хэцүү байдаг. Энэ дээр Монголбанк нэмж хариулах ёстой байх. Тийм ээ.

Н.Учрал: Монголбанкнаас нэмж хариулъя. 4 дүгээр микрофон.

Д.Аюуш: Нэмэлт тодруулга өгье. О.Цогтгэрэл гишүүний асуултад.

Хэрвээ энэ хууль батлагдах юм бол Монголбанкны Мөнгөний бодлогын хороогоороо хэлэлцэгдээд репо нэгдсэн хүүгийн бодлогын хүрээндээ хүүгийн асуудал репо хүү ямар байх вэ, ямар нөхцөлөөр олгох вэ гэдэг шаардлагууд нь тавигдаад явна.

Өнөөдрийн байдлаар репо санхүүжилтийн хүү 14 хувьтай байгаа. Өмнөх ковидын хууль болон гол нэрийн бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой тухайн үеийн хөнгөлөлттэй зээлийн үед 6-аас 14 хувийн хүүтэйгээр репо санхүүжилт олгогдож байсан. Тэр үед шатахуун дээр олгож байсан төлбөрүүд бүрэн ямар ч асуудалгүй төлөгдсөн байгаа.

Н.Учрал: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулна.

О.Цогтгэрэл: Тийм. Харин тэгэхээр тэр репо чинь бодлогын хүү дээр нэмэх нь 2.5 гэхээр 14.5 арилжааны банкаар дамжих нь. Багадаа 3 хувь нэмэгдэх нь. Тэгээд 18, 19 хувьтай 17, 18 хувьтай зээл аваад тэр шатахууны компаниуд чинь сав ёмкост яг барья гэж байгаа юм уу? 18 хувийн хүүтэй зээл аваад, тэгээд эдийн засгийн үр ашгийн тухай. Мэдэхгүй.

Тэгээд сүүлд нь яг л нэг ийм схем манайханд чинь яваад, сүүлд нь нөгөөдөх нь яг эдийн засгийн үр ашиггүй болоод, зээлийн зориулалтаа өөрөөр ашигласан гээд. Дахиад нэг баахан хүмүүс бие биеэ аваачиж ялладаг, шоронд хийдэг, эрүүгийн хэрэг үүсгэдэг. Эргээд явсаар байгаад нөгөө хэдэн бизнесүүд нь дарамтад ордог нэг ийм л юм болдог шүү дээ.

Зээлийн зориулалт буруу ашигласан гэдэг нэг заалт л үүний цаана та баахан аж ахуйн нэгжийг л оруулах л ийм л юм болж байх шиг байна. Яг үнэндээ 18 хувийн хүүтэй санхүүжилтээр шатахууны сав барихгүй дээ.

Н.Учрал: Г.Дамдинням сайд.

Г.Дамдинням: Энэ дээр тийм эргэлзээ байлгүй яах вэ. Зөв зөв. Тэгээд яах вэ шатахуун дээр урт хугацааны том гэрээ хийж, ядаж 3 сарынхаа хэрэглээг урьдчилж захиалмаар байгаа юм. О.Цогтгэрэл гишүүн ээ. Тэгж байж бид бас нэг үнээ ч, тэгээд орж ирэх бүтээгдэхүүнийхээ хэмжээг ч нэг тогтвортой байлгамаар байна.

Оросын Холбооны Улсын зүгээс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас бидэнд хамгийн том шаардаад байгаа зүйл бол урт хугацаагаар захиалаач. Нэг.

Хоёрдугаарт, нэгтгээд нэг том захиалга хийгээч ээ. Та нар чинь яг манай дотоодын аж ахуйн нэгжүүд шиг сар сараар эргэлдүүлж захиалаад байх юм. Үүнийгээ болиоч ээ гэдэг байнгын шаардлага тавьдаг.

Савтай холбоотой асуудал дээр энд бас нэг свопын асуудалтай холбоотой заалтууд энд явж байгаа. Бид арай хямд өртгөөр хийх боломжууд э Монголбанк дээр байгаа гэж үзсэн. Энд хоёр төрлийн санхүүжилт гарна гээд байгаа нэгдүгээрт бүтээгдэхүүний урт хугацааны захиалга, нөгөө талд нь савны захиалга... /минут дуусав/

Н.Учрал: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна.

Б.Түвшин: Зарим нэг асуулт давхцаж байгаа учраас товчхон асууя.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн хангамж, нийлүүлэлтийг дэмжих гээд байгаа. Энэ хуулийн нөхцөл байдал дээр сард бид 60 мянган тонн энгийн А92 хэрэглэдэг байсан бол энэ маань өсөөд одоо 80 болоод байгаа.

Тийм учраас бага зэрэг ложистикийн дутагдалд ороод байна л гэсэн ийм асуудал.

Тэгэхээр хуулийн 7.1.4-д байгаа. 7.1.3-т заасан чиг үүргийн хүрээнд импортын бүтээгдэхүүнийг хуваарилах, жижиглэнгээр түгээх, борлуулах арга хэмжээг тогтооно гэсэн.

Тэгэхээр нэг ёсондоо засаг маань орж ирээд энэ бүх үйл ажиллагааг хяналтдаа авах нь байна л даа.

- Тэгээд засаг маань орж ирээд энэ хяналтдаа авч байгаа тохиолдолд харин ложистик, түгээлт нь сайжрах уу?
- Ялангуяа энэ дарга нар орж ирээд түүнийг дагасан хүнд суртал, өөртөө болон бусдад давуу байдал үүсэх нөхцөл болох юм биш үү?

Ер нь зах зээлийн эдийн засгийн тогтолцоо мөн үү гэдэг нэг ийм асуулт байна.

- ➔ **Хоёрдугаарт**, Оросын Холбооны Улсаас хөнгөлөлттэй үнээр 705 ам.доллараар тогтмол гүйлгээ нийлүүлж байгаа энгийн 92 бензинд 60 мянган тонноор хязгаарлагдаад нэмэгдүүлэх боломжгүй нөхцөл байдалтай байна гээд байгаа юм.
- Тэгэхээр хөнгөлөлтгүй үнэ нь хэд вэ?
- Хөнгөлөлтгүй үнээр авах юм бол энэ нь дээшээгээ хэмжээ хязгааргүй авч болох юм уу?

Аль ч тохиолдолд эсвэл энэ 60 мянгаар хязгаарлагдаад байгаа юм уу гэдэг хоёр дахь асуулт.

- ▶ **Гуравдугаарт**, ер нь стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн, хангамж, нийлүүлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжийг сонгох эрхийг Засгийн газарт олгох тухай гээд байгаа юм.
- Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих аж ахуйн нэгж гэдгийг яг юу гэж үзэж байгаа вэ?
- Энэ одоо яг хаанахын ямар хөрөнгө оруулалттай, ямархуу статустай, юу гэж томъёологдсон байгууллага байна вэ?
- ▶ **Дөрөвдүгээрт**, хуулийн хэрэгцээ шаардлага 20 мянган тонн шатахуун дутагдаад байдаг. Гэтэл шийдэл маань өөрөө агуулах сав барина гээд байдаг.

- Агуулах сав бариад өргөтгөх гэсээр байтал хэдэн жил болох вэ?
- Ямар хугацаанд шийдэгдэх вэ: Богино хугацааны шийдэл энэ байж чадах уу?

Цаашдаа ерөөсөө энэ агуулах савны дутагдлын асуудал биш. Одоо байгаа савуудаа харин дүүргэх ложистик тогтолцооны л асуудал юм биш үү л гэдэг ийм дөрвөн асуултыг танаас асууя.

Н.Учрал: Г.Дамдинням сайд.

Г.Дамдинням: Б.Түвшин гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуулт бол энэ хуваарилалт, хязгаарлалт хийх хэмжээтэй холбоотой асуудал дээр нэг ийм асуудал үүсээд байгаа юм.

Улсын хэмжээнд 1800 орчим шатахуун түгээх станц байна. Улаанбаатар хотод 280 орчим шатахуун түгээх станц байна. Сая шатахууны хямралууд жил жилд болоход манай улсад бид аль шатахуун түгээх станцад хэдий хэмжээний ямар бүтээгдэхүүн байгаагаа мэдэхэд туйлын хүндрэлтэй байна. Зарим шатахуун түгээх станцууд байгаа мөртөөсөө зарахгүй байна. Ямар шалтгаанаар гэдгийг нь мэдэхгүй. Зарим аж ахуйн нэгжүүд маань бөөний борлуулалт руугаа түлхүү анхаарал хандуулаад, жижиглэнгийн борлуулалт руугаа хийхгүй байна.

Сая жишээ нь ямар гажиг үүсэж байгаа вэ гэхээр сая 4 хоногийн хугацаа нь засагдаад дуусаж байгаа дизель түлштэй холбоотой асуудал дээр ямар асуудал үүсээд эхэлж байна гэхээр –

- бөөний үнэ нь 3800,
- жижиглэнгийн үнэ нь 3160,

- бөөний хэрэглээ нь манай улсын нийт хэрэглээний 60 гаруй хувь,
- жижиглэнгийн хэрэглээ буюу иргэдийн хэрэглээ 30 орчим хувь.

Ингэнгүүт одоо бас энэ шатахууны асуудал хүндрэх гээд байна гэдэг нэг ийм зарим социал ойлголтоос шалтгаалаад аж ахуйн нэгжүүд маань их хэмжээгээр нөөцлөөд иргэдэд олдохоо байгаад эхэлж байгаа юм. Нөгөө сумдуудад очихоо байгаад эхэлж байгаа байхгүй юу. Энэ үед яах вэ. Зах зээлд нь найдаад орхих уу. Болиоч ээ. Энэ хуваарилалтаа нэг зохицуулаач ээ гэдэг юмыг хийх үү.

Тэгэхээр энэ улсын хэмжээнд байгаа бүх шатахуун түгээх станцууд дээр мэдрэгч тийм бүтэн системүүд байдаг юм билээ. Харж байдаг. Хаана нь байгаа юм. Байхгүй юу. Нөөцөө яаж удирдах юм. Одоо бол утсаар ярьдаг, хүн явуулдаг, минзуркаар хэмждэг ийм л ажилтай. Хүний хүчээр дийлэхээсээ өнгөрчхөөд

байна. цахим систем оруулж ирье. Цахим удирдлагын тогтолцоондод шилжүүлбэл гэж байгаа юм.

Гол нөхцөл нь хэзээ төр орж ирэх вэ гэ гэвэл импортын хэмжээ 50 хувиас доош унавал төр хуваарилалт, зохицуулалт дээр нь оролцоно л гэсэн ийм л зохицуулалттай. Ийм төрлийн зохицуулалтыг либерал эдийн засагтай орнууд бүгдээрээ л өөрсдөө үйлдвэрлэдэггүй ийм орнууд хийдэг л юм билээ. Шатахуун стратегийн тийм бүтээгдэхүүн учраас бид энэ дээр онцгой анхаарах ёстой юм билээ.

Оросын Холбооны Улсаас орж ирэх 60 мянган тонн бол хатуу тогтсон үнэ байдаг. 705. Үүнээс дээших хэмжээг хамаагүй хязгааргүй аваач ээ л гэдэг юм. Хүссэн хэмжээнд чинь өгнө.

Энэ нь тухайн үеийн зах зээлийн үнээсээ хамаарна гэж байгаа юм. Заримдаа 800 гаруй доллар байна. Одоо бол энэ чинь хэдтэй байна даа. 800 орчим доллар л байгаа даа. Евро стандартынх.

Н.Учрал: Б.Түвшин гишүүн тодруулна.

Б.Түвшин: Дөрвөн асуултын нэгд л хариуллаа. Тэгээд цаашаа дахиж тодруулаад хариулахыг хүсье. Г.Дамдинням гишүүн ээ.

Зүгээр ер нь ингэж л байна л даа. Шатахууны хэмжээг бид мэдэхээсээ илүү импортын хэмжээ 50-иас доош унавал гээд байгаа юм. Авах арга хэмжээ маань импортын хэмжээг 50-иас доош унагахгүй л байх нь төрийн авах арга хэмжээ учраас энэ асуудлаа тэгвэл больвол яасан юм.

Ер нь импортын хэмжээ доош унах л юм бол тэр чинь тодорхой хэмжээний тэр бизнесээ хийж байгаа хүмүүс чинь чухал хэсэг рүүгээ хуваарилна. Тэр хуваарилалтад төр орох биш, төрийн оролцох нь импортын хэмжээг 50-иас буулгахгүй байх тухай бодлогын асуудал юм биш үү гэдэг нэгдүгээр санал байна.

Хоёрдугаарт, ерөөсөө стратегийн нийлүүлэлтийг дэмжих аж ахуйн нэгжийг төр сонгоно гээд байгаа нь өөрөө зарчим биш юм биш үү. Яг өнөө маргаашдаа бид тулчхаад байгаа 20 мянган тонны шатахууны асуудлаа шийдэх гэхээр дунд хугацаанд хэрэгжиж эхлэх агуулах барья. Тэгээд тэрийгээ Монголбанкнаас гаргая гээд байгаа чинь цаг хугацаа... /минут дуусав/

Н.Учрал: Г.Дамдинням сайд.

Г.Дамдинням: Тийм. Мэдээж төр бол Б.Түвшин гишүүн ээ, 100 хувь байлгахыг л хүснэ шүү дээ.

- ▶ **Нэгдүгээрт**, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд бид 3-аас 6 сарын нөөцөө бүрдүүлнэ гээд хуульчлаад заасан. Энэ нөөцөө бүрдүүлэх бодлогыг л бид хийх гээд байгаа юм.
- ▶ **Хоёрдугаарт**, ямар аж ахуйн нэгжүүд авах гээд байгаа вэ гэвэл энд-
 - › бүх төрлийн шатахууны импортын тусгай зөвшөөрөлтэй 151 аж ахуйн нэгж байна,
 - › бөөний худалдаа эрхлэгч 173 зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байна,
 - › жижиглэнгийн тусгай зөвшөөрөлтэй 180 байна.

Үүнээс гадна өнөөдөр л гэхэд би 3, 4-ийн зөвшөөрлийг өгөөд л гаргалаа. Стандарт аюулгүй байдлын нормоо хангаж байгаа бүх бичиг баримттайнуудад өгч байгаа. Бүгдэд нээлттэй. Барьцаа хөрөнгөө байршуулаад л тэгээд л энэ банкныхаа шаардлагыг хангаж байвал хэн ч авч болно шүү дээ.

Ямар хугацаанд вэ гэхээр ер нь 1.5-аас 2 жилийн хугацаанд бариад дуусгана л гэж байгаа юм. Аж ахуйн нэгжүүд бол. Тэгээд дээрээс нь бид одоо байгаа саваа бүтэн хэмжээнд их хэмжээгээр захиалж дүүргэх хэрэгтэй байгаа юм. Аж ахуйн нэгжүүд чинь нэг сарын хэрэглээний юмыг 12... /минут дуусав/

Н.Учрал: Нямтайширын Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Энэ асуудал дээр би нэлээн шүүмжлэлтэй хандаад байгаа юм. Энэ хуулийг баталлаа гээд шатахууны хувьд бид хараат байдлаас гарахгүй.

Одоо байгаа бодит хараат байдлаас гарах арга зам юу вэ гэхээр газрын тос боловсруулах үйлдвэрээ ашиглалтад оруулах. Үүний хажуугаар нөгөө Газрын тосны тухай хуулиа шинэчлээд аж ахуйн нэгж, компаниуд нь эрх чөлөөг нь олгоод, өөрсдөө дотооддоо нөөц нь байдаг бол олоод, олборлоод, боловсруулаад дотоодынхоо ханган нийлүүлэлтийг л хангах нь хамгийн зөв л байгаа юм л даа.

Нөгөө талаараа шатахуунтай холбоотой асуудал гэхээр Оросын Холбооны Улстай харилцааны хандлага юундаа байдаг юм. Өнгөрсөн 100 жилийн хугацаанд оросууд гэхээр л айдаг, агшдаг, дээрэлхүүлдэг иймэрхүү хандлага одоо ч үргэлжлээд байгаа юм. Төр нь компаниудаа дэмжээд Оросын Холбооны Улсад нь олборлолт, боловсруулалтын үйл ажиллагааг нь дэмжээд хувь эзэмшээд явах бүрэн бололцоотой.

Энэ асуултыг асуухаас өмнө би энэ Оросын эрх зүйн орчны тухай хуулийг бас уншлаа. Учиргүй хаалттай зүйл ердөөсөө биш шүү дээ.

Одоо саяын Евразийн эдийн засгийн хэлэлцээрийг бас нэг эн тэнцүү эрх ашгаа хамгаалсан, харилцан ашигтай ажиллах зарчмыг баримталсантай

жишихээр энэ нефтийн хувьд томоохон бодлого баривал яасан юм бэ. Г.Дамдинням сайд аа.

Дээрээс нь, түрүүн Ардчилсан намын дарга О.Цогтгэрэл асуугаад л байна. Би санал нэгтэй байгаа юм. Энэ явж явж нохойн замаар орох вий. Хэн нэгэн хүнд зориулсан, хэн нэгэн хүний захиалгаар зээлийг зориулалтын бусаар ашигласан. Тэгээд яг үнэндээ хэн энэ зээлийг өндөр хүүтэй авъя гээд байгааг би бас ойлгохгүй л байна. Яагаад би үүнийг асуугаад байна гэхээр хэд хэдэн нефть импортлогч компаниудтай ярилаа. Манайх авахгүй. Ямар ч шаардлагагүй л гэж байна лээ шүү дээ.

Дээрээс нь заавал ийм байдлаар шийдэхээс гадна онцгой болон бусад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, эсвэл дараа төлөх нөхцөлөөр аж ахуйн нэгж компаниудаа дэмжиж болдоггүй юм уу. Болно шүү дээ.

Хэдий хэмжээний нөөц сав барих гээд байгаа юм, хэдэн төгрөг хэрэгтэй юм. Энд нь үүнтэй дүйцэхүйц хэмжээний татварыг дараа төлөхөөр больё. Үгүй бол Хөгжлийн банкн дээр чинь 500 билүү, 530 сая доллар юунд зарцуулахаа мэдэхгүй хэвтэж л байгаа юм билээ шүү дээ.

Өдөр болгон хүү нь бодогдоод л. Хүү нь харьцангуй бага л юм билээ. Үгүй үүнийг зарцуулж болдоггүй юм уу. Гэх мэтчилэн заавал хамгийн төгс шийдэл юм шиг бид ярьж байгаатай би ердөөсөө санал нийлэхгүй байгаа юм.

Тэгэхээр Г.Дамдинням сайд аа, та энэ асуудлууд дээр хариу өгөөдхөөч.

Дээрээс нь энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн хүрээнд хадгалах сав суулга тооцоод барьж л байгаа байлгүй дээ. Өнөө маргаашгүй ашиглалтад орно гээд л яриад л байна лээ. 2028 оны 01 сард ашиглалтад орно гэсэн. Энэ нөөц савыг бид ашиглаж болдоггүй юм уу?

Яагаад ингэж асуугаад байна гэхээр өнөөдөр ашиглалтын баталгаажсан нөөц тухайн үйлдвэр ашиглалтад ороход 4.5-хан жил хангах л нөөц өнөөдрийн байдлаар тодорхой байгаа шүү дээ.

Тэгээд энэ нэг сав суулга нь Энэтхэгийн ЭКСИМ банкнаас 1.7 тэрбум долларын зээл аваад баригдаад байгаа биз дээ.

Тэгэхээр гол миний энэ асуултуудын өнцөг дүгнэлт нь юу вэ гэхээр өөр боломжууд байсаар байтал яагаад заавал гэнэт нэг их сүржин гоё нэртэй. Тэгээд үүнийг эсэргүүцэх юм бол эх орноосоо урвасан дүр эсгэх нэг ийм хүнд байдал руу гишүүдийг оруулж энэ хуулийг оруулж ирээд байгаа юм бэ?

Тэр үүднээсээ би даргын зөвлөлийн хурал дээр энэ асуудлыг нухацтай ярья. Сайдыг нь байлгаж байгаад ярья. Өөр шийдэх арга замууд байна. Заавал ийм нэг репо зээлийг Монголбанк энэ нэг... /минут дуусав/

Н.Учрал: Г.Дамдинням сайд хариулъя.

Г.Дамдинням: Н.Номтойбаяр гишүүн маань салбарт мэдээлэлтэй байгаа учраас тодорхой асуудлууд дээр шууд л хатгаж асууж байна даа.

Газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж байна. Одоо 50 гаруй хувьтай болсон. Би сая тусгай баг явуулаад тоног төхөөрөмжүүдийнх нь үйлдвэрлэлийн ажил хэр явж байгаа талаар яг газар дээрээс нь хяналт хийгээд яв гээд Газрын тосны үйлдвэрийнхэн явж байна. Байнгын мэдээлэлтэй байгаа. Одоо энэ том хэмжээний тоног төхөөрөмжүүдээ оруулж ирж угсрах ажлууд хийгдэнэ. Тээвэрлэлтийн ажил гэж нэлээн том ажлууд бэлтгэл ажлууд хангагдаад явж байна.

Тэгээд энэ үйлдвэр дээр хамгийн том асуудал бол түүхий эд. Түүхий эдээ хангахад манай Газрын тосны тухай хууль болохгүй байгаа.

Манай яаман дээр Ашигт малтмалын тухай хууль болон Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга нэмэлт, өөрчлөлтүүд бэлэн болоод одоо ингээд үзэл баримтлалыг нь батлуулахаар яамд руу гаргаад байж байгаа.

Газрын тосны хууль маань ерөөсөө боомилоод хаясан. Шинэ хөрөнгө оруулагчдыг гацаасан. Дээрээс нь хожим нь гарсан баахан татвар хураамжтай холбоотой хуулиар орж ирсэн хөрөнгө оруулагчдаа бүгдийг нь хөөгөөд явуулсан.

Хайгуул судалгаагаа хийх боломжгүй ийм л нөхцөл байдал руу оруулсан байгаа юм билээ. Үүнийг засах ёстой.

Хамгийн гол бидний бодлого бол дотоодынхоо тосоор дотоодынхоо үйлдвэрт бүрэн хэмжээнд хангадаг болох ёстой гэдэг таны саналтай 100 хувь санал нэг байна.

Хоёрдугаар асуудал. Оросын Холбооны Улсын дотоодын аж ахуйн нэгжүүдэд хувь хэмжээ эзэмших асуудал аж ахуйн нэгжүүдийн асуудал байх. Гэхдээ Оросын Холбооны Улс геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаасаа шалтгаалаад дотооддоо хязгаарлалттай байгаа. 11 муж улстай А92 бензин, дизель түлшний хязгаарлалттай байгаа.

Засгийн газар хоорондын хэлэлцээр хийж байж бид ямар нэг тасалдалгүйгээр авах хэмжээнд л авчирч чадаж байна. Хувийн аж ахуйн нэгжүүдэд маань нийлүүлэхгүй байна. Үүний нэг тод жишээ бол баруун 5 аймгууд

цаанаасаа Цагааннуур, Такашкен боомтуудаар авдаг байсан бол 8 сараас хойш хаагдсан байсан. Сая бид тасралтгүй хэлэлцээ яриа хийсээр байгаад энэ 12 сараас эхлээд импортыг нээж байна.

Тэгэхээр энэ гол импортлогч орны маань дотоодын асуудал хүнд байгаа учраас бид өөр аргагүй болоод л ийм хууль оруулж ирж байна.

Хууль төгс хамгийн мундаг шийдэл биш ээ. Өөр олон төрлийн боломжуудыг би бас оруулж ирж хөөцөлдөөд засгийнхаа түвшинд ажиллаад явж байгаа.

Газрын тосны үйлдвэрийн дэргэд баригдаж байгаа сав –

- ▶ **Нэгдүгээрт**, аюулгүй байдал стандарт, нормын хувьд ерөөсөө болохгүй гэсэн хариуг өгсөн. Бид судалж үзсэн. Тэр савнууддаа шууд хийе гэж үзсэн.

Галын аюулгүй байдал, стандарт норм, тэгээд бусад асуудлуудаар бид чадахгүй ээ.

- ▶ **Хоёрдугаарт**, дэргэд нь эрчим хүчний эх үүсвэр байхгүй. Чадахгүй ээ.
- ▶ **Гуравдугаарт**, хөрөнгө оруулалт хийж байгаа Бүгд Найрамдах Энэтхэг Улсын талаас энэ боломжгүй гэдэг хариуг бидэнд өгч байгаа.

Нэг ийм л нөхцөл байдалтай байна.

Н.Учрал: Н.Номтойбаяр гишүүн тодруулна.

Н.Номтойбаяр: Тэр Газрын тосны тухай хууль үзэл баримтлал нь удахгүй орж ирэх юм байна. Даруй оруулж ирье. Магадгүй та энэ салбарын сайд байхад танаар овоглох нэг том чухал ажил болж магадгүй шүү.

Яах вэ, Оросын Холбооны Улстай харьцах хандлагын хувьд би зүгээр жишээ болгож хэлсэн юм. Тэгээд хуулийг нь нэлээн судалж үзлээ л дээ. Болохгүй зүйл ердөөсөө биш. Бид Орост хүнд байгаа гээд Оросын хүндийн зовлонг бид өнөөдөр энд ойлгоод харамсаад суух биш. Үгүй, ямар ч нөхцөл байдалд байсан би бид өөрсдийнхөө эрх ашгийг эн тэргүүнд тавиад харилцан ашигтай байх байдлаар хамтарсан компани хөрөнгө оруулалтыг хийж болно шүү дээ. Гагцхүү үүнийг төр өөрөө үүд хаалгыг нь нээж өгөх ёстой байхгүй юу? Төр нь өөрөө үндэснийхээ компаниудыг тэнд хөрөнгө оруулалт хийлээ гэхэд хамгаалах ёстой. Ийм л юм би хүсээд байгаа юм.

Тэгэхээр энэ сэтгэхүйн хувьд бид энэ хандлагаа өөрчилье өө. 100 жил л Орос гэхээр л айдаг. Алуулах вий гэж болгоомжилдог... /минут дуусав/

Н.Учрал: Г.Дамдинням гишүүн хариулъя.

Г.Дамдинням: Тийм. Н.Номтойбаяр гишүүн ээ, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Ашигт малтмалын хууль хоёрыг би сайд байгаа дээрээ нэг өөрчлөх юмсан гэж бодож байгаа.

Маш их зорьж байна. Их Хурал дээрээс маш их дэмжлэг хэрэгтэй байгаа. Галтай ч юм билээ.

Хийсэн хуулиуд нь ер нь цаг үеэ өнгөрөөсөн. Шинэ хөрөнгө оруулалт байхгүй. Орж ирэх боломжгүй. Бүгдийг нь хумьсан. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийнх нь тоо ашиглалтын тусгай зөвшөөрлөөсөө хоёр дахин бага болсон. Газрын тосонд хөрөнгө оруулалт хийсэн бүх компаниудаа зовлонг нь далайд унагаагаад ямар ч хөрөнгө оруулалт хийх боломжгүй болгоод бүгдийг нь хөөгөөд гаргасан.

Саяхан гэхэд бас дахиад л Монголын дотоодын хөөрхий хэдэн аж ахуйн нэгжүүдийн хийж байсан талбайгаа Засгийн газартаа буцааж өгч байгаа байхгүй юу.

Үүнийг засна. Олон улсын жишиг рүү нь явуулна. Хатуу ашигт малтмалтай ойролцоо байдаг хууль руу нь энэ газрын тосны хуулийг өөрчилнө өө. Тэгээд Та бүхэн маань дэмжээрэй.

Н.Учрал: Дэмжиж болно. Хууль хаана байна. Хуулиа оруулж ир ээ. Дэмжээрэй гээд хоосон юм дэмжилтэй биш. Тэр АМНАТ энэ тэрээ хуваарилах асуудлаа хурдан шийдээд Их Хуралд оруулж ирээд батлаад өгье өө л гэж байгаа шүү дээ. Тийм. Г.Дамдинням сайд хэзээ оруулж ирэх юм?

Г.Дамдинням сайдад микрофон өгье. Тэгээд яг юу өөрчлөх гэж байгаа юм?

Г.Дамдинням: Их Хурлын даргын асуултад хариулъя.

Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг бэлэн болгоод бид үндсэндээ сар орчмын өмнө Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яаманд өгсөн байгаа. Үзэл баримтлалаа батлуулж гаргаж ирэхийг хүлээж байна. Ойрын үед яамдтайгаа идэвхтэй ажиллаж байна. Үзэл баримтлал нь гараад ирэнгүүт энэ чуулган тарахаас өмнө өргөн барих төлөвлөгөөтэй байгаа. Манай яамд хурдан ажиллах байх.

Гол концепц юун дээр байгаа вэ гэхээр нөлөөлөлд өртөж байгаа газрын ард иргэд дэд бүтэцтэй илүү хөрөнгө оруулалт оруулдаг, АМНАТ-ын хуваарилалтыг олгодог, уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжихгүй

байгаа аймаг, орон нутгуудад АМНАТ-ын хуваарилалтыг багаар хүртээдэг. Мөн хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр болон тендерээр, бас төсөл шалгаруулалтаар олгодог, олон төрлөөр олгодог болох.

Гуравдугаарт, хариуцлагатай уул уурхайг дэмжих гэсэн ийм томоохон чиглэлүүдийг агуулсан хууль эрх зүйн орчныг бид бэлдсэн байгаа.

Ер нь хөрөнгө оруулалтад ээлтэй байх зарчим руу нь л шилжүүлж байгаа. Ингэж байж бид дараачийн Оюу Толгой, Тавантолгой, уул уурхайгаа нийгэм зөв ойлгуулдаг зохицуулалт руу оруулна.

Мөн энэ стратегийн орд гэж нэг ойлгомжгүй томъёоллыг ч гэсэн бас нэг ойлгомжтой болгоод оруулаад ирье гэсэн ийм зохицуулалтуудыг хийсэн байгаа.

Мөн энэ хуулийн хэрвээ үзэл баримтлалынхаа хүрээнд батлагдаж чадвал АМНАТ-аас орж ирэх орлогын хэмжээ хоёр дахин хуваарилагдаж хуваарилалт нь тодорхой, ойлгомжтой болно.

Газрын тосны тухай хууль дээр бид олон улсын жишиг нь ер нь хатуу ашигт малтмалтай ижил нөхцөлөөр явдаг ийм зарчим руу шилжсэн байгаа. Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар хуучирсан. Бид хатуу ашигт малтмалтай ижилхэн байх энэ ойлголтыг энэ хуульдаа шингээгээд бэлэн болгосон. Ойрын үед яам руу гаргаж үзэл баримтлалыг нь батлуулаад Улсын Их Хуралд өргөн барина. Тийм.

Ч.Учрал: Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөлтэй танилцсан.

Баруун бүсэд ерөөсөө бензин шатахуун маш өндөр үнэтэй байгаа. Хуучин Цагааннуурын дамжлага баазын Нефть бааз гээд байсан. Ер нь баруун аймаг дээр Увс, Ховд, Өлгийд сав ёмкостын багтаамж хэр байна? Хэдэн сая тонны багтаамжтай. Тэрний юуг гаргасан уу ер нь.

Одоогийн байдлаар бензин үнэд орохоос өмнө өнгөрсөн 2 жилд 1 литр бензин хотод 2390 байхад манайд 2800-гаар авч байсан. Одоо 3350, хотод 2590 байгаа. Зөрүү нь 760 төгрөг.

Тэгэхээр чинь баруун бүсэд ийм өндөр байгаа. Зарим алслагдсан сумууд дээр дизелийн түлш 4 мянга хүрсэн байгаа. Импорт олж байгаа бензин шатахуун импорт олж байгаа компани үгсэн хуйвалдаж үнийг нь нэмдэг. Яагаад гэвэл хотоос алслагдсан гэдгээрээ хотоос зөөж байна шүү дээ.

Тийм учраас баруун аймгуудыг Увс, Баян-Өлгий, Ховдынхныг цаанаас нь зөөж болдоггүй юм уу? Гэрээг нь тэгж хийж болдоггүй юм уу. Ер нь. Зудын байдалтай. 760 төгрөгийн зөрүүтэй байна шүү дээ. Энэ чинь. Үүнийг яая гэж бодож байна. Дараа тодруулъя.

Н.Учрал: Г.Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Манай баруун бүсийн гол агуулах, хангалтын төв Баян-Өлгий аймаг байдаг.

Баян-Өлгий аймагт 15 мянган тонны хадгалах савны нөөцтэй. Цаашдаа бид Ховд аймагт бас дараачийн агуулах савны нөөцийг бүрдүүлэх бодлого барьж байгаа. Судалгаа тооцооллоор ингэж гардаг.

Баруун бүсийн аймгуудын яагаад үнэтэй авдаг хоёр шалтгаан бий. Нэгдүгээрх нь, баруун бүсийн 5 аймгууд маань үндсэндээ Увс, Ховд аймагт 92 бензин 3300 төгрөг байж байгаа. Импортлож байгаа үнэ нь тээвэр ложистик нийлүүлэгчдийн нөхцөл байдлаас шалтгаалаад 1050 доллар 1 тонн дээр. Улаанбаатарт орж ирж байгаа үнээс 300 долларын үнэтэйгээр орж ирээд байгаа юм.

Нэг зүйлийг хэлье. Юу вэ гэхээр баруун бүсийн аймгууд маань Евро-5 стандартын шатахуун хэрэглэдэг юм шүү. Евро-2-ыг биш. Хамгийн сайн чанарын бүтээгдэхүүнүүдийг хэрэглэдэг.

Тэгээд дизель түлш 3860 төгрөг байх ёстой. Эндээс мөн 960-аас 1100 орчим өндөр үнээр Евро-5 стандартын бүтээгдэхүүн худалдан авч байгаа.

Зүүн аймгууд төмөр замтай. Эрээнцаваар орж ирдэг учраас харьцангуй бага үнэтэй байдаг. Цаанаасаа нийлүүлж байгаа. Б.Бейсен гишүүн ээ. Цаанаасаа нийлүүлэгдэж орж ирэхдээ автомашинаар орж ирдэг. Баян-Өлгий аймаг дээр төвлөрдөг. Баян-Өлгий аймгаасаа тараагддаг.

Ингэхдээ “Газпром” компаниас орж ирдэг. Төвийн бүсээр орж ирж байгаа голлох бүтээгдэхүүн “Роснефть”-ээс орж ирдэг. “Газпром” компани зөвхөн Евро-5 стандартыг үйлдвэрлэдэг. Евро-5 стандарт нь 300 төгрөгийн үнэтэй байгаа байхгүй юу. Тонн тутамдаа.

Тийм учраас үнэтэй болоод байгаа юм. Сая 8 дугаар сарын 01-нээс эхлээд баруун бүсийн импортыг хаасан. Улаанбаатараас бид хангаж байсан. Улаанбаатар, Эрдэнэтээс хангаж байсан. Ингэхэд тээвэр, ложистикийн автомашины зардал, хугацаа ороод нэлээн асуудал бэрхшээлтэй байлаа.

Сая Монгол Улсын Ерөнхий сайдын Оросын Холбооны Улсад хийсэн ажлын айлчлалын хүрээнд бид Оросын талтай тохиролцож баруун бүсийн импортыг нээж 12 дугаар сард үндсэндээ импорт дахин нээгдээд орж ирж байгаа. Удахгүй гол импортыг нийлүүлдэг “Рысжан” компаниас өгсөн мэдээллээр 2 мянган тонны А92-ын захиалгыг өгсөн. 3300 орчим төгрөгөөр зарна гэсэн ийм мэдээллийг өгсөн бид нарт.

Тэгэхээр баруун бүсийн үнэтэй байгаа гол шалтгаан тэр. Баруун талаасаа орж ирж байгаа нь сая л нээгдлээ. Буцаад. Тийм.

Н.Учрал: Б.Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ 760 төгрөгөөр үнэтэй байна гэдэг чинь ард иргэд хүндээр тусаж байгаа байхгүй юу. Хилийн цаана энэ чинь 1500 төгрөгөөр хямд байгаа.

Тэгэхээр энэ асуудал дээр та дүгнэлт хийгээд үзэхгүй бол баруун аймгууд ер нь хүнд байна шүү. Зудын хүнд байдалтай.

Нөгөө талаар түрүүн танд хэлсэн эко стандарт гээд Төв аймгийн Сэргэлэн суманд 3 мянган тонн хаягдал тосноос 210 мянган тонн дизелийн түлш боловсруулж байгаа юм байна. Танай яамныхан үзээрэй. Бас дэмжлэг үзүүлээрэй гэсэн. Тэрийг үзсэн үү? Дотоодын бензин, шатахуунаар уул уурхайг таслалгүй явуулах боломж юм билээ.

Н.Учрал: Г.Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Тийм. Манай Б.Бейсен гишүүн тэр нэг жижиг үйлдвэрүүдийг надад хэлсэн. Би ажлын хэсэг явуулаад үзүүлж байгаа.

Ер нь сүүлийн үед нефтийн бүтээгдэхүүний хомсдолтой холбоотой юу, аж ахуйн нэгжүүд маань нэлээн юм хийх гээд оролдоод байгаа. Жижиг ийм үйлдвэрүүд бий.

Хэд хэдэн төсөл, хөтөлбөрүүд яригдаж байд гэдэг юм. Бага хэмжээний, бага оврын. Энд нэг нь тэр ажилласан масло тосноос гаргах. Дараачийнх нь хөлөг онгоцны түлш. Түрүүн яригдаад байгаа нөгөө хуурамч бензин, түлш хийгээд байдаг гол асуудал тэнд явагдаж байдаг.

Тэгэхээр манай яамны зүгээс олон улсын стандарт норм, Монгол Улсын стандарт нормыг хангасан бүхий л зөвшөөрлөөр нь бүрэн хэмжээнд дэмжиж хамтарч ажиллаж байгаа. Цаашид энэ бизнес хийх сонирхолтой хүмүүс байвал бид ямар нэг хүнд суртал үзүүлэхгүйгээр чөлөө зөвшөөрлийг нь дэмжиж өгч байгаа.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Эцсийн хэлэлцүүлэг.

Зарчмын зөрүүтэй санал дээр дэмжсэн, дэмжээгүй хүн үг хэлж болно.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслөөрх зарчмын зөрүүтэй санал.

1.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Хууль хууль хүчин төгөлдөр болох.

11.1.Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөнө.” гэж.

2030 он хүртэл юм уу? 2030 оны 12 сарын 31. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Ц.Сандаг-Очир, Н.Номтойбаяр гишүүн нэрээ өгсөн. Б.Пүрэвдорж гишүүнийг нэмье. Ингээд 3 гишүүнээр тасаллаа.

Цэндийн Сандаг-Очир гишүүн үг хэлнэ. Ц.Сандаг-Очир гишүүн үг хэлэхээс нэрээ татлаа.

Нямтайширын Номтойбаяр гишүүн үг хэлэхгүй.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн дэмжих юм уу, дэмжихгүй юм уу?

Б.Пүрэвдорж: Би Монгол, Оросын парламентын бүлгийн дарга бөгөөд парламент хоорондын комиссын даргын хувьд тодорхой мэдээллийг хэлэх нь зүйтэй. Яагаад гэвэл энэ асуудал Монголчуудын хувьд чухал асуудал болдог.

Тэгэхээр энгийн 92, энгийн дизель түлшийг Монголд зориулж 200 доллар орчмын хямдаар Ангарск үйлдвэрт Монголчуудын хүсэлтээр л үйлдвэрлэдэг.

Тэр нь дээд тал нь 60 мянган тонн энгийн 90 юм уу, 92 бензин гаргах боломжтой.

Тэгээд ер нь энэ асуудлууд яагаад 11 сард асуудал үүсдэг вэ гэхээр 10 сард Ангарскийн үйлдвэр өвлийн түлш үйлдвэрлэхийн тулд түр зогсолт хийдэг. Тэгээд засвар энэ тэрээ хийдэг. Тэгээд 1 сар зогсдог. Энэ хооронд 11 сарын хангамж хүндэрдэг ийм л зүйл болоод байдаг юм.

Тэгээд энэ 11 сарынхаа хангамжийг та нар хавар яг тэр өвлийн түлшээ зогсоогоод зуны түлш хийх үед та нар нөөцлөөд авчхаач ээ л гэдэг ийм зүйлийг Оросууд ярьдаг байхгүй юу даа. Гэтэл манай хангамжийн асуудал, нөгөө савны асуудал юу байгаа билээ.

Тэгээд би та нарт савыг нь хэлээд өгье. Монголд 480 мянган тонн нөөцийн савтай. Тэрний 27 хувьд нь буюу 130 мянган тонн нь нөгөө хуурамч шатахуун чинь хадгалагдаад хэдэн жил хэрэглэгдэхгүй компаниудыг саваа ашиглах боломжгүй. Тэгээд дээрээс нь хамгийн их стратегийн тэр зангилаа төмөр замын газрууд дээр бүгдээрээ хадгалсан байж байгаа. Хөдөлдөггүй.

Тэгээд ер нь энэ 480 мянган тонноос 30 хувьд нь буюу 150 мянган тонныг л 28 хоног хадгалах боломж л манай Монгол Улсад байгаа.

Тэгэхээр үүнийг хийх гэхээр нэгдүгээрт компаниуд нь өөрсдөө тэр санхүүгийн эх үүсвэр муутай байдаг. Дээрээс нь савны боломж нь хомс байдаг.

Тийм учраас л энэ зүйлийг 200 мянган тонноор хадгалах савыг нь нэмээд өгье. Тэгээд тодорхой хэмжээний тэр саванд нь хадгалах тэр шатахууных нь эргэлтийн хөрөнгийг нь нэмэгдүүлээд өгье гэдэг ийм л хууль байхгүй юу даа.

Тийм учраас энэ хуулийг дэмжиж байгаа юм. Тэгээд ард иргэдээ 11 сард тэр чигээр нь тэгж очер дараалалд оруулж, тэр уур бухимдал бүх зүйлийг нь хүргэсэн нь дээр үү, аль эсвэл төр, засгаас мөнгө гаргахгүйгээр аж ахуйн нэгжүүдэд илүү сайн боломжийг олгох замаар, санхүүгийн дэмжлэг олгох замаар асуудлаа шийдэх нь зөв үү гэдэг ийм сонголтоор бид ирээд байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ хуулийг миний хувьд дэмжиж байгаа. Тийм учраас гишүүдийг энэ 11 сард. Одоо ингээд юм өнгөрөхөөр хэл амгүй сайхан болж байгаа. Тэгээд л 11 сард яадаг билээ. Үгүй мөн тэгээд Монголоороо л нэг төр, засгаа шүүмжлээд л явдаг.

Тийм учраас иргэдээ тайван сайхан амьдруулна гэдэг чинь Монгол төрийн бас нэг томоохон үүрэг шүү дээ.

Н.Учрал: Б.Пүрэвдорж гишүүн дэмжиж үг хэллээ.

Евразийн хэлэлцээр, энэ стратегийн хангамж, бүтээгдэхүүний хууль гээд эдгээр хуулиудын санал хураалтыг маргааш өглөө 10.00 цагт хийнэ. Тэгээд 10.00 цагт ирцээ бүрдүүлэхийг хүсэж байна. 10.00 цагт байгаа ирцээрээ санал хураана. Тийм.

Тийм учраас 10.00 цагт цагтаа цуглахыг хүсье. Дараагийн асуудалд оръё.

**Тав. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн
үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ренчинбямбын Сэддорж танилцуулна.

Индэрт урья.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан бөгөөд ингэхдээ “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулахад чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг ажлын хэсэг болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулах нь зүйтэй гэсэн санал дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийг боловсруулж Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны дарга Р.Сэддорж Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт Монгол Улсын ачаа тээврийн гол авто сумд болон Улаанбаатар хотын эрчим хүчний дэд станцуудын өргөтгөл, шинэчлэлийн асуудал тусгагдсан эсэх талаар ажлын хэсгээс асуулт асууж хариулт авлаа.
 - Мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар цаашид улсын төсвийн
-

орлогыг зөв тооцож төлөвлөдөг байх нь зүйтэйг дурдаад тогтоолын төслийг дэмжиж байгаа талаар,

- Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат ажлын хэсгээс санаачилсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоолын төсөл нь дунд хугацаанд бодитоор төлөвлөх нөхцөлийг бүрдүүлж байгаа тул төслийг дэмжиж байгаа талаар саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцсэн “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлнэ. Нэр авъя.

Асуулт асуух, үг хэлэх гишүүн байхгүй байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо байнгын хорооны саналаар санал хураалт мөн явуулах ёстой. Энэ санал хураалтыг мөн өглөө 10.00 цагт үргэлжлүүлнэ.

Дараагийн асуудлыг танилцуулъя.

Зургаа. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Индэрт урьж өгье.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.

Улмаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана гэж заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан тогтоолын төслийг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг тогтоолын төсөлд төрийн байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах, иргэнд очих төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай болгох хүрээнд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгохоор тусгалаа.

Тухайлбал, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулахад төрийн хяналт шалгалтын тогтолцоог оновчтой болгох, үүнтэй холбогдуулан бизнес эрхлэх үйл ажиллагааг дэмжих, зөвшөөрөл олгох процессыг хөнгөвчлөх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх шаардлагатай байгааг харгалзан дараах хууль тогтоомжийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт үүрэг болгохоор төсөлд тусгасан. Үүнд:

1.Иргэн аж ахуйн нэгжид зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн хяналтын хүрээг оновчилж, хүнс, эрүүл ахуй, эм, эмчилгээний чанар, уул уурхай, газрын тос, байгаль орчин, дэд бүтэц, боловсрол зэрэг нийтийн эрх, хууль, ёсны ашиг сонирхол, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хөндөгдөх, эсхүл зөрчигдөх эрсдэлтэй үйл ажиллагаанд хяналт тавих төрийн хяналт шалгалтын зарчмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг.

2.Аж ахуй эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах, өрсөлдөөнт чөлөөт зах зээлийн эдийн засаг, хөгжих

боломжийг бэхжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, өмчийн халдашгүй байдал, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах хүрээнд Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг, түүнчлэн Засгийн газрын 11:11 төвд улсын байцаагчтай холбоотой –

- 2020 онд - 80,
- 2021 онд - 274,
- 2022 онд - 1579,
- 2023 онд - 1999,
- 2024 онд - 2651,
- 2025 онд - 2310 –

-гомдол ирсэн бөгөөд Үндэсний хөгжлийн хүрээлэнгээс 2025 онд хийсэн салбарын хяналтын өнөөгийн байдал ба цаашдын хандлагын талаарх судалгааны үр дүнгээр төрийн хяналт шалгалтын зөвлөн туслах, соён гэгээрүүлэх чиг үүрэг орхигдсон байдлыг засах, бизнесийн үйл ажиллагааг төрийн хяналт шалгалт нэрийдлээр хясан боогдуулдаг байдлыг таслан зогсоох, давхардсан хяналт шалгалтыг оновчлох, төрийн хяналт шалгалтыг нэгдсэн удирдлагаар хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах хүрээнд салбарын хяналтыг улсын төсөвт ачаалал үүсгэхгүйгээр, төрийн албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэхгүйгээр Засгийн газар дахь хяналтын чиг үүрэгт нэгтгэж төвлөрсөн удирдлагаар хангах арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлэхээр тус тус тусгалаа.

Байнгын хорооны хуралдааны үеэр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан –

- Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн нийтийн аж ахуйн салбарын хяналтыг сайжруулах нь зүйтэй талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат аливаа шийдвэр гаргалт дахь олон шат дамжлага бүхий төрийн хүнд суртал, иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж буй асуудлыг шийдвэрлэх талаар дорвитой шийдлийг холбогдох хуулийн төсөлд тусган оруулж ирэх нь зүйтэй талаар тус тус үг хэлж, санал бодлоо илэрхийлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийг дэмжих талаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Н.Учрал: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууна. Нэр авъя.

Аюушийн Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Цагаанхүүгийн Идэрбат гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Баярлалаа. Засгийн газарт чиглэл өгөх гэж байгаа энэ Улсын Их Хурлын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.

Мэдээж эдгээр хуулиудыг шинэчилж оруул гэдэг зүйлийг бид ярихдаа энэ хуулийн хэрэгжилтийг дүгнэсэн тэр судалгаанууд дээр үндэслэсэн байх гэж би найдаж байгаа. Ийм зүйл байгаа юу гэдэг зүйлийг Байнгын хорооны дарга хариулж өгөөч.

Хоёрдугаарт, Төрийн хянан шалгалтын хуулийн шинэчилсэн найруулгыг оруулж ир гэсэн байна.

Би энэ дээр оруулж ирэхээс нь өмнө саналаа хэлье гэж бодож байна. Ер нь төрийн хяналт шалгалт гэхээр их явцуураад байгаа юм. Тэгээд хяналт шалгалтын зарим эрсдэлгүй салбаруудыг мэргэжлийн холбоонд шилжүүлбэ гэхээр төрийн гэдэг үгэн дээрээ очоод гацдаг.

Тийм учраас мэргэжлийн хяналтын тухай хуулийг гэж цаашдаа нэршлээр нь оруулж ирээд, зарим эрсдэл багатай салбаруудаа яамдад нь үлдээж болж байна. Эсвэл яг мэргэжлийн холбоо буюу мэргэжлийн танхимд нь үлдээгээд эрсдэлтэй энэ хэсгүүд дээрээ төр тодорхой нэгжээ ажиллуулах бололцоо байх ёстой.

Тэгэхээр төрд байгаа зарим чиг үүргүүдээ яг чаддаг институцэд нь өгье гэж байгаа учраас энэ төрийн хяналт шалгалт гэдэг нэршлээс эхлээд, нэр томъёоноос эхлээд дүгнэлт хийгээсэй гэж би хүсэж байна. Тэгээд мэргэжлийн хяналт гэдэг чиглэл рүүгээ ороод. Жишээ нь, Словени Улс мэргэжлийн хяналтын тухай хуультай. Би энэ асуудлыг нэлээн судалж байсан буюу Зөрчил шалган шийдвэрлэх хуулиудтай уялдуулах асуудлын хүрээнд судалж байсан хүний хувьд жоохон мэдээлэл байгаа.

Тэгэхээр мэргэжлийн хяналт гэдэг зүйл рүүгээ илүү дөхүүлж орж ирээсэй гэж хүсэж байгаа юм. Тэгээд зайлшгүй хүнс, эрүүл мэнд, эмийн асуудлыг нэг

агентлаг болгож болж байгаа юм. Бусад тэр уул уурхай, барилга гэдэг юм уу дэд бүтцийн чиглэлийн мэргэжлийн хяналтыг нэгтгэж болж байгаа. Уг нь хоёр тусдаа явах ч болохгүй юм байхгүй.

Тэгэхээр зарчим тогтолцооны хувьд анхаарна биз дээ. Тэгээд илүү их байгууллагын үйл ажиллагааг дарамталж хаах гэхээсээ илүүтэй зөвлөн тусалж хуулийг хэрэгжүүлэхэд туслах тэр философиор энэ хуулийг бичиж орж ирэх ёстой гэдэгтэй санал нэгдэж байна.

Хоёр дахь заалт байна. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гээд нэрийг нь зааж өгч байна л даа. Уг нь бид хэд ингэж нэрийг нь зааж өгөх буюу хууль санаачлагчийн эрхийг хязгаарлах дэмий л байх. Энэ чиглэлийн хуулийг гээд ерөнхий байдлаар тавивал цаашдаа зохимжтой байх.

Тэгээд үүнийгээ Засгийн газар Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гэнэ үү, эсвэл бусад уялдуулаад нэршлүүдээ байж болно. Хатуу ингэж хууль тогтоогчоос чиглэл өгч байна гээд зохимжтой юу, үгүй юү гэдэг дээр цаашдаа анхаарна биз дээ.

Тэгээд энэ хүрээндээ Эдийн засгийн эрх чөлөө болон холбогдох бусад хууль гээд Зөвшөөрлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлмээр байгаа юм. Болж өгвөл Тендерийн хууль байна. Эргээд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Хөрөнгө оруулалтын хууль ч байдаг юм уу иймэрхүү хуулиудыг нэг багц байдлаар нь орж ирээд иж бүрнээр нь л яримаар байна. Салгаж яриад ерөөсөө бас нэг тийм амжилт олохгүй шинжтэй л байна.

Тэгээд ерөөсөө л энэ эдийн засгийн харилцааг чинь боомилчхоод байгаа буюу явах чөдөр тушааны суурь нь газрын хууль тогтоомж дээр чинь очоод гацаад байгаа шүү. Сая бид хэд сая стратегийн ач холбогдол бүхий бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг сайжруулах буюу Г.Дамдинням сайдын хуулийг хэлэлцэхэд л газрын тосыг хайгуулын асуудлаас эхлээд гацлаа л гэж байгаа байхгүй юу. Энэ чинь ерөөсөө л цэвэр очоод л газрын хууль тогтоомж шүү дээ.

Тэгэхээр ийм зүйлүүд байх юм. Тэгээд үнэхээр эдийн засгаа сэргээе, хууль эрх зүйн түгжээг нь арилгая гэвэл явж ирсэн суурь нөхцөл байдлуудыг анхаарч авч үзмээр байна гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд мэдээж гишүүдээс мэргэжлийн холбоотой холбоотойгоор танхимын хуулийг өргөн барих шаардлагатай гэдгийг түрүүн Н.Номтойбаяр гишүүн ч хэлж байна лээ. Миний хувьд ч санал нэг байгаа. Энэ бүх зүйлүүдийг уялдуулж авч үзээд төр өөртөө байгаа зарим эрсдэл багатай салбарыг мэргэжлийн холбоо, танхимд нь өгөх энэ бололцоог бүрдүүлье.

Тэгээд төрийн шалгалтын хуулийг арай жоохон шинэлэгээр бодож орж ирээсэй гэж хүсэж байна.

Н.Учрал: Үг хэллээ. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулах чиглэлээр зөвшөөрлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар луу санал авахаар хүргүүлсэн.

Тэгээд П.Сайнзориг гишүүний саналуудыг бид цаашдаа анхаарч авч хэрэгжүүлэх хэрэгтэй, Засгийн газрын гишүүд анхаарах хэрэгтэй. Тэр хяналт шалгалтын хууль гээд томъёолж болно. Заавал төрийн гэх шаардлагагүй.

Өнгөрсөн хугацаанд компани, аж ахуйн нэгжүүдтэй холбоотой маш олон гомдлууд ирж байгаа юм. Жишээ нь, шалгалт хийх нь буруу биш. Ажлыг сайжруулах зорилгоор хяналт шалгалт хийж болно.

Жишээ нь, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрт –

- 2023 онд 10 байгууллагаас 36 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна.
- 2024 онд 9 байгууллагаас 33 удаа. Хоорондоо хамтарч ажилладаггүй.

Зөвхөн Дархан төмөрлөгийн үйлдвэрт гэхэд 2023 онд 7 байгууллагаас 14 хяналт шалгалт. Хоорондоо давхцалтай.

Жишээ нь, Монгол Улсын хамгийн чухал хяналт болох хүнсний аюулгүй байдлын нийт 48 хяналт 8 өөр байгууллагад харьяалагдаж байгаа.

- Стандартчилал, хэмжил зүйн газар,
- Эрүүл мэндийн яам,
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,
- Боловсролын яамнаас –

-нэг чиглэлээр 4 газраас дүгнэлт авдаг.

Ийм орчин, нөхцөлд Монгол Улсад бизнес эрхлэх ямар ч бололцоо байхгүй.

Тийм учраас энэ Байнгын хорооны тогтоол бол эрх чөлөөг бий болгосон, зах зээл дэх төрийн оролцоог бууруулсан холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт орвол, мөн дээрээс нь энэ хяналт шалгалтын ажлаа нэг мөр болго гэж.

Тэгэхээр нөгөө мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгахад анх хяналт шалгалтыг нэг мөр болгоё, бууруулъя гэдэг зорилготой байсан бол одоо маш олон байгууллага, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд дээр зорилго нь нэг мөртөө олон төрлийн хяналт шалгалтуудыг хийдэг ийм байдал байна.

Төрийн хяналт шалгалтын чиг үүргийг салбарын 11 яамдад шилжүүлснээр төлөвлөгөөт хяналтын хэрэгжилт хангалтгүй болсон.

Тэгэхээр цаашдаа бид энэ хяналт шалгалтыг цэгцлэхгүй бол нэг талаасаа бизнес эрхлэхэд хэцүү, нөгөө талаасаа төр өөрөө иргэдийнхээ эрүүл амьдрах, аюулгүй амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд анхаарахгүй байна л гэсэн үг.

Тийм учраас ямар нэгэн төсөв, мөнгө нэмэгдүүлэхгүйгээр хяналтынхаа чиг үүргийг нэгдсэн удирдлагаар ядаж хангах ёстой. Засгийн газар. Тэгж байж төлөвлөгөөгөө гаргаад хяналт шалгалтыг давхардуулахгүй байхад анхаарах ёстой.

Тийм учраас Төрийн байгуулалтын байнгын хороо цаг үеэ олсон ийм тогтоолыг энэ хяналт шалгалтын ажлын хэсгийн үр дүнд оруулж ирж байна гэж ойлгож байгаа. Хугацаатай үүрэг даалгавруудыг өгсөн.

Аюушийн Ариунзаяа гишүүн үг хэлнэ.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын даргын 111 дүгээр тоот захирамжаар байгуулагдсан Д.Энхтүвшин гишүүний ахалсан ажлын хэсэг жилийн хугацаанд ажиллаж, тайлангаа Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулж, дагасан тогтоол гарч байгаа.

Тэгээд энгийн хүний ойлгогдох хэлээр хэлэх юм бол Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг эргүүлэн сэргээн байгуулах хэлбэр лүүгээ орж байна гэж ойлгох хэрэгтэй. Тэгээд хэдүүлээ төр, төрийн байгууллагаараа жоохон тоглосон л асуудал болоод байгаа юм л даа.

Ер нь яах вэ, би хувьдаа мэргэжлийн хяналтын байгууллага байх нь зүйтэй гэж ер нь боддог хүний нэг. Тэгээд одоо эргээд нэг газар төвлөрүүлэх, салбар яам болгон дээр очсон байгаа хяналтын мэргэжилтнүүдийг эргүүлж нэг газарт төвлөрүүлэх ийм л одоо. Энгийнээр хэлэх юм бол ийм тогтоол, даалгавар өгч байна.

Тэгээд Улсын Их Хурлын тогтоол нь өөрөө бас биелэгдэх боломжтой байх ёстой гэдэг агуулгаараа 2026 оны 01 сарын 01-ний дотор төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэхгүйгээр, улсын төсөвт ачаалал үүсгэхгүйгээр нэгдсэн удирдлагаар хангаж, арга хэмжээ авах даалгаврыг өгч байгаа нь яг биелэх боломжтой юу, үгүй юу гэдэг дээр миний хувьд эргэлзээтэй байна.

Яагаад гэхээр яг энэ салбар яамдад байгаа салбарын хяналт хариуцсан ажилтнуудыг Засгийн газрын хяналт, шалгалт хэрэгжүүлэх газар луу нэгтгэнэ гэдэг маань өөрөө Засгийн газрын тухай хуулийг өөрчлөх ёстой. Мөн тухайн

салбар яамд дээр нь тавигдсан байгаа төсвийг нь дагуулж тухайн газар луу нь шилжүүлэх ёстой.

Тэгэхээр чуулган хаах гээд байдаг. 01 сарын 01-нээс өмнө яг энэ Засгийн газрын хуулийг, төсвийн тодотголыг хийж хэрэгжүүлэх боломжтой гэж үзэхгүй байна л даа.

Тэгэхээр магадгүй энэ тогтоол дээрээ өгч байгаа хугацаагаа хойшлуулах ёстой юу. Ямар ч байсан нэг ийм логикийн алдаатай байна гэдгийг хэлмээр байна. Хяналт хэрэгжүүлэх газрыг яах вэ, Хэрэг эрхлэхийн сайдын дэргэд байх үед Засгийн газрын үйл ажиллагаа дотооддоо хяналтыг хэрэгжүүлдэг байсан бол одоо бүх улсын хэмжээнд бүхий л салбарууд дээр хяналт хэрэгжүүлэх хуучны л мэргэжлийн хяналтын байгууллагатай адилхан нөхцөл рүү орж байгаа нь эргээд нөгөө Засгийн газрын үйл ажиллагааг хянадаг бүтэц, механизм нь алдагдах магадлалтай болно. Тийм ээ.

Тэгэхээр үүнийгээ ч гэсэн хэрхэх вэ гэдгийгээ бодож ер нь Засгийн газар өөрөө яг энэ бүтэц, бүрэлдэхүүн болоод системийн дахин инженерчлэлээ нэг томоор авч үзээд нэгдсэн байдлаар оруулж ирсэн нь зүйтэй бус уу гэж бодож байна.

2026 оны 01 сарын 01-нээс үүнийг хэрэгжүүлээ гэсэн даалгавар нь өөрөө их тулгамдуу хэрэгжүүлэх боломжгүй даалгавар болов уу гэсэн ийм л саналтай байна.

Н.Учрал: Санал хэллээ. Тогтоол гарснаараа хяналт шалгалтын хууль, түүнийг дагасан хуулиудын өөрчлөлт ороогүй цагт мэргэжлийн хяналтын байгууллага сэргэж байгуулагдах бололцоогүй.

Тийм учраас хавар хуулиудаа тэр тогтолцооныхоо хувьд эргэж хараад нэгтгээд оруулж ирэх л чиглэлийг өгч байгаа. Гэхдээ тэр яам болгон дээр байгаа улсын байцаагч гээд нэртэй нэг ийм улаан канттай, нэг бланктай, нэг хэдэн тамгатай. Тэгээд хэний удирдлагаар ажиллахаа мэддэггүй хэдэн хүмүүстэй болоод байна шүү дээ.

Тэгэхээр эд нарыг нэг ийм төлөвлөлттэй болгоод, уялдуулаад нэг ийм төлөвлөгөөт шалгалтуудыг нь хийхэд ядаж давхцуулахгүй болгоход зохион байгуулалт хийхгүй бол тал талд жишээ нь хүнсний аюулгүй байдлаар 8 байгууллага зэрэг шалгаад эхлэхээр хувийн хэвшил ер нь яаж ажиллах юм бэ.

- Төрийг нэг л гэж бодож байгаа шүү дээ.

- ▶ Нийслэл нь байна уу,
 - ▶ засаг нь байна уу,
-

- ▶ агентлаг нь байна уу,
- ▶ дүүрэг нь байна уу.

- ▶ Дүүрэгт нэг очно,
- ▶ нийслэлд нэг очно,
- ▶ яаманд нэг очно,
- ▶ агентлагт нэг очно.

Тэгээд ер нь өдөр болгон очиж шалгуулсаар байгаад амьдрал дуусаж байна.

Эрсдэлийн үнэлгээнд суурилсан зөвшөөрөл сунгах үйл явц огт хэрэгжихгүй байдалтай.

Тэгэхээр Засгийн газар давхардсан хяналт шалгалтаа бууруул гэдэг л үүрэг. Тэгээд хавар тэр хяналт шалгалтын хуулиа оруулж ир ээ. Тэгээд асуудлаа шийдэхгүй бол ийм орчин нөхцөлд энэ жил баталсан төсвийн хүрээ чинь зах зээл дэх төрийн оролцоог бууруулъя гээд байгаа. Гэтэл энэ орон зайнд яаж бизнесийнхэн ажиллах вэ. Хүнд суртлыг бууруулна, чөдөр тушаа болсон зөвшөөрлүүдийг багасгана гэдэг чинь тэр чигтээ мөчлөг сөрсөн бодлого гэж яриа биз дээ. Тийм.

Тэгэхээр тэр талд анхааръя. А.Ариунзаяа гишүүний саналыг Засгийн газар анхаарах хэрэгтэй.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Тогтоолын төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа.

Хяналт шалгалтын асуудал дээр ер нь тэр нэгтгэх гэдэг туйлын зөв. Аймаг нэг очоод л, агентлаг нэг очоод л, сумынх нь түшмэл нэг очоод л ингээд л нэг цуварсан баахан юмнууд нэг асуултаа гурав дахин асуугаад явдаг. Үүнийг уг нь орон нутагт нь өөрсдөө зохион байгуулах бололцоо байдаг.

Тэгэхээр орон нутаг дахь хяналт шалгалтыг аймаг, орон нутаг нь өөрөө зохион байгуулаад хууль эрх зүйн орчныг нээгээд өгвөл гал нь, онцгой байдал нь, стандарт нь бүгд нэгдээд явах бололцоо байдаг л даа. Тэгэхээр үүнийг нь уг нь нээгээд өгмөөр байгаа юм.

Нөгөө талдаа мэргэжлийн хяналтын байгууллагыг яах вэ татан буулгасан ч гэсэн чиг үүрэг нь яам руугаа шилжсэн. Тэгээд энэ дээр чиг үүрэг нь шилжээд яагаад хэрэгжих бололцоогүй байна вэ, хэрэгжихгүй байна вэ энэ хяналт шалгалт гэдгийг бас нэг судлаад үзэх нь би зүйтэй болов уу гэж бодож байгаа.

Яг амьдрал дээр яваад очихоор мэргэжлийн хяналтад байсан хоёр байцаагч нь нэг агентлаг дээр яваад очдог. Нөгөө агентлагийн дарга нь одоо тэгээд тэр хяналт шалгалтынх нь асуудал дээр нэг их тийм онцгой ач холбогдол өгдөггүй, унаа машин хангадаггүй гээд олон л гомдлууд байдаг юм билээ.

Тэгэхээр ер нь энэ хуулийн хэрэгжилт юун дээр саармагжав, яагаад болохгүй байна вэ гэдгийг бас давхар би үзэх нь зүйтэй болов уу гэж бодож байгаа.

Сүүлийн үед төрийн албан хаагч нар зөвлөн туслах л үүрэгтэй шүү л гээд байгаа. Зөвлөн туслах үүрэгтэй. Амьдрал дээр яг зөвлөн туслаад хуулиа хэрэгжүүлдэг үү гэвэл бас үгүй л дээ.

Тэгэхээр эхлээд зөвлөн туслаад, дараа нь хариуцлага гэдэг юм чинь давхар тэр механизм байхгүй бол зүгээр нэг сайхан аргадсан гуйсан. Энэ төрийн албан хаагч нар чинь тийм л хүмүүс болох гээд байна шүү дээ. Тийм.

Тэгэхээр энэ дээр би зөвлөн туслахаасаа гадна эхлээд зөвлөн тусал, дараа нь тэр хариуцлага юм нь тодорхой байх ёстой гэдгийг би зориуд хэлмээр санагдаад байгаа юм.

Хоёрт нь, Эдийн засгийн эрх чөлөөний хууль гарч байна.

Ер нь төр аж ахуйн нэгжүүднээс өмнө үүрэг хүлээдэг баймаар байгаа юм. Чи үүнийг ингээд хий гээд сонгон шалгаруулалтаар оруулаад өгдөг. Юмаа хийгээд цагт нь хүлээлгээд өгөхөөр мөнгийг нь өгдөггүй. Одоо яг ийм процесс ялангуяа орон нутагт байгаа аж ахуйн нэгжүүдийг сөхрүүлж байна шүү дээ.

Төрийн өмнө үүрэг хүлээгээд баахан өндөр хүүтэй зээл аваад юмаа хийдэг. Мөнгөө аваад эргээд төлнө дөө гэтэл нөгөө мөнгийг нь өгдөггүй. Хүү гүйж л байгаа.

Тэгэхээр хувийн компани юмаа хийгээд хүлээлгэж өгөхгүй бол алданги тооцдог шиг төр ч гэсэн улсын комиссоо хүлээлгэж өгөөд авсан бол тэр аж ахуйн нэгжийн өмнө мөнгийг нь хугацаа алдахгүй шилжүүлдэг ийм юм руугаа явахгүй бол аж ахуйн нэгжүүдийг туйлын хүнд байдалд оруулж байна.

Би өчигдөр Байнгын хороон дээр хэлсэн.

Хийсэн юмныхаа төлбөр мөнгийг авах гэж 7 сард хорин хэдэн хүний гарын үсэг цуглуулж, санхүүгийн баримтаа бүрдүүлж авах гэсээр байтал ихэнх хүмүүс нь амраад алга болдог. 9 сараас нааш ирэхгүй.

- Ингээд ажил гацдаг.
- Ингээд хөрөнгө оруулалт хойшоо болдог.
- Ингээд аж ахуйн нэгжүүд санхүүгийн алдагдалд орж эхэлдэг.

Тэгээд нөгөө төсвөө нэмэгдүүлэх юм явж эхэлдэг гээд. Үүнийг би тэр эрх чөлөөний хууль гэж томъёолсон юм байна. Юу гэж орж ирэх байгаа юм. Энэ дээрээ төр аж ахуйн нэгжүүдийнхээ өмнө ямар үүрэг хүлээх юм бэ гэдгийг би оруулж ирээсэй гэж бодож байгаа.

Тэгэхээр Засгийн газар энэ тогтоолын хэрэгжилтийг хангах үүрэг хүлээх байх. Ингээд ирэхээр иргэдийн өмнө, аж ахуйн нэгжүүдийн өмнө, бизнес эрхлэгчдийн өмнө маш том тийм өндөр хүлээлт орж ирнэ. Хүлээлт үүснэ.

Тэгэхээр тэр хүлээлтийг биелүүлж чадах хэмжээний бизнесийн орчныг сайжруулах талын хуулиа ч тэр, төрд иргэдийн үйлчилгээг ойртуулах тал дээр ч тэр тийм цогцоор нь харсан... /минут дуусав/

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны тогтоолтой холбоотой гишүүдийн саналыг протокол, тэмдэглэлд үлдээе. Засгийн газарт чиглэл өгөх хэрэгтэй.

Энэ хяналт шалгалтын давхардлыг арилгах чиглэлээр Засгийн газар дээр unelgee.gov.mn ажилладаг. Үнэлгээ хийгдэж байгаа. Мэдээ, мэдээллүүдийг бид мэдээллийн технологи ашиглаад цахимаар анализ хийдэг болсон.

Ирэх жил хийгдэх гэж байгаа төлөвлөгөөт шалгалтуудын давхардлыг арилгах чиглэлээр бодлого боловсруулах хэрэгтэй. Тэгэхгүй бол төрийн байгууллагуудын шалгалт давхцаад байна. Үзүүлж байгаа, харуулж байгаа ажлууд нь адилхан. Энэ олон байгууллагууд ажил явуулдаггүй. Зөвлөн туслах гэх юм байхгүй.

Сүүлийн судалгаанаас харахад бараг 34 хувь нь торгоход чиглэж байгаа. Тэнд ямар зөвлөн туслах байгаа юм.

Дээрээс нь Стандарт, тохирлын үнэлгээний хууль Их Хурал дээр хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн. Стандарт, тохирлын үнэлгээний хуультай энэ зөвшөөрлийн хууль, энэ хяналт шалгалтын хуулиуд уялдах ёстой юм.

Тийм учраас нэгэнт нэгтгэгдээд байгаа дата дээрээ суурилад ирэх жилийн төлөвлөгөөт шалгалтуудаа цэгцлэхгүй бол төрийн байгууллагуудын шалгалтын давхардал хэрээс хэтэрлээ.

Дээрээс нь наад олон салбарын байцаагч нарын чинь нэгдсэн удирдлагаар хангадаг эрх бүхий албан тушаалтан байхгүй боллоо.

Тэгэхээр үүнийг Засгийн газар тэр хяналт хэрэгжүүлэх газар дээрээ төлөвлөгөөг нь гаргаад нэгтгээд үе шаттайгаар мэдээллийн технологи ашиглаад төлөвлөх хэрэгтэй. Тэгж байж хувийн хэвшил дээр үүсээд байгаа хүнд суртлууд багасна. Үүнийг Засгийн газарт чиглэл өгмөөр байна.

Түрүүн Эдийн засгийн эрх чөлөөний хууль гэхгүйгээр зах зээл дэх төрийн оролцоог бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах гэдэг байдлаар томъёолоод орж ирж болно.

Мөн төрийн хяналт шалгалтын гэхгүйгээр зөвхөн хяналт шалгалтын хууль гээд томъёолж болж байна. Ингээд Засгийн газарт чиглэл өгөх тогтоолыг гаргаад, энэ олон Их Хурлаас батлагдсан тогтоолууд, бодлого шийдвэрүүдийн үнэлгээг Их Хурал өөрөө хийнэ.

Хэрэгтэй хэрэггүй баахан тогтоол гаргасан. Тогтоол хэрэгжүүлээд байгаа юм байдаггүй шүү дээ.

Би өөрөө хяналт хэрэгжүүлэх нөгөө хууль тогтоомжийн биелэлтийн талаар Төрийн байгуулалтын байнгын хороон дээр саяхан тайлан танилцуулсан шүү дээ. Их Хурлын тогтоолд Байнгын хорооны тогтоол хэрэгжиж байгаа юм байгаа юм уу. 30 хувь ч хүрэхгүй байгаа шүү дээ.

Хэрэгжихгүй тогтоолууд баталж байснаас батлахгүй байсан нь дээр. Ер нь олон юм хийж сюрприз барихгүйгээр бизнесийнхнийг ч гэсэн, ард түмнийг ч гэсэн амар амгалан амьдруулах хэрэгтэй.

Тийм учраас бид зарим үед дуугай суух нь хүчтэй байж магадгүй шүү. Зарим үед үйлдэл хийхгүй байгаа нь хувийн хэвшлийнхэнд, иргэдэд том тус. Өглөө болгон босож ирж гэнэт янз бүрийн юм сэтгэж улс төрчдийн энэ олон сюрпризээс чинь залхаж байна.

Тийм учраас хэрэгжүүлэх боломжтой тогтоол батална. Хэрэгжүүлэх боломжгүй бүх тогтоолуудыг цуцлах хэрэгтэй.

Тийм учраас эрх зүй, дүн шинжилгээний хэлтэс цаашдаа “AI” дээр нийт гарсан энэ эрх зүйн актуудыг бүгдийг нь шүүж үзээд шаардлагагүй, хэрэгжээгүй тогтоолуудыг бүгдийг нь хүчингүй болгох арга хэмжээнүүдийг сая ажлын хэсгүүдийг татан буулгасантай адил цуцална.

Ингээд хэрэгжих боломжтой тогтоолуудаа бариад хэрэгжилтээ шахаад явбал ирэх жил ч гэсэн Төрийн байгуулалтын Ц.Сандаг-Очир даргын Байнгын

хороон дээр ядаж наад тогтоолууд чинь хэрэгжсэн юм гэдэг дүгнэлтэд хүрэхгүй бол жил болгон 20, 30 хувийн биелэлттэй тогтоол хэлэлцдэг. Нөгөө юмаа ярьдаг. Сайд нар ч нөгөө юмаа ярьдаг. Бид ч асуух юмаа асуудаг. Тэгээд ийм байдалтай л байна.

Тийм учраас үүн дээр илүү цэгцтэй ажиллая гэдэг саналтай байна. Тэгээд Байнгын хорооны тогтоолтой холбогдуулж гишүүд саналаа хэлсэн тул энэ саналуудыг тусгая. Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулах ёстой.

Маргааш өглөө санал хураалтыг явуулъя. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж байна.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудыг маргааш өглөөний 10 цаг 00 чуулган эхлэхэд санал хураана.

Тэгэхээр 10.00 цагт гишүүдийг танхимд цуглахыг хүсэж байна.

Шууд санал хураалтаар эхэлнэ. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 5 цаг 58 минут үргэлжилж, 17 цаг 16 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД